



МОНГОЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН  
Монгол Улсын Их Сургууль

# ACTA MONGOLICA

Боть 16 (426)

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

Эрхлэн нийтлүүлсэн  
Ж.Бат-Ирээдүй



МУИС ПРЕСС ХЭВЛЭЛИЙН ГАЗАР



INSTITUTE FOR MONGOL STUDIES  
National University of Mongolia

# ACTA MONGOLICA

Volume 16 (426)

ANNUAL JOURNAL

Edited by  
J. Bat-Ireedui

Монгол судлалын хүрээлэнгийн ACTA MONGOLICA сэтгүүлийн Зөвлөл

Дарга: Ж.Бат-Ирээдүй

Гишүүд:  
Д.Заяабаатар (Монгол)  
Удо Б.Баркманн (ХБНГУ)  
И Сөн-Гю (БНСУ)  
Ли Нарангоо (Австрали)  
Чимэддорж (БНХАУ)  
Алан Ж.Сандерс (Англи)  
Хашимото Масарү (Япон)  
С.Чулуун (Монгол)  
Хитоши Күрибаяаши (Япон)  
Юү Вон Сү (БНСУ)

ISSN 2074-1014

Ulaanbaatar  
2015

*Монголын нэрт эрдэмтэн, академич Бямбын Ринчений  
мэндэлсэний 110 жилийн ойд энэхүү дугаарыг зориулав.*



*Б.Ринчен Хэнтий аймгийн Мөрөн сумын Ардын депутатуудын хурлын  
байрны үүдэнд сууж байгаа нь*

*(Academic and Scholar B.Rinchen sitting in front of the premises of the  
National Committee in Mörön, Khentii aimag)*

## “ACTA MONGOLICA” СЭТГҮҮЛИЙН ТУХАЙД

МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэнгийн “Acta Mongolica” сэтгүүлийн арван зургаа дахь дугаарыг уншигч Танаа өргөн барьж байна. Энэ дугаараа бид энэ онд мэндэлсний нь 100 жилийн тэгш ой тохиож байгаа Монгол Улсын нэрт эрдэмтэн, академич, профессор Йөншөбү Бямбын Ринчений ойд зориулан 2015 оны 3 дугаар сард хийсэн “Монгол хэл бичиг, өв соёлын тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын хэрэглэгдэхүүнээр голлон бэлтгэв.

Тус дугаарт Монгол, Япон, БНХАУ, ОХУ, ХБНГУ, Унгар, Чех зэрэг орны эрдэмтдийн монгол судлалын чиглэлээр хийсэн бүтээл хэвлэгдэж байгаа бөгөөд мөн монгол судлалд хүч түрэн орж ирж байгаа бидний хойч үе, дэлхийн олон оронд эрдмийн зэрэг хамгаалсан залуучууд олноор өгүүллээ ирүүлсэнд бид их баяртай байна. Сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх шаардлага болон хэм хэмжээ урдын адил бөгөөд та бүхнийг монгол судлалын чиглэлээр бичсэн эрдэм шинжилгээний шинэхэн судалгаагаа манай сэтгүүлд байнга хэвлүүлж байхыг хүсэж байна.

Эл сэтгүүлийн редакцийн зөвлөлд Британийн монгол судлаач Алан Сандерс, Австралийн Үндэсний Их Сургуулийн Монгол Институтийн захирал, профессор Ли Нарангоо, БНСУ-ын Сөүлийн Их Сургуулийн профессор Юү Вон Сү, Данкоокийн Их сургуулийн профессор Ли Сөн Гю, ХБНГУ-ын монгол судлаач Удо Баркман, Японы Монгол Судлалын Холбооны Ерөнхийлөгч, профессор М.Хашимото, Тохоку Их Сургуулийн профессор Х.Күрибаяаши, БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн дэд захирал, профессор Чимэддорж, Монгол Улсын ШУА-ийн Түүх, Археологийн Хүрээлэнгийн захирал, д-р С.Чулуун, Монгол Улсын Ерөнхий Сайдын дэргэдэх Монгол Судлалын Үндэсний Зөвлөлийн нарийн бичгийн дарга, МУИС-ийн профессор, д-р Д.Заяабаатар нарын гадаад дотоодын нэр хүндтэй эрдэмтэн судлаач нар хамтран ажиллаж байна.

Манай сэтгүүл бол монгол судлал түүний дотор монгол хэл шинжлэл, эх бичиг сурвалж судлал, утга зохиол, урлаг, соёл, нийгэм, эдийн засаг, улс төр, социологийн асуудлаар өргөн хэмжээтэй олон улсын эрдэмтдийн бүтээл хэвлэгддэг Монгол Улсдаа нэр хүнд бүхий сэтгүүл бөгөөд нэртэй судлаач нар peer review хийж тогтмолжиж байгаа энэ чиглэлээрх хамгийн чанартай сэтгүүлийн нэг мөн болой.

МУИС-ийн Эрдэм шинжилгээ, Инновацийн албанаас тавьж байгаа шаардлагын дагуу энэ дугаараас эхлэн сэтгүүлийн зөвлөл уг сэтгүүлийн формат болон хийц маяг, өнгө зүс, хавтасны хийцийг эрс өөрчлөхөөр шийдэж цаашид импакт факторын жагсаалтанд бүртгүүлэхээр бэлтгэл ажил хийж байна.

Энэхүү дугаарыг хэвлэн гаргахад тусалж дэмжиж өгсөн МУИС-ийн Эрдэм шинжилгээ, Инновацийн хэлтэс, болон ШУС-ийн удирдлагад талархал илэрхийлье. Эрдэм номын цагаан мөр үргэлж гэрэлтэж, дардан сайхан байхын ерөөлийг өргөн дэвшүүлье.

Сэтгүүлийн Ерөнхий эрхлэгч  
Проф. д-р Жанцангийн Бат-Ирээдүй  
2015 оны 9 дүгээр сарын 15

**АКАДЕМИЧ Б.РИНЧЕН БАГШТАНЫ ЭРДЭМ  
БҮТЭЭЛИЙН ТОЙМ**

С.Дулам  
/МУИС/

Нэхэн дурсахад нэн гэгээлэг багын нэгэн дурсамжийг татан гаргаж ирвэл соньхон байх болов уу хэмээн санасаар үүнээс эхэлж тэрлэв. 1964 оны орчим үе, Баянхонгор аймгийн Байдрагийн долоон жилийн сургуулийн 6-р ангийн сурагчид бид олон сайхан зохиолыг нь уншиж, ухаант мэргэн үгсийг нь ам дамжуулан хэлэлцэж, бахдан биширдэг их эрдэмтэн Ринчен аругайд хөвгүүд голдуу хэдэн сурагч хоорондоо хэлэлцэж, амьхандаа их л тунгаан бодож байгаад нэгэн захидал бичиж илгээсэн билээ. Тэр аугаа их хүнд бидний хэдэн бөөдий сурагчийн бичсэн захиа хүрсэн эсэхийг ч бүү мэд, тэгсхийгээд мартчихсан байж. Захианы гол утга нь “явал Тан шиг олон хэлтэй, их эрдэмтэй хүн болж болох бол” гэсэн шиг утгатай л юм байсан санагдана. Гэтэл хаврын нэг өдөр манай ангийнхан хоорондоо нэг зүйлийг булаалдаад, овоорч шаваарч уншаад байхлаар нь өнгийн үзвэл өнөө бидний явуулсан захианы хариу хүрээд ирсэн юм санж. Нүүртээ монгол бичигтэй судрын зурагтай ил захидлын нөгөө талд нь бидний хаягийг бичсэний дээр “ном зохиолтой сайн нөхөрлөж, их хичээнгүйлбэл, эх орондоо хэрэгтэй тустай хүн болно доо” гэсэн утга бүхий настай хүний гарын хэв бүхий бичигтэй захиа байж билээ. Бидний хамгаас их бахадсан зүйл бол ийм алс хязгаарын хөдөөгийн сургуулийн хэдэн жулдрай сурагчдад тэр аугаа их хүнээс хариу захиа тоож ирүүлдэг нь гайхам байлаа. Бид хэд тэр захиагаа элэг зүрх мэт хайрлан нандигнаж, ээлжлэн өвөртөлж унтах нь халаг байгаад сүүлд хэнд маань хоцорсоныг ч одоо хэлэхэд бэрх болжээ. Сүүлд сонсох нь ээ бид мэтийн хүүхдүүд их эрдэмтэнд арвин их захиа бичдэг байсан агаад тэр болгонд хариу илгээдэг байсан гэх. Энэ бол их эрдэмтний гэгээн зан төрхийн нэгэн зурвас болой.

Ринчен багштан маань хэл шинжлэл, уран зохиол судлал, ардын билиг зүй, угсаатны зүй, монгол нэр томьёо судлал, монгол бөө мөргөл судлал, монгол шашин судлал, түүх судлал, урлаг судлал, утга соёлын өв, монгол түүхэн сурвалж судлал зэрэг шинжлэх ухааны олон салбарт их бүтээл туурвисан гайхамшигт эрдэмтэн болох тул тэр болгоныг нэгэн удаагийн илтгэл өгүүлэлд багтаан гүйцээх боломжгүй агаад зарим чухал бүтээлээс нь цухасхан өгүүлье. Эдгээр бүтээл нь монгол, орос, англи, франц, герман, польш, мажаар, чех хэлээр нийтлэгдсэн билээ.

Түүний бичсэн 1100 гаруй тал хуудас “Монгол бичгийн хэлний зүй” (1956) хэмээх дөрвөн боть зэрэг горилсон бүтээлээ уламжлалт ёсыг баримтлан авиан зүй, үгийн зүй, өгүүлбэрийн зүй гэж гурав ангилан судалжээ. Удиртгал хэсэгт монгол

хэл аялгууны учрыг тайлбарласан бөгөөд монгол хэлийг Ч авиатай хэл, Ш авиатай хэл, С авиатай хэл хэмээн гурав ангилжээ. Тухайлбал, дагуур хэлийг Ш авиатай хэл гэж үзсэн байна. Монгол үгийн зүйлийг урьд аймаглан хэвшсэн ёсыг шууд таягдаж, орос хэлний зүйн загварыг хүн хорхойчлон дуурайсан зүйл гэж үзжээ. Үгийн аймгийг ангилан үзэхдээ оросчлон хэвшсэн аймаглалаас эрс ялгаатай, нэрийн ай, үйл үгийн ай, сул үгийн ай гэж гурван ангилал буй болгож, нэр үг, төлөөний нэр, тооны нэр, дагавар үгийн зүйлийг ч нэр үгийн айд багтаасан билээ. Тухайлбал, монгол хэлнээ нэр үг, тэмдэг нэрийг ялгах бололцоогүй гэж үзсэн байна. Харин нэр томъёоны хувьд өнөөгийн бидний “тэмдэг нэр” гэдгийг “хавсрал нэр” хэмээн томъёолсон бөгөөд энэ тухай өөрөө “оросоор прилагательное гэдгийг латин, орос зэрэг хэлнээс монголчилж нэрлэсэн” хэмээн бичсэн удаатай. Энэ талаар ак. Л.Лигети “орос хэлний хавсрал нэрийн хэв шинжтэй энэтхэг-европ хэлний хавсрал нэрээс, монгол хэлний хавсрал нэр тэс ондоо гэж үзэх хэрэгтэй” гэжээ. Энэ бол өмнөх нэр үгтэйгээ эр, эм, эрс хүйс, ганц, хоёр, олон тоогоор хувилан зохицдог хавсрал нэрээс огт ондоон болохыг хэлсэн хэрэг болов уу. Мөн энэ академичийн үнэлснээр “үгийн зүйн хамгийн сайхан, хамгийн сонин бүлэг зүйл нь үйл үгийн цаглан хувилах байдлыг үзүүлсэн зүйл байна. Тэр бүлэг нь монгол үйл үгийн цаглан хувилах байдлыг Монголын судлал бичигт ер урьд өмнө гараагүй бүрэн гүйцдээр, цоо шинэ сонин байдлаар үзүүлжээ. Тэр шинжлэн тогтоосон тогтолцоо нь шив шинэ зүйлээр ч барахгүй, юуны өмнө магадтай лавтай бөгөөд бүх монгол хэлний судлах ухаанд үлэмжхэн тустай юм боллоо” (Ринчен 1958, 114, 115)<sup>1</sup> гэсэн байна. Өгүүлбэрийн зүйн тухайд нэр өгүүлэхүүний асуудлыг ялган таньж, зөвөөр үзэнд бахархалтай” гэсэн байна. Бүхэлд нь аваад үзвэл монгол хэлний зүйн тухай монгол эрдэмтний бичсэн анхны томоохон суурь судалгаа гэдгээрээ ч, монгол хэлийг эртний Энэтхэг Банины хэл зүйн нөлөө тусгал бүхүй Төвөдийн “Сүмжүба”, “Даганжүг” хэмээх “Гучит”, “Тэмдэгийн оролгын” хэл зүйн ёсоор судалдаг, хуучин судар номын уламжлал болон XIX зуунаас хүчээ авсан Энэтхэг-Европ зүгийн хэл зүйн уламжлал, тэр дундаа орос хэлний хэл зүйн ай болгоныг монгол хэлнээс албадан шахаж гарган ирдэг ардын хувьсгалын дараах хэл зүйчдийн уламжлалыг бүрмөсөн таягдан орхиж монгол хэлнийхээ уугал байгаль жамаар нь судалсан гэдгээрээ ч цоо шинэ шинжлэл судлал болсон билээ. Ринчен багшийн хэл зүй бол монгол хэлний зөв цэвэр хэлэлцэх аман яриа болон яруу тансаг бичгийн найруулгатай найрсан зохирч байдгаараа ихээхэн шинжлэх ухаанч хэл зүй болно. Энэ шинэхэн туршилтыг түүний шавь нарын дотроос миний номын багш, профессор Чой.Лу багштан залган авч, олон үнэтэй санал дэвшүүлсэн билээ. Олон улсын монголч эрдэмтдийн II их хуралд тавьсан “Монгол хэлний тийн ялгалын тухай”, мөн III их хурал дээр тавьсан “Монгол хэлний туслах үйл үгийн тухай”, V их хурал дээр тавьсан “Монгол үгийн язгуур” зэрэг илтгэл нь үүнийг гэрчилнэ.

Академич Б.Ринчен монгол ардын аман зохиол, угсаатны зүй, бөө мөргөлийн дурсгалыг судлахад олон жилийн хөдөлмөрөө зориулсан юм. Ринчен багш маань ардын оньсого, зүйр цэцэн үг, үлгэр тууль зэрэг аман зохиол, бөө мөргөлийн үлэмж

<sup>1</sup> Ринчен Б. *Баруун этгээд зорчсон тэмдэглэл* (Мажар улсаар явсан минь). Улаанбаатар, 1958, 209 т.х.



эх хэрэглэхүүнийг цуглуулснаа “Монгол аман зохиол”<sup>2</sup> гэсэн нэрээр дөрвөн дэвтэр болгож Герман улсын Висбаден хотноо хэвлүүлсэн нь дэлхийн монголч эрдэмтдийн анхаарлыг монгол аман зохиолын зүг хандуулахад чухал ач холбогдолтой ажил болсон юм. Тухайлбал, бидний судалдаг монгол домог зүйн талаар л гэхэд “*Монгол ардын аман зохиол*”<sup>3</sup> хэмээх цуврал эмхэтгэлдээ (“*Тэнгэрийн замын учир*”, “*Хүн нүцгэн, нохой үстэй болсон учир*”, “*Үхрийн бөөрний учир*”, “*Ертөнцийн гурван их саналтан*”) зэрэг од гарагийн болон бүтээл туурвилын домгийг ардын үлгэрчдээс сурвалжлан цуглуулж нийтлүүлсэн юм. Мөн “*Монгол бөө мөргөлийг судлах эх хэрэглэгдэхүүн*” [Rintchen III, 1975, 188-195]<sup>4</sup> хэмээх бүтээлд нь эртний домог зүйн болон бөөгийн домог зүйн холбогдолтой яруу найргийн зүйл, дуудлага, тамлага, өчил, сацал зэрэг орсон байна. Энэ гурван ботийн эхнийх нь гар бичмэлийн эх сурвалжууд болох бөгөөд олонх нь хожим үрэгдэж үгүй болсон нэн ховор эх сурвалжуудыг латин галигаар галиглан хэвлүүлжээ. “Монгол бөө мөргөлийг судлах эх хэрэглэхүүн” хэмээх гурван ботийн хоёрдугаар боть нь буриад бөөгийн эх бичвэрүүд бөгөөд өнөө цагт олдохуйяа бэрх болсон дурсгалууд байна. 1996 онд Буриадын Улаан-Үдэ хот, Байгаль далайн хөвөөнд болсон “Төв Азийн бөө мөргөл” олон улсын эдэм шинжилгээний хурлын үеэр Ри багштаны энэ бүтээлийг бүтнээр нь буриад кирил үсгээр хөрвүүлэн “Хүхэ мүнхэ тэнгэри” (Улан-Удэ, 1996) нэртэй түүвэр болгон хэвлүүлсэн билээ.

“Монгол бөө мөргөлийг судлах эх хэрэглэхүүн” хэмээх гурван ботийн гуравдугаар боть нь монгол бөөгийн эх бичвэрүүд бөгөөд энд монгол худам болон тод үсэг, төвөд үсгээр буй эх бичвэрүүдээс гадна голдуу олон монгол угсаатны бөө нэрээс янз бүрийн цаг үед бичиж тэмдэглэж авсан 126 дуудалга, даатгал, айладхал, залбирал, өчиг, сацлын үг, тамалга, сэржим, шившлэг, хурайлга, зүхэл, ураа дуудалга зэрэг бөөгийн аман яруу найргийн олон төрөл зүйлүүд багтсан байна. Энэ бүтээлийг Францын монголч эрдэмтэн Мари-Доминик Эвен франц хэлээр орчуулан судалж, “Монгол бөөгийн дуудалга” нэртэй нэг сэдэвт зохиол бичиж, докторын зэрэг хамгаалсан бөгөөд “Монгол Сибирийн судлал” цувралын 1988-1989 оны 19-20-р боть болж хэвлэгдсэн байна.

Академич Б.Ринчен эл арвин баялаг эх хэрэглэхүүнийг хээрийн шинжилгээний ангиар явах үедээ тэр цагийнхаа сайн бөө нарын амнаас сурвалжлан тэмдэглэж авснаас гадна орон шоронд орсон үед нь ч элдэв аргаар тэтгэн тусалж итгэлийг олоод үг алдуулж чаддаг хосгүй уран аргатай байжээ. Монгол бөө нар өөрсдөө Ри багшийг дээд Хурмаст тэнгэрийн аль нэгнийх нь илгээсэн биет элч хэмээн итгэж, юугаа ч нууцлалгүй харамгүй хэлж өгдөг байсан нь ийм их амжилтад хүрэхийн үндэс болжээ. Дээрх цуглуулгын гуравдугаар ботид орсон аман эх бичвэрийн зарим хэсэг нь юу юугүй бөөгийн онгод орох гэснээс болоод дутуу орхисныг тэмдэглэн үлдээсэн нь үүний нэгэн гэрч юм. Түүгээр ч барахгүй, Дамдин зааринг

<sup>2</sup> Rintchen. Folklore Mongol. Asiatische forschung. Bd 7.11. 12. 15., Wiesbaden: Harrassowitz, 1960. 1963. 1964. 1965., Rintchen. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. Asiatische forschung. Bd 8. Wiesbaden: Harrassowitz, 1961

<sup>3</sup> Rintchen B. Folklore Mongol. - *Asiatische Forschungen*. Bd 7, 11, 12, 15, Wiesbaden: Harrassowitz, 1960, 1963, 1964, 1965 [Rintchen 1960, 1963, 1964, 1965]

<sup>4</sup> Rintchen B. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. III. Textes chamanistes mongols. Wiesbaden: Otto Harrassowitz, 1975, 151 p. [Asiatische Forschungen, Band 40] [Rintchen III, 1975]

дагуулан Энэтхэгт олон улсын хуралд очсон баримтыг түүний үр хүүхэд нь дурсан ярьж байна.

Ринчен багштан бүр 1928 онд орон нутагт хээрийн шинжилгээний ажлаар Булган аймгийн Хутаг сумын нутаг Гучингурт, Гурван Хайлантайд Сулхарнай баатар хэмээх онгодыг сүлдлэн тахидаг нэгэн халх зааринтай уулзсан хийгээд тэр бөө өөрөө Сулхарнай баатар хэмээгч нь чухам ямар түүхтэй онгод болохыг мэдэхгүй байжээ. Үүнийг Ри багш дараа дараагийнхаа судалгаагаар тодруулж, Сулхарнай баатар бол эртний Грекийн хаан, Дундад болон Баруун өмнөд Азийг байлдан дагуулагч Македоны Александр мөн болохыг нэхэн тодруулсан байдаг. Энэхүү халх зааринтай анх 1928 оны зун Сэлэнгэ мөрний Гуртын тавилан дээр уулзаж яриаг нь тэмдэглэн авсан тухайгаа түүхч О.Пүрэв агсанд 1967 онд ярьж байжээ (Билгүүн номч Б.Ринчен 1990, 69)<sup>5</sup>. Ринчен багшийн “Монголын бөөгийн шажинг судлахын хөтөлбөр” нэртэй 19 тал хуудас 427 асуулттай эх хэрэглэхүүнийг 1997 оны 6-р сарын 23-нд оточ маарамба Батын Пүрэвсүрэн аругай надад өгсөн бөгөөд 1967 оны орчим Ри багштан түүнд нэг хувийг өгсөн байжээ. Энэ тухай миний бие 2005 онд 100 жилийн ойд нь зориулсан эрдэм шинжилгээний хуралд тусгайлан илтгэл тавьсан тул дэлгэрүүлэн ярихгүй.

Домог зүйн судалгааны хувьд академич Б.Ринчен домгийн үйл явдал, дүрийг түүхэнд болсон явдал, түүхэн хүний дүртэй харгалзуулан үзэх гэсэн эвмегерч маягийн үндэслэл боловсруулж байв. Тухайлбал, буриад домгийн Эсэгэ Малаан тэнгэрийн дүр бол үнэн хэрэгтээ Чингис хааныг тэнгэрчилсэн хэрэг гэж үзэж байв (Ринчен 1975, 188-195)<sup>6</sup>.

Аман зохиолыг сурвалжлан цуглуулах арга зүйн хувьд манай судлаачид орон нутгаар явж үлгэрч туульч хүмүүсээс хэлүүлж тэмдэглэж авахаас гадна орон нутаг даяар алдаршсан ардын авьяас билигтнүүдийг урин ирүүлж аман зохиолын зүйлийг бичиж авч байжээ. Тухайлбал, ардын хувьсгалын дараахан Алтанбулагийн сууринд аж төрөн сууж байсан үлгэрч, туульч Өлзийн Лувсан хуурчаас “Баруун тивийг эзэлсэн Бодь мэргэн хаан” хэмээх туулийг 1927 оны 8-р сарын 9-нөөс эхлэн олон хоног сууж байж аялгууны хамт бичиж авсан нь туулийн хөг аялгууны судлалд үнэтэй өв болсон байна. 1929 оны үед Засагт ханы хүрээний халх лам, үлгэрч Дэндэвээс 14000 мөр шүлэг “Нэг зуун тавин таван насыг насалсан хөгшин Луу мэргэн хаан” зэрэг үлгэр туульсыг тэмдэглэн авсан нь энэ зуунд халх, ойрадчуудаас бичиж авсан туульсын дотор хэмжээгээр хамгийн томоохон нь байдаг. Мөн “эрхийдээ эрчтэй эрийн сайн Хамбуудай мэргэн хаан”, “Дан цагаан морьтой Дансүрэн гуйлгачин”, “Жангар” туулийн хувилбарууд зэргийг Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Хэнтий, Булган, Хөвсгөл зэрэг аймгийн халх туульчдаас бичиж авсан байдаг. Энэ бүх олдвортоо тулгуурлаж, Жангар туулийг гагц Халимаг, Шинжааны ойрадууд хэлдэг биш, халхчуудын дунд нийдэм дэлгэрсэн гэсэн санааг анх хэлсэн байдаг. Мөн Гэсэр судлалын хүрээнд Гэсэрийн хамгийн томоохон

<sup>5</sup> Билгүүн номч Бямбын Ринчен. Эмхэтгэж эрхэлсэн Г.Аким, “Монгол уран зохиол” хэвлэлийн газар, Улаанбаатар, 1990, 238 т.х.

<sup>6</sup> Ринчен Б. *Культ исторических персонажей в монгольском шаманстве*. –В кн.: Сибирь, Центральная и Восточная Азии в средние века. –Новосибирск: Наука, 1975, с. 188-195



хувилбар “Заяын Гэсэр”, “Номч хатны Гэсэр”, “Замлин Сэнчиний намтрын”<sup>7</sup> эх бичгийг хэвлүүлж, олон судлаач эрдэмтний хүртээл болгосон билээ.

Баатарлаг туульсын тухай бичихдээ “Монгол ардын баатарлаг туульсын агуулгыг нь үзвэл, цөм түүхээ бүтээгч манай ард түмний өнгөрсөн эрт цагийн түүхийг тусган үзүүлж, дээр цагт монгол овогтон буй болж, улс түмэн болж ирсэн баатарлаг тэмцлийн явдлыг яруу сайхан дүрслэл болгон найруулж, эрх чөлөө тусгаар тогтнолоо харийн дайсны халдан довтолж, түрэн эзлэгсдээс хамгаалж, ... тэмцэж байснаа магтан дуулж, ... эх орон, нутаг ус, түмэн олондоо халуун хайртай сайн баатар эр хүн бол ийм хатан зоригтой, эр чадалтай, самбаа их ухаантай, тэсвэр их хатуужилтай байдаг юм. ... Санасан газарт нь сэтгэлчлэн хүргэж, сандарсан газарт нь ухаан сэлбэдэг хүлэг сайн морь нь ийм шинжтэй байдаг юм. Зоригт эр баатрын хань нь ийм сайхан сэтгэлтэй, тийм сайхан царайтай, бат их журамтай, сод их ухаан самбаатай, хайр их халамжтай байдаг юм. Дайсан гэдэг ийм их айхтар сүртэй, сүрдэм их чадалтай, тийм их муухай санаатай, холын их хар харгис бодолтой байдаг юм. Тийм бэрх дайсныг эх орон, түмэн нь олон сайн баатар хөвгүүдийнхээ амь бие хайргүй зүтгэснээр хэзээд туулан давж, эцсийн эцэст муу муухай бүгдийг даван туулж, ... ялан давдаг ёстой юм гэж бэрхийг тохиолдох цагт зориг бадруулж, баатар айцуулын жишээгээр хүмүүжүүлдэг учраас үлгэр жишээ болох ёстой юм гэж үлгэр гэж эртнээс нааш нэрлэсээр ирсэн байна” (Ринчен 1966, 14-15)<sup>8</sup> гэж бичжээ. Буриад зэрэг зарим монгол угсаатан “Тууль” гэхийн оронд “Үлигэр” гэж нэрлэдэг нь ч үүнтэй холбоотой бөгөөд ард түмний үлгэр дуурайл болсон баатрууд гардаг гэсэн үг юм. Аман зохиол сурвалжлан цуглуулдаг арга барилаас нь түүний гарын шавь Чой.Лу багштан дурсан хуучилсан нь: ...Тэгээд илүү үгтэй би гэдэг чинь бас л: «Та зуны дэлгэр цагт ирж таатай сайхан амрахгүй, баахан хүйтэн цагаар морилж иржээ дээ» гэв. Чингэтэл багштан ширвээ сахлаа ширвэн шувтарч: «Амралтанд би амрах гэж ирдэггүй, ардынхаа аман зохиол, ардын билгийн зүйлийг хотоос холхон амралтанд ирж хөдсөн дээлтнээс ардын эрдэм гэгчийг бичиж тэмдэглэж авдаг юм. Танай энд зун амардаг улс чинь бас амарч чаддаггүй, зусаг ямаа, шүдлэн ухна шиг хоёр хоёроороо Шунхлайдаад, хад чулуун дээр элдэв юм зүй бусаар эрээчээд явдаг юм» гэж айлдахад нь, би бас л буруудсанаа мэдсэнийг багштан даруйхан болгоомоц, «Өвлийн цагт хол газрын амралт хүн нь ч цөөн хоол нь ч сайн байдаг гэж айлдарынхаа эрчийг зөөлрүүлэв. Хүн нь цөөн болохоороо настан өвгөд эмгэдтэй уулзан ярилцахад хөлсөх амьтан ховор, цөөн хүнтэй амралтанд дуртай хоолоо хийлгэж идээд байж болдог юм» гэж айлдахад нь яагаа ч үгүй хүний үгэнд даган хөөрдөг зантай би чинь бас л: «Ай, нээрээ тийм байх шүү. Дандаа хуушуур бууз хийлгэж идээд байсан ч болох юм даа» гэж үгстэл багштан: «Би хуушуур бууз бараг иддэггүй, одоо цагт хуушуур дотор хулгай бий, буузан дотор булхай бий.

<sup>7</sup> *Say-a-yin Geser-ün tuuji*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM Tomus IX, Fasc. 2, Шинжлэх ухаан, Дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл, Улаанбаатар, 1960, 192 т.х. *CAMLING ŠENGČIN-Ū NAMTAR ORUSIBA*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM, Tomus X, Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн Хэвлэл, Улаанбаатар, 1959, 233 *Nomči qatun's version of Kesar saga*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM Tomus IX, Fasc. 4, Эрдэм шинжилгээний хэвлэл, Улаанбаатар, 1960, 192 т.х.

<sup>8</sup> Ринчен Б. *Манай ардын туульс*. “Монгол ардын баатарлаг туульсын учир” номд, Эмхэтгэсэн У.Загдсүрэн, редактор С.Лувсанвандан, ШУА-ийн хэвлэл, Улаанбаатар, 1966, 127 т.х.

*Би мах, шөл, гурилтай хоол гээд л задгай хоол идэх дуртайй» гэж айлдав. За би ч амаа хамхихгүй бол горьгүй нь гэж бодтол, багштан босож гарахыг завдахуйяа би: «Та манайд анх морилж ирсэн, би аяга сайхан задгай хоол хийж өгье дөө» гэтэл, «Би амралтын газар албаны хоолтой, сайн идэж салхи залгиж яваа хүн, та надад хоол хийх цагаа хятад хэлээ үзэхэд зориул даа» гэж айлдаад гарахад, би бараа болон явж амралтын өрөөнд хүргэн морилуулав» (Лувсанжав 2003, 95-96)<sup>9</sup> гэсэн байдаг.*

Угсаатны зүйн талаар Ринчен багштаны санаачлага болон удирдлагаар зохиосон иж бүтээл бол 1979 онд хэвлэгдэн гарсан “Монгол Ард Улсын угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас” юм. Хоёр зуу гаруй газрын зураг болон биет зургуудаас бүрэлдсэн энэхүү атласын нэлээд хэсгийг БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр байсан эртний овог аймаг, хаант улсууд, тус орны эдүгээгийн угсаатны бүрэлдэхүүн, овгийн тархацыг харуулсан үзүүлэлтүүд эзэлж байгаа нь угсаатны зүйчид, хүн судлалтан, түүхчид, бусад олон салбарын судлаачид, жирийн уншигчдад тус болох сайхан бүтээл болжээ. Мөн тус атласт Монголд байсан бүх хүрээ хийд, жалгын дуган, сүмүүд, бархантай болон тийтэй хүрээ хийд, бичигт хад, гэрэлт хөшөөдийн байршлыг тэмдэглэсэнээрээ мэргэжлийн судлаачдад олдошгүй ховор гарын авлага, хөтөлбөр болжээ. Энэ нүсэр ажлыг бүтээсэн арга зүй нь сонин бөгөөд гадаад, дотоодын эрдэмтдийн удирдлагаар манай улсын нутаг дэвсгэр дээр 1921-1970-аад оны хооронд явсан хээрийн шинжилгээний ангиудын цуглуулсан мэдээ мэдээллээс гадна сум, орон нутаг болгонд өөрийн итгэмжит мэдээллийн эх сурвалжийг олж байршуулан тэднээс байнгын шинэ сэвүүн мэдээлэл авдаг байжээ.

Ринчен багшийн түүхэн зохиолын түүчээ нь 1945 онд бичсэн “Цогт тайж” кино тууж болно. Энэ бол санаандгүй бичсэн зохиол биш, эх орны чөлөөлөх дайны өмнөхөн “Невийн Александр” шиг чин зоригт эх орончийн тухай кино бүтээхээр зориулж бичсэн гэдэг. Уг үйл явдал нь XVII зууны үеийн Монгол, Төвөдийн түүхэнд холбогдох бөгөөд улааны шашин, шарын шашны хоорондын зөрчилд Цахарын Лигдэн хаан, Халхын Цогт хун тайж хоёр нэг тал болж, Зүүнгарын Гүш хаан Төрбайх эсрэг тал болж тулалдсан тухай өгүүлдэг. Түүхийн харгуйгаар аялж явах зуураа түүний дээд өвөг нь Халхын Цогт Хун тайжийн удам, Охин Хун тайжийн угсааны хүн болохыг олж тогтоожээ. Чингээд эрэлхэг дайчин өвөг дээдсийнхээ тухай кино зохиол туурвихаар шийдсэн хэрэг. Түмэнхэн Цогт Хун тайж бол XVI-XVII зууны үеийн улс төрийн зүтгэлтэн, бичиг номын сэхээтэн, яруу найрагч Гэрсэнзийн гуравдугаар хөвгүүн Үйзэн хааны хүү Бахарай хошуучийн гэрт мэндэлжээ. Энэ бол түүхийн сэдэвт томоохон кино туульс бүтээх анхны шилдэг сонгодог туршиц болжээ.

XIX зууны эцэс, XX зууны эхэн үеийн монгол нийгмийн жаран жилийн амьдралыг жирийн малчин Ширчингийн дүрээр төлөөлүүлэн үзүүлсэн “Үүрийн туяа” хэмээх том хэмжээний туульсын зохиол (“Манжийн талхинд” тэргүүн боть 1947 (1951) онд, “Гал усны гашуун зовлон” дэд боть 1952 онд, “Байлдаж олсон эх орон” гутгаар боть 1955 онд тус тус хэвлэгджээ) туурвижээ. Энэхүү гурамсан романд монгол нийгмийн олон анги, давхаргын төлөөлөл болсон баатруудын хувь заяаг дүрсэлжээ. Эмгэн Сүрэн, Тансаг, өвгөн Луузан, Хөвчийн хар дархан,

<sup>9</sup> Лувсанжав Чой. *Насаараа дурсахуй* (ярилцлага). “Эрдмийн хэлхээ” цуврал No1, 2003, 95-108-р тал.

өвгөн Батбаяр, хүү Насанбат, Дамиран гавж, Балданчоймбол гачэн, хар Дондог лам, Жамсранжав тайж, Лодой баян гэх мэт олон сонин зан төрхтэй, сонирхолтой хувь заяа бүхүй баатрууд гардаг. Харин гол баатар Ширчин бол уг язгуурын ядуу малчин ард бөгөөд Соном зангийн зарц байснаа Богд хаант Монгол улсын цэрэгт дайчлагдаж, Да хүрээний Хужирбулангийн цэрэг болжээ. Тэндээс Хатанбаатар Магсаржавын цэрэгт элсэж, улмаар Ховдын хязгаарыг Манжийн дарангуйлагчдаас чөлөөлөх дайнд оролцсон байна. Ийнхүү тэр цагийнхаа нийгмийн олон донсолгоонт үйл явдлын амьд гэрч болж, айлын зарцаас монгол төрийн эр цэрэг, сүүлд нь улсын сайн малчин болтлоо өсөж дээшилсэн баатар болсон юм.

Ер нь уран бүтээлийн хувьд түүх соёлын нэвтэрхий их мэдлэгээ ашиглан монголчуудын өвөг дээдсийн балар эртний аж төрлөөс эхлэн өөрийн төрж мэндэлсэн цагийг хүртэлх аугаа их түүхэн туульс бүтээхээр зорьж байжээ. Тухайлбал, балар эртний хүний ан агнуурын соёл, нум сум хэмээх шинэ зэвсэг үүсэж гарсан болон галын шүтлэг тахилга, овог аймгийн зохион байгуулалтыг урнаар дүрсэлсэн “Заан Залуудай” романаа туурвисан бөгөөд зохиолын гол баатар нь Чонос овгийн өндөр их дээдэс Шонхолой, түүний идэр залуу хөвгүүн Залуудай, түүнтэй санамсаргүй уулзан танилцсан Бай-күл нуур хавиар нутагтай, Ихэрэс ясны Бух өвгөн хэмээх гурван хүний аяллын тухай өгүүлдэг. Энэхүү зохиол нь овог хоорондын дайсагнал, догшин араатан амьтадтай хийсэн аюумшигт тулаан, хүний мах хүнсэлдэг Шар махчингуудын тухай зэрэг сонирхолтой үйл явдлаар дүүрэн. Залгаад түүний бичсэн томоохон зохиол бол ЗТӨ III зууны үеэс Төв Азид мандаж байсан Наран эхт Саран эцэгт Хүн улсын түүхэнд холбогдох “Их нүүдэл” хэмээх романы тэргүүн дэвтэр (1969) болно. Хүн гүрний ирээдүйн эзэн Модун шаньюй харь дайсан гүрний барьцаанд байхдаа “Төрийн төлөө төрлийг тэвчих” гэсэн догшин хатуу тангарагтай болж, Түмэн шаньюйг хөнөөсөн тухай, хятадын Чин улсыг үндэслэгч Циньши хуанди Түмэн газрын цагаан хэрмийг Хүн улсын нутгаас таслан авч, үргэлжлүүлэн барьж байгуулсан тухай, Дунху-г дайлаар мордох болсон учир шалтгаан зэргийг нанхиад сударч Сыма Цяний “ШиЖи” буюу “Түүхэн тэмдэглэл” зохиолоос санаа авч бичжээ. Хүн улсын дайчин эрсийн чин зориг, өнгийн бэлгэдэлт морин цэргийн жагсаал, цэргээ аравт, зуут, мянгатаар зохион байгуулдаг байлдааны урлаг зэргийг “Баруун Хан улсын түүх” сурвалжаас сэдэвлэн авсан байна. Эртний улсуудын соёлын харилцааны тухайд Торгоны замаар түгэн дэлгэрсэн Кушан, Грек соёлын үндэс дамжлага, эртний нүүдэлчид Грекийг Эллин улс, Африк тивийг Хөөст тив хэмээн нэрлэдэг байсан тухай өгүүлжээ. Эртний түүхтэй холбоотой эдгээр романаа угтуулан “Сандо амбан” хэмээх бичил романаа туурвисан билээ. Манж төрийн зараалаар ирсэн сүүлчийн энэ амбан нь дорно зүгийн бичиг соёлд нэвтэрхий бичгийн угтгач байсан тухай ч өгүүлсэн байдаг.

Б.Ринчен багштан бол 1960-аад оны өгүүллэг туурийн нэрт уран дархны нэг юм. Чингэхдээ түүхэн туурийн /историческая новелла/ уран дархан гэвэл илүү оновчтой билээ. Түүний түүхэн тууриуд нь эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсэн монголын ард түмний эрэлхэг баатрууд, монголын урлаг соёлын гарамгай зүтгэлтнүүд, тэдний бүтээлч үйл ажиллагаанаас сэдэвлэн авсан байдаг. Тухайлбал: “Ану хатан”, “Нууцыг задруулсан захидал”, “Сүүлчийн хичээл”, “Гүнж”, “Шүхэрч Бунъяа”, “Бадарчин” зэрэг түүхэн туурь бий. “Ану хатан” түүхэн туурь XVII зууны

дунд үед Зүүнгарын хаант улсыг нэгтгэн байгуулж, Манжийн булаан эзлэгчдийн эсрэг тэмцэж байсан баруун монголчуудын тэмцлийг тусгасан байна. Энэ туурь ардын түүх, домог, хууч ярианд үндэслэж түүхэн үйл явдал, түүхт хүмүүсийн дүрийг уран сайхны дүр, ургуулан бодох бодлоор “буйлуулан” тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсэн эрэлхэг баатрууд, ард түмний нугаршгүй хатан зоригийн тухай өгүүлсэн байдаг. Туурийн гол баатар Ану хатан харийн булаан эзлэгчдийн эсрэг тэмцэж буй өөрийн нөхөр Галдан бошигтын үйл хэргийг дэмжиж, аян дайны хүнд цаг үеийг толгой гудайж, сэтгэл гансралгүй туулж, эр нөхрөө үнэнч ханийн ёсоор халамжлан, хатамжилж байдаг. Зохиолч Галдан бошигтын дүрээр Дорно дахины гүн ухааныг нэвтэрхий судалсан эрдэмтэн, улс орныхоо тусгаар тогтнолын төлөө мохошгүй хатан зоригийг барин тэмцэгч, цэргийн жанжин, Манж дайчин улсын монгол угсаатныг уусган эзлэх гэсэн улс төрийн заль мэхийг гүнээ ухаарсан, төрийн мэргэн бодлоготон гэдгийг дүрсэлсэн байна. Энэ зохиолын бусад баатар тухайлбал, Чинбай баатар ард түмний баатарлаг тэмцлийн амьд биелэл болсон жинхэнэ ардын баатрын дүрийг бүтээх гэж зорьсон ажээ. Галдан уг нь Зүүнгарын ноёны заль мэхэнд автаж, Төвөдийн гурван хийдэд Бурхны шашин, гүн ухаанд суралцахаар төрсөн нутгаасаа алс газар зайлуулагдсан хүн юм. Энэ хооронд түүний төрсөн ах, зориг шийдвэр муутай, хулчгар Сэнгэ ноёныг Зүүнгарын зайсангууд хаан ширээнд суулгажээ. Гэвч Зүүнгарын ноёдын дунд хагарал болж хаан төр эзгүйрэхийн хамт, элч буухиа довтолгон Зүүнгарын зайсангууд Галдан бошигтыг хаан ширээндээ эргэн залрахыг гуйж байна. Гэвч Галдан бошигт үүнийг үл сонирхон, татгалзсан боловч, эцэг хааны шадар Чинбайн айлтган өргөсөн эх нутгийнх нь ганц атга агь, идэр залуудаа хайр сэтгэлтэй явсан Ану гүнжийн захидал хоёрыг авсан мөчөөс эхлэн, Төвөдийн номын их хийдийн ширээт болох хувь заяанаасаа татгалзаж, эх нутгийн зүг яаравчлан эргэж, Ойрад, Зүүнгарын хаан ширээг авсан байна. Энэ үеэс эхлэн Галдан бошигт Манжийн булаан эзлэгчдийн хамгийн гол дайсан болно. Энэ туурьд Галдан бошигтын бүх тулалдааны тухай биш, харин Манжийн цэрэгтэй тулалдсан сүүлчийн /1696/ Зуунмодны тулалдааны тухай өгүүлдэг. Манжийн цэрэг сэхээ зав өгөлгүй Галдан бошигтыг мөрдөж байлаа. Галдан хүрээ байгуулж, Манжийг тосож байлдахаар зэхэж байв. Ану хатан энэ тулалдаанд эртний монгол дайчдын уламжлалаар хүлэг мориныхоо толгойд марал буюу бугын баг хийж өмсгөөд, манжийн цэргийн бүслэлтээс Галдан бошигтыг, нөхдийн хамт аварч гаргаад өөрөө амь үрэгддэг. Энэ бүгдээс үзвэл Ану хатан, чин зориг, үнэн журмын хөрөг бэлгэдэл (icon) болсон баатар хүн.

Мөн “Нууцыг задруулсан захидал” туурийн гол баатар нь Ойрадын дайчин эр Гөлөгдэй, түүний хүү Шонуу нар юм. Зохиолын үйл явдал Манжийг эсэргүүцсэн тэмцлийн эхний шатанд болсон үйл явдал юм. Ойрадуудын замд Орхон гол үерлэсэн нь нэгэн хэсэг саатахаас өөр аргагүй болсон ажээ. Энэ үед Ойрадын жанжин Чорос овогт Гөлөгдэй баатар Энх-Амгалан хааны бие төлөөлөгч манжийн Фү жанжинтэй холбоо байгуулж найрсаг нөхөд болжээ. Ардын дунд шулуун шударга, цэх журамтай гэж алдаршсан баатар дайсантай шадарласан нь олон түмний эгдүүцлийг төрүүлэн цуу үг ч гарчээ. Нэг өдөр Фү жанжин шадар цэргээ дагуулан Гөлөгдэй баатрын өргөөнд зочлохоор иржээ. Гол өргөөнд монголын уртын сайхан дууны эгшиг уянгалж байхын хамт цэргүүд Фү-ийн тушаалаар

Гөлөгдэй баатрыг Шонуу хүүтэй нь баривчлан, Ойрад цэргийг бүслэн эзэлжээ. Уг нь энэ үед Гөлөгдэй баатар Фү жанжинг урьж найрлаад тусгай дохиогоор баривчлах ёстой байжээ. Гэтэл өөрөө баригдсан нь урвагчийн харгайгаар нууц нь дайсанд мэдэгдсэнээс болжээ. Гөлөгдэйн жинхэнэ захианы оронд хуулбар өгснийг идэр залуу Шонуу мэдсэнгүй. “Элчийн үг аманд гэдэг” эртний мэргэн үгийг залуу хүү эс хайхарснаас ийм их эндэл осол гарчээ.

Фү жанжин хуйвалдаанд оролцсон бүх хүмүүсийг удам угсаагаар нь хүйс тэмтрэх, Гөлөгдэйн гал голомтыг устгах зарлиг буулгажээ. Цаазын үед Гөлөгдэй – хүүгээ амьд үлдээгээч! гэсэн цорын ганц хүсэлтийг тавьж байна. Фү жанжин энэ хүсэлтийг “амьд үлдэх Шонуу эх, эцэг, дүү нараа цаазлах” болзолтойгоор биелүүлэх болно гэж хүлээн авч байна. Эцэг, эхийнхээ гуйлт учирлалын эцэст Шонуу эцгийнхээ зэвсэгт, эхийн хормойд сөхөрч мөргөөд аав, ээж хоёроо цаазалдаг. Мөн адил хоёр бүсгүй дүүгийн толгойг авч байна. Гөлөгдэй, Шонуу нарын дүр бол тусгаар тогтнолын төлөө тэмцэгч хамгийн эрэлхэг зоригтны дүр болжээ.

Зохиолчийн “Гүнж” туурь Манжийн эсрэг үзэл санаатай монголын нэгэн ноён Дархан чин ван Дондовдоржийн манж угсааны хатан Хичээнгүй Амгалан гүнжийн тухай түүхэн баримтанд дулдуйдан бичжээ. Монголын ноёдыг улс төрийн хувьд хараат байлгахын тулд манж нар тэдэнд зэрэг хэргэм олгох, хээл хахууль цутгах, охид гүнжээ өгч хүргэн тавнан болгох башир арга хэрэглэж байв. Хичээнгүй гүнж Дорно дахины төгс эрдэм боловсролтой эртний Төвөд, Манж, Хятадын түүх, гүн ухаан, яруу найргийг сайн мэддэг, эзэн хааны ертөнцөөс тусгаарлагдмал уйтгарт нэг хэвийн амьдралд залхаж, чөлөө жаргалыг эрмэлзсэн бүсгүй байв. Энэ бүсгүй монгол хүний гэргий болж, Монгол нутгийн сайханд бишрэн хүн ардынх нь зан заншлыг хүндэтгэн, эр нөхрийн хүсэл бодлыг дэмжин, дайснаас хамгаалагч болон хувирчээ.

Ринчен багшийн яруу найргийн туурвилууд тэр дундаа “Бэр цэцэг” найраглал нь өрлүүд овгийн өвгөд настнаас сонссон домгоос улбаатай бөгөөд Сартуул иргэнийг дайлаар мордоод эргэн ирж буй цэргийн цуваан дотроос халуун хайртаа өнжин хонон хайгаад олоогүй монгол бүсгүй өндөр дэнжийн оройд толгой гудайн бие нь хөшиж, алаг нүднээсээ нулимс цувируулан байхад *“ариун тэр нулимс унасан газар анхилам сайхан цэцэг ургасныг хөөрхий тэр бүсгүйн дурсгал болгож, хөгшид “бэр цэцэг” гэж нэрлэсэн”* тухай гардаг. Энэ бол орчин үеийн монгол уран зохиолын бэлгэдэл дүрийн нэгэн жишээ мөн бөгөөд өнгөрсөн оны 10-р сарын 25-нд “Бэр цэцгийг” “Үндэсний бахархалт цэцгээр” өргөмжилсөн нь санаандгүй учир тохиол биш бололтой. Монголчууд эртнээс нааш бэр цэцгийг эрүүл саруул, дайн дажинүй, энх амгалан амьдралын бэлгэдэл болгож ирсэн бөгөөд орон нутгийн нэр нь “баавар цэцэг”, “тосон тором” гэдэг. Гадаад төрхөөрөө монгол эмээлийн бааврыг санагдуулам уран гоёмсог, Монгол орны бүх нутгаар нийдэм тархан ургаж, зуны гурван сарын турш цэцэглэн цэнхэр, нил ягаан өнгөөр туяардаг билээ. Мөн түүний гадаад улс орноор аялан явах зуур бичсэн “Үдэш Невскийд”, “Геллерт ууланд” зэрэг олон сайхан аян замын шүлэг буй. Ри багшийн яруу найргийн манлай нь өнөө өглөөний хурлын нээлтийн ёслолын үеэр дуу болон дуурьссан, манай монгол угсаатны соёл оюуны дархлааг яруу сонголонт бичгийн хэлээр урлан туувисан “Монгол хэл” шүлэг билээ. Чингээд би илтгэлийнхээ өндөрлөгөөг энэ шүлгийн



*Мөрөн голын цутгалант ширгэшигүй их далай мэт  
Мөнхөд үр ач нарын залгамжаар бадранхан дэлгэрч  
Хөндий цээжинд орогч бүхнийг нэвтрүүлэх чадалт*

*Хөгжим мэт яруу баясгалант монгол хэл мину гэсэн нэгэн утга төгөлдөр,  
бадрангуй эгшиглэнт бадгаар дээшлүүлэе.*

Энэ удаа Ринчен багштаны сэтгүүл зүй, орчуулгын бүтээл туурвилын зүйлийг бусад мэргэжлийн нөхдөд даатган орхиод, эрдэм судлал, уран зохиолын бүтээлийг нь голлон өгүүллээ. Эцэст нь дүгнэн үзвэл:

1. Академич Ринчен багштан бол монгол хэл шинжлэлийг монгол хэлний хууль зүй жамынх нь дагуу хөгжүүлсэн анхдагчийн нэг мөн.
2. Монгол утга соёлын үнэт өвийг насан залуугаас сурвалжлан цуглуульж, гадаад, дотоодод хэвлэн нийтлүүлж, судалгааны хүрээнд оруулан, утгынх нь чанад хязгаарт нэвтэрсэн их шинжээч билээ.
3. Орчин цагийн монгол уран зохиолын туульсын том төрөл зүйлийг үндэслэгч, түүхэн туурь зэрэг богино төрөл зүйлийг ч үүсгэн хөгжүүлэгч мөн.
4. Ринчен багштан бол манай өнөөгийн нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны олон салбарын үндэс суурийг тавьсан эрдэмтэн билээ.
5. Монголын орчин үеийн шинжлэх ухааныг дэлхийн тавцанд түлхэн гаргахад онцгой гавьяа байгуулсан “сартваахь” мөн.

### ЗҮҮЛГИЙН НОМ ЗҮЙ

1. *Say-a-yin Geser-ün tuiji*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM Tomus IX, Fasc. 2, Шинжлэх ухаан, Дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл, Улаанбаатар, 1960, 192 т.х.
2. *CAMLING ŠENGČIN-Ū NAMTAR ORUSIBA*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM, Tomus X, Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн Хэвлэл, Улаанбаатар, 1959, 233
3. *Nomči qatun's version of Kesar saga*. Redigit Prof. Dr. Rintchen, CSM Tomus IX, Fasc. 4, Эрдэм шинжилгээний хэвлэл, Улаанбаатар, 1960, 192 т.х.
4. *Билгүүн номч Бямбын Ринчен*. Эмхэтгэж эрхэлсэн Г.Аким, “Монгол уран зохиол” хэвлэлийн газар, Улаанбаатар, 1990, 238 т.х.
5. Лувсанжав Чой. *Насаараа дурсахуй* (ярилцлага). “Эрдмийн хэлхээ” цуврал No1, 2003, 95-108-р тал.
6. Ринчен Б. *Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл* (Мажаар улсаар явсан минь). Улаанбаатар, 1958, 209 т.х.
7. Ринчен Б. *Из нашего культурного наследия* (сборник статей). Улан-Батор, 1958, 171 с.
8. Ринчен Б. *Культ исторических персонажей в монгольском шаманстве*. –В кн.: Сибирь, Центральная и Восточная Азии в средние века. –Нобосибирск: Наука, 1975, с. 188-195
9. Ринчен Б. *Манай ардын туульс*. “Монгол ардын баатарлаг туульсын учир” номд, Эмхэтгэсэн У.Загдсүрэн, редактор С.Лувсанвандан, ШУА-ийн хэвлэл, Улаанбаатар, 1966, 127 т.х.



10. Ринчен Б. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*, I боть (Монгол хэл бичгийн ухаан). Ариутган хянасан академич Ринчений Барсболд, -Улаанбаатар, 2011. 200 т.х.
11. Ринчен Б. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*, II боть (Монгол утга зохиол судлал). Ариутган хянасан академич Далантайн Цэрэнсодном, -Улаанбаатар, 2011. 204 т.х.
12. Rintchen B. Folklore Mongol. - *Asiatische Forschungen*. Bd 7, 11, 12, 15, Wiesbaden: Harrassowitz, 1960, 1963, 1964, 1965
13. Rintchen B. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. I. Sources littéraires, Wiesbaden: Otto Harrassowitz, 1959, 124 p. [Asiatische Forschungen, Band 3]
14. Rintchen B. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. II. Textes chamanistes bouriates, Wiesbaden: Otto Harrassowitz, 1961, 156 p. [Asiatische Forschungen, Band 8]
15. Rintchen B. Les matériaux pour l'étude du chamanisme mongol. III. Textes chamanistes mongols. Wiesbaden: Otto Harrassowitz, 1975, 151 p. [Asiatische Forschungen, Band 40]

**НИЙЛМЭЛ ХЭЛЦ БҮТЭЭВЭР ДЭХ ОРУУЛБАР  
ДЭД БҮТЭЭВРИЙН НЭГ ЖИШЭЭ**

М.Базаррагчаа  
/МУИС/

Монгол хэлнээ үйл үгээс тэмдэг нэр бүтээх “-mtayai...” хэмээх дагаврыг В.М.Котвич “тухайн үйл хэрэгт чадамгай байх төдийгүй байнга хичээмтгий байх”<sup>1</sup>; А.Попов “үйл үгээс үүсэх тэмдэг нэр (хавсрал нэр) нь үйл үндэснээ “-mtayāi, tayāi, yāi” зэрэг дагавар залгаж, уг юмын янз бүрийн шинжийг заах”<sup>2</sup>; А.Бобровников “аль нэг юманд чадамгай, эвсүүрхэн төдийгүй байнга дадамгай байх”<sup>3</sup>; Н.Н.Поппе “үйлийг гүйцэтгэх чадвартай байх”<sup>4</sup>; Б.Х.Тодаева “-mal” дагавартай утгаараа ойролцоо<sup>5</sup>; М.Н.Орловская “үйлийн үр дүнд бий болох чанар ба тухайн үйлийг чадамгай гүйцэтгэх эв дүйг зааж, “tayāi, mqi” дагавартай адил утга илтгэх”<sup>6</sup>; Н.Поппе “үйлдэл хийх авьяас сонирхол, дур хүсэл ба тухайн үйлийг хийх бололцоо, чадварыг илэрхийлсэн утгатай”<sup>7</sup>; Ш.Лувсанвандан “тухайн үйлийг гүйцэтгэхдээ хүсэлтэй давамгайг заасан тэмдгийн нэр үүсгэнэ”<sup>8</sup>; П.Бямбасан “-мхай, мгай, мтгай” дагаврыг үйл үгнээ залгаж, голдуу хүн амьтанд хэвшил дадал болсон зан үйлийн шинжийг заасан тэмдгийн нэр үүсгэнэ (аймхай, түрэмгий, оромхой, айтмгай, очимтгой, ичимтгий)<sup>9</sup> гэх мэтээр үзэцгээсэн байна. Ц.Жанчивдорж багш “-мтгай...” дагавар нь үндсийн уул шинж чанараар зуршил буюу хэвшил болгосон утга бүхий тэмдгийн нэр бүтээнэ (мартамтгай, уурламтгай, очимтгой, үрэмтгий)<sup>10</sup> гэжээ.

Ш.Цэцэнцогт “-matayāi...” дагавар нь “-ma, maqāi, tay, mang, tayāi, mal” гэх мэт тэмдэг үг үүсгэдэг “-ma” бүтцэт дагаврууд гарал язгуур нэгтэй ба “-mta-yā...” дагавартай гарал нэгтэй, утга ойролцоо бөгөөд түүнээс улирч хувирсан байна”<sup>11</sup>

<sup>1</sup> В.М.Котвич. Лекций по грамматике монгольского языка. Петербургъ, 1902, стр.57

<sup>2</sup> А.Попов. Грамматика калмыцкого языка. Казань, 1847, стр.78-79

<sup>3</sup> А.Бобровников. Грамматика монгольско- калмыцкого языка. Казань, 1849, стр.64- 65

<sup>4</sup> Н.Н.Поппе. Грамматика письменно- монгольского языка. М.-Лгр., 1937, стр.104

<sup>5</sup> Б.Х.Тодаева. Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология. М., 1951, стр.79

<sup>6</sup> М.Н.Орловская. Имена существительные и прилагательные в современном монгольском языке, М., 1961, стр.87

<sup>7</sup> Н.Н.Поппе. Монгол бичгийн хэлний зүй, Уб., 2012, 70-р т.

<sup>8</sup> Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэл. Бээжин, 1961 (1962), 236-р т.

<sup>9</sup> П.Бямбасан. Тэмдгийн нэр. “Орчин цагийн монгол хэл зүй”, Уб., 1966, 114-р т.

<sup>10</sup> Ц.Жанчивдорж. Орчин цагийн монгол хэлний тэмдэг нэрийн тухай, “Заах арга, эрдэм шинжилгээний хуудас”, Уб., 1961, 52-р т.

<sup>11</sup> Ш.Цэцэнцогт. Монгол хэлний үгсийн язгуурын толь. Жанг Жияа Кеу, 1988, 2717-р т.

гээд, дагуур хэлнээ “-γa” нь “ra” болон сэлгэж “-mtə.rə” болдог ажээ. (“içimetegei” гэхийг дагуур хэлнээ “-xitsimtə.re:” гэнэ. Тэрээр, энэ дагавар нь тухайн үйлийг гүйцэтгэх дуртай буюу гүйцэтгэх заншил дадлагатай болсныг илтгэх утгатай. (ayu-mtəqāi, kī-mtegei, soçi-mtəyāi, uquçila-mtəyāi, ukila-mtəyāi, buça-mtəyāi, niçu-mtəyāi, iniyē-mtegei, urba-mtəyāi, уayāra-mtəyāi, kōrbe-mtegei, qolçi-mtəyāi, öber-mtegei) гэсэн бол Ц.Норжин тухайн үйлийг олонтоо хийдэг зан бүхийг илтгэх утгатай (kele-mtegei, yabu-mtəyāi)<sup>12</sup> гэж тэмдэглэжээ. Ц.Норжин энэ дагавар нь “-mtəyū (taki-mtəyū (тахиж шүтэхдээ сайн, байн байн тахидаг), kündüle-mtegeü, umartam-təyū, yabu-mtəyū, ire-mtegeü) дагавартай гарал нэг гэж үзэж, “-mtəyāi” дагавар лугаа ойролцоо утгатай боловч баахан дагаварлах буюу царж хэлэх хандлагатай байдаг” гэсэн байна. Энэ дагаврын тухайд Ц.Норжин “matayāi” гэх дагаврын “m”-ийн арын “a” эгшиг нь гээгдсэн гэж үзсэн нь үе-утгалбар задрах ёстой<sup>13</sup> холбогдоно. Т.А.Бертагаев “-matayāi” дагавар нь тэмдэг нэр бүтээх онцгой дагавар боловч буриад хэлний судалгаанд төдий л дурдсангүй явж иржээ. Энэ дагаврын “-ma” нь “боломж бололцоо”-ны утгатай, цагт нэрийн “-ma, m” дагавар, “-tuγāi” хэмээх ерөөн хүсэх нөхцөл хоёроос бүтсэн иж дагавар (комплексный суффикс- хэлц дагавар (М.Б) гэж үзсэн байна. Жишээ нь, “oγu-matayāi” (оромтгой) нь “oγu-ma-təyāi” гэсэн бүтцээс улиран үүссэн ба “ямар нэг юманд авьяас чадвартай” гэсэн утга бүхий дагавар болно<sup>14</sup> гэжээ. Т.А.Бертагаев энэхүү иж буюу хэлц дагаврын “-γa” нь “qa” болон сэлгэж болох ба “-mataγai, məyāi, maqāi” гурав нь бие биеэ төлөөлөн хэрэглэгдэж болно” гэж үзсэн байна.

Энэ бүхнээс үзвэл “-matayāi” дагаврын “-t/a” нь гээгдэж, “-maγāi” гэсэн хувилбар үүсэж, улмаар “γa” нь “qa” үе-утгалбартай сэлгэж “-maqai” гэсэн хувилбар бүтсэний дээр “-ma” үе-утгалбар нь задарч, дан ганц “-m” бүтээвэр үүссэн байна. Иймээс эрдэмтэд “-matayāi” бүтээврийн оронд голдуу “-maγai, maqai” дагаврыг дурдсаар ирсэн байна. Үүнд: В.Л.Котвич “хийх чадвартай” гэсэн утгатай “-mγāi (ol(u)-mγāi, nekemkei) дагаврын “γai” нь “-qāi” болж, “tasurqāi, quγurqāi, keremkei, ebderemkei” зэрэг үг бүтсэн ба үүнээс “юманд авьяаслаг, хийх дуртай” гэсэн утга бүхий “-rqa-” (sāyi-rqa-, omu-rqa-, sanaγā-rqa-, noya-rqa-) гэсэн дагавар үүссэн<sup>15</sup> гэж үзсэн байна. Тэрээр “-maqāi, maγ (biçimekei, medemer) дагаврыг мөн л “хийн гүйцэтгэх туршлагатай, алив үйлд авьяас чадвартай” гэсэн утгатай гээд, “-mtəyāi...” дагаврыг “уг үйл гүйцэтгэх чадвартайн дээр уг үйлийг байнга хийх” гэсэн утгатай гэж тодорхойлжээ<sup>16</sup>. Н.Н.Поппе “үйл гүйцэтгэх чадвартай” гэсэн утгатай “-mγāi” (olomgoi, ha:mγai, iabaamγa (явамгай), “-mqāi” (martamxai, idemxei), “mtai” (вəсəmtei (бичимтэй), “-ma” (боломж заасан утгатай) (хуреме, sabardama, ylγeme)<sup>17</sup> гэсэн дагаврыг дурдсан нь бидний сонирхож буй “-matayāi” дагавартай утга гарлаараа нэг бөгөөд “-mtai” гэсэн дагавар нь “γa” үе- утгалбарыг гээснээс үүссэн байж болох юм. Мөн Н.Поппе “-maγāi, mqāi” хоёр нь нэг дагаврын хувилбар<sup>18</sup> (suru- məyāi,

<sup>12</sup> Ц.Норжин. Монгол хэлний үг бүтээх дагаврын хураангуй, Хөх хот, 2001, 101-р т.

<sup>13</sup> М. Базаррагчаа. Монгол хэлний үе задрах ёс, ЭШБ., №1, Уб., 1996, 41-46-р т.

<sup>14</sup> Т. А. Бертагаев. Лексика современных монгольских литературных языков, М., 1974, стр. 201-202

<sup>15</sup> В. Л. Котвич. Опыт грамматики калмыцкого разговорного языка, Прага, 1929, стр. 113-114


<sup>16</sup> В.Л.Котвич. Лекций по грамматике монгольского языка. Петербургъ, 1902, стр. 67

<sup>17</sup> Н.Н.Поппе. Грамматика бурят- монгольского языка. М.-Лгр., 1938, стр. 90

<sup>18</sup> Н.Поппе. Монгол бичгийн хэлний зүй. Уб., 2012, 70-р т.

martamqāi, untamqāi, idemkei) гэж үзжээ. Тэрээр, үйлээс тэмдэг нэр бүтээх дагаварт “-mqāi” дагаврыг дурдсан байна<sup>19</sup>. Д.Д.Амоголонов “-мгай, мхай” дагавар нь “тухайн юмын чанарыг эзэмших чадвар”-ыг тэмдэглэдэг<sup>20</sup> гэж тэмдэглээд, “-мар/шадмар, дүүмэр (младший), -уу (ёhorx- уу, бүдүүрх-үү) дагавартай утга нэг гэж үзсэн байна. У-Ж.Ш.Дондуков “-нтуу, мтуу” дагавар нь а) үйл гүйцэтгэх чадвартай гэсэн утгатай (яба-мтуу (любящий ходить), марта-мтуу (немного забывчивый), сошо-мтуу (пугливый); б) үйлийн шинж чанарыг заасан (бэлшээлтүү-пасуцийся) яарантуу (торопливый)<sup>21</sup> гэж үзсэн нь “-mataγai (mtaγū)” дагавартай гарал нэг ажээ. Тэрээр, “ямар юм байгааг зааж буй, эсвэл ямар нэг юманд чадварлаг буйг заасан (ухаа-мгай, эрэ-мгэй, ханаа-мгай; дуула-мгай (послушный), зоримгой (смелый, решительный) “-мгай” дагавар, “ямар нэг юманд өртөмхий утга, эсвэл “ямар нэг юманд дуртай” гэсэн утгатай. “-мхай” дагавар (сошомхой, аймхай, haamxai; эдимхэй, гоёмхой)-ыг өөр өөр бүтээвэр<sup>22</sup> гэж үзжээ. Мөн А.А.Дарбеева “-мхай” дагаврыг “өртөх, шунах, дурлах” гэсэн утгатай, “-мгай” дагаврыг “ямар нэг юманд чадварлаг авьяастай” гэсэн утгатай<sup>23</sup> гэж үзжээ.

Дээрх хоёр дагавар нь гарал нэг бөгөөд хэрхэн хэлц дагавар болсныг харьцуулбал,



гэсэн байдалтай болох ба “-ta-” нь оруулбар бүтээврийн шинжтэй ажээ. “-m/ ataγai” дагаврын “боломж буюу уг үйл болох нь тулж ирсэн” гэсэн утга бүхий “-ma” хэмээх

үе- утгалбарын эгшиг нь гээгдэн, уул үе- утгалбар задарч, үе төгсгөсөн “-mtaγāi” гэсэн хувилбар үүссэнийг Ш.Цэцэнцогт “-mtaγāi ~ mataγai” (2717, 2730-р т.) гэж тэмдэглээд, -ma, maqai, maγ, maγāi, mal, mta- γū” дагавартай гарал нэг гэж үзжээ. Бидний санавал, дээрх дагавар төдийгүй, erči- m, kerči- m, alqu- m, toqu- m, aγūda- m, čayida- m, erči- m, siqa- m, ula- m, tut(u)- m, oγču- m, taki- m, toγū- m (kötül), čalgi- ma, egere- me (tala), saγā- ma, boγū- ma, čör- me, jaγā- ma, nāyi- ma- n, tū- me- n, čim- bāi ~ čiki- māi, qoki- māi, γuldu- māi, no- mūn, čol- mun, sur- maγ, qāyil- maγ, amaγ- maγ, ir- meg, ara- maγ tara- maγ, bōyira- maγ, saγār- maγ, sire- mel, šuγu- mal, aqa- mad, dūyi- med (degūyi- med), ali- mad, γayiqā- mar, qoyi- mur, talii- mur, yam- bur, ūje- mūri, asara- mji, tara- mčā/ uy, udu- mčir, köke- mdüg, bari-mta, boγū- mta” зэрэг дагавартай гарал нэг ажээ. “-mtaγāi” гэсэн иж буюу нийлмэл хэлц дагаврын “-i” бүтээвэр нь “-γa” бүтээврийн “a” нь “i”-тэй, “γ” нь “y”-тэй тус тус сэлгэж, “үргэлжлэх” гэсэн утгатай ажээ. “sartaγa ki-” гэдгийн “онцгойрох, огцом” буюу “зөгсөхийх” гэсэн утгатай “γa” нь “үргэлжлэх” буюу “эс ялгаран онцгойрох” утгатай “-yi” үе- утгалбараар сэлгэжээ. Энэ тухай акад. Б.Ринчен “bol-ba-i” (болов) гэсэн үйл өгүүлэхүүн гишүүний “-ba-i” нөхцөлийн “-i” авиа- утгалбар нь “... өнгөрсөн цагийн үйл үгийн байдлыг тухайн үйл байдал хэдийн өнгөрсөн боловч өгүүлэгчийн сэтгэлд үргэлжилж одоо байгаа юм шиг тодхон байгааг үзүүлэгч

<sup>19</sup> N.Poppe. Khalkha- mongolische Grammatik. Wiesbaden, 1951, p. 39

<sup>20</sup> Д.Д.Амоголонов. Современный бурятский язык. Улан-Удэ, 1958, стр. 162

<sup>21</sup> У-Ж.Ш.Дондуков. Аффиксальные словообразованные частей речи в бурятском языке, Улан-Удэ, 1964, стр. 92

<sup>22</sup> У-Ж.Ш.Дондуков. Дурдсан зохиол, стр. 78

<sup>23</sup> А.А.Дарбеева. Имя прилагательное, Грамматика бурятского языка, Фонетика и морфология, М, 1962, стр. 117-118

дагавар тул үйл үгнээсээ салгадаггүй нь үйл үгийн бусад дагаврын нэгэн адил<sup>24</sup> гэж тун ч оновчтой тодорхойлсон байна. Ш.Цэцэнцогт “dad-may → dadmayāi, jūyig → jūyirei, qongyur → qong- qurāi, sur- may → surmayāi, qabtaγ → qabtaγāi, qabciγ → qabciγāi, kelteg → keltegei, qayūr → qayūrāi, γar → γarui, degel → degelei (ханцуйгүй дээл), qulaγ → qulaγāi, šal → šalāi, qabciγi- → qabci, urbāyi- → urba-, yudūyi- → yudu, šbttūyi- → šbttu, samayui ~ samayū-n, mayūi ~ mayū, engküre ~ engkürei, nelü ~ nelüi, jabqa → jabqāi, daru- → darūi” зэрэг нэр үйлийн зүйл үгсийг бүтээхэд “i” авиа-утгалбар чухал үүрэгтэй болохыг тэмдэглэжээ<sup>25</sup>. Иймээс “-yi” буюу “-i” авиа-утгалбар нь хөрвөлийн аргаар нэр ба үйлийн аль алиныг бүтээдэг байна. Б.Я.Владимирцов “-mtayāi” бүтээврийн “-γa...”-гийн “γ/ g” нь гээгдээгүй<sup>26</sup> гэж үзээд, “jirumtayāi, bičimtegei” гэж галигласан ба “-āyi” нь “ayī”-гаас, “āyi” нь “oyī”-гоос, “ūyi-” нь “uyī”-гаас, “ūyi-” нь “ügi”-гээс, “iyi” нь “igī”-гээс, “āyi” нь “awī”-гаас, “ōyi” нь “owī”-гоос, “eyi” нь “ewī”-гээс, “ūyi” нь “uwī”-гаас тус тус үүссэн хэмээн үзсэн нь “-γa” нь “yi” болон сэлгэдгийг гэрчилж байна.

“qarčaya- i, malaγa- i, jilaγa- i, qoγūla- i, amidu- i, engküre- i” гэж эцэстээ “i” бүтээвэртэй үгс байх ба

siru- γa ~ sirū-i  
sibe- ge ~ sibe- i  
jula- γa ~ jula- i

köke- ge ~ köke- i гэж харьцуулсныг Б.Я.Владимирцовын дээрх бүтээлээс (стр.295- 298) үзэж болно.

“ayu-ma-(ta)-γai (аймтгай) ayu-m-qai” хоёрыг харьцуулбал оруулбар бүтээвэртэй нь “уг үйлийн шинж эрчимтэй бол оруулбар бүтээвэргүй нь “уул үйлийн шинж эрчим багатай юм. Харин “-γai” нь “онцлон ялгасан”, “-qāi” нь “онцлон ялгаагүй, бүхэллэг” утгыг зааж байх шиг санагдана. Оруулбар “-t/ a-” бүтээвэр нь “өргөөшөө тэлэх, уужимсах” утгатай учир уг тэмдэг нэрнээ “эрчимтэй байх” утгыг нэмдэг байна. Энэ оруулбар “-t/ a-” бүтээвэр нь

gilāyi- (гялайх) ~ gil(t)ayi- (гялтайх)  
gilalja- (гялалзах) ~ gil(t)alja- (гялталзах)  
gilγana- (гялгана) ~ gil(t)ayana- (гялтганах)  
gilas ki- (гялс хийх) ~ gil(t)as ki- (гялтас хийх)  
gilγar (гялгар) ~ gil(ta)γar- (гялтгар)  
gilang (гялан) ~ gil(t)ang (гялтан)  
gilγana (гялгана загас) ~ gil(ta)γana (гялтгана загас)  
gilγanaγūr- (гялгануур) ~ gil(ta)γanaγūr- (гялтгануур)  
göliγi- (гөлийх) ~ göl(t)üγi- (гөлтийх) ~ göltügene (гөлтгөнө)  
- nilāyi- (нялайх) ~ nil(t)ayi- (нялтайх)  
nilalja- (нялалзах) ~ nil(t)alja- (нялталзах)  
nilayana- (нялганах) ~ nil(t)ayana- (нялтганах)  
nilas ki- (нялс хийх) ~ nil(t)as ki- (нялтас хийх)

<sup>24</sup> Б.Ринчен. “Үүрийн туяа” (түүхэн роман), Уб., 1971, 451-452-р т.

<sup>25</sup> Ш.Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кеү, 1988, 2502-2505-р т.

<sup>26</sup> В.Я.Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Лгр., стр.284, 266-279

- nilаγar- (нялгар) ~ nil(t)аγar- (нялтгар)  
nilаγа- (нялга) ~ nil(t)аγа  
nilаγанаγүг- (нялгануур) ~ nil(t)аγанаγүг- (нялтгануур)  
- babana- (бавнах) ~ bab(tu)na (бавтнах)  
bebene- (бэвнэх) ~ beb(tü)ne (бэвтнэх)  
böbüne- (бөвнөх) ~ böb/ü(tü)ne- (бөвтнөх)  
bübüne- (бүвнэх) ~ büb/ü(tü)ne- (бүвтнэх)  
bubuna- (бувнах) ~ bub/u(tu)na-, bub(tu)na- (бувтнах)  
bobuna- (бовнох) ~ bub/u(tu)na-, bob(tu)na- (бовтнох)  
- ququna- (хухнах) ~ ququ(tu)na- (хухтнах)  
kiquna- (хяхнах) ~ kiqu(tu)na- (хяхтнах)  
qaqana- (хахнах) ~ qaqu(tu)na- (хахтнах)  
küküne- (хүхнэх) ~ күкү(tü)ne- (хүхтнэх)  
- quükina- (хуухинах) ~ quüki(tu)na- (хуухитнах)  
- šuükina- (шуухинах) ~ šuüki(tu)na- (шуухитнах)  
šakina- (шахинах) ~ šaki(tu)na- (шахитнах)  
- ebürle- (өвөрлөх) ~ ebür(tü)le- (өвөртлөх), ebürid(ü)le- (өвөртлөх)  
söliyi- (сөлийх) ~ söl(te)-yi- (сөлтгийх) (selterkei)  
salayi- (салайх) ~ sal(tā)-yi- (салтайх) (saltas ki-)  
seleyi- (сэлийх) ~ sel(te)-yi- (сэлтийх) (seltes kī-)  
salayi- (салайх) ~ sal(tā)-yi- (салтайх)  
salγana- (салганах) ~ sal(t)аγана- (салтганах)  
- sarāyi- (сарайх) ~ sar(tā)-yi- (сартайх), sartаγar (сартгар)  
sorūyi- (соройх) ~ sor(t)ü-yi- (сортойх), sortuγūr (сортгор)  
sereyi- (сэрийх) ~ ser(t)e-yi- (сэртгийх), serteger (сэртгэр)  
sörüyi- (сөрийх) ~ sör(t)ü-yi- (сөртгийх), sörtügür (сөртгөр)  
- yöyliyi- (ёйлийх) ~ yol(tu)-yi- (ёлтойх), yoltuγur (ёлтгор)  
- meleyi- (мэлийх) ~ mel(t)eyi- (мэлтийх), melteger (мэлтгэр)  
melegene- (мэлгэнэх) ~ mel(t)egene- (мэлтгэнэх), meleger (мэлгэр)  
melelje- (мэлэлзэх) ~ mel(t)elje- (мэлтэлзэх), melteljegür (мэлтэлзүүр)  
maliyi- (малийх) ~ mal(t)iyi- (малтийх), maltiγar (мальтгар)  
moliyi- (молийх) ~ mol(t)üyi- (молтойх), moltuγur (молтгор)  
moltuγčin (молтогчин)  
möliyi- (мөлийх) ~ möl(t)üs (мөлтөс, ам мөлтөс)  
möllilje- (мөлөлзөх) ~ möl(t)ü (мөлт татах), möli- (мөлөх- элэх хорлох)  
nilаγана- (нялганах) ~ nil(t)аγана- (нялтганах), nilаγar (нялгар)  
- irāyi- (ярайх) ~ ir(t)āyi- (яртайх- ярвайх)  
- kiqua- (хяхнах) ~ kiqu(tu)-na- (хяхтнах), kiqu(tu)naγān (хяхтнаан)  
- čiqua- (чახнах) ~ čiqu(tu)na- (чახнах), čiqu(tu)naγān (чახтнаан)  
- sibene- (шивнэх) ~ sibe(tü)ne- (шивтнэх)  
- šuükina- (шуухнах) ~ šuüki(tu)na- (шуухитнах) ~ šuükitunaγān (шуухитнаан)

зэрэг дүрс дуурайх ба хааяа авиа дуурайх үгнээ тохиолдож байна. Энэхүү оруулбар бүтээврийн талаар П.Бямбасан багш “...түүн дээр бас дурдсан “-ай, лз, га, на, р, схий” залгаж болох нэг хэсэг, мөн язгуур дээр нь дурдсан морфемүүдийг



сэр-ий, сэр-лз, сэр-т-гэ-нэ, сэр-т-гэ-р, сэр-гэ-р, сэр-с-хий гэх мэт залгаж болно<sup>27</sup> гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, *segeyi-* (сэрийх) ~ *ser(t)eyi-* (сэртийх) гэхчлэн дээр дурдсан шиг “*t*” оруулбар бүтээвэр шургаж болохыг П.Бямбасан багш өгүүлжээ. Жич, дүрслэх үгийн идэвхгүй язгуурт залгаж “-уи” буюу “i” дагавар нь дээр өгүүлсэнчлэн “үргэлжлэх” буюу “жигд нэг хэвэндээ байх” гэсэн утгатай бөгөөд эгшгээр төгссөн үг бүтээвэрт залгаж ордог<sup>28</sup>. Монгол хэлнээ одоо цагийн утгатай “-i” нөхцөл нь “u”-тай сэлгэж, *bu-yu* (буюу) ~ *bū-i*” хэмээх хоёр хувилбар бүтээсэн ажээ<sup>29</sup>. Г.И.Рамстедт энэхүү “-i” нь *dagū-i* (даруй), *muḡū-i* (муруй), *ayisu-i* (айсуй), *ayi-l* (айл), *baḡūḡā-i* (буурай), *bala-i* (балай), *ede-ī* (ээдий буудай), *üge-i* (үгүй), *ügegū-i* (үгээгүй) зэрэг үгнээ тохиолдож байна гэж үзжээ. Тэр ч байтугай, энэхүү “-i” бүтээвэр нь *sön-i* (шөнө ~ сөнө), *muḡ-i* (муж), *ayuḡūl-i* (аюул), *ükügül-i* (үхүүл) хэмээх нэрийн зүйлд ч орж байна гэж үзсэн нь төрөл хэлнүүдэд “i”-гүй хэлбэрт үг байгаагаас болсон байна. Тэгтэл Б.Я.Владимирцов “*bu-i*” нь одоо цагт нэр (үйлт нэр) нь хөгжлийн явцад одоо цагийн нөхцөл (*bola/ u-i*- болой)-ийн “-i” болон салаалсан гэж үзжээ<sup>30</sup>. Бидний санавал, “*ser-yi-*” зэрэг дүрслэх үгийн “үргэлжлэх” гэсэн утга бүхий “-уи” үе- утгалбар нь “зогсосхийх” гэсэн утгатай “-ḡa” үе-утгалбараас сэлгэж үүссэн бөгөөд “*bu-i, bu-yu, bola-i*” болон “*dagū-i, ügegū-i, ḡar(u)-i, üge-i, edū-i, murū-i*” зэрэг үгнээ тохиолдож байна. Энэхүү “-i” авиа-утгалбар нь “-ḡaḡā-i, ḡasā-i, tuḡā-i, ḡtu-i, (-ḡtun), -ḡüḡā-i, mū-i, luḡā-i (-luḡā), ba-I (-ba), qu-I (qūn)”<sup>31</sup> зэрэг үйлийн нөхцөлд оролцож явдаг ажээ. Харин Г.И.Рамстедт “-ḡaḡā-i” хэмээх зөвлөн захирах төгс нөхцөл дэх “-ai” гэсэн хэлбэрийг эрчимжүүлэх бүтээвэр (усилительная частица) гэж үзсэн байна.

“-m/ a-ta-ḡā-i” хэмээх дагавар дахь оруулбар “-ta” нь гээгдвэл “-ma-ḡāi (-мгай) буюу “-ma-qā-i” дагавар салаалсан ба “уг үйлийг богино хугацаанд чадмаг гүйцэтгэх” гэсэн утга илтгэнэ. Жишээ нь: *agu-maḡ/ qāi, sun(u)-maḡ/ qāi, mede-meg/ kei, ayū-maḡ/ ḡāi, iči-mek/ geī, ab(u)-maḡ/ ḡāi, türi-mek/ geī, qari-maḡ/ ḡāi, quḡa-maḡ/ ḡāi, sur-maḡ/ ḡāi, kinu- maḡ/ ḡāi, ḡar-maḡ/ ḡāi, kele-mek/ geī, dad- maḡ/ ḡāi, niḡūr- maḡ/ ḡāi, qaḡū- maḡ/ ḡāi, šū- maḡ/ ḡāi*<sup>32</sup>. Энэ хоёр хувилбарын “-qāi” нь “бүхэл, том, ихсэх; “ḡāi” нь “хэсэг, бага, ялгарах” гэсэн утгатай боловч хэлэхүүний түвшинд төдий ялгарахгүй, саармагшсан шинжтэй юм.

“-maḡāi” хэмээх дагаврын “үргэлжлэх” утга бүхий “i” дагаврыг хасвал “-maḡa” болон “-maḡ” хэмээх нийлсэн хэлц дагавар үүснэ. У-Ж.Ш.Дондуков “-maḡ” дагаврын утгыг 1) ялгарах онцгойрох (*ḡoḡi- maḡ, ida- maḡ*); 2) шунан дурлах (*qaḡūr- maḡ*); тогтмол шинж чанар (*qoli- maḡ, iḡar- maḡ*); 4) аль нэг байвал (*nḡuyir- maḡ*<sup>33</sup>) гэсэн бол Ш.Цэцэнцогт 1) гүйцэд бус байдал (*aki- maḡ, qaḡur - maḡ, ḡoḡi- maḡ, qoli- maḡ, duta- maḡ, čida -maḡ*); 2) юмыг нэрлэх (*ači- maḡ, egēde- meg, qali- maḡ, čoči-*

<sup>27</sup> П.Бямбасан. Орчин цагийн монгол хэлний үйл үгийн идэвхгүй язгуурын тухай зарим ажиглалт. “Хэл зохиол судлал”, 16-р боть, Уб., 1987, 18-42-р т.

<sup>28</sup> М.Базаррагчаа. Уйгуржин монгол бичигт урт хос эгшгийг тэмдэглэсэн нь. “Монгол хэлний авианы чөлөөт сэлгэцийн тухай”, Уб., 1992, 107-126-р т.

<sup>29</sup> Г.И.Рамстедт. Введение в алтайское языкознание, М., 1957, стр. 98

<sup>30</sup> Б.Я.Владимирцов. Остатки причастия настоящего времени в монгольском языке. “Работы по монгольскому языкознанию”, М., 2005, стр. 95- 96

<sup>31</sup> Г.Д.Санжеев. Сравнительная грамматика монгольских языков, Глагол, М., 1964, стр. 95- 131

<sup>32</sup> Ш.Цэцэнцогт. Дурдсан зохиол, 2713- 2715-р т.

<sup>33</sup> У-Ж.Ш.Дондуков. Дурдсан зохиол, стр. 90-91

maγ, amaγ- maγ, qāyil- maγ); 3) төстэй буюу холбогдолтой (āyi- maγ, śegēji- meγ, jāyir- maγ, ir- meγ, naγur- maγ, uūji- maγ); 4) тухайн зүйлийн шинж тэмдэгтэй буюу түүгээр дутмаг байх (jegūr- meγ, nōyir- maγ, ege- meγ, qosi- maγ, dura- maγ); 5) тоо хэмжээ заасан (qous- maγ, būira- maγ, aга- maγ tara- maγ)<sup>34</sup> гэх мэтээр ангилсан байна. Энэ дагаврын утгыг Т.А.Бертагаев ерөнхийд нь “үйлийн илрэх боломж буюу дутмаг болох” гэж тайлбарлажээ<sup>35</sup>. Тухайн юмын шинж чанар дутмаг буюу боломж, төсөөтэйн утга бүхий “-maγ” дагавар нь

taγā- ma- (ta)- γā- i → taγā- ma- q/ γā- i → taγā- ma- γ (таавар, тойм, сэжиг)  
qata- γā- ma- (ta)- γā- i → qata- γā- ma- q/ γā- i → qata- γā- ma- γ (шарж хатаасан талх)

śarśa- γā- ma- (ta)- γā- i → śarśa- γā- ma- q/ γā- i → śarśa- γā- ma- γ (царцааж хийсэн идээний зүйл)

saγa- ma- (ta)- γā- i → saγa- ma- q/ γā- i → saγa- ma- γ (далайн алгана загас)

baγa- ma- (ta)- γā- i → baγa- ma- q/ γā- i → baγa- ma- γ (ааруул, архи нэрснээс үлдсэн цагаа)

oγiγā- ma- (ta)- γā- i → oγiγā- ma- q/ γā- i → oγiγā- ma- γ (ороож хийсэн юм, зэс ороомог)

śarśa- ma- (ta)- γā- i → śarśa- ma- q/ γā- i → śarśa- ma- γ (ээзгий зэргийг шар тосонд царцаасан нь)

→ śida- ma- q/ γā- i → śida- ma- γ (сурамгай, дадамгай)

tara- ma- (ta)- γā- i → tara- ma- q/ γā- i → tara- ma- γ (армаг тармаг)

nuūr- ma- (ta)- γā- i → nuūr- ma- q/ γā- i → nuūr- ma- γ (нуурам тогтуун)

jaγūr- ma- (ta)- γā- i → jaγūr- ma- q/ γā- i → jaγūr- ma- γ (зуурч хийсэн нь)

jaśa- ma- (ta)- γā- i → jaśa- ma- q/ γā- i → jaśa- ma- γ (засах төлөвтэй, агталсан)

śala- ma- γā- i → śala- ma- γ (гавшгай түргэн, хурдан)

qaγūr- ma- (ta)- γā- i → qaγūr- ma- q/ γā- i → qaγūr- ma- γ (хуурамч, худал)

kerči- me- (te)- ge- ī → kerči- me- k/ge- ī → kerči- me- g (шөлөнд хөшиглөх гэдэс дотор)

sigū- me- (te)- ge- ī → sigū- me- k/ge- ī → sigū- me- g (шүүр шанага, хэвлээгүй үйрмэг бяслар)

türki- me- (te)- ge- ī → türki- me- k/ge- ī → türki- me- g (түрхэх юм)

gūyi- me- (te)- ge- ī → gūyi- me- k/ge- ī → gūyi- me- g (зэрвэс гүйцэтгэх) зэрэг үгстэй ихэвчлэн ойролцоо утгатай болох ба “-ma- (ta)- γā- i” нь “-ma- q/ γā- i” дагаврын хувилбар болно. Үүнд оруулбар дэд бүтээвэр нь уг үйлээс үүссэн тэмдэг нэрнээ зөвхөн “яльгүй онцлон ялгасан буюу бяцхан эрчим нэмэх төдий” утга оруулдаг ажээ.

Г.И.Рамстедт “Үйл үгээс үүссэн “-γāi ~ qāi...” дагаврын хажуугаар мөн ийм дагавраар нэрээс үүссэн үг олонтоо дайралдаж байна. Энэ хоёрын язгуур нь анх нэр үйлийн аль нь байсныг зарим тохиолдолд ялгахад бэрх байдаг. Үүний “-γāi” нь ихэвчлэн багасгах утгатай байдаг. Жишээ нь: tara-γāi (халзан), jōgē-kei (зөөхий), śinu- qai (чонохой, чонын бэлтрэг), kei-kei (хүүхэй), soluγāi (солгой- зүүн тал), śul- γa/ ui (цулгай), gūnjegei (гүнзгий), malaγāi ~ malaqai (малгай), aγuqāi (архай, ар тал),

<sup>34</sup> Ш.Цэцэнцогт. Дурдсан зохиол, 2713- 2715-р т.

<sup>35</sup> Т.А.Бертагаев. Дурдсан зохиол, стр. 202

gergei (гэргий)<sup>36</sup>.

Бидний үзсэнээр “-ya...” үе- утгалбарын “a” нь “i” -тэй сэлгэж, улмаар “y” нь “y” -тэй сэлгэж, “yi” гэсэн үе- утгалбар үүсэж, “y” нь гээгдэн, “i” нь өмнөх эгшигтэй нийлж, хэлц хос эгшиг, тухайлбал “-ma-i” гэсэн дагавар бий болжээ. Энэ дагавар нь “-maᠢ”, “maᠢ” дагавартай гарал нэг болно. Г.И.Рамстедт нэрээс тэмдэг нэр бүтээх “-mai” дагаврын “tala-māi (тэгш, хавтгай), jaᠢal-mai (загалмай), naᠢ-mai (бүх), nouᠢr-mai (нойрмог), qoᠢ-mūi (“qoᠢ” нь халаас, саадаг), ere-meᠢ (эрмэй- эр-), naᠢyūr-maᠢ (нуурмаг)<sup>37</sup> зэрэг жишээ татаж, ere-meg (эрмэг гүү), kir-maᠢ (анхны цас), kiraᠢyū (хяруу) гэсэн жишээг харьцуулжээ. Тэрээр, “-ma, -maᠢ (qolimaᠢ), -ma (tar-ma-), -m (udu-m, ula-m, (ulaᠢā, ulari- bari- m, quri- m, jiru- m, erde- m, aᠢyūda- m, qoᠢj-i- m, ayu-m-siᠢ), -maᠢ (čida-maᠢ, ida- maᠢ), -mal (tari- mal, biči- mel), -mta (boᠢyū- mta, daru- mta, bari- mta, jaᠢᠢya-mta, tö᠒ürü- mte (бөгж, tö᠒ür-) i- mᠢi (ergü-mᠢi, neᠢyle- mᠢi, üle-mᠢi, ula-mᠢi); -mᠢāi, mtaᠢāi, mtaᠢyū (martam- qāi, ide- mkeᠢ, ūyila- mᠢqāi, sočima- yāi); -mᠢui, mᠢ, m (a- mūi, amᠢ, am) зэрэг дагаврууд нь нэг эхтэй болохыг дурджээ<sup>38</sup>.

Ийнхүү оруулбар дэд бүтээврийн жишээг монгол хэлний дүрслэх үгийн үндэс болоод тэмдэг нэр бүтээх дагавар дотор шурган орсон “-tu-” болон “-ta-“ үе- утгалбараар гаргахыг оролдлоо.

З.А.Потиха “орос хэлнээ об + вернуться → обернуть(ся), об + влако → облака” гэх мэтээр “в” авиалбар гээгдэх на- в- острить (острый), в- отчина (отчий) гэхчлэн “в” авиалбар нь оруулбар бүтээвэр болжээ<sup>39</sup>. Иймэрхүү авиа-утгалбар дүрслэх үгийн дундаас “харжигнах-хажигнах, бархирах-бахирах, дэрдийх-дэрийх, дэдийх, ханхайх-хахайх” гэх мэтээр “р, н, д” зэрэг авиа-утгалбар гээгдэх нь монгол хэлнээ тохиолддог<sup>40</sup> Е.А.Земская “Орос хэлний үг бүтэх ёсноо авиалбар сэлгэх нь бүтээврүүдийн уулзварт төдийгүй, тухайн үгнээ тодорхой утгагүй хэрчим буюу хэлбэртэй холбогдох заагт тохиолддог. Авиалбарын бүрэлдэхүүн ба сэлгэцээрээ бүтээвэртэй тохирч буй утгагүй хэрчмийг дэд бүтээвэр гэнэ. Энэ нь бүтээврээс доод түвшний нэгж болно”<sup>41</sup> гэж дэд бүтээврийг тодорхойлжээ. Орос хэлнээ “любимый→ любим- ец, любимч- ик; сын→ сын- ок→ сыноч- ек; простой→ прост- ак→ простич- ок” гэвэл “-ец, ик” нь дагавар, чепец→ чепч- ик, чулок→ чулоч- ек, замок- замоч- ек, конец→ кончи- к” гэвэл “-ек, ик” нь дэд бүтээвэр болох ажээ. Е.А.Земская дэд бүтээвэр нь эртний үгсийн бүтцийн үлдэц бөгөөд өмнөх үндэс язгууртайгаа зууралдан энгийншсэн буюу угшсан ажээ. Ингэж үгийн үндэс дагавар хоёрын ялгаа арилах нь бүтээврийн авиалбар зүйн түвшинд буюу дэд бүтээврийн түвшинд үргэлж давтагдаж байдаггүй” гэж үзжээ<sup>42</sup>. Иймэрхүү энгийнших (опрошение) ёс монгол хэлнээ “ebed- čin (өвчин), geᠢ- čin (гийчин), qaᠢyū-čín (хуучин), qaᠢyū- čí (хууч), öᠢnū- čin (өнчин)<sup>43</sup>, jiᠢya- čin (загасчин), dāyü- čin (дайчин)” гэхэд “-či-n” дагавар нь язгууртайгаа нягт нийлж дэд бүтээвэр болсон

<sup>36</sup> Г.И.Рамстедт. Дурдсан зохиол, стр. 184-185

<sup>37</sup> Г.И.Рамстедт. Дурдсан зохиол, стр. 193

<sup>38</sup> Г.И.Рамстедт. Дурдсан зохиол, стр. 100- 105

<sup>39</sup> З.А.Потиха. Современное русское словообразование, М., 1970, стр. 131-133

<sup>40</sup> М.Базаррагчаа. Монгол хэлний авиа сэлгэх ёс. Уб., 1987, 178-179-р т.

<sup>41</sup> Е.А.Земская. Современный русский язык. Словообразование, М., 1973, стр. 81

<sup>42</sup> Е.А.Земская. Дурдсан зохиол, стр. 82

<sup>43</sup> М.Базаррагчаа. “Өнчин” хэмээх үгийн гарал. МУИС., Scientific journal, N 6, Уб., 1995, 16-24-р т.

байх ба зарим түүхэн гарвалын үүднээс язгуур дагавраар задарч болохуйц авч “aduу- ёi- n, mal- ёi- n” гэсэн дагавраас өөр юм. Академич Б.Ринчен genel (гэрэл), gere (гэр, загас гэрдэх), gegēn, gegegēn (гэгээн), geуi- (гийх), geуigūlūgсi (гийгүүлэгч)<sup>44</sup> зэрэг үгсийг “ge-” гаралтай гэжээ.

Энэхүү “-ёin” бүтээвэр нь Е.А.Земскаягийнхаар дэд бүтээврийн нэг төрөл хувилбар болох юм.

И.А.Мельчук “палец” гэдгийн “-ец” нь дэд бүтээвэр болох бол “пе(ть) → певец” хэмээх үгийн “-ец” нь дагавар болно гэж үзсэн ба тэрээр “Бүтээврийн адилаар зарим нэг үндэс язгуурт залгаж болох боловч утгагүй, зөвхөн цэвэр хэлбэрийн махбодь болж чаддаг зүйл хэл шинжлэлд тохиолддог. Түүнийг бид дэд бүтээвэр гэж болно”<sup>45</sup> гэж тодорхойлсон нь Е.А.Земскаягийн үзсэнтэй ижил байна. Ийнхүү бүтээврийн гаргалгын хувьд, дэд бүтээвэр нь үг бүтээх дагавартай тохировч дагавар шиг бие даасан утгагүй юм. И.А.Мельчук франц хэлний “cev” гэсэн дэд бүтээвэр нь “recevoir (хүлээн авах, хүртэх), concevoir (ойлгох, учрах), décevoir (мэхлэх, урам хугарах), pecevoir (мэдрэх, ойлгож авах)” зэрэг үгнээ тохиолдох авч өөр дагавартай дүйцдэггүй байна” хэмээгээд, энэхүү “cev” нь ховор тохиолддог дэд бүтээвэр болох (Үүнтэй монгол хэлний “-t/ a-” гэсэн оруулбар дэд бүтээврийг харьцуулна уу) ба “cev” нь нэлээд олон үгнээ тохиолдож, франц хэлний язгуур мэт сэтгэгддэг. Мөн франц хэлний угтвар “re-, dé...” бүтээвэртэй заримдаа тохирох дэд бүтээврийн дараа “cev” гэсэн дэд бүтээвэр орох бөгөөд “cev ~ sov ~ coiv ~ cept” (réception- хүлээн авалт, perceptible (хүлээн авч буй) гэж авианы сэлгэцээр ялгарах нь франц хэлний үйл үндсэнд байнга тохиолддог<sup>46</sup> гээд, “cev, soi, coiv, cept” зэргийг бүтвэрэнцэр (морфоид) гэж болохгүй, дэд бүтээвэр юм гэжээ. Тэрээр, “ceiv ~ cept” гэсэн махбодь нь англи хэлний “receive-хүлээн авах; conceive (учрыг нь олох), deceive (хуурах мэхлэх), perceive (хүлээн авах), reception (хүлээн авалт), conception (чиглэл, хандлага), deception (хуурмаг), perception (хүртлэг) зэрэг жишээнд тохиолдох бөгөөд мөн “-tain” гэдэг дэд бүтээвэр нь англи хэлний detain (хүчээр барих), obtain (хүлээн авах), retain (барих, хадгалах), maintain (дэмжих, хадгалах) зэрэгт оролцдогийг И.А.Мельчук тэмдэглээд, энэ дэд бүтээвэртэй таарах бүтээвэр нь франц хэлний үйл үгнээ тохиолдох “ten” гэсэн бүтвэрэнцэр байдаг гэжээ. Тэрээр, бүтвэрэнцэр нь франц хэлний “lunette” (жижиг сар) гэхэд орсон “багасгах” утга бүхий “-elte-” хэмээснийг хэлэх<sup>47</sup> ба энэ нь хэвшмэл бүтээвэр (фразеологизованные или лексикализованные комплексы морф, морфологические фраземы) болох ажээ. Ингэж дэд бүтээврээс бүтвэрэнцэр нь утгын улбаатай байдгаараа ялгаатай юм. Монгол хэлнээ “aya-s (аяыг нь /аясыг нь дагах), игма-s / урам зориг), ёуi-s (үед, орчимд, тухайн үес) зэрэгт орсон “-s” нь олны утга нь ихэд бүдгэрсэн тул бүтвэрэнцэр болж, “uridu-s (урьдын хүмүүс), erdeni-s (эрдэнийн зүйлс), mёёi-s (олон мөч), beke-s (бэхний олон тоо) зэрэг үгсийн “-s” (олон тоо) дагавраас ялгаатай юм. Т.А.Бертагаев “аж амьдрал, аж байдал, аж үйлдвэр, аж ахуй, аж төрөх” гэсэн холбоо үгсийн “аж”, “суга тат-, суга үсэр-” гэсэн холбоо

<sup>44</sup> Б.Ринчен. Монгол бичгийн хэлний зүй, Дэд дэвтэр, Авиан зүй. Уб., 1966, 146-147-р т.

<sup>45</sup> И.А.Мельчук. Курс общей морфологии. Т.IV. Москва- Вена, 2001, стр. 282- 283

<sup>46</sup> И.А. Мельчук. Дурдсан зохиол, стр. 284

<sup>47</sup> И.А. Мельчук. Дурдсан зохиол, стр. 95,280

үгсийн “суга”, “цав цагаан, шав шар” гэдгийн “цав, шав” зэргийг бүтвэрэнцэр буюу угтвар бүтвэрэнцэр (префиксоиды)<sup>48</sup> гэж үзсэн билээ. Мөн дүншаан хэлнээ хулан → ху(пу)лаган (улаан → час улаан), шира → ша(бэ)-рги (шар → шав шар) гэж тэмдэг нэрийн давуу зэргийг илтгэх оруулбар бүтээвэр (инфикс) гэж үзсэн нь бүтвэрэнцрийн нэг хувилбар болно. М.Энхжаргал “-su-n” (-s) хэмээх дэд бүтээврийн утгыг 1.үйлийн үр дүн хийгээд үр дүнд бүтсэн нэр (нэмнээ-с, нугалаа-с); 2.үйлийн багаж хэрэглэгдэхүүн (тушаа-с, уяа-с, түгжээ-с); 3.үйлийн байр байдал заасан нэр (тавиа-(с)-тай, ноёлоо-(с)-той) гэж ангилсан байдгийг<sup>49</sup> энэ тухайд дурдъя.

И.А.Мельчук нийлмэл хэлц бүтээврийн тухай “Өгүүлбэрийн гишүүдийг бүтээж байгаа энгийн хэсэг болдог тэмдгүүд хэвшсэн хэлц болохыг бүтээврийн хэлц (морфологические фраземы)” гэж тодорхойлоод,

1) язгуур + язгуур (хэвшмэл нийлмэл үндэс)

2) язгуур + дагавар (дагавар + язгуур) (үүнд хэвшмэл дагавар ба нөхцөлүүд хамаарна)

3) дагавар + дагавар (хэвшмэл иж дагавар) гэж хэвшмэл бүтээврийг ангилж, эдгээрээс тухайн бүтээвэр нь бие даасан шинжээ алдаж, бүтвэрэнцэр болох нь буй. Үүнийг хуурмаг бүтээвэр (квазиморфема- квазиморф) гэдэг байна<sup>50</sup>. Бидний санавал, CV гэсэн үе-утгалбар нь язгуур дагавар нөхцөл болон угтвар оруулбар бүтээврүүдэд орохдоо өөр хоорондоо агуулга гаргалгын талаар нэгдэж, нийлмэл хэлц бүтээвэр үүснэ. Монгол хэлний *bara-γün, je-gün, čina-γün, ina-γün, ala-γün* (үүд орчим газар), *tüü-gün* (өмнө), *teri-gün, degē-gün, doüra-γün, dotura-γün, dergede-gün, ečine-gün, qöyina-γün, -ečine-gün, urida-γün, jaqa-γün, öyira-γün, dotu-γün*<sup>51</sup> зэрэг орон цагийн утга илтгэх “-γün” дагавар нь идэвхтэй идэвхгүй язгуурт залган орж буй. Үүнээс идэвхгүй язгуурт залгасан нь хэвшмэл хэлц бүтээврийн шинжтэй юм.

*čina-γün, čina-γ-si, ina-γün, ina-γsi, čina-du, ina-du, čing-gi-jü, ing-gi-jü* зэргийн “či-“үе-утгалбар нь “ta ~ ti” үе- утгалбараас “t ~ č”-гийн сэлгэцээр үүссэн ба “ta ~ či” гэсэн хоёрдугаар биеийн төлөөний үг ч эдгээр үгтэй гарал нэг юм. Цаашилбал: “te-yī-n, e-yī-n, te-yī-mü ~ i-yī-mü, te-n-de ~ e-n-de, te-gū-n ~ e-gū~n, te-dü-ī ~ e-dü-ī” зэрэг заах төлөөний үгтэй болон гуравдугаар биеийн ганц олон тоот “a ~ i” төлөөний үгтэй гарал нэгтэй болно. Иймээс “či-na...” үндэс нь “či-na” гэсэн үе-утгалбараас үүсэж, нэгэнт хэвшмэл хэлц үндэс болжээ. Үүний “-na” гэсэн хоёрдахь үе- утгалбар нь өгөх-оршихын “-a” нөхцөл “үндэс үүсгэх “-n” бүтээвэртэй нийлж, či-n-a → ta-p-ā (танаа өргөдөл барих) гэснээс “čina-” гэсэн үндэс болж, хэвшмэл хэлц бүтээвэр бий болжээ. “či-n-a”-гийн “-n” нь “-m”-тай сэлгэж, “či-ma-” гэсэн үндэс үүсжээ<sup>52</sup>. Ийнхүү үе-утгалбар нь “C-V” болон задарч, өөр өөр бүтээвэр буюу үндэс бүтээх “-n ~ m” өгөх-оршихын “a” нөхцөл болсон боловч өөр хоорондоо нийлж, či-n-a-, či-m-a гэж байснаа čina-, čima- гэсэн хэлц бүтээвэр болсон байна. Т.А.Бертагаев “явнам” гэхэд одоо цагийн “-на” нөхцөлд ирээгүй цагт “m” нөхцөлийг залгасан гэж

<sup>48</sup> Т.А.Бертагаев. Морфологическая структура слова в монгольских языках, М., 1969, стр. 24-28

<sup>49</sup> М.Энхжаргал. Монгол хэлний “-с” дэд бүтээврийн утга, үүрэг, найруулгын онцлог. “Оюуны хэлхээ”, ЭШБ., 12-р боть, Уб., 2014, 76-84-р т.

<sup>50</sup> И.А. Мельчук. Дурдсан зохиол, стр. 453, 458

<sup>51</sup> Ш.Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кеү, 1988, 2625-2626-р т.

<sup>52</sup> Хасбаатар. Монгол манж хэлний нэгдүгээр биеийн төлөөний нэрийн тухай харьцуулал, ӨМИС., ЭШ-ний сэтгүүл, 1992, №3, 23-р т.



үзсэн бөгөөд “-γ-san, m/a- taγū, ug-gi-n-᠑a/ ir дагавруудыг нийлмэл хэлц дагавар<sup>53</sup> гэжээ.

Түүнчлэн хэлц бүтээврийн аль нэг авиа-утгалбар нь гээгдэж, хувилбар үүсэх нь монгол хэлний үйлдэгдэх хэвийн дагаварт тохиолдоно. Жишээ нь: үйлдэгдэх хэвийн “de ~ te...” хувилбарын “-de” нь “-l”-ээр төгссөн үгнээ “-te” нь “b, γ, r”-ээр төгссөн үгэнд залгадаг. П.Бямбасан “Харин “-de ~ te” хоёр нь “-γda...” хувилбараасаа салж байгаа морфем зааглагдах үзэгдэл байж болно<sup>54</sup>” гэж үзсэн ба хэлц бүтээврийн “γ” гээгдэх нь оруулбар бүтээврийн нэг өвөрмөц тохиолдол болно. Тухайлбал, deγl-de- (дийлдэх) ~ deγilγgde- (дийлэгдэх), duγl-da- (дуулдах) ~ daγula-γda- (дуулагдах), qaγūr-ta- (хууртах) ~ qaγūru-γda- (хуурагдах), sonus-da- (сонсдох) ~ sonusu-γda- (сонсогдох), ög-ke- (өгтөх) ~ öggūgde- (өгөгдөх), ab-ta- (автах) ~ ab(u)-γda- (авагдах) (?) qan-ta- (хантах) ~ qon(u)-γda- (ханагдах-хангагдах), sur-ta- (суртах) ~ sur(u)-γda- (сурагдах) (?), kūr-te- (хүртэх) ~ kūr(ü)-gde- (хүрэгдэх) (?), ol-da- (олдох) ~ ol(u)γda- (ологдох) (?), bol-da- (болдох) ~ bol(u)-γda- (бологдох) (?) гэх мэтээр “-γ/g-” гээж, “-γda-” гэсэн хэлц дагавар хагасарчээ. Үйлдэгдэх хэвийн энэ хоёр хувилбар нэг үндэснээ давхарлан “qaγūr-ta-γda- (хууртагдах), ab-ta-γda- (автагдах), kūr-te-gde- (хүртэгдэх), deγl-de-gde- (дийлдэгдэх)” гэх мэтээр хэлэгдэж, нийлмэл хэвийн ховор тохиолдол байж болох ажээ.

А.Н.Тихонов, Р.И.Хашимова нар нэвтэрхий толь бичигтээ “Дэд бүтээвэр нь бие даасан бүтээвэртэй адил мэт байх боловч үг бүтээх ба хувилгах бүтээврийн авиалбар зүйд чухал үүрэг гүйцэтгэдэг чухал нэгж мөн<sup>55</sup>” гэж тодорхойлсныг эцэст нь дурдахын зэрэгцээ Ш.Цэцэнцогт үйлээс нэр бүтээх “-dal” дагаврыг “-γda” гэсэн үйлдэгдэх хэвийн дагаварт үйлээс нэр бүтээх “-l” дагавар залгаж, уул хэвийн “-γ” гийгүүлэгч- авиалбар гээгдэж, “-da-l” гэсэн хэлц бүтээвэр болсон<sup>56</sup> гэж үзсэн байх ба Г.И.Рамстедт “ükü-del, bāyi-dal, yabu-dal” зэрэг үгийн “-da-” нь үйлдэгдэх хэвийн “-da...” (-γda...) дагавраас эхтэй<sup>57</sup> гэж үзсэн байна.

Бидний бодвоос, “-γda...”-ын “γ” нь а) “бусдаас ялгарах” → “бусдаар үйлдүүлэх” гэсэн утгатай “-γa ~ qa, γü-l, l-γa” дагавар, б) “бусдаас ялгарах → одоо ба ирээдүй цагт үргэлжлэх; байнгад байх” (o᠑i-γā+ edüi, yabu-γā, oγul᠑a- γā), в) “бусдаас ялгарах → өчүүхэн болж ялгарах → жижигрэх” (a᠑i-γda-, a᠑i-γtun, üje-gsen) гэсэн утга ба авианы хувирлаас үүссэн бөгөөд “-γa...” үе-утгалбарын эгшиг нь гээгдэж, “-da” дагавартай нийлж, өөрийн эрхгүй үйлдэгдэх “-γda” гэсэн нийлмэл хэлц дагавар үүсжээ. Энэхүү “-γda”-ын “-da” нь “өөрийн эрхшээлд оруулах” (gejige-de-, bilegü-de-, ama-da-, daγü-da-), “үг юмын хэтэрч, зохисгүйдэх” (ilegü-de-, maγü-da-, γasiγü-da-, möküs-de-, γomu-da-, qo᠑i-da-) гэсэн утгатай “-da” дагавраас үүсэлтэй биз. Учир нь, бусдын эрхэнд аяндаа үйлдэгдэх үйл нь “-da” дагаврын “алив юмс давхарлах → дээшлэх → “хүч давхарлах буюу ихсэх” ба “давтах” → хүчирхэх, зохисгүйдэх” гэсэн утгатай холбогдох болно. “ke᠑egü-de-, dabayā-da-, qomsa-da-”

<sup>53</sup> Т.А. Бертагаев. Дурдсан зохиол, стр. 54-55

<sup>54</sup> П.Бямбасан. Орчин цагийн монгол хэлний үйл үгийн хэв байдал. “Хэл зохиол судлал”, 2-р боть, Уб., 1970, 259-р т. “Монгол хэлний онол бүтцийн асуудал”, Уб., 2006, 155-р т.

<sup>55</sup> А.Н.Тихонов, Р.И.Хашимова и другие. Энциклопедический словарь-справочник лингвистических терминов и понятий. Русский язык. Т.1. М., 2008, стр. 649

<sup>56</sup> Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кеү, 1988, 2797-р т.

<sup>57</sup> Г.И.Рамстедт. Введение в алтайское языкознание, М., 1957, стр. 133



гэвэл “хүч үл хүрэн зохисгүйдэх”, “sinā-da-, čilayū-da-, tasiγūr-da-, qola-da-” гэвэл “хүч хэтэрч зохисгүйдэх” буюу ”хүчээр уг юманд дарангуйлах, хүчирхэх” утга илтгэх тул үйлдэгдэх хэвийн дагаварт голлох махбодь болон оржээ. Ийнхүү аливаа хүчинд өөрийн эрхгүй өртөж, улмаар “ūje-gde-, bodu-γda-, yabu-γda-, soru-γda-, čida-γda-, čina-γda-, seǰigle-gde-, kūrge-gde-, yegūdge-gde-, durusu-ǰda-, toquā-γda-” гэхчлэн хэлэлцэх ба Г.Д.Санжеев “энэ хэв нь түүхэн үүднээс үйлдүүлэх хэвээс үүссэн”<sup>58</sup> гэж үзсэн нь “-γa...” үе- утгалбарын авиа утга хоёрын түүхэн хувьсалтай холбогдоно.

### РЕЗЮМЕ

В монгольском языке субморфы, не обладающие конкретным значением встречаются не только в конце слова или в разных суффиксах, но и внутри корня. Это можно назвать инфиксальным субморфом. При сравнении слов “gil- γana- (сверкать, блестить) и gil- ta- γana- (блестеть, сверкать) суффикс “-ta” в последнем слове можно назвать инфиксальным субморфом, так как он не имеет определённого значения. Но с точки зрения терминологии с помощью этого инфиксального субморфа “-ta” образуются слова “giltayanaγūr” (слюда) и “gilγanaγūr” (блестящий, щеголеватый) с разным значением. Кроме вышеназванных изобразительных слов редко наблюдаются инфиксальные субморфы в знаменательных словах. ebürle- (спать вместе, класть за пазуху). ebür- tū- le- (спать вместе, класть за пазуху). Со стороны фономорфологии или морфонологии в морфемном шве выделяются субморфы, что ждёт своего исследования на новом уровне.

---


<sup>58</sup> Г.Д.Санжеев. Сравнительная грамматика монгольских языков. Глагол, М.,1964, стр. 44

**УДАМ ДАМЖСАН НЭРТ ЭРДЭМТЭД**

Э.Пүрэвжав  
/ШУА/

Монгол улсын Төрийн шагналтан, Монгол улсын Шинжлэх ухааны академийн анхны жинхэнэ гишүүн (академич), үндэсний монгол хэл шинжлэлийн шинжлэх ухааны ууган доктор (Sc.D), профессор, гарамгай дуун хөрвүүлэгч, эрдэмтэн зохиолч Ёншөөбү овогт Бямбын РИНЧЕН (1905-1977) бол эх орондоо үндэсний монгол судлалыг үүсгэн хөгжүүлж, монгол туургатны хэл бичиг, утга соёлын өв уламжлалыг дэлхий дахинаа таниулан сурталчлахад үлэмжийн хүндтэй гавьяа байгуулсан монголын агуу их бичгийн мэргэдийн нэг мөн билээ.

Профессор Б.Ринчен монгол хэл шинжлэл, монгол хэл бичгийн ухаан, монгол нэр томъёо судлал, монгол ардын аман зохиол судлал, монгол угсаатны зүй, монгол бөө мөргөл судлал, монгол шашин судлал, монгол утга зохиол судлал, эх түүх судлал, урлаг судлал, утга соёлын өв судлал, монгол ардын зан заншил судлал, монгол түүхэн сурвалж судлал тэргүүтэн монгол судлалын бараг л бүх салбараар эрдэм шинжилгээний өгүүлэл, тэмдэглэл, нийтлэл, товхимол, эмхэтгэл, дээж бичиг, ном, судалгааны ганц сэдэвт бүтээл туурвиж хэвлүүлсэн нь шинжлэх ухааны нарийн үндэслэлтэй, эрдэмтэн хүний холч хараа, гярхай ажиглалт, нягт дүгнэлттэй байдаг учраас уншиж танилцсан хэн хүний анхаарал сонирхлыг ямагт татаж чаддагаараа нэн өвөрмөц онцлогтой.



Бямбын РИНЧЕН (1905-1977)

Академич Б.Ринчен монгол судлалд үнэт хувь нэмрээ оруулж чадсан “Монгол бичгийн хэлний зүй” (1964-1967) хэмээх дөрвөн боть суурь судалгааны бүтээл, “Монгол нутаг дахь хадны бичээс, гэрэлт хөшөөний зүйл” (1968), “Монгол ард улсын хамниган аялгуу” (1969), “Монгол ард улсын угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас” (1979) зэрэг бүтээлийг Улаанбаатар хотноо хэвлүүлж, монгол ардын аман зохиол, аман билиг судлалаар “Folklore Mongol” (1960-1972) хэмээх таван боть судалгааны цуврал бүтээл, монгол бөө мөргөл судлалаар “Les Matériaux pour L'étude du Chamanisme Mongol” (1959-1975) хэмээх гурван боть тэргүүтэн эрдэм шинжилгээний бүтээлийг ХБНГУ-д нийтлүүлж хэвлүүлсэн юм. Эдгээр ном бол эдүгээгийн монгол судлалд тэр болгон дахин давтагдашгүй хосгүй ховор бүтээл туурвил гэж дотоод, гадаадын монголч эрдэмтэд зүй ёсоор үнэлэн цэгнэдгийг онцлон дурдалтай.

Их эрдэмтэн, академич Б.Ринчен монгол судлалын чиглэлээр хэдэн зуун бүтээлийг монгол, орос, англи, франц, герман, польш, унгар, чех хэлээр бичиж нийтлүүлжээ. Гадаадын сэтгүүл, цувралд хэвлүүлсэн судалгааны өгүүлэл, эрдэм шинжилгээний бүтээлүүд нь эдүгээ

*“Эрээд эрээд олдошгүй эрдэнэ  
Сураад сураад олдошгүй сувд”*

лугаа адил олдохуйяа ховор эрдэнэ болжээ. Түүний туурвиж хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны бүтээлийн бүрэн түүвэр нь хэвлэгдэж хараахан гараагүй байгаа. Эрдэмтэн зохиолч Б.Ринчен 1927 оноос 1977 он хүртэл хагас зуун жил Монгол улсын Судар бичгийн хүрээлэн, Шинжлэх ухааны хүрээлэн, Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнд тасралтгүй үр бүтээлтэй ажилласан манай хүрээлэнгийн ахмад судлаач болно. Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн үүсэн байгуулагдсаны 90 жил, Монгол улсын Шинжлэх ухааны академи болон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн байгуулагдсаны 50 жилийн тэгш дүүрэн их ойг тохиолдуулан, академич Б.Ринчен докторын монгол судлалын чиглэлээр туурвиж нийтлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээл туурвилыг нь “Бямбын РИНЧЕН. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*” гэсэн ерөнхий нэрээр 2011 онд анх удаа ботилон хэвлүүлэх их ажлыг эхэлж, “Монгол хэл бичгийн ухаан” (I), “Монгол утга зохиол судлал” (II), “Mongol Studies” (III), “Монголоведение” (IV) хэмээсэн дөрвөн боть, 2012 онд “Монгол бичгийн хэлний зүй”, тэргүүн дэвтэр [удиртгал] (V), “Монгол бичгийн хэлний зүй”, дэд дэвтэр [авиан зүй] (VI), “Монгол бичгийн хэлний зүй”, гутгаар дэвтэр [хэлбэр судлал] (VII), “Монгол бичгийн хэлний зүй”, дөтгөөр дэвтэр [өгүүлбэр зүй] (VIII) гэсэн бүтээлийг өргөн олны хүртээл болгосон билээ. “Бямбын РИНЧЕН. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*” цувралын есдүгээр ботид академич Б.Ринчен докторын бичиж нийтлүүлсэн монгол ардын аман билиг судлалын чиглэлээрх эрдэм шинжилгээний бүтээлүүдийг нь эмхэтгэн “Монгол аман билиг судлал” гэсэн нэрээр гаргахаар бэлдэж байна.

Академич Бямбын Ринчен багштаны бичиж туурвисан эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалтыг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн секторын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, хэл бичгийн ухааны доктор (Ph.D), дэд профессор Э.Пүрэвжав 1989 онд “Монгол судлалын мэдээлэл” сэтгүүлийн № 2 (4)-ын 79-90 дүгээр тал [228 бүтээл], 1997 онд “Э.Пүрэвжав. Монгол хэл бичиг судлал” цувралын нэгдүгээр дэвтрийн 115-133 дугаар тал [477 бүтээл], 2000 онд “Л.Болд. Монгол хэл шинжлэлийн түүхэн найруулал” номын нэгдүгээр дэвтрийн 159-176 дугаар тал [477 бүтээл], 2003 онд “Ц.Шагдарсүрэн,

О.Адъяа. Бямбын Ринчен” (“Монгол улсын шинжлэх ухаан” 108 боть цувралын V боть) хэмээх номын 99-132 дугаар тал [667 бүтээл], 2005 онд “МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг “Acta Mongolica”, Volume 5 (246)” сэтгүүлийн 21-38 дугаар тал [714 бүтээл], 2005 онд “Э.Пүрэвжав. Их эрдэмтэн, академич Б.Ринчен” судалгааны бүтээлийн 99-135 дугаар тал [715 бүтээл], 2011 онд “Бямбын Ринчен. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган”, I боть (монгол хэл бичгийн ухаан)” эмхэтгэлийн 7-28 дугаар тал [900 бүтээл], 2015 онд “Монгол хэл бичиг, өв соёлын тулгамдсан асуудал - III” (академич Б.Ринчений мэндэлсний 110 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал) эмхэтгэлийн 97-131 талд [900 бүтээл] нэмэн дэлгэрүүлж, нийтдээ найман удаа хэвлэн нийтлүүлсэн болно.

Профессор Б.Ринчен монгол судлалын олон салбарыг дэлхий дахинаа хөгжүүлэн бэхжүүлэхэд өөрийн бүтээлч хувь нэмрээ оруулсан бөгөөд түүний нэн идэвхтэй зүтгэл санаачилгаар 1950 хэдэн оны сүүлээс “Монголын судлал”, “Хэл зохиол судлал”, “Аман зохиол судлал”, “Дурсгалт бичгийн чуулган” зэрэг цуврал бичиг тогтмол хэвлэгдэх болсон бөгөөд эдүгээ ОУМСХ-ны эрхлэн гаргадаг “Монголын судлал” цуврал нь 45 дугаар, ШУА-ийн Хэл зохиолн хүрээлэнгийн эрхлэн гаргадаг “Хэл зохиол судлал” цуврал 37 дугаар, “Аман зохиол судлал” цуврал 34 дугаар, “Дурсгалт бичгийн чуулган” цуврал нь 28 дугаар хэвлэгдэн гараад байна.

Академич Б.Ринчен Монгол орны гадаад харилцаа харьцангуй хязгаарлагдмал хэцүү байсан (1959) тэр үед академич Цэндийн Дамдинсүрэн (1908-1986), Шадавын Лувсанвандан (1910-1983), Амгаагийн Лувсандэндэв (1927-1997) нартай хамтран Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурлыг анхлан санаачилж, эх орондоо амжилттай зохион байгуулахад голлох үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэхүү их хурал нь дэлхийн олон орны монголч эрдэмтний байнгын хамтын ажиллагаа, хүчин зүтгэлийг нэгтгэн өгч, олон улсын монголын судлалд нэгэн шинэ үе шатыг нээснээрээ түүхэн ач холбогдолтой билээ.

Монгол хэл бичгийн судлал, монгол ардын аман билиг судлал, монгол угсаатны зүй, монгол сурвалж судлал, монгол утга соёлын өв судлал, монгол бөө мөргөл судлал, монгол орчуулгын онол, намтар судлал тэргүүтэн олон төрлийн нарийн судалгаа шинжилгээ, ажил мэргэжлийг нэгэн биеэр тэгш эзэмшин, туурвиж бүтээхийн ид хав, эгэлгүй эрхэмсэг үлгэр жишээг биеэрээ үлгэрлэн үзүүлсэн Монгол улсын Төрийн шагналтан, эрдэмтэн зохиолч, академич, профессор Эншөөбү овогт Бямбын РИНЧЕН доктор (Sc.D) нь халуун эх оронч, ард түмэндээ чин үнэнч, гуйвшгүй цэх шударга, улс монголоо гэсэн сонин содон чанараараа монгол туургатны хүндэтгэл бишрэлийг татсан, үнэхээрийн билиг танхай, их бичгийн хүмүүн байсан юм. Их эрдэмтэн, академич Эншөөбү овогт Б.Ринчен багштан бол эх орондоо төдийгүй дэлхий дахинаа монгол судлалыг дэлгэрүүлэн хөгжүүлэхэд үлэмжийн их гавьяа байгуулсан [Пүрэвжав, 2005, 84], үеийн үед дуурсагдах агуу их эрдэмтэн мөнөөсөө мөн.

Их эрдэмтэн, академич Б.Ринчен профессорын эрдэм шинжилгээний олон талт бүтээл туурвил нь зөвхөн монголын судлал төдийгүй, алтай судлалын цар хүрээ, төв Азийн олон ард түмний утга соёлын харилцааны түүхнээ онцгой ач холбогдолтой байсныг дотоод гадаадын эрдэмтэд олонтоо тэмдэглэсэн нь буй. Дэлхийн шинжлэх ухааны хөгжилд оруулсан бодит гавьяа зүтгэлийг нь зүй ёсоор үнэлж, 1958 онд Олон улсын Фин-угорын нийгэмлэгийн хүндэт профессор, 1965 онд Олон улсын Алтай судлалын байнгын Бага хурлын алтан медаль, 1970 онд БНУАУ-ын ШУА-ийн хүндэт гишүүн, 1970 онд Польшийн зохиолчдын

нөхөрлөлийн мөнгөн медалиар урамшуулан шагнаж байсан нь түүнийг дэлхийн соёлт хүмүүн төрөлхтөн бодитоор үнэлж байсны илрэл мөн.



Будын РАДНААЖАВ (1874-1921)

Түүний өвөг эцгийн нэрийг Бямбын Буд (1842-1913) гэдэг байсан аж. Түшээт хан аймгийн Буурын голд төрж өссөн, хөх нохой жилтэй Б.Раднаажав (1874-1921) нь Хиагтын хэлмэрчийн сургуульд нэг хэсэг суралцаж байгаад, Богдын хүрээ орж “хичээнгүй сайд” гэж олноо алдаршсан Б.Цэрэндорж (1867-1928) багшаар манж хэл, хятад хэл бичиг заалган, Их хүрээнээ суудаг оросын консул Я.П.Шишмарев (1833-1915)-ын тусламжаар Бээжин хот орж хятад, манж хэл бичгийг тусгайлан оролдож, Хиагтын хязгаарын комиссарын яаманд манж, монгол, хятад хэлний орчуулагч, комиссарын албыг 1899-1915 онд хашиж, Монгол, Орос, Хятад гурван улсын гэрээнд хэлмэрчлэн оролцож, онцгой идэвх зүтгэл гаргасны төлөө “Эрдэнийн очир” одонгоор шагнуулж байсан удаатай.

Хятад хэлний дээд зэрэглэлийн орчуулагч (старший классный переводчик китайского языка) Б.Раднаажав нь буриад, орос хэлнээс гадна монгол, манж, хятад, англи, герман хэлийг зохих хэмжээнд гарамгай эзэмшсэн [Чимитдоржиев, 2004, 111] хэл бичиг судлаач байжээ. Хуучин монгол бичгийн хэл судлаач, монгол хэлний хэл зүй судлаач, монгол орос хоёр хэлний таван толь бичиг туурвин гаргаснаараа олонд алдаршсан юм.

Өргөн хэрэглээний 1600 гаруй толгой үгийг багтаасан “Халх аялгууны орос монгол орчуулагч” гэсэн толийг 1910 онд Троицкосавск хотод хэвлүүлсэн нь тухайн үеийн түүхийн сурвалж, засаг захиргааны тухай үндсэн мэдээллийг агуулснаараа өвөрмөц онцлогтой. Энэхүү толь бичгийг тэр үеийн Монголд ажиллаж байсан оросын худалдаачид, хээрийн шинжилгээний ангийнхан өргөн ашигладаг байжээ.

Нэрт толь зүйч Б.Раднаажав 1913 онд 10000 гаруй толгой үгтэй “Халх аялгууны ярианы хэлний орос монгол толь бичиг”-ийг цөөн хувиар хэвлүүлсэн байна. Уул толь бичиг хэвлэгдэж олны хүртээл болсноос хойш эдүгээ яг 100 жил болжээ. Энэхүү толь бичиг зохиогчийн өмнөх үгэнд монгол хэлний хэл зүйн асуудалд онцгой анхаарлаа хандуулж, үгийн өргөлт, нэр үгийн тоо, хүйс, нэр



үгийн хувилал<sup>1</sup>, төлөөний нэр, үйл үгийн хувилал, хэв, тооны нэр, үгүйсгэх сул үг тэргүүтний талаар товч тодорхой тайлбарласан байна. Тэрбээр “Монгол бичгийн хэл нь ярианы хэлнээсээ нэлээн ялгаатай болж, бичиг үсэг мэдэхгүй монголчууд нь уншиж ойлгоход түвэгтэй болсон. Монголчууд “о” авиаг хоёр янзаар дууддаг. Орос хэлний “слово” хэмээх үгэн дэх “о”-той адил дуудна. Жишээ нь: “Олон” (много) гэсэн үгийн авиа нь “о”, “у”-гийн дундуур холилдсон маягтай дуудагдана. Тухайлбал: “осо” (вода) нь “усо” биш юм. “Соргоули” (училище) гэдэг нь “соргули” биш болно” [Раднаажав, 1913, II] хэмээсэн дүгнэлт гаргасан нь нэн сонирхолтой байна. Б.Раднаажав монгол бичгийн хэлний үгийн бүрэлдэхүүнийг кирил үсэгт хөрвүүлэн буулгах анхны оролдлогыг тодорхой хэмжээнд тогтолцоотой хийж, зохиож хэвлүүлсэн “Халх аялгууны ярианы хэлний орос монгол толь бичиг” бол монгол хэлний түүхэн хөгжил, нэн ялангуяа үгийн сангийн үндсэн бүрэлдэхүүний төлөв байдлыг танин мэдэхэд хэрэглээний ач холбогдолтой толь бичиг мөн гэж үзэж байна. Энэ толь бичгийн “А” толгойт үгээс цөөн хэдэн жишээ дурдсу:

*Абазурь* гырэбчи, сарабчи, хухурь (гэрэвч, саравч, хөхүүр)

*Авангардь* габшигай цэригь (гавшгай цэрэг)

*Аграномія* таряный соргоули (тарианы сургууль)

*Азартная игра* муруйтуй тоглонь (мөрийтэй тоглоом)

*Актерь* си долдагь хунь (ший дулдаг хүн)

*Алмазь* дорчжипалма (доржпалам)

*Амбарь* юмь хоряхо байшинь (юм хураах байшин)

*Анархисть* орбасань хунь (урвасан хүн)

*Анекдоть* аля үгэ (алиа үг)

*Аптека* эмьй пуцзэ (эмийн пүүс)

*Аристократія* сорбальчжитань (сурвалжтан)

*Ариөметика* цзорхай (зурхай)

*Артиллерія* ухырь боу (үхэр буу)

*Архивь* дансо хоряхо гырь (данс хураах гэр)

*Атамань* туру, дарго, атамань (төр, дарга, атаман)

*Аукционь* доудачжи ходалдахо (дуудаж худалдах).

Еншөөбү овогт Б.Раднаажав 1913 онд хэвлэн нийтлүүлсэн “Халх аялгууны ярианы хэлний орос монгол толь бичиг”-ийнхээ хавсралт болгон 1912 оны X сарын 21-ний өдөр Өргөө хотод гарын үсэг зурж баталгаажуулсан Орос, Монгол улсын хоорондын гэрээ зөвшилцөл, хурлын тэмдэглэлийг бүрэн эхээр оруулсан нь манай түүх, нийгэм судлаач нөхдөд чухал хэрэгтэй судлагдахуун болох нь дамжиггүй.

Тэрбээр 1914 онд монгол ярианы хэлний хамгийн өргөн хэрэглээний 4000 толгой үгийг багтаасан “Монгол бичгийн хэлээрх хадмал бүхий халх аялгууны орос монгол товч толь бичиг”-ийг Харбин хотноо нийтлүүлжээ. Энэ бүтээлдээ монгол бичгийн хэлний хэл зүйн зайлшгүй хэрэгцээтэй гол дүрмүүдийг тусган оруулснаараа онцлогтой юм.

Мөн 1915 онд 8000 толгой үг бүхий “Монгол орос толь бичиг” хэмээх бүтээлийг Иркутск хотноо хэвлүүлж, монгол хэлний хэл зүйн дүрэм, зөв бичих дүрмийг тухайлан тайлбарласан байна.

Монгол хэл бичиг судлаач Б.Раднаажавын ууган хөвгүүн Ринчений багынх нь нэрийг Ринчендорж гэдэг байжээ. “Ринчендорж” хэмээсэн нэрийг Хараагийн Дара эхийн хувилгаан лам хайрласан бөгөөд “өөрийн хийддээ лам болгоно” хэмээн айлдсанаар төвөд хэлний цагаан толгой, Итгэл тэргүүтнийг хар багаасаа заалгаж

<sup>1</sup> Монгол хэлийг үндсэн 9 тийн ялгалтай хэмээжээ.



байжээ. Тэрбээр Норов, Дамдинсүрэн гэдэг хоёр эрэгтэй дүүтэй, Эрдэнэ гэдэг охин дүүтэй [Чимитдоржиев, 2005, 5] эцэг эхээс дөрвүүлээ юм. Төрж өссөн “гэр бүл хуучны сэхээтэн албан хаагч бөгөөд бичиг соёлыг эрхэмлэн үздэг, орос хэлийг чадамгай эзэмшсэн, уламжлалт ардын билэг зүйг дээдлэн хүндэтгэдэг байсан нь балчир хүүд нөлөөлсөн” [Цэнд, 2001, 3] нь дамжиггүй билээ.

Академич Б.Ринчений ууган охин Р.Нямаа “Бид гоц авьяастан биш юм аа. Суут хүний дараа байгаль амардаг гэсэн үг бий. Гэвч бид муу улс болоогүй ээ. Аавынхаа өгсөн хүмүүжил, хатуужлын хүчинд бид дажгүй л сэхээтэн болсон. Бид аавынхаа мэргэжлийг өвлөөгүй ч монголоо гэсэн сэтгэл зүтгэлийг нь өвлөж авсан” [БНБР, 1990, 94] хэмээн дурсан бичсэн байдаг бол удаах охин Р.Индра нь “Яагаад аавынхаа мэргэжлийг өвлөж аваагүй юм бэ? гэж биднээс хүн их асуудаг. Үнэндээ гэхэд монгол хэл гэдэг чинь улс төр юм байна гэж ойлгосон. Аав шиг хүн энэ мэргэжлээс болж ингэж зовж байхад бид бол давахгүй гэж бодсон. Тэгээд Ринчений удмыг авч үлдье гэвэл монгол хэл гэдгээс холхон байа гэж шийдсэн юм даа. Аав ч биднийг заавал монгол хэлний мэргэжилтэн болгох гэж зүтгээгүй” [БНБР, 1990, 96] хэмээн хэлсэн байдгийг дурдахад илүүдэх юун.

Доктор, профессор, академич Еншөөбү овогт Бямбын Ринчений ууган охин Р.Нямаа (1923) нь Монгол улсын хүний гавьяат эмч (1983), Анагаах ухааны дээд сургуулийн профессор, нүдний нарийн мэргэшлийн эмчээр олон жил дагнан ажиллаж, “Нүдний өвчин” сурах бичиг, “Нүд эмчлэх арга” зэрэг бүтээл хэвлүүлжээ.

Дунд охин Р.Индра (1928) нь мал зүйч мэргэшилтэй, Монгол улсын гавьяат багш (2007), хөдөө аж ахуйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, монгол цагаан идээ болон хавтгай тэмээ судлаач бөгөөд “Монгол орноо хөдөө аж ахуйг хөгжүүлэх байгалийн нөхцөл” (1974), “Молочная продуктивность, состав и свойства молока различных видов сельскохозяйственных животных, разводимых в МНР” (1983), “Сүү, сүүн бүтээгдэхүүн” (1984), “Тэмээний амьдын жин тодорхойлох арга” (1993), “Хавтгайн байршил, тархалт” (1999), “Монголд хавтгайн хорогдлын шалтгаан” (2000), “Монгол тэмээ” (2003) тэргүүтэн эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлсэн байна.

Бага охин Р.Шанзаа (1933-1999) нь ЗХУ-д дээд сургууль төгссөнийхөө дараа Мажар улс дахь Монгол улсын элчин сайдын яаманд орчуулагчаар ажиллаж байв.

Хүү Р.Барсболд (1935) нь палеонтологийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, Монгол улсын ШУА-ийн академич (1991), АНУ-ын Нью-Йоркийн академийн жинхэнэ гишүүн, ОХУ-ын Хүндэтгэлийн одон (2013) хүртжээ. Академич Р.Барсболд бол Монголын болон Төв Азийн үлэг гүрвэлүүдийн судалгаагаар газрын цээжинд өнгөлөн торойн гарсан их эрдэмтний нэг мөн бөгөөд “Биостратиграфия и пресноводные моллюски верхнего мела Гобийской части МНР” (1972), “A New Dinosaur, Gallimimusbullatusn. gen., n. sp. (Ornithomimidae) from the Upper Cretaceous of Mongolia” (1972), “Хищные Динозавры Мела Монголии” (1983), “The Dinosauria” (1990), “Encyclopedia of Dinosaurs” (1997), “Fighting Dinosaurs: They really fought - First Intern. Meeting on Dinosaur Paleobiology, Museum Nacional de Historia Natural” (1998), “The skull of Velociraptor (Theropoda) from the Late Cretaceous of Mongolia” (1999), “The Age of Dinosaurs in Russia and Mongolia” (2000), “Non-marine Lower Cretaceous of Mongolia and Necessity of Dinosaur Hunting” (2007), “History of Oviraptors: From an Egg-thief to Big Mama and the Flightless Bird” (2009), “Эртний үлэг гүрвэлүүд. Палеонтологи” (2011), “Палеонтологи. Монгол орны эртний ургамал амьтны ангилал, морфологи, таксономи, нас, тархалт” (2011) тэргүүтэн судалгааны бүтээл туурвижээ.



Ринчений БАРСБОЛД

Еншөөбү овогт Ринчений Барсболд 1935 онд Улаанбаатар хотод төрж, 1959 онд ЗХУ-ын Москва хотын Геологи, хайгуулын дээд сургуулийг төгсчээ. Тэрбээр 1969 онд Ленинград хотноо “БНМАУ-ын говийн нутаг дэвсгэрээр тархсан дээд цэрдийн хурдсын давхарга зүй болон зөөлөн биетэн” сэдвээр дэд эрдэмтний зэрэг, 1979 онд Улаанбаатар хотноо “Монгол орны цэрд галавын махан идэшт үлэг гүрвэлүүд” сэдвээр палеонтологийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалжээ.

Палеонтологийн шинжлэх ухааны доктор Р.Барсболд 1959-1961 онд Геологи, шинжилгээний удирдах газрын алтны хайгуул, зураглалын ангийн инженерээр хөдөлмөрийн их гараагаа эхэлж, 1961 онд МУИС-ийн геологийн тэнхимийн эрхлэгчээр томилогдож, 1965-1966 онд ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Палеонтологийн тасгийн эрдэм шинжилгээний ажилтан, 1967-1988 онд ШУА-ийн Геологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, 1988-1997 онд Геологийн хүрээлэнгийн захирал, 1997 оноос ШУА-ийн Палеонтологийн төвийн захирлаар үр бүтээлтэй ажиллаж байна. Тэрбээр 1993 оноос Монгол-Оросын найрамдлын нийгэмлэг, 1994 оноос Дэлхийн үлэг гүрвэл судлаачдын нийгэмлэгийн гишүүнээр сонгогдон идэвхтэй ажиллаж байгаа билээ.

Профессор Р.Барсболдын хөдөлмөр зүтгэлийг төр засгаас өндрөөр үнэлж, 1971 онд Хөдөлмөрийн хүндэт медаль, 1991 онд ШУА-ийн жинхэнэ гишүүн (академич), 1997 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, 2002 онд Засгийн газрын хүндэт өргөмжлөл, 2005 оны VI сард Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээжээ. Монголын болон Төв Азийн үлэг гүрвэлийн судалгаанд академич Р.Барсболд докторын оруулсан хувь нэмрийг үнэлж, АНУ-д төвтэй олон улсын сээр нуруутны палеонтологийн нийгэмлэгээс мэргэжлийн дээд шагнал А.Ромер-Ж.Симпсоны нэрэмжит медалиар шагнажээ.

Монголын шинжлэх ухааны хөгжил дэвшилд академич Р.Барсболдын оруулсан гол хувь нэмэр, нээлт гэвэл: Монголын махан идэшт үлэг гүрвэлийн бүтэц зүйн урьд нь шинжлэх ухаанд мэдэгдэж байгаагүй шинжүүдийг анхлан ялган тогтоож, тус аймгийн ангиллыг шинэчлэн тогтоож, дэлхийд тархсан анги бүлгүүдтэй нь жишиж, Монголын үлэг гүрвэлүүдийн эзэлж байсан байр суурь, түүхэн хөгжлийн

зүй тогтлыг улс орныхоо шинэ олдворуудын судалгаагаар батлан харуулсан [ШУА, 2011, 107] юм. Монголын махан идэшт үлэг гүрвэлүүдийн ангиллын жагсаалтыг ихээхэн өргөжүүлж, шинжлэх ухаанд 20 орчим шинэ нэгж төрөл, анги бүлгүүдийг санаачлан дэвшүүлж, Монголын олдворуудыг голлон түшиглэж, Умард Америк, Ази тивд тархалттай Oviraptorosauria, Ornithomimosauria гэж нэрлэсэн томоохон анги бүлгүүдийг нэгтгэн тогтоож, олон улсын ангиллын ерөнхий тогтолцоонд тусган оруулж чаджээ. Үлэг гүрвэлүүдийн улиран хувьслын зүй тогтол, тив хоорондын харилцаа холбоо, дэлхийн шинжлэх ухаанд дөнгөж л судлагдаж эхэлсэн төдий үлэг гүрвэлийн биологийн асуудлыг Монголын ховор олдворуудын үндсэн дээр судлан тайлбарлаж, үлэг гүрвэлүүдийн олдворын чулуужилтаар хадгалагдах боломжгүй зан үйлийн шинжүүдийг тодорхойлон босгох зам нээгдэж байгааг харуулж өгсөнд оршино.

Удам дамжсан нэрт эрдэмтэн, монгол хэл бичиг судлаач Еншөөбү овогт Б.Раднаажав (1874-1921), монгол хэл шинжлэлийн шинжлэх ухааны ууган доктор (Sc.D), профессор, гарамгай дуун хөрвүүлэгч, эрдэмтэн зохиолч, академич Б.Ринчен (1905-1977), палеонтологийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, академич Р.Барсболд (1935) нар болон тэдний үр хүүхдүүд нь эх орондоо үндэсний монгол судлалыг үүсгэн хөгжүүлж, монгол туургатны хэл бичиг, утга соёлын хосгүй нандин өв дурсгалыг дэлхий дахинаа таниулан сурталчлахад хүндтэй гавьяа байгуулсныг онцлон тэмдэглэе.

#### АШИГЛАСАН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. [БНБР, 1990] – Билгүүн номч Бямбын Ринчен (эмхэтгэж эрхэлсэн Г.Аким). -Уб., 1990. 238 х
2. [Пүрэвжав, 1997] – Э.Пүрэвжав. Монгол хэл бичгийн судлал (нэг) [редактор Х.Сампилдэндэв]. -Уб., 1997. 134 х
3. [Пүрэвжав, 2005] – Э.Пүрэвжав. Их эрдэмтэн, академич Бямбын Ринчен. -Уб., 2005. 152 х
4. [Пүрэвжав, 2005, а] – Э.Пүрэвжав. Монголын түүхэн сурвалж судлалд академич Б.Ринчений оруулсан хувь нэмэр. –“ШУА-ийн мэдээ” сэтгүүл, № 3 (177). -Уб., 2005. х.60-63
5. [Пүрэвжав, 2005, б] – Э.Пүрэвжав. Академич Б.Ринчений нэгэн захидал. –“Өнөөдөр” сонин, № 117 (2466). 2005.V.18
6. [Раднаажав, 1913] – Р.Бимбаевъ. Русско-Монгольский словарь разговорнаго языка на халхасскомъ наръчии. -Троицкосавскъ., 1913. XII + 424 + 05 стр
7. [Раднаажав, 1914] – Р.Бимбаевъ. Краткій Русско-Монгольскій словарь халхасскаго наръчия съ монгольской азбукой и необходимыми грамматическими правилами. -Харбинь., 1914. XXIII + 127 + III стр
8. [Цэнд, 2001] – Д.Цэнд. Бямбын Ринчен (намтар, уран бүтээл) [“XX зууны монгол зохиолчид” цувралын 66 дугаар дэвтэр]. -Уб., 2001. 47 х
9. [Чимитдоржиев, 2004] – Ш.Б.Чимитдоржиев. Кто мы – бурят-монголы. -Улан-Удэ., 2004. 129 стр
10. [Чимитдоржиев, 2005] – Ш.Б.Чимитдоржиев. Академик Бямбын Ринчен – выдающийся ученый и писатель (1905-1977). -Улан-Удэ., 2005. 96 стр
11. [ШУА, 2011] – Монгол улсын Шинжлэх ухааны академийн гишүүд (эмхэтгэсэн М.Чимэдлхам, Б.Амарзаяа, Ц.Энхжаргал). -Уб., 2011. 310 х

**Монгол төрөл хэлнүүд дэх үйлээс нэр бүтээх \*-gur<sup>2</sup> дагаврын тухай  
\*ШИОТАНИ Шигэки**

The Deverbal Nominal Suffix \*-gur<sup>2</sup> in the Mongolic Languages

SHIOTANI Shigeki

[Summary]

Some of the Mongolic languages have a unique deverbal nominal suffix \*-gur<sup>2</sup> which denotes “ have a habit or a tendency to do something ”.

The author analyzes in detail the origin and the development of the suffix from a diachronic viewpoint, and insists that the dialectal distribution of the suffix coincides with the dialectal classification of the Mongolic languages proposed by Sh. SHIOTANI (2014).

[Түлхүүр үг]

монгол төрөл хэлнүүд; үйлээс нэр бүтээх дагавар; дур сонирхол, дадал заншил

**1. Эхлэл**

Би энэ өгүүлэлдээ монгол төрөл хэлнүүд дэх «тухайн үйлийг үйлдэх дур сонирхолтой, заншилтай» гэсэн утга санааг илэрхийлэх үйлээс нэр (тэмдэг нэр ч багтана) бүтээх \*-gur<sup>2</sup> дагаврын гарал үүсэл, хувирал хөгжил болон өвөрмөц онцлогийнх нь талаар дурдахын зэрэгцээ энэ дагаврын тархац нь Ш.Шиотанигийн дэвшүүлсэн монгол төрөл хэл аялгуунуудын ангилал (2014)-ыг огтхон ч зөрчөөгүй гэдгийг ч бас дурдаж болмоор байна.

**2. Хятад дахь монгол төрөл салангид хэлнүүдийн \*-gur<sup>2</sup> дагаврын байдал**

Монгол төрөл хэлнүүдийн дотор Хятадын Ганьсу, Цинхай мужийн салангид хэлнүүдэд хамаарагддаг Баоан, Канжаа, Дуншаан, Монгор зэрэг дөрвөн хэлэнд үйлээс нэр (тэмдэг нэр ч багтана) бүтээх өвөрмөц дагавар байгаа бөгөөд энэ нь зарим үйл үгийн үндсэнд залгагдаж, «тухайн үйлийг үйлдэх дур сонирхолтой, заншилтай» гэсэн утгыг илэрхийлнэ. Харин ч Зүүн ёгор, Дагуур хоёр хэлэнд энэхүү дагавар ер харагдахгүй байна.

Энд Баоан, Канжаа, Дуншаан, Монгор хэлний энэхүү дагавар болон жишээнүүдийг нь үзүүлбэл доорх мэт :

Баоан : -Gөг

Канжаа : -Guar

Дуншаан : -бу

Монгор : -gurtə ~ -gərcdzə

Жишээ нь :

Баоан : ajiGər 《胆小的 “аймхай”》 (< aji- 《害怕 “ай-”》 )  
la:Gər 《愛哭的 “уйланхай”》 (< la:- 《哭 “уйл-”》 )  
ceGər 《愛尿炕的 “шээрэн”》 (< ce- 《撒尿 “шээ-”》 )  
jiχteeGər 《愛打架的 “зодоонч”》  
 (< jiχtee- 《打架、互相打 “зодолд-”》 )

Канжаа : ajiGuar 《胆小的、怕死鬼 “аймхай”》 (< aji- 《害怕 “ай-”》 )  
ilaGuar 《愛哭鼻子的人 “уйланхай”》 (< ila- 《哭 “уйл-”》 )  
᠑iniGuar 《愛笑的 “инээмтгий”》 (< ᠑ine- 《笑 “инээ-”》 )

Дуншаан : ajiχu 《胆小鬼 “аймхай”》 (< aji- 《怕 “ай-”》 )  
uilaχu 《愛哭的 “уйланхай”》 (< uila- 《哭 “уйл-”》 )  
᠑idzəχu 《怕羞的 “ичимхий”》 (< ᠑idzə- 《羞 “ич-”》 )  
hət᠑əχu 《没勁的人 “эцэнхий (→ хүчгүй)”》  
 (< hət᠑ə- 《乏 “эц- (→ ядар-)”》 )

Монгор : la:Gurtə ~ ula:Gərcdzə 《愛哭的 “уйланхай”》  
 (< la:- ~ ula:- 《哭“уйл-”》 )

Дээр дурдсан Баоан -Gər, Канжаа -Guar, Дуншаан -χu, Монгор -Gurtə ~ -Gərcdzə гэдэг үйлээс нэр бүтээх дөрвөн дагавар нь цөм гарал нэгтэй байгаа бөгөөд харьцуулсан хэл шинжлэлийн аргаар эдгээр хэлбэрээс эртний нийтлэг хэлбэрийг нь **\*-gur<sup>2</sup>** гэж таамаглаж болно.

Монгор хэлний -Gurtə ~ -Gərcdzə дагавар нь **\*-gur + či** гэсэн нийлмэл дагавраас бүтсэн нь лавтай бөгөөд нэрээс нэр бүтээх **-či<sup>1)</sup>** дагавар залгадаг онцлогоороо Монгор хэл нь бусад Баоан, Канжаа, Дуншаан зэрэг гурван хэлнээс ялгаатай юм.

Энэхүү дагаврын гарал үүслийн тухайд бол урьд нь зарим монголч эрдэмтэн<sup>2)</sup> Баоан, Дуншаан хэлний нийтлэг дагавар гэж үзсэн боловч энэ нь монгол бичгийн хэл болон орчин цагийн монгол хэлний чухам ямар дагавартай гарал нэгтэй болохыг нь өдий хүртэл хэн ч дурдаагүй байгаа.

### 3. Монгол төв хэл аялгуун дахь **\*-gur<sup>2</sup>** дагаврын байдал

Дундад зууны монгол хэлний байдлыг илэрхийлдэг “Монголын Нууц Товчоо”, “Мукаддимат ал-Адаб” зэрэг сурвалж бичигт энэ дагаврын ул мөр огт харагдахгүй байна. Энэ байдлаас үзэхэд дундад зууны монгол хэлэнд энэхүү дагавар нь огт байхгүй байсан юм уу, аль эсвэл бараг хэрэглэгдээгүй байсан байж тун магадгүй. Харин дээр таамагласан **\*-gur<sup>2</sup>** хэлбэр, илэрхийлэх утга хоёрыг нь харгалзан үзвэл монгол бичгийн хэл (Мо.) болон орчин цагийн монгол хэлэнд үйлээс нэр бүтээх Мо.-уур, -gür (-уур, -үүр) дагавар бий бөгөөд үүнтэй гарал нэгтэй байсан болов уу гэж үзэж байна.

Мо.-уур, -gür (-уур, -үүр)<sup>3)</sup> дагавар нь монгол бичгийн хэл болон орчин цагийн монгол хэлэнд зарим үйл үгийн үндсэнд залгагдаж, «тухайн үйлийг олон дахин үйлдэх байдалтай» буюу «тухайн үйлийг үйлдэх заншилтай» гэсэн утга санааг илэрхийлэх нэр үг (тэмдэг нэр ч багтана) үүсгэнэ.

Жишээ нь :

Мо. kinaуур (хянуур) «careful, cautious»

( < kina- (хянах) «to check, to examine» )

Мо. doliуанауур (долигонуур) «flattering, sycophantic»

( < doliуana- (долигонох) «to flatter» )

Мо. angуалжауур (ангалзуур) «open-mouthed»

e.g. ангалзуур хүүхэн «a talkative woman»

( < angуалja- (ангалзах) «to open one’s mouth repeatedly» )

Энэхүү дагавар нь Монгол хэлний Халх, Өвөр монголын аялгуунаас гадна, Халимаг, Буриад хэл зэрэг Монгол төв хэл аялгуунд бүгд харагдаж байгааг дашрамд дурдъя.

#### 4. Хоёр эгшгийн хоорондох **\*-g-** гийгүүлэгчийн асуудал

Дээр Хятадын монгол төрөл салангид хэлнүүд дэх **\*-gur<sup>2</sup>** (>-gur) дагаврыг Монгол төв хэл аялгуун дахь **\*-gur<sup>2</sup>** (>-уур) дагавартай гарал нэгтэй байх гэж үзсэнтэй холбогдуулан авиа зүйн талаар нэг юмыг тодруулах хэрэгтэй байна.

“Хэл сурах авьяастай хүн гэж байдаг”, “Монгол хүн гадаад хэл сурахдаа сайн”, “Эмэгтэй хүүхэд хэл сурахдаа хурдан” гэх мэт үндэслэлгүй яриа байдаг бөгөөд энэ талаар гадаад оюутнууд ямар бодолтой байдгийг харъя. Тэдний үзсэнээр, гадаад хэл \монгол хэл\-ийг эрт сурах тусмаа сайн бөгөөд төрөлхийн хэл сурах авьяастай хүн байдаг, түүнчлэн аль нэг гадаад хэлийг эзэмшсэн хүний хувьд дахин гадаад хэлийг сурах нь амархан байдаг ажээ. Дийлэнх оюутнууд өөрийн гадаад хэл сурах чадварт итгэлтэй байгаа ба хэл сурах чадварт хүйсийн ялгаа огт хамаагүй гэж үзсэн байна. Түүнчлэн тоо болон байгалийн ухааны хичээлдээ сайн хүн гадаад хэл сурахдаа ч сайн гэдэгтэй санал нийлэхгүй, хэн ч гадаад хэл сурч чадна гэж үзэж байгаа бөгөөд сонирхолтой нь монголчууд биднийг гадаад хэл сурахдаа маш сайн гэж дүгнэсэн байна.


2. Хэлний сургалтын онцлог (Асуулт 8, 11, 16, 20, 25, 26)





Энэ хэсэгт нь монгол хэл сурах гадаад оюутнуудын арга барилтай холбоо бүхий асуултууд багтсан бөгөөд тэдний дийлэнх нь гадаад хэлийг тухайн улсад нь очиж сурах нь дээр гэж үзээд монгол хэлийг сайн сурахын тулд монгол соёлыг мэдэх нь зайлшгүй шаардлагатай зүйл гэж үзсэн байна. Улмаар монгол хэл сурахад үгийн баялаг нэн чухал буюу үгээ сайн чээжлэх хэрэгтэй гэж үзэн, цэгцтэй дүрмийн мэдлэг болоод монгол хэлнээс орчуулга хийх, эхийг унших, хуулан бичихийн чухлыг ч дурдсан байна.

### 3. Харилцааны болоод сурах арга барил (Асуулт 7, 9, 12, 13, 17, 18, 19, 21)




Өөр нэг сонирхолтой зүйл нь оюутнуудын 80 орчим хувь нь монгол хэлийг зөв цэвэр дуудах нь чухал гэж үзсэн байна. Түүнчлэн монгол хэл сурахад дасгал ажлыг сайн давтан хийх нь монгол хэл сайн сурахын үндэс гэж үзжээ. Мөн сайн ярьж чадахгүй байсан ч аль болох монгол хүнтэй ярихыг хичээх, үзсэн үг хэллэгээ санахгүй байсан ч алдахаас айлгүй харилцах нь чухал гэж үзсэн байна. Ерөөс хэлний харилцаанд холбогдох чухал зүйл бол үгэн бус харилцаа байдаг бөгөөд өгүүлэгчийн гадаад байдал, нүүр царайны хөдөлгөөн, хувирал, дохио зангаа, дуу хоолойны өөрчлөлт зэрэг нь нэмэлт учир холбогдолтой ба хэлний харилцааг дагалдан түүнийг утга төгөлдөр болгоход тус дэм болохын зэрэгцээ зарим үед түүнээс ч илүү баялаг багтаамжтай мэдээллийг хамгийн ойлгомжтой, товч илэрхийлэх нь буй<sup>5</sup>. Ийм үгэн бус харилцааны бүх хэв маяг нь хэл судлал, хэл-орон судлал, олон улсын харилцаа зэрэг янз бүрийн салбарт нэн чухал учир холбогдолтой байдаг нь энэхүү гадаад оюутнуудын судалгаанаас ч харагдаж байна.

<sup>5</sup> Мөнх-Амгалан Ю. (1999) Монгол хүний дохионы хэлийг ангилал тухай асуудалд. ЭШБ.ОИС. №2.49-64 дэх тал.

#### 4. Суралцагчдын идэвх сонирхол болон хүлээлт (Асуулт 23, 27, 30, 31)

Зураг 7



Дээр үзүүлсэн зураг 7 бол оюутнуудын идэвх сонирхол, хүлээлттэй холбоотой хэсэг. Хариултаас үзвэл суралцагчдын маань дийлэнх нь тун өөдрөг хүлээлттэй буюу монгол хэлийг сайн эзэмших нь ажил албанд (тухайлбал төрийн алба, цалин өндөртэй ажил) орох боломж, монгол хэлээр дамжуулан танилын хүрээгээ тэлж, олон талын мэдлэг авах боломжийг олгоно гэж үзээд зогсохгүй монголчуудаас илүү монгол хэлийг сурах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Бидний хийсэн дээрх судалгааг нэгтгэн дүгнэвэл, монгол хэл сурч буй гадаад оюутны хувьд алдаагүй ярих нь тийм ч чухал биш харин монгол хэл сурахад дүрмийн мэдлэг, баялаг үгийн сантай байх нь хамгийн чухал агаад монгол хэлээр дамжуулан олон хүнтэй танилцаж, нөхөрлөн монгол хэл, соёлтой гүнзгий танилцах хүсэл эрмэлзэлтэй байдгийг харж болох байна.

Энэхүү судалгаандаа бид зөвхөн хэлний бэлтгэл ангид монгол хэл сурч буй гадаадын 11 орны 53 оюутныг хамруулсан бөгөөд оюутнуудын монгол хэл сурахтай холбоотой үзэл бодол, итгэл үнэмшлийн талаар ойлголт авч, цаашдын хичээлдээ бага ч болов судалгааны үр дүнг тусган, илүү сайн сурах орчинг бүрдүүлэхийг зорих болно.

#### НОМ ЗҮЙ

1. Бат-Ирээдүй Ж. “Гадаад хүнд монгол хэлний үгийн сан, утгын хичээл заах аргын асуудалд”, МХСС, МС, 2007, №27(285), 154-159.
2. Мөнх-Амгалан Ю. “Монгол хүний дохионы хэлийг ангилах тухай асуудалд”, ОИС-ийн ЭШБ №2, 49-64
3. Horwitz, K. E. (1985). “Using student beliefs about language learning and teaching in the foreign language methods course.” *Foreign Language Annals*, 18, (4), 333-340.
4. Horwitz, K. E. (1997). Surveying student beliefs about language learning. In

- A. Wenden & J. Rubin (Eds.), *Learner strategies in language learning* (pp. 119-129). Englewood Cliffs, NJ: Prentice Hall.
5. Kern, G. R. (1995). "Students' and teachers' beliefs about language learning." *Language Annals*, 28, (1), 71-92.
  6. Lightbown, M. P. and Spada, N. (1999). *How languages are learned* (p59). Revised Ed. Oxford University Press. Oxford.
  7. Mori, Y. (1999) "Epistemological beliefs and language learning beliefs: what do language learners believe about their learning?" *Language Learning* 49, (3), 377-415.
  8. Oxford, L. R. (2001). *Language learning styles and strategies*. In M.Celce-murcia (Ed.), *Teaching English as a second or foreign language* (pp. 359-366). Heinle & Heinle.
  9. *The Cambridge Dictionary of philosophy*. Cambridge university press,1999.p 56-57

### **ABSTRACT**

#### **Student's Beliefs about Mongolian Language Learning**

From surveys of foreign learners at National University of Mongolia

With a purpose to investigate the nature of the language learning beliefs of the foreign students, we have made a survey from the Mongolian language learners at the National University of Mongolia, using Horwitz's BALLI (Beliefs about Language Learning Inventory).

It has provided the following findings. First, they want to put the communication skills through the mongolian language. Second, it is important to speak the mongolian language with an excellent accent for the students. Third, the significance of learning Mongolian language is mostly based on the grammar and new words for them. Fourth, it is important to repeat and practice a lot of mongolian expressions. Fifth, it was found that many of them want to know the Mongolain culture.

Keywords: language learning beliefs, foreign learners, mongolian language learning strategy

МОНГОЛ ХЭЛНИЙ “ХАР” ХЭМЭЭХ ҮГИЙН  
САЛАА УТГЫН ОНЦЛОГ

М.Базаррагчаа  
Ч.Бямбаханд  
/МУИС/

Монгол хэлний “хар” хэмээх өнгө заасан тэмдгийн нэр нь бусад тэмдгийн нэрээс утга агуулгын хувьд өргөн дэлгэр бөгөөд нэлээд өвөрмөц онцлогтой юм. Жишээлбэл, Б.Ренчин гуай “хар хүн” гэх үгийн эртний утга нь эмэгтэй хүн, эр нөхрөө нэрлэдэг болохыг тэмдэглэж, монгол зарим аймгийн гэрлэх ёсны байдлыг гэрчлэх сонин нэр томьёо<sup>1</sup> юм гэжээ. Үүнчлэн монгол хэлний “хар” хэмээх үг бусад үгстэй холбогдон элдэв хэлц утга үүсгэдгийг дараах байдлаар ялгаж болмоор байна. “хар” гэсэн өнгө заасан тэмдгийн нэр нь өнгө өнгөтэйгээ хольцолдох, өнгө заасан үг өөр бусад үгтэй хольцолдох гэсэн эсрэг тэсрэг хоёр утгаар ялгарч байна. Тухайлбал,

I. Зэрэгцээ харьцаа бүхий үгийн санжсан буюу хэвшмэл хэлц холбоо үг  
1.а.

хар { хөх  
ногоон  
бор  
хүрэн  
саарал  
хээр  
бараан  
буурал  
эрээн  
халиун  
халгар  
тарлан  
цоохор

гэх мэтээр хоршоо үг бүтээж өнгө хольцолдсон утга үүсгэх ба “бор хар, бараан хар” гэгчлэн тонгоргож болно. Жишээ нь:

-Хүрэн царайтай том гэгчийн нуруутай тангадын мэхийн ёсолж, дээшээ сууна уу гэж гарын алга өөд харуулан сандлын зүг заасанд хариу ёсолж тана шигтгэсэн сийлмэл түшлэгтэй *хар хүрэн* суман модон сандал дээр суужээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тогоо эмгэн, хүн болсоор ер сайд хүнийг үзээгүйн дээр, хүргэн охин хоёрын сандран тэвдсэнд сэтгэл зовниж, Сувдын хойноос дагалдан гарваас, машин,

<sup>1</sup> Б.Ринчен, “Монгол бичгийн хэлний зүй”, дөтгөөр дэвтэр, дэд, өгүүлбэр зүй, Уб, 1967, 58-р т.

сургуулийн том хашааны төв дундад хүрээд зогсож, жолоочийн хажууд сууж байсан, *хар ногоон* дээлтэй, итали гоёмсог бүрх малгайтай хүн угтсаар айсуу хэдэн хүнийг хараад инээмсэглэв. (Б.Р “Үүрийн туяа”)

-Наран шингэх үес хоньчин, ам муруйн ярвайж үхсэн, зүс царайн үзэшгүй муухай хөхрөн *харласан*, бадарчийн хүүр, хээр хэвтэж байсныг олж ихэд айжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Хоёр дахь тэмээ Доржийн анх удаа аянд явж байгаа дөрвөн настай цагаан тайлаг байв. Тэр амьтан эгээ л хүүхэд шиг үе мөчөө атируулан, бяцхан цагаан толгойгоо угжгар бөхөндөө тулган, хажуулдан хэвтэнэ. Цэвэрхэн бор туулай хамраас нь *хүрэн хар цус* гарснаас нь Хүрэл зүрх нь хагарч гэж мэдэв. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

**1.6.** “хар гурил, хар байван, хар талх, хар тугалга, хар хусам, хар бурам, хар тогоруу, хар сойр, хар будаа, хар зээргэнэ, хар гүйлс, хар галуу, хар хэрээ, хар балчиргана” гэх зэргээр “хар” хэмээх тэмдгийн нэр нь шууд утгаар угсран орж, хэвшмэл нийлмэл үг бүтээсэн нь ихэвчлэн нэр томьёо бүтээдэг ажээ.

Мөн хоршсон тэмдгийн нэр нь тус тус бие даасан юмыг заасан байвал, өнгө хольцолдох гэсэн утгагүй байдаг.

Жишээ нь: *Шар хар лам*, түшмэдийн дунд ч амбаны гар хөл болсон хүн бий юм гэнэ билээ. (Б.Р “Үүрийн туяа”) гэхэд “шар хар” нь “шар лам, хар түшмэл” (феодал) гэсэн салангид утгатай тэмдгийн нэр болно. Мөн нэг юмын доторх хоёр өөр өнгө зэрэгцэн орсон нь буй. Жишээ нь: хөх торгон даалин дээлтэй, хар цагаан хурган чихтэй, хөх цэмбэн малгайтай, гялалзсан булигаар шинэ гуталтай цэрэг их л гоё сайхан үзэгдэж, хүн шүү хувцас өмссөндөө урамшингаа жагсаал сургуулиа тэр өглөө бузгай хийжээ. (Б.Р “Үүрийн туяа”), хар араа (малын ус өвс, эрдэс тэжээлд фтор илүүдэж, араа үүдэн шүд, хар бор өнгийн толботой болж харлах, малын эрдэс солилцооны өвчин) (Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь-д (2008) хар арьстан (африк тивд амьдардаг хүмүүс), хар байван (нэгэн зүйлийн хужир), хар гурил (хөх тарианы гулр), хар гэр (ядуу бор гэр), хар дэл (дэл гэдэг ургамлын үрийн харыг хэлнэ), хар талх (хөх тарианы гурилаар хийсэн талх), хар тос (олсны үрийг шахаж авсан тос), хар тугалга (хорголж, зөөлөн бөгөөд хүнд хөхөвтөр өнгийн төмөрлөг), хар хас (бараан хар өнгөтэй нэгэн зүйлийн хас чулуу), хар хусам (түлэгдэж харласан хусам), хар хөрс (тариалан тарихад тохиромжтой үржил шим бүхий бор хөрс), хар шороо (хар хөрсний шороо), хар нүд (хүний хүүхэн хараа цэцгий), хар саарь (хар сарьс), хар сарьс (битүү туурайтны хондлойн арьсаар элдэж хийсэн илэг), хар цагаан (эсрэг тэсрэг хоёр өнгө), хар амар (амар загастай адил бөгөөд хөх гэрэлтэй нэг зүйл загас, мах сайнгүй, зохимж муутай цөсөөр нь нүдний өвчин засна), хар галуу (бие хар, хошуу матаастай хэрээнээс томхон, нэгэн зүйл шувуу), хар голио (үнсэн өнгөтэй болоод харавтар, жигүүргүй хэвэл том түрс орхихгүй хэвлээсээ хорхой гаргадаг голой), хар гургуул (хэлбэр гургуултай адил бөгөөд бараан өнгөтэй шувуу), хар дэлэнч (нэг зүйлийн жижигхэн ялаа, төрөл зүйл олон), хар нүдэн (начин шувууны адил бөгөөд бяцхан нэгэн зүйл махчин шувуу), хар өрөв (бие цагаан, омруу чандар харавтар өнгө) хар сойр (сойр шувууны нэг зүйл), хар тогоруу (тогоруу шувууны нэг зүйл), хар үнэг (цагаан сортой, хар үстэй үнэг), хар хайга (өргөн хавтгай хэлбэртэй нэгэн зүйл загас), хар хөхөө (толгой нуруу бараавтархан, сүүлэндээ цагаан чандартай, охор хөлтэй тавгийн өмнө хойноо хошоод хуруутай нэг зүйл шувуу), хар хул (барс шиг бидэртэй, таван хумстай, өргөн цагаан нүүртэй нэгэн зүйл араатан амьтан, гавшгай бөгөөд догшин), хар хулан (янз үнэгтэй адил болоод хар, үхрийн толгой шиг толгойтой, ганц эвэртэй, жил удвал

хайрс ургадаг, сүрхий махчин араатан амьтан), хар агар (цайвар хөхөвтөр өнгөтэй, сайхан үнэртэй мод), хар балчиргана (агширганы өөр нэр), хар будаа (хар хальстай жижиг шар будаа, зэрлэг таримал хоёр зүйл байдаг), хар бурам (чихрийн ургамлын чихрийг боловсруулан аваад, үлдсэн шаарыг хорхоглон өтгөрүүлж хийсэн нэгэн зүйл чихэрлэг, идээ, зэрлэг ургасан зэгс, хулсны түрүүнээс гарах нь бий), хар гүйлс (модноос ургадаг түүхий үедээ ногоон, боловсормогц шаравтар өнгөтэй болно. Утаагаар утвал харавтар өнгөтэй болно. Маш исгэлэн амттай нэг зүйл жимс), хар даль (далийн төрлийн ургамал, гол төлөв ягаан цэцэгтэй анхилам үнэртэй шөвгөр уртлаг навчтай мөнх ногоон жижиг мод), хар зээргэнэ (морин зээргэнийн өөр нэр, навчгүй нэгэн зүйл сөөг), хар маалинга (халтсны өнгө хар нэг зүйл маалинга), хар майлс (илжгэн чих, хурмагийн мод), хар мөөг (доторх салбан нь хатахдаа хар болдог дэлбэгэр мөөг), хар нэрс (нэгэн зүйл жимсгэнэ), хар хамаг, хар хамхаг, хармаг (элсэрхэг улингар газарт ургах бутархаг өвс), хар хус (хөхөвтөр өнгийн арзгар үйс, зузаан навч нягт ширхэгтэй тураг мод), хар хэрээ (нэгэн зүйлийн бараан шувуу, нэгэн зүйл махчин шувуу, урт нь 64-66 см, хүйтэн сэрүүн газар түгээмэл байдаг, ямагт хоёроороо явна, хавар эрт модны оройд өндөглөнө), хар чийр (гондийн нэг зүйл), хар шаваг (шавгийн төрлийн нэг зүйл бут), хар шарилж (шарилжны төрлийн нэг зүйл), хар нүх (хэдэн сая нарны масс нэг цэгт хуримтлагдах үед бий болдог физикийн гайхамшигтай огторгуйн биет), хар цай (нэгэн зүйл цай, шахмал задгай хоёр зүйл бий), хар нүд (хүний хүүхэн хараа цэцгий) гэх мэт.

-Аян хийсэн олон жуулчин, *Хар балгасанд* бууж, сүрлэг байдалт эртний тэр эвдэрхий балгасны орчин тойрон хүн амьтангүй, эзгүй газар, шингэх нарны гэрэлд адуу тэмээ, орос монгол хүн бужигнан, аравдугаар зуунаас нааш тийм их олон хүний хөлтэй хөдөлгөөнийг үзээгүй, Уйгарын эртний тэр хотын эвдэрхий хэрэм балгасанд хүн амьтны дуун цуурайтаж, адуу унгалдах, тэмээ буйлах, орос монгол үг хэлэлцэх чимээ сонсогджээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тэмээний доогуур *хар хар юмс* бүртэгнэн гүйхийг үзлээ. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Гадаа үүр цайсан болов уу гэлтэй байвч нэвсэрсэн *хар уул* тэнгэрийг битүү бүрхэн шөнө мэт байгаа бөгөөд хашаа дүүрэн гамин байгаа нь л тодхон үзэгдэнэ. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Хэл буруутны гарт иймэрхүү явж байхад бас эндхийн лус савдаг мөн уурлан хилэгнэх мэт том ширхэгт цасыг зай завсаргүй хаялж эхэлнэ. Одоо бол халх оронд тэсгим жаварт дүн өвлийн цаг сан. Гэтэл энд тийм биш, орсон цас газарт буухтайгаа зэрэг хайлан нунтаг *хар шороог* лагалдуулна. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Өөх тос, элгэн цагаан идээ, болсон түүхий будаа, гурил бөгөөд түүнээ гагцхүү өвөр лүүгээ чихэн хийх тул өвөр нь маш том болоод бөөн *хар хир буртаг* явна. (Д.Нам “Цаг төрийн үймээн”)

-Аа тэг хүүхээ. Энд чинь ёстой хүний *хар нүднээс бусад нь байдаг газар* гэж санаа сэтгэл нь сэргэх болов уу гэхдээ уриалгахнаар хэлэн, мориныхоо амыг татлаа. (Д.Нам “Цаг төрийн үймээн”)

## II. Энэ тэмдгийн нэр нь шилжсэн салаа утгаар орж буй өвөрмөц хэлц

**2.а.** Дан ганц зөвхөн буюу цэвэр дагнасан гэсэн утга илтгэнэ. Тухайлбал, хар хүн (дагнасан нөхөр), хар чийг (зөвхөн шөнө, үдэшдээ буух чийг), хар тавхай (зөвхөн тавхайн ёроол), хар амиа бодох (зөвхөн өөрийгөө бодох), хар хамраараа таслуулах (яг урдуураа таслуулах), хар хөлс асгарах (дан хөлс гоожих), хар ажил



(дан биеийн хөдөлмөр), хар сээр (сээрийн гол нэг нугалам яс), хар айраг (дан цагаан гүүний сүүгээр исгэсэн айраг) Жишээ нь:

-Чичрэг өвчин тусаж, шонтгор богино хамартай, халзан их духтай, чавганц царайтай тэр ноёны улцгар нүүр нь *хар хөлс* чихарч, хэвтэж байсан билээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-*Хар хүн* чинь миний хонины махыг төлж өгөг дуулав уу? гэж хашгиртал... (Б.Р “Үүрийн туяа”)

-Хоёрдугаар удаад нь дээрхийн гэгээнтэн, *хар үүрээр* гэнэт бушуу цай аваад ир гэж зарлиг болдог байжээ. Цай сая л чанаж арай сүлж гүйцээгүй байлаа. (Б.Р “Үүрийн туяа”)

-Альд нь байна уу? Морь эмээллэ! гээд Богд гарын дор тохиолдсон нэг ламыг дагуулж, шар хүүхэнтэй хамт Гандан өөд *хар хурдаар* таварган давхижээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тэр айлын хүүхэд, эмэгтэйчүүд, чавганц нар Шамба сэлтийн хойноос хараал тавьж үнс шороо цацах нь үнс шороо цацаж, хар ус цацах нь хар ус цацав. (Б.Р “Үүрийн туяа”)

-Өвгөн Жан, хүн бүр, өөрийн эрхэлсэн урлах дархлах, юм бүтээх ажлыг хийгээд дэлхийд юу ч болж байсан ер бусдын хэрэгт хөндлөнгөөс эс оролцвол, сая хүн бүр аяга будаатайгаа болж чадна гэж *хар ухаанаараа* боддог байжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-*Муу хар гуйлгачин*, мориноос буу! (Б.Р “Үүрийн туяа”)

-*Хөвчийн хар дархан* гэдэг алдрыг чинь дээрээс сонсож, найман хигээстэй хүрдэн тамгыг чинь хэд хэд үзсэн. Энэ чиний гарын ур биш биз? гэж хутгаа үзүүлбэл, хөвчийн хар дархан тэр хутгыг сэтгэл хөдлөн үзээд... (Б.Р “Үүрийн туяа”)

-Огторгуй ихэд уйлахад хүрвэл, ганц миний *хар толгой дээр* уйлах юм биш, дая олны толгой дээр уйлах юм байлгүй дээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тасдаад хаяна даа эмгээ! Олны бухимдаад үймээд ирэхэд нэг самбаанд нь тасдаад хаячихна гэж далан нөхөөс болсон уранхай дээлтэй, нэг хүдэр *хар хүн* дуугарав. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тэгээд хониноороо ганцаар үлдээд, хөхрөн харагдагч тэнгэрийн хаяаны зүг холдож яваа аянчны хойноос удтал харж зогсохдоо, манжийн төр эцэс болох цаг ойртож байгаа юм гэж *хар багаасаа* сонссон дам үгийг санаж, Монгол нийгмээр эрх чөлөөтэй, амар сайхнаар жаргах цаг ирэх юм гэж хэлэлцдэгийг бодоод, Батбаяр өвгөө, миний багад ярихдаа, юм бүхэнд хэмжээ байдаг юм даа. (Б.Р “Үүрийн туяа”)

-“Цагаан сар ба *хар нулимс*” (Д.Нацагдорж)

-Хангай говийн хооронд халхын уудам нутаг

*Хар бага наснаас* хөндлөн гулд давхисан газар (Д.Нацагдорж)

-Хуриманд ирж согтоод Буянхишиг Да лам, “Хувилгаан сүнс” гэж өөрийгөө дөвийлгөн агсганадгийг санагдуулж, Цэрэнлхамын *хархуутэй* тэврэлдэн суугааг хараад “уур нь бадарч” Лодон “байшингийн хаалгыг хэмх цохин орж хэрүүл шуугиан гаргаж байна. Буянхишиг Да лам Ванлийгийн өөр хүнтэй суух “мөрий нь өдрийг сонсоод” дугана сүмдээ муужран унаж улмаар хуриманд нь очихоор явахдаа... (Д.Нацагдорж)

-Хашааны булан тохойгоор яваа хүмүүсийн хувцасны өнгө ялгаран *лам хар нь* танигдахуйц тэмээг хэвтүүлэв. (Д.Намдаг. “Цаг төрийн үймээн”)

-Гэрийн хаалга зөөлнөөр онгойж нэг хүн дуу чимээ гаргахгүйг хичээнгүйлэн орж ирсэн нь арван тав, зургаа орчим настай, нарийхан биетэй гурдгархан *хархуу* байлаа. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Залуудай, эмэг эхийн хамт, Поодойн цөмөрсөн өрхийн дэргэд очиж, доошоо эмээн харваас, хирис, өрхийн дээврийг махаараа цөм дарж ойчихдоо, нарийвтар сургааг унин дээр **хар модны** долон холтос дэвсэж, дээрээс нь ширэг жигдлэн өрж хийсэн дээврийг нь цөм дарж ойчихдоо, өрхийн тооно тулсан дөрвөн баганын нэг нь цав гарсан газраа цуурч, шор мэт хурц үзүүртэй болсон нь, тэр нүсэр том амьтны гэдсийг нь нэвт хатгаад, бөөрөн тушаа нь цус бултайн цухуйжээ. (Б.Р. “Заан залуудай”)

-Санамсаргүй сахлаа илэхэд хурууны нь үзүүрт хүйтэн, нойтон юм баригдав. Энэ нь тун саяхан асгаруулсан нулимс хацраа даган урссаных байжээ. Балданцэрэн тийнхүү уйлснаа санахтайгаа зэрэг, би сахал самбайгаа хүртэл ургуулсан нэг ёсны *төрийн хар хүн* байж, ухаан жолоогүй уйлах нь юу вэ? гэж зүрхээ чангалан цааш явлаа.

-өөрийнхөө хэргийг дэвэн дэлхийд мэдэгдэх гэсэн юм шиг *хар тэнхээгээрээ* хашгичин ярив. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Гэтэл чамаас эхлэн *хар амиа бодох* нь юу вэ? (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Гэвч Балданцэрэн нэгэнт тэндээс *хар багаасаа* тасарч малын захаас холджээ. (Д.Нам “Цаг төрийн үймээн”)

-Үүнийг би чамд *хар хорын сэтгэлээс* хэлж байгаа биш, эмэгтэй бидний хувь заяа нэгэн адил дорой болоод, гаслан зовлонгийн дунд хүлээстэй байдгийн хувьд хэлж байна. (Д.Нам. Цаг төрийн үймээн)

**2.6.** Бүхэлдээ муу муухай ба муушаасан баймж гэсэн утга: хар толбо, хар амтай, хар дотортой, хар үйл, хар мөртэй, хар санах, хар буух, хар дарах, хар элэгтэй (муу санаатай), хар ихтэй, арван хар нүгэл, хар ихтэй (маш сэрдэмтгий)

-Тийм байлгүй, сүнсээ алдсан *хар ноход!* Удахгүй тэр чандруунуудтайгаа цуг үнсэн чандруу болон тонилохоо мэдэж байна уу? (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

- Энэ юун сав бэ? Шорон уу? Биш, зорь! Тэгэхдээ ногооных биш, хүнийх ёстой хүн нэрэн дээр нь амьд хүүр болгодог *хар тамын зорь*. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Хаалга нээ, хөгшин *хар илжиг*. Бид цэргийн улс, танай данжаадтай уулзана гэхэд нь, (Б.Р “Үүрийн туяа”)

-...хүний морь хөлслөөд хөлсийг нь өгөхгүй, задарсан *хар тархи вэ*, хө чи? Би чамайг гар хоосонгүй эрхбиш явсан хүн гэж яс зуух байх гэж бодсон чинь биш болжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Чиний зөөлөн сайхан сэтгэл чинь, миний нүдийг бөглөсөн *арван хар нүглийн*

саравчийг сөхөж өглөө. (Б.Р “Үүрийн туяа”)

-Хүрээний амбас, тэр мэдээг олж сонсоод олныг өдөөн хатгаж самуун өдүүлэгсдийг барьж чандлан шийдтүгэй гэж олон хошуугаар тусгайлан зарлаж, тэр ёсоор олон хүнийг хар гэрт хийсэн гэнэ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Аа, муу хар гэмин, чи энд хоргодож байдаг юм бий? Мөд чи үхсэн хар илжиг болно доо. (Б.Р “Үүрийн туяа”)

-Хар үгэнд наймаа хятад хоёр гэж нэг ухагдахуун байжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Нүүртээ тойрсон мянган *хар нүд*тэй... (Б.Р “Үүрийн туяа”)

-Миний хэсч үзсэн газар их боловч, би өнчин өрөөсөн *хар яст*, харц ард, Далай ван болбол, цагаан яст хүн болоод, биеэ номтой ч гэсэн ноён, номгүй ч гэсэн харц нарыг захирах ноён гэж үздэгийн нэгэн билээ. Ван, манжийн үед ч эрхтэй, ямбатай, дураараа байжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

**2.в.** Эгэл энгийн гэсэн утга: хар болох (төрийн шашны биш болох), хар иргэн (эгэл ард), хар тэргүүт (энгийн иргэн, хүн төрөлхтөн), хар гэртээ хаан, бор гэртээ богд, хар яриа, хар үг

-Гээгний тав тавьсан саяхан *хар* болсон байдалтай нэгэн цоохор цэрэг богц дотроос хонины болгосон хоёр толгой гаргаж Ширчингийн зүг аньсхийж, (Б.Р “Үүрийн туяа”)

-Мал сайхан зуншиж байна гэж хариулаад, салхины нь дороос зайлж, хоорондуураа салхи цохихоор тааруулан морио зогсоосон учир нь, Дүйнхараас яах аргагүй өмхий шиврийн үнэр ханхалж, ой гутмаар муухай бөгөөд, харвал *ажлын хар гутлын* зулаг шивэрт нь нойтон үзэгджээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Муу хар овоохойдоо галайхаан эхийг тахиж, умар зүгийн *Хар Тогмагын* газраас тэмээний хишиг хүртэж, Төмөр уулын газраас хурдан буу хурц ирт хутга мэсийн хишиг хүртжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Чингээд хүрээлэн буусан хуарангийн утаа болсон хуучин *хар майхнуудын* тэнд хүрээд, тэр цэрэг Ширчинг нэг майханд оруулаад, Дүйнхартай хоёулан Жамсранжав бэйсэд айлтгах гэж, олон майхны төв дунд, үүдэндээ туг зоолттой улаан халзан том гэр лүү оржээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Урьд өмнө дуулдаагүй тэр өгөөмөр болсныг жасын мал харж байсан ядуу зарц нарын хүн бүр агшин зуур сонсоцгоож, гэнэт тийм болсныг ноорхой *хар гэртээ* гайхан хэлэлцжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тэр завсар, сор залахыг харах гэж цугласан олон *харчуул*, ам амандаа ярих нь ярьж арилжаа наймаа хэлэлцэх нь наймаа хэлэлцэж яргачин, панзчин, мал худалдахаар ирсэн ардуудтай ханцуй дотроо хуруу атган үнэ хэлэлцэж гуйланчин, төлөгчин, хятад хайрцгийн наймаа, дамнуурчин, газар дороос гарсан юм шиг олны дотор бий болж боов чихэр, маахуур, маатан худалдаж эхлэв. (Б.Р “Үүрийн туяа”)

**3.а.** төрөл биш, харь, онцгойрох ялгарах гэсэн утга: харь элэгтэн (харь хүмүүс),

хар нүдэн хийх (айрагт архи холих), хар нүд хага татах, хар нүд хуулах, хар цагааныг ялгах, хар нүдэн хонь, хар цагааны газар, жич: Норжин нарын тольд хар хэмээх үг нь хамаг, бүгд, буй, бүхий, (хар хурдаараа давхих, хар хүч) гэсэн утгыг тэмдэглэжээ.<sup>2</sup> бичиг хар (бичиг бусад зүйл), мал хар, хүн хар, данс хар, морь хар гэхчлэн “бас бус, юм, бүгд” гэсэн утга, илтгэж, бүхэлжсэн хэлц холбоо үг бүтээнэ. Тухайн юмыг бүхэлд нь “харлуулан” муухай болгох гэсэн утга нь “дагнасан буюу холих найрах утгагүй “хар хүн, хар цас, хар хөлс, хар тамир” зэрэг холбоо үгээс салаалж, өгүүлэгч этгээдийн муушаасан баймж утга нэмсэн байдгаараа ялгарна. Жишээ нь: хар гамин, хар нохой гэвэл “хар” хэмээх үг нь “дан, дагнах” гэсэн утга буй боловч юмыг жигшин муушаасан баймж утга нэвт шингэсэн байгааг ажиглана уу?

-Хожим хойчийн нэгэн цагт манж нарын хуучин данс хараа агуулах газраас эрхэм өв тэгш эх бичиг тарах болзошгүй. (Б.Р “Үүрийн туяа”)

-Би арай гэж нэг гүзээ тос, *хар баагаар* өгч явуулсан. Юм авахгүй гээд халгааж өгсөнгүй. (Б.Р “Үүрийн туяа”)

-Энэ хэргийн үнэн худал, *хар цагааныг* яаж мэдэх билээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-*Хар өглөө* арайхийж, *хоёр хар нүдээ* хага татаад хараал хийж гардаг тань яасан жигтэй юм бэ? (Б.Р “Үүрийн туяа”)

-*Харцагааня*с холилдож, харцноёд хутгалдаж болохгүй гэж эвэртэн сүүлтэнгүүдийн гэр өргөө барих газар нь бас анги газар бий гэж тэр цагдаагийн ярихад Батбаяр, тоглож байгаагий нь бүү мэд, үнэхээр асууж байгаагий нь бүү мэд. (Б.Р “Үүрийн туяа”)

**4.а.** Нууц далд (хамгаалах, нууцлах) гэх мэт утгыг илтгэдэг гэж болно. Жишээ нь: хар хайрцагны бодлого гэх нийлмэл хэлц нь хар авах, хар дотор, хар арилжаа, хар санах зэрэг үгсийн хардах сэрдэх утгаас эхтэй гэж болно. (хар арилжаа) гэх мэт. Жишээ нь: Цэрэн,- Би мөнгөндөө **хар буугаад** ч уйлж байгаа юм биш. (Б.Р)

-Гэвч манж нар, маш хартай улсаа, Жамгон Римбуучийг дайчин гүрний нутгаас гадагшаа гарч болохгүй гэж хориод, бараа болох амбан сайд, дэргэд нь томилж, наагуураа их ламыг хүндэтгэн ёсолж байгаа юм шиг...(Б.Р)

I ангилалын хувьд академич Б.Ринчен гуай “Хоршоо үгийн аймгийг ангилан үздэгийн шувтарганд бас элдэв хоршоо үг гэж ангилах нэг зүйл бий. Түүнээ багтах хоршоо үгийн байдал нь монгол хэлний сэтгэхүйн үүднээс нягтлахад дээрх хуваарьт орууламгүй бөгөөд монгол ардын утга соёл, эдийн боловсролын түүхнээс тайлбарлах зүйл болно.

“Хүн хар, данс хар, бичиг хар” гэх мэт хоршоо үгнээ хоёрдугаар хоршиц үг нь “хар” гэсэн өнгийн нэр үг бөгөөд “хар” гэсэн үгсийн утга нь нэг зүйл өнгөөс гадна, монгол хэлнээ хольцоогүй дан нэгэн зүйл гэсэн утга санаатай үг ажээ. “хүн хар” гэхдээ дан хүний зүйл, дагалдсан мал сүрэг зэргийг дурдахгүй, хүний нь голлосон санаа болгож “хар” гэдэг хоршоо үг зүүсэн учрыг өгүүлэлтэй.<sup>3</sup> гэж тайлбарласан байна.

II ангилал нь “морь хар, данс хар” гэх мэт зэрэгцсэн хоршоо үгнээ морь

<sup>2</sup> Ц.Норжин нар, Монгол хэлний толь, Чуулалт хаалга, 1999, 1238-р т.

<sup>3</sup> Б.Ринчен, “Монгол бичгийн хэлний зүй”, дөтгөөр дэвтэр, дэд, өгүүлбэр зүй, Уб, 1967, 59-р тал

данс зэрэгтэй холбоо бүхий зүйлийг хамруулах утга илтгэх нь “бүхэл хэсэг” гэсэн утгын “хэсэг бусад” гэсэн утга бүхий “хар” хэмээх тэмдгийн нэртэй холбогдоно. “хольцгүй дан, цэвэр, зөвхөн ганц, дагнасан” гэсэн гол утгаас дээрх 4-5 салаа утгын дундаж хоёрдмол шинжтэй үгс бас тохиолдоно. Жнь:

хар ус	а.дан ус б.архи (муушаасан утга)
хар гэр	а. зүдэг ядуу б. хорих гэр (шорон)
хараар наадах	а. шатрын хараар эхэлж наадах б. хар хор, мөрий агаагаар наадах
хар бор	а. хар өнгөнд цайвар өнгө орох б. эгэл боргил, хатуу, хүтүү
хар үйл	а. муу үйл б. бүдүүн хадуун зүйл,
хар толгой	а.цайраагүй үс бүхий б.зөвхөн амиа бодох
хар элэгтэй	а.муу санаатай б. харь удам угсаатан

Үүнчлэн “хар дэлэн” гэвэл а. муу муухай өвчин б. зөвхөн дэлэн нь хавдах өвчин гэж хоёрдмол утга мэр сэр дайралдаж байна. “Хэрээ хэрээнийхээ харыг гайхна” гэвэл а. хар өнгө нь ижил, б. нэг нь нөгөөгөөсөө ялгарах гэсэн санаа, тухайлбал, “Чинийх долоо, минийх долоохон” гэсэн санаа илтгэнэ. “хар” хэмээх өнгө заасан тэмдэг нэрийн салаа утгат холбоо үгсийг дээрх ангиллын дагуу хэрхэн орсныг үзүүлбэл, дараах байдалтай болно.

Г.И.Рамстедт<sup>4</sup> хар алба-(татвар, албан ажил), хар гуяа (хөх гуяа), хар яс, хар өдмөг (хар талх), хар аюу (хар баавгай), хар газар, хар буурь, хар гөрөөс, хар сүлд, хар хулд, хар хул, хар хөө, хар хэдмэн, хар хэл, хар хөлс, хар хүн, хар мах, хар мод, хар мөрөн, хар нүүр, хар өдөр, хар шашин, хар сээр, хар таваг, хар тамхи хар толгойтой, хараас айдаггүй, харанхуйгаас цочдоггүй;

О. Ковалевский<sup>5</sup> цаг sig- харанхуй, бүрэнхий, хар үйл, хар улс (энгийн), хар үг (ярианы үг), хар үхэр, хар нүд, хар нүгэл, хар халзан галуу, хар хус (чёрная береза), цага qula (барс), харын барилга (ургамлын нэр) хар бичиг (черновое письмо), хар сар (новолуние), хар сэтгэл, хар сээр, хар шажин (ислам), хар зүг (чөтгөр шуламс, сарын сүүлч үе) хар гэр (гал зуух), хар хятад (хар Кидан), хар хүснэгт там (гал там); гэсэн бол “Халимаг –Орос толь бичиг”-т;

- 1.1 хар харанхуй а.хар газар б. цасгүй газар
2. цэвэр, хольцгүй (хар мах, хар цай, хар ус, хар архи)
3. энгийн а. хар хүн б. төрийн хар хүн, хар яриа
4. хүнд (хар хөдөлмөр, хар хүч)
5. хорлонтой (хар санаат, хар хов, хар хэрэг), алдаатай, өөдгүй
6. хамгийн хүчтэй (хар хүйтэн хар салхи)
- 2.1 зөвхөн, ганц, онцгой, а. хар амиа харах б.хар өглөөгүүр
- 3.1 хараар наадах (шатар тоглохдоо хараар эхэлж нүүх)

<sup>4</sup> G.J.Ramstedt. Kalmükisches Wörterbuch, Helsinki, 1935, p.168

<sup>5</sup> О.Ковалевский, Монголо-Французский словарь, Т II, Казань, 1849 стр.823-826

2. муу үйл (хар санах, чүдэнзний хусах хар, нүдний хар цэцгий), хар ям, хар шажин, хар цагааныг ялгах, хар боргүй, хар сэр, хар даг, хар газарт ор-, хар хувцас, хар усан дээр өрөм тогтох, хар хүн (энгийн чөлөөтэй тайван амар) хар байх (энгийн байх);<sup>6</sup>

“Буриад-Орос толь бичиг”-т;

1.1 хар, хар шир, хар өнгө, хар нэрс, хар зандан, хар азарга, хар үнэг, хар гөрөөс, хар баавгай, хар нохой, хар шөнө, хар нүх, хар зүс, хар азарга, хар царай, хар тамхи, хар газар (цасгүй),

2.цэвэр хольцгүй; хар мах, хар цай, хар шөл, хар усаар хооллох, мөнхийн хар ус, хар архи

3. энгийн: хар хүн, хар зөн, хар хэл хар яриа

4. энгийн биеийн: хар хөдөлмөр (хар ажил, хар хүч)

5. хар барга хүн (мунхаг бүдүүлэг хүн), хар худал, хар дотортой, хав хар, хар санаа, хар гай, хар хэрэг

6. хамгийн хүчтэй, хар хүйтэн, хар салхи, хар бороо, хар багаасаа

7. жинхэнэ өөрийн: хар мөрөө хараад явах, хар тархиндаа гомдох, хар зөөр хар зоргондоо

2.1 зөвхөн онцлог: хар амиа харах, хар бие хүн, (ганцаар хүн)

2. маш нэн: хар эрт, хар түмэн (хар мянган)

3.1 хар: хараар хувцаслах, хараар наадах,

2. муу санах: хар хийх, хар санах, хар буух, хар бараг, хумсны хар, нүдний хар, хар шар (шар хүрэн)<sup>7</sup> гэх мэтээр “хар” хэмээх үгийн утгыг дээрх байдлаар ангилан тайлбарласан байна.

Хэл шинжлэлд үгийн салаа утга, ижил үг хоёрын хооронд эрс зааг тавьж болохгүй хэмээн эрдэмтэд үздэг. Учир нь, үгийн утга салаалах нь харьцангуй хөдлөнг шинжтэй юм. Өөрөөр хэлбэл, тухайн үг хэлэхийн цуваанд ямагт шинэ утга бүтээх боломжтой байдаг. Эдгээр нь тухайн үгийн салаа утгыг бий болгож улмаар тэрхүү утга нь анхдагч үүр утгаасаа аажмаар холдон алсарсаар өөр зүйлийг тэмдэглэхэд хүрдэг. Энэ нь ижил үг болдог. Жишээлбэл, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь (2008)-д

хар I цагааны эсрэг утга, хөө нүүрс зэргийн өнгө (хар хяруу, хар сүлд, хар гурил)

хар II хардах сэрдэх байдал (хар авах, хар буух, хар дарах)

хар III бичиг хар (бичиг хэрэг болон бусад зүйл)

хар IV хар сээр (хүзүү сээрийн завсар дахь гаднаас түгдийж үзэгдэх нэг нугалам яс) гэснийг үзвэл “хар сээр” гэсэн үгнээ хар чийг, хар шөл, хар хяруу, хар борви, хар яриа, хар ажил гэсэн холбоо үгнээ орсон “дан ганц, цэвэр, нарийн” гэсэн утга хадгалагдан байна. Иймд “хар сээр” гэсэн холбоо үг нь тус тольд дурдсан I бүлэгт утгаараа багтаж болом санагдана. Ф.де Лессинг<sup>8</sup>, Я.Цэвэл<sup>9</sup>, Норжин<sup>10</sup> нар энэ холбоо үгийг I бүлэг үгсэд багтаасан байна. Ийнхүү үгийн салаа утга<sup>11</sup> уу, эсвэл бие даасан ижил үг үү? гэдгийг ялгахад энэ мэт зөрөө гардаг байна.

Мэдэгдэхүүн хэлэгдэхүүний үүднээс, хэлний нэг гаргалгад нэг агуулга байх

<sup>6</sup> Калмыцко-русский словарь. Под редакцией Б.Д.Муниева, М., 1977

<sup>7</sup> Бурятско-русский словарь, Составил К.М.Черемисов. М., 1973, стр. 547-548

<sup>8</sup> F.de.Lessing Mongolian-English dictionary. Bloomington,1982, p.931

<sup>9</sup> Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Уб.1966, 661-р т. 2013, 907-р т.

<sup>10</sup> Ц.Норжин нар. Монгол хэлний толь, Чуулалт хаалга,1999, 1244-р т.

<sup>11</sup> Polysemy (*/pəˈlɪsɪmi/* or */ˈpɒlɪsɪmi/*,<sup>[1][2]</sup> from *Greek*: πολυ-, *poly-*, "many" and σῆμα, *sēma*, "sign")



ёстой боловч, хэлний агуулга, гаргалга хоёр нь мэдэхүүн хэлэхүүний хувьд зөрөөтэй болдог. Үүнд,

ижил утга	салаа утга			
I. цага- цагааны эсрэг өнгө	А.	I.	дан ганц, зөвхөн, цэвэр, дагнасан	(хар хүн, хар тавхай, хар хамраараа таслуулах, хар сээр)
II. цаг- хар хар хийх		II.	эгэл энгийн	(хар болох, хар иргэн, хар тэргүүт, хар аяндаа, хар байх)
III. цаг-а харах	Б.	III.	бүхэлдээ муу муухай	(хар, толбо, хар элэгтэй, хар амтай, хар буух, хар мөртэй)
		IV.	онцгойрох ялгарах	(хар цагааны газар, бичиг хар, хүн хар, хар нүд хуу татах)
		V.	нууцлан далдлах	(хар хайрцгийн бодлого), хар арилжаа (нууц худалдаа), хар хор (далдуур хор хүргэх үг)
хэлний гаргалга	↔	хэлний агуулга		

Энэхүү ангилалыг жишээгээр баяжуулан тайлбарлавал,

Салаа утга			
A.	I.	хар амтай (дандаа муу юм ярьж явдаг) хар мөртэй (муу үйлстэй, бусдад дандаа гай болж явдаг) хар данс (муу зүйл бичиж тэмдэглэх данс) хар хэл амтай (ямагт муу муухай, сэжиг хүрмээр үгтэй, зүхэлч) хар зураг (хар цагаанаар ялгасан фото зураг) хар зураг (ерөнхий зураг гаргах) хар шоргоолж шиг (тоймгүй олон, маш олон) хар газар (цасгүй газар) хар сувай (ерөөс хээл авдаггүй эм мал) хар сүлд (монголын нэгдсэн тулгар төр байгуулагдсан үеэс эхлэн хэрэглэж ирсэн дайсныг айлгах догшин зүс бүхий хар өнгийн хялгасаар хийсэн эртний монгол цэргийн туг) хар лам (христийн шашны лам) хар ус (архи) хар цай (сүлээгүй цай) хар тавхай (тавхайн ёроол) хар хувцастан (улсын аюулгүй байдалд онц ноцтой хор учруулах гэмт халдлага, гэмт хэрэгтний	хар хөлс нь асгарах (ажил явдалд түүртэн ихэд хөлрөх, ихэд айж сандрах) хар бороон дундуур (яг бороо орж байхад ийм их бороон дундуур хэмээн түвэгшээх нь) хар өглөөгүүр (ийм эрт, өглөө эрт, яршиг удах) хар шуурганаар (очиж очиж шуургатай үеэр түвэг удах) хар бага нас (нялх бага нас) хар бага наснаас (балчир бага наснаасаа) хар үүрээр (маш эрт) хар хүн (эр эм бологчдийн эрийг нэрлэсэн нь) төрийн хар хүн (төрийн албан хаагч) хар ухаан (төрөлх ухаан, ажил амьдралаас олж авсан мэдлэг ухаан) хар амь (өөрийн амь, хар амиа бодох зөвхөн өөрийгөө бодох амин хувиа хичээх) хар бие (ганц бие) хар биеэрээ зүтгэх (ганцаар зүтгэх, багаж зэвсэггүй зүтгэх) хар толгой (ганц өөрийн бие) хар толгойдоо гомдох (өөрөө өөртөө гомдох) хар архи (спиртийн хэмжээ нь их архи) хар мах (өөхгүй мах) хар айраг (дан цагаан гүүний сүүг тусгай нарийн аргаар хийсэн архи)

	<p>эсрэг ажиллах тусгай бэлтгэгдсэн цэрэгжсэн бие бүрэлдэхүүн)  хар чийг (зөвхөн үдэш шөнийн цагт буух чийг)  хар шал (жинхэнэ банзан шалны доорх шургааг шал)  хар ямаацах (хүүхэд, ямаа, чоно, эзэн, хүн, хоточ нохой оролцож хүн нохой нь чононоос ямаагаа хамгаалж наадах тоглоом  хар нүдэн (нүднийхээ тойронд хартай малын зүсэм, хонины ухархайн хар үс)  хар хяруу (хүйтэн дулаан ээлжлэн өөрчлөгдөх нөхцөлд хөрсний гадарга дээр үүсэх нимгэн мөсөн бүрхүүл)  хар тамхи (намуу цэцгийн төрөл, урт бөгөөд том навчтай шар буюу улаан цэцэгтэй ургамал)  хар борви (тэмээний тойгийн дотор талд их өвчин орж хавдах)  хар дэлэн (хонь ямааны сүү гарахгүй болох нэгэн зүйл халдварт өвчин их төлөв дэлэн нь хавдаж сүү нь ширгэнэ)  хар цэцэг (цагаан цэцэг өвчин буруугаар эрхэж, хүндэрсэн нь, хонинд тохиолдох нэг зүйл өвчин)  хар хүч (байдаг хүч)  хар ажил (биеийн хүчний ажил)  хар ажилчин (оюуны биш биеийн хүчийг үнэлэн амьдрах хүмүүс)  хар алба (төрийн алба, хар алба хүчээр хийх)  хар мод (харгай мод гацуур адил болоод яс чийрэг, чанга хүнд дүрс зузаан уул хөвчийн чийглэг чихүүн газар ургадаг нэг зүйл мод шинс  хар муйхар бодох төлөвлөх юмгүй арга эвээр биш хүчээр үзэх )  хар муйхраар зүтгэх (ухаанаар биш хүчээр хийх гэж зүтгэх)  хар хөлс (биеэр дааварлан гарах их хөлс)</p>	<p>хар нутаг (айл нь нүүсэн эзгүй бууц)  хар нутагт (хаягдах айлын буурин дээр буцах)  хар салхи (ихэнхдээ далай, далайн эрэг орчмын газар үүсдэг маш хүчтэй хуй салхи)  хар сээр (хүзүү сээрийн завсар дахь гаднаас түүдийж үзэгдэх нэг нугалам яс)  хар чээж (морины бүдүүн хүзүү)  хар хамраараа таслуулах (ээлж дугаартай юманд орох гээд орж чадалгүй яг урдуураа таслуулах)  хар шүлс (дан шүлс гарах)  хар ялаа (дан ганц ялаа олшрох, батгана)  хар таамаг (зөвхөн таамгаар үзэх)  хар феодал (төрийн түшмэл)  хар зах (хотын зах дахь хар бор наймааны газар)  хар хүү (идэр залуу)  хар намар (намрын гол үе)  хараар хүйтрэх (цасгүй хүйтрэх)  хар бараан (гаальд цаазлагдсан бараа)  хар бяр (эр чадал)  хар ташуур (ялтан шийтгэл, гүрмэл сур ташуур)  хар тэнхээ (мэхийг үл бодолцох)  хар зун (зуны гол үе)  хар зуд (цасгүй өвлийн гамшиг)  хар алхаа (унааны хөнгөн алхаа)  хар аюул (хүнд хүчир аюул зовлон)  хар өвөл (хөхөө өвөл цасгүй өвөл)  хар бүрий (харуй бүрий)  хар хамуу (нойтон хамуу)</p>
<p>II.</p>	<p>хар болох (энгийн иргэн болох)  хар иргэн (эгл жирийн ард, сахил санвааргүй хүн)  хар тэргүүт (энгийн иргэн, хамаг хүмүүс, хүн төрөлхтөн)  хар гэртээ хаан, бор гэртээ богд (гэртээ энгийн чөлөөтэй байх)</p>	<p>хар нүдэн хийх (айрагт архи холих)  хэрээ хэрээнийхээ харыг гайхах (адилхан)  хар нүд хага татах (нойроос дөнгөж сэрэх)  хар нүд хуулах (хар нүд хага татах)  хар цагааныг ялгах (зөв буруу, сайн)</p>

		хар аяндаа (өөрийн эрхгүй зөнгөөрөө) хар элэгтэн (харь хүмүүс)	мууг ялгах) хар нүд хамхих (унтах) хар цагаан дуугүй (сайн муу үггүй)
Б.	III.	хар хөө (гай уршиг чирэх юм) хар гэр (шорон) хар ихтэй (маш их хартай, маш их сэрддэг) хар авах (муу санах, сэжиглэх) хар буух (харамсан гэмших, хайран юм гэж сэтгэл гутрах) арван хар нүгэл (биеэр үйлдэх гурав, хэлээр үйлдэх дөрөв, сэтгэлээр үйлдэх дөрөв, арван цагаан буяны эсрэг үйл) хар санаа (муу санаа, сэжигтэй санаа) хар санах (сэжиглэх, итгэхгүй байх, муу санаа агуулах) хар сэр (хардах санаа) хар буруу (муу үл итгэх) хар буруу санах (муу юм бодох, итгэхгүй байх) хар хор (атаархал сэтгэл, бусдын сайнд хорсох, хэтэрхий хартай сэтгэл) хар дарах (аймаар муухай зүүд зүүдлэх) хар толбо (гутамшигт муу нэр)	хар ёртон (бүтэлгүй муу этгээд) хар өвөр (муу өвөр) хар ёр муу (зүйлийн учрал) хар үйл (зүй зарчмаас гаж муу үйлс) хар дарах (муухай зүүд зүүдлэх) хар дотортой (муу санаатай) хар хэл ам (бусдын хэлэх муу үг яриа) хар хэл ам хүрэх (хүний муу хэлснээс ажил үйлс бүтэлгүйдэх) хар хэл амд идүүлэх (хов жив муу ярианы бай болох) хар түвэг (их яршиг) хар хэрүүл (их хэрүүл) хар хоншоор (аманцар зан) хар хор (муу атаа) хар хуян (хар судлын өвчин) хар гөр (гүжир үг) хар мал (эзэнгүй мал) хар сэтгэл (өрөвдөх энэрэхийг мэдэхгүй сэтгэл)
	IV.	хар үсийг нь хагалах (эхнэр болгох) хар нүд хуу татах	хар цагааны газар бичиг хар хүн хар
В.	V.	хар хайрцгийн бодлого (төрийн дотоод нарийн нууц бодлого) хар арилжаа (нууц далдуур хийх хууль бус худалдаа)	хар үг (тагнуул дээрэмчдийн хоорондоо харилцах далд нууц утгатай этгээд хэллэг буюу чимээ дохио) хар хор (далдуур хүнд хор хүргэх үг яриа үйл ажиллагаа)

Хэрэв “бүхэл хэсэг” гэсэн утгын харьцаагаар үзвэл, II, III-рх утга нь дээрх ангиллаас зөвхөн солигдож болно. Учир нь “А”-гийн II, “Б”-гийн III нь “А, Б” хоёрын завсрын шинжтэй болно. “Б”-гийн III нь сэтгэлийн өнгө аяс заасан баймж утгатай юм.

Хэлний нэг агуулгад нэг гаргалга тохирч байвал, түүнийг ганц утга (моносемия), гэх ба нэг гаргалгад өөр өөр утга таарвал түүнийг ижил үг (омонимия) гэнэ. Гэтэл энэ хоёрын дундаж байдлаар нэг гаргалгад олон утга үүсвэл салаа буюу олон утгат нэг үг бүтнэ. Үүнийг “полисемия” гэнэ. Ганц утгыг тохиолдмол утгатай гэх бол тэр үгсийг өөр утгын чадамжтай үгс гэнэ. Тэгвэл, салаа утгыг хувилбар (узема) гэнэ.

Үүнийг И.М.Кобзева дараах байдлаар харьцуулж, ганц утгат үг нь олон утгат, түүнээс ижил үг үүсдэг гэж тэрээр үзжээ. Тухайлбал,

бага нэгж	→	завсрын нэгж	→	их нэгж
ганц утгатай үг	→	салаа утга	→	ижил үг

гэж харьцуулжээ. Ганц утгат үг нь олон утгат, түүнээс ижил үг үүсдэг гэж тэрээр үзжээ.

Монгол хэлний “цул бараан” гэсэн утга “хар” гэсэн тэмдгийн нэр нь ганц утгатай байснаа хэлэхүүний цуваанд олон салаа утгатай болж, “хар хар хийх” гэсэн үгийн дуу чимээний үгтэй гаргалгын хувьд нэг болж, улмаар бие даасан өөр өөр утгат үгийн бүлэглэл үүсгэсэн ижил үг болжээ. Нөгөө талаар, “хар” хэмээх үгийн хар авах, хар дарах, хар буух, хар санах гэсэн үгс нь сэтгэл санааны тавгүй байдлыг заасан үгс бие даасан үг болон хувирсан тул ижил үг гэж үзсэн байна. Эдгээр үгс нь “хар санаа авах, хар юм дарах, хар бодол дарах” гэсэн холбоо үгсийн тодотгуулагч жинхэнэ нэр нь гээгджээ. Утгын хувьд эдгээрийн “хар” гэгч тэмдгийн нэр нь “харанхуй, муухай” гэсэн утга нь “цул бөөн” гэсэн утгаа хадгалсаар буй тул салаа утга буюу “хар” хэмээх үгийн холдсон хувилбар юм.

Т.А.Бертагаев монгол хэлний үгийн салаа утгыг ойр (диффундированные виды) ба холын (рефракционные виды) салаа утгат гэж ангилаад үүний эхнийхэд хараал, цаг, ган, өдөр, санаа, амь, чих, нүд, утас, кино, концерт, жүжиг, асуулт, зорилт, тайлан, илтгэл, тэг, цалин, хүнсний ногоо, эх үүсвэр, морь тавих” гэх мэт салаа утгыг дараагийн хэсэгт нь утас, утасны хороо, цахилгаан утас, утас явуулах, утас цохих; нүүдлийн кино, шатрын нүүдэл, бэх нүүх, байгууллагын хэлтэс; цаг улирах, анги улирах” гэх мэт утгыг багтаажээ.<sup>12</sup>

Иймээс “хар” (qara) хэмээх тэмдгийн нэрийн I ба II, III ба IV ангилал нь дор дороо ойр буюу нугарсан салаа утгатай бол I ба II нь III ба IV дэх хэсэгтэй хол буюу хугарсан салаа утгатай гэж болно. Харин дээрх 5-р утга өмнөх ойр холын салаа утгаас нэлээд ангид учраас холын салаа утга болох ажээ. Харин энэ сүүлчийн утга нь “qar qar ki-” (хар хар хийх) гэдгийн “хар”-тай ижил үг болох боломжтой ажээ.

### Resume

Thus, it can be considered that the first group referring to the meaning of adjective “black” (qara) has contact polysemy to the second group, and the third one to the fourth one whereas the groups first and second have distant polysemy from other two. The meaning of the fifth group is far distant and different from the contact and distant polysemies. And it is possible that this last one is a homonym of the “qar” which is in “qar qar ki-”.

### Ном зүй

1. Б.Ринчен, “Монгол бичгийн хэлний зүй”, дөтгөөр дэвтэр, дэд, өгүүлбэр зүй, Уб, 1967
2. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Уб., 2008
3. Ц.Норжин нар, Монгол хэлний толь, Чуулалт хаалга, 1999
4. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Уб.1966, 2013
5. Т.А.Бертагаев. Лексика современных монгольских литературных языков.М., 1974
6. Бурятско-русский словарь, Составил К.М.Черемисов. М., 1973
7. Калмыцко-русский словарь. Под редакцией Б.Д.Муниева, М., 1977
8. О.Ковалевский, Монголо-Французский словарь, Т II, Казань, 1849
9. F.de.Lessing Mongolian-English dictionary. Bloomington,1982
10. G.J.Ramstedt. Kalmükisches Wörterbuch, Helsinki, 1935

<sup>12</sup> Т.А.Бертагаев. Лексика современных монгольских литературных языков. М., 1974, стр.72-123

**МОНГОЛ, ӨВӨРМОНГОЛЫН НЭР  
ТОМЬЁОГ ХАРЬЦУУЛАХ НЬ**

Авиа зүйн нэр томьёоны жишээн дээр

Liu Yue [Сарангол]  
/ӨМӨЗО-ны НШУХ/

*Хураангуй:* Монгол улс, Өвөрмонголын монголчууд адил бусын хоёр өөр үсэг бичиг хэрэглээд 70 жил болжээ. Монгол улсад нэр томьёоны толь бичиг ихэвчлэн Орос-Монгол, Монгол-Орос, Англи-Монгол, Монгол-Орос-Англи хэлэн дээр хэвлэгдэж, Өвөрмонголд их төлөв Хятад-Монгол хэлэн дээр хэвлэгдэж байдаг. Иймээс хоёр хил дэх монгол нэр томьёоны толь бичгүүдийг харилцан ашиглахад зарим хүндрэл гарч ирдэг. Өгүүлэлд, Д.Төмөртоогоо багшийн “Хэл шинжлэлийн Нэр Томьёоны Хураангуй Толь”, На.Гончигсүрэн багш нарын “Хэлний Шинжлэлийн Нэр Томьёо” хэмээх бүтээлүүдийг ашиглаж, хэл шинжлэл дэх авиа зүйн онолын өргөн хэрэглээний нэр томьёоноос нийт 462-г харьцуулан үзэж, зөрөөтэй зүйлийг нь жишээгээр харуулж, нэг талаас хоёр хил дэх монголчуудын солилцоон дахь хүндрэлийг багасгахыг хичээсэн бол нөгөө талаас Өвөр монголчууд нэр томьёо боловсруулахдаа Монгол улсын нэр томьёо боловсруулах туршлагаас лавлалт авах зүйл байх болов уу гэдэг санаагаа дэвшүүлэв.

*Түлхүүр үг:* нэр томьёо, боловсруулах, орчуулах, толь бичиг, авиа зүй

Өнгөрсөн зууны 50-90-ээд оны эхэн үе хүртэл улс төрийн тодорхой шалтгааны улмаас Монгол, Өвөрмонголын хэл, соёлын солилцоо бараг тасарсан аж. 90-ээд оноос Монгол, Өвөрмонголын харилцаа сэргэн хөгжих болов. Гэсэн хэдий ч Монгол улс 1946 оноос монгол бичгийг халж кирил бичгийг төрийн албан ёсны бичиг болгон нийт даяар хэрэглэж, Харин Өвөрмонголд монгол бичгийг өнөө хэр ашигласаар байна. Ийнхүү хоёр хил дэх монголчууд хоёр өөр үсэг бичиг хэрэглээд 70 жил болж байна.

Монгол улс, Өвөрмонголд нэр томьёоны толь бичгүүд цөөнгүй хэвлэгдсэн боловч, Монгол улсад ихэвчлэн Орос-Монгол, Монгол-Орос, Англи-Монгол, Монгол-Орос-Англи хэлэн дээр хэвлэгдэж, Өвөрмонголд их төлөв Хятад-Монгол хэлэн дээр хэвлэгдэж байдаг. Ийм ч учраас хоёр хил дэх монгол нэр томьёоны толь бичгүүдийг харилцан ашиглахад зарим хүндрэл гарч ирдэг.

Сүүлийн жилүүдэд Монгол, Өвөрмонголын монгол хэлний үгийн сан, нэр томьёоны зөрөөтэй байдлын талаар эрдэмтэн, судлаачид анхааралдаа авах болов. Үүний нэг тод илрэл бол 1999 онд “Шинэ[кирил]Монгол Хятад Толь”, 2009 онд “Хятад Монгол Үгсийн Толь” хэвлүүлснийг дурдаж болох юм. Гэвч энэхүү хоёр толь бичигт Монгол, Өвөрмонголын өргөн хэрэглээний нэр томьёо орсон боловч

мэргэжлийн нарийн нэр томьёо цөөн байна.

Энд би Д.Төмөртоого багшийн “Хэл шинжлэлийн Нэр Томьёоны Хураангуй Толь”, На. Гончигсүрэн багш нарын “Хэлний Шинжлэлийн Нэр Томьёо” хэмээх бүтээлүүдийг ашиглаж, авиа зүйн нэр томьёог хооронд нь харьцуулж зөрөөтэй талыг гаргаж ирэхийг хичээсэн билээ.

Нийт авиа зүйн нэр томьёо 462-г харьцуулж, зөрөөтэй нэр томьёоноос жишээ болгон доор харьцуулан авч үзье. Үүнд:

### 1. Phonetics 语音学

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Experimental phonetics	Туршилтын авиа зүй	Туршилтын авианы шинжлэл	实验语音学
Historical phonetics	Түүхэн авиа зүй	Түүхэн авианы шинжлэл	历史语音学
Comparative phonetics	Харьцуулсан авиа зүй	Харьцуулсан авианы зүй	比较语音学
Theoretical phonetics	Онолын авиа зүй	Онолын авианы зүй	理论语音学
Descriptive phonetics	Товчоолсон авиа зүй	Тодорхойлсон авиа зүй	描写语音学
Phonetics variant	Авиа зүйн хувилбар	Авианы хувилбар	语音变体

“Phonetics” буюу авиа зүйг Өвөрмонголд авианы шинжлэл, авианы зүй, авиа зүй хэмээн гурван өөр янзаар орчуулан хэрэглэх нь бий. Энэ мэтчилэн нэг зүйлийг өөр өөрөөр орчуулах, нэрлэх нь нэг талаас нэр томьёог жигдлэх, хэвшүүлэхэд сөрөг нөлөөтэй. Нөгөө талаас хүмүүс ойлгож тогтоох, ашиглахад хүртэл хүндрэлтэй байдаг. Авианы шинжлэл гэдэг нэр томьёо оновчгүй биш боловч хэл шинжлэлийн үг зүй, өгүүлбэр зүй, найруулга зүй хэмээх нэр томьёонуудын нэг адил “зүй” гэдэг үгийг ашиглан хэрэглэх нь зүйтэй. Авианы зүй хэмээн хэрэглэх нь зүйтэй боловч харьяалахын тийн ялгал л нэр үгийг хооронд нь холбодог учраас нэр томьёо зохиоход харьяалахын тийн ялгалын ачаалал даанч их. Харьяалахын тийн ялгалыг дахин давтан хэрэглэхээс зайлсхийх нэг арга бол англи, орос, франц, герман зэрэг Европийн гол гол хэлэнд олон улсын нийтийн журмаар хэдэн үг холбон бичиж, нэг юмны нэр байгааг үзүүлдэг зарчим<sup>1</sup> юм. Тухайлбал: classroom, blackboard зэрэг болно. Үүний нэгэн адил Монголд хэл шинжлэл, авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүй, найруулга зүй, авиалбар зүй, утга зүй гэх мэтчилэн харьяалахын тийн ялгалыг хураан бичиж нэр томьёо бүтээдэг зарчимтай юм.

Харин “Phonetics variant” нь авиа зүйн хувилбар болно. Өвөрмонголд ашиглагдаж буй авианы хувилбар хэмээх нэр томьёо нь хятад хэлний “语音变体” хэмээх үгийг үгчлэн орчуулснаас үүдэлтэй аж. Өвөрмонголд аливаа нэр томьёог зохиож орчуулахдаа гол төлөв хятад хэлнээс орчуулдаг. Үүнд гол анхаарууштай зүйл бол нэр томьёочид орчуулан зохиох гэж байгаа нэр томьёогоо сайтар ойлгож,

<sup>1</sup> Чой. Лувсанжав. Англи Хэл Өөртөө Сурах Бичиг. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. УБ., 2014. 28 дахь тал



тухайн үгийг англи, латин хэлэнд хэрхэн нэрлэж байгааг мэдэж, нэр томъёоныхоо цаад агуулгыг зөв мэдэх шаардлагатай билээ.

## 2. Intonation 语调

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Emotive intonation	Сэтгэл хөдлөлийн аялга	Сэтгэл хөдлөлийн аяс	感情语调
Modal intonation	Баймжийн аялга	Хандлагын аяс	情态语调
Exclamatory/ vocative intonation	Дуудах аялга	Дуудах аяс	呼语调
Imperative intonation	Захирах аялга	Захирах хүсэх аяс	祈使语调
Normal/stress/ ordinary intonation	Ерийн өргөлт	Ерийн аяс	一般语调

Юуны өмнө аялга, аяс гэдэг хоёр үгийн тайлбарыг тодруулан авч үзье.

Аялага – 1. Ярихад сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлдэг ая хөг, аялга үг; сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн хэл зүйн хувьд үл хувилах үг. 2. Харийн хэл буюу бусад нутгийн ярианы өвөрмөц дуудлагад эрхшээснээр өгүүлэх байдал; сонин аялагатай ярих. 3. Ая аялгууны энгийн хэмнэл нэгж, аялагад нь тохируулах<sup>2</sup>.

Аяс – 1. Хүн амьтны зан авир, төлөв байдал, аясыг нь дагах. 2. Юмны учир чанарын тухай эе зүй, юмны аясыг тааруулах, аясаар бүтэх ажил (үйлдсэн үгэлсний ёсоор хялбархнаа болох бүтэх ажил), аяс хаалга (ойрыг бодож чухам хаалганаас өөр газар хийсэн жижиг хаалга). 3. Дуу хөгжмийн ая аялгууны удаан түргэний төлөв<sup>3</sup>.

Энэхүү Intonation[语调] гэдэг нэр томъёог монголоор аялга хэмээн орчуулах нь оновчтой болно. Харин аяс хэмээн орчуулах нь хүмүүст нэн түрүүнд салхины аяс, аясыг нь дагах гэх мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Монгол хэлний аялга үг нь:

Нэгдүгээрт, хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөн, сэрэл мэдрэхүйд холбогдох аялга үг;

Хоёрдугаарт, адгуус амьтныг дуудах, туухад холбогдох аялга үг;

Гуравдугаарт, яруу найраг, дуу хөгжмийн айзам хөгийг илтгэдэг аялга үг<sup>4</sup> гэсэн гурван төрөлд хуваагддаг байна.

“Normal/stress/ ordinary intonation” нь ерийн аялгыг ерийн өргөлт хэмээн андуурсан байх талтай байна.

<sup>2</sup> Я.Цэвэл. Монгол Хэлний Товч Тайлбар Толь. Хоёр дахь хэвлэл. УБ., 2013. 72 дахь тал

<sup>3</sup> Монгол Хэлний Товч Тайлбар Толь. Хоёр дахь хэвлэл. УБ., 2013. 72-73 дахь тал

<sup>4</sup> Түмэнжаргал. Одоо Үеийн Монгол Хэл. Хөххот, 2009. 354-357 дахь тал

## 3. Tone 声调

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Tone of voice	Дууны хөг	Аяс	音调
Polytonic stress	Давхар хөгт өргөлт	Давхар аяст өргөлт	多调重音
Tonality	Дэвсгэр хөг	Дэвсгэр аяс	基调
Basic/fundamental tone	Үндсэн хөг	Үндэсэн аяс	基调 (本调)
Even/level tone	Жигд хөг	Жигд аяс	平调
Musical tone	Эгшиглэх хөг	Эгшиглэх аяс	乐调
High tone	Өндөр хөг	Өндөр аяс	高语调
Low tone	Нам хөг	Нам аяс	低降调
Rising tone	Өгсөх хөг	Өгсөх аяс	上升语调
Descending/falling tone	Уруудах хөг	Уруудах аяс	下降语调
Toneme	Хөглөвөр	Аяслабар	调位

“Intonation” хийгээд “tone” гэсэн хоёр өөр нэр томъёог “аяс” хэмээн нэг үгээр орчуулах нь учир дутагдалтай болно. Тодруулбал “Intonation”, “Tone” нь хэл шинжлэлийн хоёр өөр ойлголт юм. Хэл шинжлэлийн хятад нэр томъёоны тайлбар толинд бичсэнээр tone → 声调, intonation → 语调 гэж байна.

Tone буюу 声调 гэдэг нэр томъёо хятад хэлэнд л байдаг өвөрмөц онцлогтой. Үүнийг “Intonation”-тэй ялгалгүйгээр дутуу ойлгож, оновчгүй нэрлэж болохгүй. Дашрамд хэлэхэд “Хэлний Шинжлэлийн Нэр Томъёоны Тайлбар Толь”-д 调位 → хөглөвөр<sup>5</sup> гэжээ.

## 4. Function 功能

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Non-phonemic sound	Авиалбарын үүрэггүй авиа	Авиалбарын чадамжгүй авиа	无音位功能音
Separable function	Салгах үүрэг	Салгах чадамж	分离功能
Distinctive function	Утга ялгах үүрэг	Утга ялгах чадамж	区别意义功能
Hyphen	Холбох үүрэг	Холбох чадамж	连接功能

“Function” хэмээх англи үгийн язгуур утга нь үүрэг болохыг толиноос мэдэж болно. “Чадамж” хэмээн орчуулсан нь хятад нэр томъёо болох “功能”-г үгчилсэн орчуулга болно. Иймээс “function” хэмээх нэр томъёог орчуулахдаа үгийн үндсэн утгыг харгалзан үүрэг хэмээн тогтоох нь зүйтэй юм.

<sup>7</sup> P.H.Matthews, “Oxford concise dictionary of linguistics”, Oxford, 2007, pg.119

<sup>8</sup> Д.Энхбат, “Хэл шинжлэлийн Англи-Орос-Монгол толь бичиг”, Уб., 2003, 57-р тал

<sup>9</sup> P.H.Matthews, “Oxford concise dictionary of linguistics”, Oxford, 2007, pg.78

“огцом эгшиг” гэжээ.

Тухайлбал, “Балархайшил гэдэг нь эгшиг авианы дуудлага өргөлтгүй байршлаас үүдэн сулрах, өөрчлөгдөх үзэгдэл юм. Өргөлтгүй бүх эгшиг балархайших бөгөөд өргөлттэй эгшгээс богино, сул, хүчдэл багатай дуудагдана. Орос хэлэнд өргөлтөөр утга ялгадаг бол монгол хэлний өргөлтөд эгшиг утга ялгадаггүй. Монгол хэлний гол өргөлт нь ямагт үгийнхээ тэргүүн үед, дэд өргөлт нь ерөнхийдөө хоёрдугаар үед байдаг ... Монгол хэлэнд балархай эгшиг тэргүүн үеэс хойш орсон гийгүүлэгч авиануудыг бие биеэс нь салгах, зааглах үүрэг гүйцэтгэнэ. Тэргүүн үеэс хойш тохиолдох богино эгшиг хэлэгдэх сонсдохын талаас, тод бус болохыг ‘балархайших, огцомших, сулрах’ зэргээр нэрлэсэн байдаг”<sup>10</sup> гэснийг үзвэл балархайшил гэдэг нь өргөлтгүй байрлалд байгаа эгшиг авиа сулрах үзэгдлийг хэлж байгаа бөгөөд англи хэлэнд яг энэ ойлголтыг “vowel reduction” гэж ялгаж нэрлэсэн байдаг. Харин “reduction” гэдэг нэр томъёо нь авиа гээгдэн эсвэл сугаран богиносч, хураагдан хэлэгдэх төдийгүй хэлний бусад нэгжийн хувьсал өөрчлөлтөд ч хамаатай ажээ.

Дээрх нэр томъёоны тодорхойлолтууд болон жишээ тайлбаруудаас үзвэл ярианы урсгалд өргөлттэй хэлэгдэж буй үг бүр авианы үг болох бөгөөд дотроо дан, нийлмэл гэж хуваагддаг байна. Монгол хэлэнд, хэлэхийн явцад нэг өргөлтөнд хоёроос дээш үг нэгдэн орж, өргөлтөд үеийн эгшигтэй өргөлтгүй үеийн эгшгүүд ижилсэхийн зэрэгцээ, ондоошин мөн эгшиг, гийгүүлэгч зохицох ёсоор зохицон авианы хувьд нэг үг мэт хэлэгдэх үзэгдлийг **нийлмэл авианы үг** гэнэ. Англи хэлний хувьд өмнө дурдсан нэр томъёонуудаас “contraction” (хураангуйлах) гэдэг нь ярианы урсгалд заавал хоёр ба түүнээс олон үг уусан нийлж нэг үг болон дуудагдах ба ингэхдээ нэг эсвэл хэд хэдэн авиа гээгдэж болох үзэгдлийг хэлж байгаагаараа нийлмэл авианы үг гэдэгтэй илүү таарч байна. Ийм үгс ярианы монгол, англи хэлэнд түгээмэл тохиолдох авианы үзэгдэл бөгөөд үүнийг бүтээвэр дээр тулгуурлан бүтцийн талаас нь ангилан тайлбарлах юм уу эсвэл нийлж нэг үг болон хэлэгдэж буй үгсийг утга хэлбэрийн харьцаагаар нь тайлбарлаж болох юм. Монгол хэлний нийлмэл авианы үгийг ажиглавал дараах байдлаар үүсэж байна. Үүнд:

1. Бие даасан өргөлттэй үгийн араас өргөлттэй үг орох үед сүүлчийн үг нь өргөлтөө алдан өмнөх үгээ даган нийлж, нэг үг болон хэлэгдэнэ. Ингэхдээ араас нь орж, өргөлтөө алдаж байгаа үгийг ажиглавал үйл үг, туслах үг, холбоос, холбох үйл үг, дагавар үг гэх мэт байна. Жишээлбэл:

- Өргөлттэй үг + тодорхой утга бүхий туслах үг: “Цэвэрлээд орхиорой”, “үлдээж орхиорой” гэхэд тус тусдаа өргөлттэй хоёр бие даасан үг байснаа сүүлчийн үг нь өргөлтөө алдсан учир өмнөх үгээ дагалдан “о” авиа гээгдэн, улмаар “р” авиа орхигдон “цэвэрлээдхээрэй”, “үлдээчхээрэй” гэсэн нэг үг болжээ. Ингэхдээ эгшиг зохицох ёсны дагуу “-оорой” гэсэн нөхцөл нь “-ээрэй” болж, “үлдээж” гэдэг үгний “ж” авиа араас нь залган орох “х” авианы нөлөөгөөр “ч” болон хувирчээ. “Нааш ир” гэсэн хоёр үгийг харвал “ир” гэсэн үйл үг “нааш” гэсэн орны нэрийг тийн ялгалын тэг хувилбараар захирч байна. Хэлэхийн явцад сүүлийн үг нь өргөлтөө алдан өмнөх үгэндээ татагдан “наашир” гэж нэг үг болон хэлэгдэнэ. Мөн “хаа очив” гэхийг “хаачив” гэж хэлдэг.
- Өргөлттэй үг + ерөнхий утга бүхий туслах үг: “Үзэж байна” гэхийг “үзжэйнэ”, “харж байсан” гэхийг “харжайсан” гэх ба энэ нь “үзэж, харж” гэсэн гол үйл үгийн араас “байна, байсан” гэсэн туслах үйл үг орохдоо өргөлтөө алдан өмнөх үгээ дагалдан нийлж нэг үг болохдоо “б” авиа

<sup>10</sup> Ч.Зэнямбуу, М.Базаррагчаа, “Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь”, Уб.,2014, 37-р тал

өмнөх “ж” авиа руу ухран ижилсэн хураагдсан байна. Мөн “үзэж” гэсэн эм эгшигтэй үгтэй “байна” гэсэн эр эгшигтэй үг нийлж хэлэгдэхдээ эгшиг зохицох ёсны дагуу хувирчээ.

- Өргөлттэй үг + холбоос: “Чоно ба туулай”, “ном буюу сургаал” гэсэн тус тусдаа авианы гурван үгийн эхний хоёр үг нь нийлж, “чоноба”, “номбуюу” гэсэн нийлмэл авианы үг үүсгэнэ.
- Өргөлттэй үг + холбох үйл үг: Хоёр үйл үгийг холбох үүрэгтэй “гэсэн” гэсэн холбох үйл үг өргөлтөө алдан өмнөх үгээ дагалдан нийлж нэг үг болдог. Жишээлбэл, “юу гэсэн үг вэ?” гэхийг “юүгсүүгүв?” гэж хэлэх ба “гэсэн үг вэ?” зэрэг үгс нь өргөлтөө алдаж, өмнөх гол үгийн өргөлтөнд захирагдан нэг үг болон хэлэгдэж байна. Хэрвээ уг “гэсэн” гэсэн холбох үйл үг өөрөө гол үйл үгийг үүргээр орвол хойноо нотлох болон асуух утгатай сул баймжит бүтээвэр авахдаа өргөлтөө алдалгүй ард байгаа үгнүүдээ өөртөө нэгтгэдэг. Жишээлбэл, “ирээрэй гэсэн юм уу?” гэдгийн “гэсэн юм уу?” нь өмнөх үгтэйгээ нийлэхгүй тусдаа хэлэгдэх ба ярианы урсгалд “гэсиймуу?” болно.
- Өргөлттэй үг + дагавар үг: “дээд, доод, урд, хойд” зэрэг орон цагийн нэрийн ард “тал” гэсэн дагавар үг ороход бид эгшиг зохицуулан “дээтэл, доотол, уртал, хойтол” гэж хэлдэг. Бид “уртал, хойтлоо хар” гэх мэтээр ярьдаг. Эндээс харахад эдгээр орон цагийн нэрийн эцсийн “д” авиа нь араас нийлэн хэлэгдэж буй үгийн “т” авиатай давшин ижилсэж улмаар сугаран хэлэгдэж байна.

2. Бие даасан өргөлттэй үгийн араас бүтээвэр (өргөлтгүй байдаг) орох үед гол үгэндээ татагдан нийлж, нэг үг болон хэлэгдэнэ. Ингэж гол үгэндээ татагдаж байгаа бүтээвэрт сул баймжит бүтээвэр, олон тоо заасан бүтээвэр, таамаглах утга илэрхийлэх бүтээвэр гэх мэт орж байна. Жишээлбэл:

Өргөлттэй үг + сул баймжит бүтээвэр: “явна шүү дээ”, “эрх юм”, “эрх юм шүү дээ”, “явж байсан юм” гэхэд орсон “юм, шүү, дээ” гэх мэт сул баймжит бүтээврүүд нь өргөлтгүй байдаг учраас хэлэхийн урсгалд өргөлтөд гол үгэндээ татагдан нийлж, “яваншд(ээ), эрхийм, эрхиймшд(ээ), явжайсым” гэсэн нийлмэл аялга үг үүсгэдэг. Ерөнхийлөн асуух “уу? үү?”, ялган асуух “бэ? вэ?” сул баймжит бүтээвр мөн л хэлэхийн явцад өмнөх үгээ даган нийлж хэлэгддэг. Жишээлбэл, “яах вэ? хэн бэ?” гэхийг “яахав? хэмб?”; “мөн үү? очих уу?” гэхийг “мөнүү? очхуу?” гэж хэлдэг. “Хэзээ очих вэ?” гэхийг “хэзээ очхов?”, “ирсэн үү?” гэхийг “ирснүү?” гэх мэтчилэн хэлдэг.

Үүнээс гадна нотлох утгатай “юм”, онцлон ялгах утгатай “л”, зэрэгцүүлэн ялгах утгатай “ч” гэх мэт сул баймжит бүтээвэр тус тусдаа өргөлттэй хоёр үгийн завсраар орж хэлэгдэх тохиолдол ч бий. Жишээлбэл, “ирэх болов уу” гэдгийн “ирэх, болов” гэсэн хоёр үгийн голоор “юм” гэсэн бүтээвэр орохоор “ирхиймболуу” гэсэн нэг авианы үг үүсэж байна. Үүнтэй ижил “явж л байна” гэхийг “явжал(б)айна”, “сурч ч байна, судалж ч байна” гэхийг “сурчич(б)айна, судалжич(б)айна” гэнэ.

- Өргөлттэй үг + олон тоо заасан бүтээвэр: “зөөгч нар”, “жолооч нар” гэхэд орсон олон тооны “нар” бүтээвэр нь өргөлтөд гол үгийнхээ эгшигтэй зохицон хувирч, “зөөхчнөр, жолоочнор” гэж нийлж хэлэгдэнэ. Энд “зөөгч” гэсэн үгийн үзүүрийн “г” авиа амьсгалын түрэлттэй “ч” авианы нөлөөгөөр “х” болон хувирчээ.
- Өргөлттэй үг + таамаглах утга илэрхийлэх бүтээвэр: “явах шиг”, “өгөх шиг”, “ ч гэх шиг” зэрэг үгийг “явахшиг, өхшиг, чихшиг” гэх зэргээр

өргөлттэй үйл үгийн ард хэлэгдэх таамаглах утгатай “шиг” бүтээвэр гол үгэндээ татагдан нийлж хэлэгдэнэ. Харин “чам шиг” гэхэд орж байгаа “шиг” бүтээвэр дээрх бүтээвэр биш, адилтгах нөхцөл бөгөөд мөн л өмнөх өргөлттэй гол үгэндээ татагдан нийлж дуудагдана.

- Өргөлттэй үг + ерөнхийлөн хамаатуулах болон чиглэл заасан тийн ялгалын нөхцөл: “цагт нь, амьдрал нь” гэхэд ерөнхийлөн хамаатуулах “нь” нөхцөл тусдаа салангид бичигддэг ч бид ярихдаа “цахтана, амьдарлана” гэж нийлмэл авианы үг үүсгэн хэлдэг. “Байр уруу, эгч уруу, уул өөд, тэнгэр өөд” гэхэд “уруу, өөд” гэсэн үгс өргөлтгүй тул өмнөх үгэндээ захирагдан, эгшиг зохицон “байрлуу, эгчлүү, уулаад, тэнгэрээд” гэж авианы нэг үг болон хэлэгдэнэ.

Үүнээс гадна “өргөлттэй үг + өргөлттэй үг + бүтээвэр (нэгээс гурван)” гэсэн дээрх хоёр бүтцийг хольсон, өөрөөр хэлбэл, хоёр өргөлттэй үгийн араас бүтээврүүд орсон нийлмэл авианы үгс байдаг. Ингэвэл мөн л дээр дурдсаны адил өргөлтөт гол үгийн араас орж байгаа өргөлтөт үг өргөлтөө алдан гол үгэндээ татагдан, түүний араас орж буй бүтээврүүд мөн өмнөх үгээ даган нийлж хэлэгдэнэ. Жишээлбэл, ерийн хэлэлцэхэд “дээд тал нь” гэхийг “дээтлэнэ”, “доод тал нь” гэхийг “доотлоно”, “нааш ир л дээ” гэхийг “наашралдаа”, “үзэж байсан юм шүү дээ” гэхийг “үзжэйсиймшдээ” гэх мэтээр хэлдэг.

3. Тус тусдаа бие даасан өргөлттэй, утга зүйн хэд хэдэн үг нийлж нийлмэл авианы үг үүсгээд сүүлдээ хэвшээд утга санаа нь нэг болчихсон үг байдаг. Жишээлбэл, “дуу гарах, өр өвдөх” гэхэд нэр үйлийн харьцаа заасан, харилцан тэгш эрхтэй, үйл үг нь нэр үгээ нэрлэхийн тийн ялгалаар захирч байгаа тусдаа хоёр үг байсны сүүлийн үг нь өргөлтөө алдан өмнөх үгэндээ татагдан “дуугарах, өрөвдөх” гэсэн нэг авианы үг болон хэвшжээ. “Өнөө өдөр, нөгөө өдөр” гэсэн тодотгогч, тодотгуулагчийн харьцаатай хоёр үгийг харвал “өнөө, нөгөө” гэсэн заах төлөөний үгийг “өдөр” гэсэн орон цагийн нэр захирсан байна. Арын “өдөр” гэсэн үг мөн л өргөлтөө алдан өмнөх үгтэйгээ нийлж “өнөөдөр, нөгөөдөр” гэсэн авианы үг үүсгэн улмаар хэвшжээ. Үүнтэй ижил “маргааш өдөр” гэдэг нь “маргаадар” болно. “Дур үгүй, тав үгүй” гэдгийн үгүйсгэх утгатай “үгүй” гэдэг үгийн “ү” авиа гээгдэн өргөлтөө алдсанаар үгүйсгэх утгатай харьцангуй тэмдэг бүтээдэг “гүй” гэсэн бүтээвэр болсноор “дургүй, тавгүй” гэсэн авианы үг үүсгэнэ. Хааяа эгшиг зохицон хувирдаг, жишээлбэл, “дуу үгүй” гэдгээс “дуугай, дугай” гэх мэт авианы үг үүсэн хэвшжээ. “Авч ирэх” гэсэн зэрэгцэн холбогдсон хоёр үйл үг “авчрах” гэсэн нийлмэл авианы үг болон хэвшсэн. Нутаг нутгийн аялгууны онцлогоос шалтгаалан үүнийг “авцрах” эсвэл “ацрах” гэж хэлэх нь ч бий.

Одоо англи хэлний “contraction” буюу “хураангуйлсан үг”-ийг авч үзье. Дээр хэлсэнчлэн энэ нэр томъёогоор илэрхийлж байгаа жишээ болон санаа нь нийлмэл авианы үг гэдэгтэй таарч байгаа юм. Англи хэлний нийлмэл авианы үгийг ажиглавал дараах маягаар үүсэж байна. Үүнд:

1. Бие даасан өргөлттэй үгийн араас өргөлттэй үг орох үед сүүлийн үг нь өргөлтөө алдан өмнөх үгээ даган нийлж, нэг үг болно. Тухайлбал:

- Үйлийн эзэн (ихэвчлэн биеийн төлөөний үг) + туслах үйл үг: энэ тохиолдолд үйлийн эзэн болох биеийн төлөөний үгийн араас түүнтэй тоогоор зохицон, цагийн утга ялгахад тусалж орж байгаа туслах үйл үг болох “to be”, “to have”, зарим нэг баймж үйл үг байх юм. Жишээлбэл, “I am” гэхийг “I’m” гэж нэг үг болгон хэлэхэд “am” –ийн “a” эгшиг гээгдсэн байна. Үүнтэй ижил “he is, she is, it is” болон “he has, she has, it has” гэхийг “he’s, she’s,



it's", "man is, that is" гэхийг "man's, that's", "you are, they are" гэхийг "you're, they're", төлөөний нэрийн ард байгаа "have" нь "ve", "had" нь "d" болж залгагдан авианы нэг үг болно. Мөн төлөөний нэрийн араас орж буй "will, shall, would" зэрэг баймж үйл үг нь өргөлтөө алдан өмнөх төлөөний үгэндээ захирагдан татагдаж, "I'll, she'll, they'd" гэх мэтчилэн нэг үг болон дуудагдана. Үүнээс гадна баймж үйл үгийн араас өнгөрсөн цагийн утга үүсгэхэд туслан орсон "have" туслах үйл үг мөн өргөлтөө алдан өмнөх баймж үйл үгээ даган нийлж, "coulda, mighta, shoulda, woulda, musta" гэх мэтээр нэг үг болон хэлэгдэх нь бий.

- Үйл үг + биеийн төлөөний үг: энэ тохиолдолд үйл үг нь гол үйл үг эсвэл туслах үйл үг байж болно. Харин биеийн төлөөний үг нь хэрвээ гол үйл үгийн араас орж байгаа бол заах болон өгөх оршихын тийн ялгалын утга ялгасан тусагдахууны үүргээр орж буй төлөөний үг байна, туслах үйл үгийн араас орж байгаа бол нэрлэхийн тийн ялгалд байгаа үйлийн эзний үүргээр орж буй төлөөний үг байна. Жишээлбэл, "let us, ask them, tell him, show her, bet you, get you, got you, want you, give me, let me" гэх мэт үгс нь "let's, askem, tellim, shower, betcha, getcha, gotcha, wancha, gimme, lemme" гэх мэт нэг үг болон хэлэгдэнэ. Америк хүн ярианы энгийн хурдаар "How are you? What are you...?" гэхийг "howaya, waddaya" гэж хэлэх бөгөөд асуух үгийн араас туслах үйл үг, түүний араас өгүүлэгдэхүүнийг заасан биеийн төлөөний үг орсон ийм цуваа бүтэц ярианы урсгалд нэг өргөлтөн дор орж нэг үг болон хэлэгдэх нь англи хэлэнд түгээмэл тохиолддог. "How do you" гэхийг "howdya", "how did you" гэхийг "howjya", "what did you" гэхийг "whajya" гэх мэтчилэн хэлдэг. Эдгээр нийлмэл авианы үгс мөн л авиа ижилсэн, ондооших, сугарах, гээгдэх гэх мэт ёсонд захирагдан хувирсан байна. Жишээлбэл, "did you" нь "jya" болсныг үзвэл "д"-ийн араас орсон "и" авиа өмнөх гийгүүлэгчээ зөөллөн, тагнайшуулснаар хамжин шүргэх "ж" болсон байна. Мөн "got you" нь "gotcha" болсныг тайлбарлавал, хатуу амьсгалын түрэлттэй "т" гийгүүлэгчийн араас дуутай гийгүүлэгч "е" орсноор мөн зөөллөн хамжин шүргэх "ч" болж хувирчээ.

2. Бие даасан өргөлттэй үгийн араас бүтээвэр орох үед бүтээвэр нь гол үгэндээ татагдан нэг үг болж хэлэгдэнэ. Тухайлбал:

- Үгүйсгэх утгатай "not" бүтээвэр туслах үйл үг болон баймж үйл үгийн араас орж, хураагдан хэлэгдэхдээ "n" болон "t" гийгүүлэгчдийн дундах "o" авиа сугаран "n't" болдог. Жишээлбэл, "isn't, aren't, wasn't, weren't, don't, doesn't, didn't, haven't, hasn't, hadn't, couldn't, wouldn't" гэх мэт.
- Англи хэлэнд өргөлттэй, өргөлтгүй үгийн араас орж буй "of", "to" угтвар буюу хийсвэр бүтээвэр нь өмнөх үгээ даган нийлж нэг үг болох үзэгдэл байдаг. Жишээлбэл, "a lot of, out of, sort of, got to, ought to" гэх мэт нь "a lotta, outta, sorta, gotta, oughta" гэж нэг болж хэлэгддгийг үзвэл "т" авиагаар төссөн үгийн араас орж байгаа "to" шууд даган нийлснээр давхарлаж орсон "т" авиаг зарим нэг хэсэг нь дан "т" шиг дуудна, нөгөө хэсэг нь давхарлаж орсон хоёр "т" авиаг дуудсанаар хэлэнд чичирхийлэл үүсэж улмаар "р" авиа шиг хэлэгдэн "go(r)a, lo(r)a" гэж байгаа юм шиг хэлэгддэг. Харин "going to, want to, trying to" гэсэн үгсийн "н" авианы араас орж буй "т" авиа нь "н" авиатай ижилсэн "gonna, wanna, trynna" гэсэн нэг үг болж хэлэгдэнэ. Үүнээс гадна "kind of" нь "kinda", "have to" нь "hafta", "has to" нь "hasta" гэж хэлэгддэг.



3. Тус тусдаа бие даасан өргөлттэй, утга зүйн болон хэл зүйн хэд хэдэн үг нийлж нийлмэл авианы үг үүсгээд сүүлдээ хэвшин, утга санаа нь нэг болчихсон үгс англи хэлэнд мөн их биш ч цөөнгүй байдаг. Жишээлбэл, “баяртай” гэсэн утгатай “goodbye” гэдэг үг нь “бурхан чамтай хамт” гэсэн утгатай “god be with you” гэсэн үгнээс үүсэн авианы үг юм. Түүнчлэн, “day’s eye” гэхийг “daisy”, “sheep herd” гэхийг “shepherd”, “fourteen-night” гэхийг “fortnight”, “loaf-ward” гэхийг “lord” гээд “of (the) clock” гэдгийг “o'clock” гэж нэг авианы үг болгон дууддаг байж байгаад улмаар бие даасан нэг үг болон хэвшжээ. Ийнхүү хэвшсэн зарим англи үг эртний англи хэлнээс үүссэн байх бөгөөд тухайлбал, “whole be thou” гэсэн гурван үг нийлж дуудагдан “hello” гэсэн авианы нэг үг болсон байх жишээтэй байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд “нийлмэл авианы үг” нь бичгийн бус ярианы хэлний үзэгдэл бөгөөд ярианы урсгалд нэг өргөлтөнд хоёр ба түүнээс олон үг нийлэн орж, нэг үг мэт хэлэгдэх үзэгдлийг хэлж байна. Энэ үзэгдэл нь монгол, англи хэлэнд түгээмэл тохиолдож байгаа бөгөөд үүсэж буй бүтцийн хувьд ч ижил төстэй байна. Авианы үг үүсэхдээ амнаас урсан гарч буй үг хэллэгийг аль болох эвтэйхэн, амар хялбар байлгахад үйлчилдэг эгшиг зохицох, гийгүүлэгч зохицох, ижилсэх, ондооших, авиа гээгдэх, сугарах ёсын дагуу хувирч хэлний хэмнэлийн зарчимд захирагдаж байна. Монгол, англи хэлний нийлмэл авианы үг үүсэж буй онцлог шинж дараах байдалтай байна:

1. Өргөлттэй үгийн араас өргөлттэй үг орох үед арын үг нь өргөлтөө алдан өмнөх үгэндээ татагдан нийлж, авианы нэг үг болж байна. Монгол хэлэнд өргөлттэй үгийн араас орохдоо өргөлтөө алдан хэлэгдэж байгаа үг нь үйл үг, туслах үг, холбоос, холбох үйл үг, дагавар үг байхад англи хэлэнд туслах үйл үг, холбоос, биеийн төлөөний үг өргөлтөө алдан өмнөх үгээ дагаж орж байна.
2. Бие даасан өргөлттэй үгийн араас орж буй бүтээвэр гол үгэндээ татагдан нийлж, нэг үг болон хэлэгдэнэ. Монгол хэлэнд уг бүтээвэр нь сул баймжит бүтээвэр, олон тоо заасан бүтээвэр, таамаглах утга илэрхийлэх бүтээвэр, ерөнхийлөн хамаатуулах болон чиглэл заасан тийн ялгалын нөхцөл гэх мэтээр илэрч байхад англи хэлэнд үгүйсгэх бүтээвэр, угтвар буюу хийсвэр бүтээврээр илэрч байна.
3. Хоёр хэлэнд хоёуланд нь дээрх аргаар нийлмэл авианы үг үүсэн улмаар хэвшин нэг үг болсон жишээ олонтоо тохиолдож байна. Үүнээс үзэхэд энэ нь гарцаагүй ярианы хэлний үндсэн шинжийн нэг юм.

### НОМ ЗҮЙ

1. Артендов.Б.Д, *Фонология современного русского литературного языка*, Кишинев, 1979.
2. Ахманова.О.С, *Словарь лингвистических терминов*, м., 1966
3. Базаррагчаа.М. *Зөв дуудах зүй*, Уб., 1984.
4. Brown, G. *Listening to Spoken English*. Second Edition. London: Longman, 1990.
5. Brown, J. and A. Hilferty. *Listening for reduced forms*, 1986. *TESOL Quarterly* XX/4: 759-763
6. Brown, J. and A. Hilferty. *The effectiveness of teaching reduced forms for listening comprehension*, 1982. Paper presented at the TESOL convention, Honolulu, Hawaii

7. Brown.J. *Authentic communication: Whyzit importan' ta teach reduced forms?*, 2006. University of Hawaii at Manoa
8. Владимирцов.Б.Я, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика*, лгр., 1929.
9. Злобина И.С. *Using Reduced Forms in Spoken American English*, Россия, 2010. Филологические науки/7. Язык, речь, речевая коммуникация
10. Зээнямбуу.Ч, Базаррагчаа.М, *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*, Уб., 2014.
11. Matthews.P.H, *Oxford concise dictionary of linguistics*, Oxford, 2007.
12. Robert W. Norris. *Keeping up with Native Speaker Speed: An Investigation of Reduced Forms and Deletions in Informal Spoken English*, 1994. Article published in *Studies in Comparative Culture*, No. 25: 72-79
13. Төмөртоого.Д. *Хэл шинжлэлийн нэр томъёоны хураангуй толь*, Уб., 2004.
14. Энхбат.Д. *Хэл шинжлэлийн Англи-Орос-Монгол толь бичиг*, Уб., 2003.
15. Weinstein, N. *Whaddaya say? Guided practice in relaxed speech (2nd ed.)*, London, 2001.
16. <http://www.etymonline.com/>
17. <http://en.wikipedia.org/>

## RESUME

When people speak fast or at natural speed, they often reduce or contract sounds, sometimes, syllables in a word or combined words because of linguistic economy principle. This phenomenon, which only occurs in spoken language, is named as “phonetic word” in Mongolian and “contraction” in English. These two terms denote a word that is made up of two or more words that are connected together. While the words are combined in flow of speech, some sounds of them can be transformed, weakened, dropped or lost, which is governed by some phonetic rules like assimilation, dissimilation, elision, vowel reduction, vowel and consonant harmony etc.

Generally, the structure and forming of phonetic words or contractions in Mongolian and English are almost same except some peculiarities. In both languages, the structure and general feature of those words are as follows:

- Stressed word + stressed word. In this situation, the first word usually keeps its stress, but the following word loses its stress. Therefore, it is attracted or governed by the preceding word and as a result, they come under the one stress becoming one word.
- Stressed word + morpheme. The morpheme is not stressed, so it usually follows and attached to the preceding stressed word.
- Some phonetic words, formed in the ways above mentioned, become standard and usual like a independent word.

**ОРЧУУЛГЫН ЗОХИОЛЫН НАЙРУУЛГЫН  
УР МАЯГТ ХИЙСЭН АЖИГЛАЛТ**  
**/А.П.Чеховын “Дугтуйтай хүн” зохиолын жишээн дээр/**

М.Алтанцэцэг  
Г.Нямгэрэл  
/МУИС/

**Товч агуулга:** Уран зохиолын найруулга нь хэлний дүрслэх болон яруу хэрэглүүрийг өргөн ашигладаг, уран дүрийг бүтээдэг, үгсийн сангийн бүхий л нөөцийг хэрэглэх боломжтой байдгаараа бусад найруулгаас ялгардаг. Энэ өгүүллэгт найруулгын ур маяг, зарим алдааг А.П.Чеховын “Дугтуйтай хүн” өгүүллэгийн жишээн дээр авч үзэв.

**Түлхүүр үг:** Үг давталт, үгийн оноолт, хэл зүйн хэлбэржилт, хэм хэмжээ, үг бүтэх ёс, хэмнэлтийн зарчим, үгийн өнгө аяс.

Дэлхий нийтийн сонгодог зохиол бүтээл, түүн дотроос оросын сонгодог бүтээлээс орчуулахдаа уншигчдын оюун санааны хэрэгцээ гоо зүйн боловсролд нөлөөлөхүйц, тэдний сэтгэлийг ямагт догдуулж байдаг нийгэм, улс төр, аж байдлын чухал асуудалд хариу өгсөн, уран бүтээлчдэд бүтээн туурвих, урнаар дүрслэхийн жишээ болсон зохиолыг манайд орчуулан нийтлэх уламжлал нэгэнт тогтжээ.

Үгийг хэчнээн зөв орчуулсан ч хооронд нь холбон найруулж чадахгүй бол өгүүлбэр болохгүй. Аливаа зохиол чухамхүү өгүүлбэрээс бүтэх учир өгүүлбэрийн ур найруулга хэдий чинээ сайтай байна, зохиол төдий чинээ яруу сайхан болох нь мэдээж. “Хэл зүйн утга нь байрлалд шүтэж, байрлал нь холбоход шүтэх тул бүтцийн утга, холбохын утга нь харилцан нягт шүтэн барилдсан зүйл”<sup>1</sup> гэж академич Ш.Лувсанвандан бичжээ. Энэ нь өгүүлбэрийг найруулахдаа үгийн байрлалыг сайтар бодож, утга нь тод байхаар холбох хэрэгтэй гэсэн үг юм.

Түүнчлэн М.И.Калинин “Хэрэв үгээр үнэн зөв, яруу тодорхой илэрхийлж чадаагүй бол хүний оюун ухааны дээд ололт, хамгийн гүн гүнзгий мэдлэг, хамгийн хурц тод санаа хүмүүст хүртэхгүй өнгөрнө” гэсэн байдаг. Энэ бол найруулгад эрхэмлэх зүйл даруй мөн. Найруулга зүйн шаардлага хангаагүйгээс найруулгын алдаа үүсдэг

Бид А.П.Чеховын “Дугтуйтай хүн” хэмээх өгүүллэгийг /Ш.Цэгмэд, 1983 он/ хэрхэн орчуулсан найруулгын ур маягийн талаас нь авч үзэхийг зорилоо.

Ер нь орчуулга, тэр дундаа уран сайхны орчуулга бол амаргүй, маш нарийн

---

<sup>1</sup> Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн асуудал. Хэл зохиол судлал. XXI боть. УБ.,1979.

чимхлүүр хөдөлмөр шаарддаг. Энэ үүднээс уг өгүүллэгийг орчуулж, монгол уншигчдын хүртээл болгосон нь сайшаалтай боловч найруулгын талаас илүү нягт нямбай хандах ёстой байжээ гэж бодогдоно.

I. Нэг үг болон төрөл үгийг ойр ойрхон давтсанаас найруулгын ур маяг сулардаг.

1. А на педагогических советах он просто угнетал нас своею осторожностью, мнительностью и своими чисто футлярными соображениями. Багш нарын зөвлөгөөн дээр бол өөрийн сэрэмж болгоомжлол, өөрийн дугтуй доторх зангаараа биднийг шаналгадаг билээ. /237-р талд/

2. ... когда мы вместе шли в гимназию, был скучен, бледен, и было видно, что многолюдная гимназия, в которую он шёл, была страшна, противна всему существу его, и что идти рядом со мной ему, человеку по натуре одинокому было тяжело. Өглөө бид хамт сургуульд нь очих замд түүний царай уйтгартай зэвхийрэн цайж, түүний очиж яваа олон хүн бүхий сургууль нь эрхтэн бүхэнд нь жигшүүртэй байсан нь илтэд үзэгдэж миний дэргэд явахад тийм ганцаар байдалтай хүнд их л хэцүү байдагсан./239-р талд/.

II. Үг оновчгүй сонгосноос илэрхийлэх гэсэн зорилгодоо хүрч чадахгүйд хүрдэг.

1. Вы должны с уважением относиться к властям. Та засгийн эрхлэгчдийг хүндлэх хэрэгтэй./245-р талд/ хэмээн буулгасан нь “Удирдлагадаа хүндэтгэлтэй харилцах ёстой” гэдэг санааг гаргах гэсэн бололтой. Найруулгын ийм төрлийн алдаатай жишээ хэд хэд байна. Тухайлбал: Катит на велосипеде Коваленко, а за ним Варенька, тоже на велосипеде, красная, заморенная, но весёлая, радостная. Коваленко дугуй унан, түүний хойноос Варенька мөн дугуй унан явна. Царай нь улайран зүдэрсэн боловч баяр цэнгэлтэй байв./244-р талд/. “Улайрах” гэдэг үг нь “ажилд, тоглоомонд” гэх мэт үгтэй холбогдож “махрах, мэрийх, чармайх”, хамаг санаа сэтгэлээ тавих гэсэн утгыг илтгэдэг. Мөн хол газар дугуйгаар явахад хөл нь цуцаж ядрахаас биш, зүдэрнэ гэхэд арай оновчгүй болжээ. Дээрх өгүүлбэрт “царай нь улайх”, “цуцаж ядрах” гэж оруулсан бол арай дээр баймаар. Иймд дээрх жишээ нь учир шалтгааны алдаатай өгүүлбэр болжээ.

2. А под вечер оделся потеплее, хотя на дворе стояла совсем летняя погода, и поплёлся к Коваленкам. Орой гадаа нь зуны цаг байсан боловч дулаан хувцаслаж Коваленкогийн руу майжрав/247-р/ “Поплёлся” гэдэг үгийг “маажрав” гэж оноосон нь үг сонголтын алдаа гэж үзэхээс өөр аргагүй. Үүний оронд “сажлав”, “гэлдрэв” гэх мэтийн аль нэгээр хэлбэл зүгээр байсан мэт санагдана. “Орой нь гадаа зуны цаг байсан”-гэж монгол хүн ярьж бичдэггүй.

3. Он молодой, высокий, смуглый, с громадными руками, и по лицу видно, что говорит басом. Энэ багш болбол өндөр биетэй, бор царайтай, залуувтар хүн, лут том гартай ба бүдүүн дуугаар ярих нь түүний нүүрний байдлаар мэдэгдэнэ. /239-р тал/. “Нүүрний байдлаар” гэхийн оронд “Харваас түүний гадна дүр төрхийг ажиглахад бүдүүн дуутай байх гэмээр” гэсэн санааг илэрхийлэхийг оролдсон бололтой. Тэгээд ч учир шалтгааны хувьд бүдүүн нарийн дууг хоолойны өнгөөр ялгахад нүүрний байдлаар мэдэж болмооргүй. Түүнчлэн адилтгал зүйрлэлийг буруу хэрэглэснээс уг зүйлийн утга агуулгад тохирохгүй этгээд хачин дүрслэл бий

болдог.

4. А она ужу не молодая, лет тридцати, но тоже высокая стройная, чернобровая, краснощёкая, -одним словом не девица, а мармелад. Эгч нь их залуу биш, гучаад насны, хар хөмсөг, улаан хацартай нь ер нь хүүхэн биш, амтат жимс билээ. /239-р талд/. Энэ өгүүлбэрт бүсгүй хүний гоо үзэсгэлэнг амтат жимстэй адилтгаж байгаа юм шиг боловч амтат жимс гэсэн нь найруулах ур маягийн хувьд тун зохисгүй болжээ. Түүнээс гадна эх зохиолд нь мармелад /бүржмэл чихэр/ гэсэн байна.

5. О, как звучен, как прекрасен греческий язык! – говорил он слапким выражением: Аяа грек хэл ямар сайхан аялгуутай, ямар сайхан сонсогдоно вэ! Хэмээх амттай дуугаар өгүүлж... /237-р талд/ Со сладким гэснийг “амттай” гэж шууд үгчлэн орчуулжээ. Ерөөсөө “амттай” хэмээх харьцангуй тэмдэг нэрийг идээ ундааны зүйлд тодотгох үүргээр шууд утгаар хэрэглэхээс гадна “амтат зүүд”, “амтат яриа” гэх зэргээр утга шилжүүлэн ярьж, бичдэг тохиолдол бий.

6. Для него были ясны только циркуляры и газетные статьи, в которых запрещалось что-нибудь. Тэр гагцхүү хориглосон зүйлийн тухай бус харин Беликовт аливаа хориглосон зүйл л илүү ойлгомжтой байдаг гэсэн санааг өгүүлж байгаа бололтой.

7. .... и так такая разбитная, шумная.... чуть что, так и зальётся голосистым смехом: ха, ха, ха! Бас их үймээнтэй шуугиантай ба ... сав л хийвэл ха, ха, ха гэж чанга гэгчээр инээнэ. /239-р талд/. Эмэгтэй хүний зан аалийг “яриа хөөрөөтэй”, “дуу шуутай”, “ижий ахай болсон” гэж хэлдэгээс үймээн шуугиантай гэдэггүй. Харин орон байр заасан үгтэй нийлж “үймээн шуугиантай анги, танхим, хот” гэх заргийн нийлэмж үг үүсэж болно.

8. ... Идёт Коваленко по улице, здоровый верзила, вышитой сорочке ..., в одной руке пачка книг, в другой толстая суховатая палка. Гудамжинд өндөр цэлгэр чээжтэй, нэхмэл цамцтай Коваленко нэг гартаа ном барин, нөгөө гартаа мод тулан явна. /241-р талд/.

“Өндөр цэлгэр чээж”, “гартаа тулах” гэсэн хэлбэр оновчгүй мэт. Харин ном сугавчлан, нөгөө гараараа мод тулан явна гэх нь арай дээр.

9. Всякого рода нарушения, уклонения, отступления от правил приводили его в уныние хотя казалось бы, какое ему дело? Аливаа нэгэн хууль дүрмийг зөрчсөн явдал гарвал хэдүй түүнд үл хамаарагдах авч тэрээр их гуниглан гутрах мэт билээ. /227-р талд/. Ямар нэгэн хууль дүрэм зөрчсөн явдал гарахад хэдийгээр өөрт нь огт хамаагүй боловч тэрээр ямагт сэтгэлээр унан гонсойдог гэсэн шиг санааг гаргах байсан бололтой. Монгол хэлэнд үйлдэгдэх хэвийн нөхцөлийг тийм ч түгээмэл хэрэглэдэггүй онцлогтой. Байгаль нийгмийн юм үзэгдэл, хүний нөхцөлийг тийм ч түгээмэл хэрэглэдэггүй онцлогтой. Байгаль, нийгмийн юм үзэгдэл, хүний мэдрэхүйн эрхтэнд аяндаа өртөн тусах, үйл явдлыг өөрөө хийе гэвч хүчин мөхөсдөх, бусдын давамгай хүч чадал, зүй тогтлын эрхэнд болохыг заасан нөхцөлд л /нүдэнд үзэгдэх, гарт баригдах, дайнд ялагдах, үерт автах, тоглоомд хожигдох/ хэрэглэгддэг.

10. В разрешении же и позволении скрывался для него всегда элемент сомнительный, что-то недосказанное и смутное. Харин зөвшөөрөх, үл зөвшөөрөх зүйлүүд бол түүнд нэг л бүдэг татгалзаатай, хэлж төгсөөгүй зүйл мэт санагдана. /237-р талд/. Дээрх онцолсон үг хэллэгийг төдийлөн дүйлгээгүй орчуулсан байна.

Уг нь ямар нэгэн хууль дүрмийн цаана эргэлзээтэй, тодорхой бус, бүрхэг, дутуу дулимаг зүйл байгаа юм шиг түүнд санагддаг хэмээх утгыг илэрхийлэх гэсэн бололтой.

III. Монгол хэлний үг бүтэх ёс, үгийн хэлбэржилт, хэл зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс хэл зүйн найруулгын алдаа үүсдэг.

1. У Ивана Ивановыча была довольно странная, двойная фамилия-Чимша Гималайский ... и его по всей губернии звали просто по имени и отчеству. Малын эмч бол Чимша-Гималайский хэмээх хачин хос нэртэй боловч мужийн олон хүмүүс түүнийг зөвхөн Иван Иванович гэж дуудна. /239-р талд/. Үүнийг “Хачин нэртэй Чимша-Гималайскийг мужийнхны олонх нь Иван Иванович гэнэ” гэж орчуулсан бол арай дээр болох мэт. Мөн “бол” гэдэг үг илүүдсэнээс гадна олны утгыг “олон хүмүүс” гэж давхар илэрхийлсэн нь зохисгүй болжээ. Монгол хэлэнд “татгалзаатай” гэсэн үг байдаггүй.

2. Мөн 237-р талд буй “ямар нэгэн сурагчдын тухай цуурхал яриа гаргах...” гэсэн жишээнд “ямар нэгэн” гэсэн ялгах төлөөний үгийг олон тооны нөхцөлтэй жинхэнэ нэрэнд угсруулж холбосон нь хэл зүйн хувьд алдаатай болсон бөгөөд “ямар нэгэн” /хэн нэгэн”/ сурагч гэж буулгасан бол зүгээр байжээ.

3. Би бас танд хэлэх зүйл хэд хэд байна. /247-р талд/ гэсэн өгүүлбэрт “би” гэдэг I биеийн төлөөний үгийг өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржүүлж “Над хэлэх зүйл байна”, “Би танд... хэлмээр байна” гэж ч орчуулж болмоор...

IV. Шаардлагатай илүү үг нуршсанаас чухам юуны тухай өгүүлж байгааг ойлгоход түвэгтэй болдог. Ийм алдаа хэлний хэмнэлтийн зарчмыг зөрчсөнөөс үүсдэг. Аль ч хэлэнд товчлох ёс, заримдаг ба нэрлэсэн өгүүлбэр, төлөөний үг зэргийг хэрэглэдэг нь хэлний хэмнэлтийн зарчмын тодорхой илрэл мөн.

1. Учитель же гимназий Буркин каждое лето гостил у графов П... и в этой местности давно уже был своим человеком. Буркин нь П... гүнгийн дунд зун цаг бүр айлчлах учир хэдүй нь эндхийн хүн мэт болжээ. /236-р талд/. Энд зун бүр гэхэд л ойлгомжтой юм.

2. Тэр хоёр элдвийн түүх ярихын сацуу ахлагчийн эхнэр Мавра гэгч ухаантай, эрүүл чийрэг эм боловч өөрийн тосгоноос хол гараагүй, хот, төмөр зам зэргийг үзээгүй сүүлийн арваад жилд гэртээ пийшингийн дэргэд сууж, гагцхүү шөнө болоход гудамнаа гардаг гэнэ хэмээн хэлэлцэж байснаа Буркин өгүүллүүн.... /236-р талд/. Энэ жишээнд “өөрийн” хэмээх ялгах төлөөний үг, “жил” гэсэн цагийн нэрд залгасан өгөх оршихын тийн ялгалын –“д” нөхцөл, “болоход” гэсэн үйл үг тус тус илүүджээ. Түүнчлэн “гэх”, “хэлэлцэх” гэдэг нь “хэлэх ярих” гэсэн адилхан утгыг илтгэдэг байхад гурвууланг нь угсруулан хэрэглэх шаардлагагүй.

Бас хоёрдугаар ангийн сурагч Петров, дөрөвдүгээр ангийн сурагч Егоров нарын хувь заяаг хэрхэн шийдэж байгааг дүрслэхдээ эхлээд сахилга батын хариуцлага тооцож дараа нь сургуулиас хөөсөн гэдэг санааг хэтэрхий нуршсаныг дараах өгүүлбэрээс ажиглаж болно. Он давил на всех, и мы уступали, сбавляли Петрову и Егорову балл по поведению, сажали их под арест и в конец концов исключали и Петрову и Егорову. Петров Егоров хоёрын сахилга батын үнэллээс хасуулж,



шоронд суулгаад бүр сүүл сүүлд нь Петров, Егоров хоёуланг хөөсөн билээ. /237-р талд/ гэсэн өгүүлбэрт хэний тухай өгүүлж байгаа нь тодорхой байсаар атал үйлийн эзнийг дахин дурдах хэрэггүй, зайлшгүй шаардлагатай бол “тэд” хэмээх III биеийн төлөөний үгийг сонгох боломжтой байсан.

3. А то, что мы проводим всю жизнь среди бездельников, сутяг, глупых праздных женщин говорим и слушаем разный вздор-разве это не фуляр? Бас бүх насыг ажил хийхгүй хүмүүс тэнэг гоёмсог хүүхэн авгай нарын дунд өнгөрүүлж жигшмээр юмсыг ярих буюу сонсож байх нь бас л дугтуй биш үү? /247-р талд/. Үгийг буруу байрлуулах нь хэл зүйн алдаа бөгөөд дээрх жишээнд “авгай хүүхэд”, “авгай хүүхэн” “хүүхэн” гэж ярьж бичдэг. Мөн ... өнгөрүүлж.. ярих буюу сонсож байх нь бас л дугтуй биш үү? гэж найруулсан нь учир зүйн хувьд алдаатай байна.

V. Ярьж бичиж буй зүйлдээ үгийн өнгө аясыг тохируулах нь найруулга зүйн чухал шаардлагын нэг байдаг. Ганц үгсийн өнгө аяс тохирохгүйгээс ийм алдаа гарч болно.

Людей, одиноких по натуре, которые, как-отшельник или улитка, стараются уйти в свою скорлупу, на этом свете не мало. Дун хорхой мэт хальсанд ороод суудаг ганцаар байдалтай хүмүүс энэ ертөнц дээр цөөнгүй /236-р талд/. Энд тэр хүнийг ганцаардмал зожиг гэж хэлсэн санаа гарч байгаа, харин “хальсанд ороод суудаг” гэсэн хэллэг нь ойлгомжгүй, этгээд хачин санагдана. Чой.Лувсанжав багшийн “Орос монгол өвөрмөц хэлцийн толь”-д “уйти в скорлупу” гэсэн хэллэгийг “довоо шарлуулах, худгийн мэлхий шиг байх, тэндээ шигдэх, явцуурах, хар амиа хаацайлах, аминдаа арчтай бай” гэх зэргээр орчуулжээ. Иймд “хальсанд ороод суух” гэхийн оронд дээрх хэллэгийн аль нэгээр орчуулах нь оновчтой байжээ.

Түүнчлэн орчуулгын зарим хэсэгт юуны тухай өгүүлж байгаа нь мэдэгдэхээргүй өгүүлбэр ч тохиолдож байна. Жишээ нь “Беликов мэтийн тийм хүмүүсийг оршуулах гэдэг их төлөв тааламжгүй хэрэг шүү. Оршуулгын газраас буцаж ирэхэд бидний нүүр царай ердийн дорой мэт байсан нь бага насандаа томчууд гадагш бид бүрэн эрхтэйгээр цэцэрлэг дотуур нэг хоёр цаг гүйж явдаг шиг тааламжтай сэтгэлийг ил гаргахыг хэн ч хүссэнгүй”. /247-248-р талд/.

Бид уг зохиолын орчуулгад гарсан улирах цагт эдгэшгүй шавхагдашгүй ер бусын цэнэгтэй байдаг. Иймд уг бүтээлийг дахин дахин орчуулдаг нь тэрхүү шавхагдашгүй чанарыг нь илтгэн харуулж байгаа хэрэг. Чухамхүү орчуулгын ачаар сонгодог бүтээл туурвил мөнхөрдөг бөгөөд тэр ч байтугай уг зохиол бичигдсэн эх хэл нь мөхсөн хойно ч орчуулга нь үлдэж өнөөг хүрсэн жишээ соёлын түүхэнд олон бий. Орчуулагч бол зохиогчийн өрсөлдөгч гэж ярилцдаг хэмээн эрдэмтэн зохиолч Э.Оюун гуайн бичсэнийг анхаарууштай юм.

## НОМ ЗҮЙ

1. Ц.Сүхбаатар. Монгол хэлний найруулга зүй. УБ., 2009.
2. А.П.Чеховын түүвэр зохиол. УБ., 1983.
3. Ш.Лувсанвандан. “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн асуудал.
4. Хэл зохиол судлал. XXI. УБ., 1986.
5. Орчуулах эрдэм. УБ., 1976.

### **РЕЗЮМЕ**

В данной статье, опираясь на материалы перевода повестей А.П.Чехова.

“Человек в футляре” сделал попытку вкратце рассмотреть некоторые стилистические ошибки на конкретных примерах.

Из проанализированных примеров видно, что при переводе нужно уделять понятиям формы и содержания языков, очень важно вникнуть в оттенки значений, оттенки ассоциаций.

**МОНГОЛ ХЭЛНИЙ “ХЭЗЭЭ” ХЭМЭЭХ АСУУХ ТӨЛӨӨНИЙ ҮГИЙН  
ӨГҮҮЛБЭРТ ИЛРЭХ БҮТЭЦ, УТГА, ҮҮРГИЙН ОНЦЛОГ**

Т.Энх-Амгалан  
/МУИС/

Төлөөний үгийг хэлний зүйн бүтээлүүдэд аливаа зүйлийг шууд заан нэрлэхээс гадна шууд нэрлэхгүй зөвхөн төлөөлүүлэн хэлэх, ялгах, асуух утгатай бүлэг үгс хэмээн эрдэмтэд тэмдэглэсээр иржээ.

“Юм ба түүний бэлэг чанарыг шууд нэрлэхгүй зөвхөн төлөөлөн хэлэх, ялган заах, асуун лавлах зэргийн утга илтгэх хэсэг үгсийг төлөөний үг” гэнэ.

Монгол хэлний асуух төлөөний үгийн гүйцэтгэх үүрэг нь маш олон талтай, хэрэглэгдэх хэмжээ нь туйлын өргөн юм. Тухайлбал: *Хэн?, юу?* гэх асуух төлөөний үгийг гол төлөв жинхэнэ нэрийн зүйлд хэрэглэх бөгөөд *хэн* гэдгийг хүн төрөлхтөнд хэрэглэж, *юу* гэдгийг хүн төрөлтнөөс бусад зүйлд хэрэглэнэ. Жишээ нь: **Хэн байна? Захирал байна. Хэн хийх вэ? Бат хийнэ. Уулнаас юу авав? Уулнаас мод авав.** гэх мэт<sup>1</sup>.

Монгол хэлний ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үгийн үндсэн утга, үүргийн талаар эрдэмтэд “...үйл явдлын цаг хугацааг лавлан асуухад хэрэглэнэ” (Ж.Төмөрцэрэн 1966, 206), “...цагийг асуух үг” (Ш.Лувсанвандан (1968)1999, 20), “...цаг хугацааг төлөөлөн асуухад хэрэглэнэ” (Л.Балдан 1987, 82), “...хэрэг юмын цаг хугацааг төлөөлөн асуухад хэрэглэнэ” (Б.Ваанчиг 1990, 243), “...цаг хугацааг лавлан асууна” (Ц.Өнөрбаян 1994, 214), “...ерөнхий төлөөлсөн үглэвэр” (М.Базаррагчаа 2005, 163) гэх мэтээр тодорхойлсон байдаг бөгөөд төлөөний үгийн утга, үүргийн онцлогийн талаар хэл судлаач эрдэмтэн М.Базаррагчаа, Б.Пүрэв-Очир, Ц.Цэдэндамба, Ю.Мөнх-Амгалан, З.Гулираанз, Ц.Оюун, Ө.Мөнхдолгор, М.Алтанцэцэг нарын бүтээлд туссан байдаг.

ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үг нь тийн ялгалаар хагас хувилна. Тухайлбал: Нэрлэх тийн ялгалд-ХЭЗЭЭ, Харьяалах тийн ялгалд-ХЭЗЭЭНИЙ, Өгөх орших тийн ялгалд-ХЭЗЭЭД, Гарах тийн ялгалд-ХЭЗЭЭНЭЭС гэж хувилдаг<sup>2</sup> байна.

ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үг нь ерийн асуусан утгын зэрэгцээ бусад төлөөний үгийн адилаар янз бүрийн бүтцээр илэрч, төрөл бүрийн утга илтгэж өвөрмөц үүрэг гүйцэтгэдэг нь ажиглагдлаа.

ХЭЗЭЭ гэх асуух төлөөний үгийн хувьд аливаа үзэгдэл юмс, үйл байдлын цаг хугацаа, болсон үеийг лавлан асуухад хэрэглэнэ. Жишээлбэл:

*Чи хэзээ хөдөө явах вэ?(ерийн асуусан)↔ Чиний нөгөө хөдөө явна гэсэн*

<sup>1</sup> ШУА.Хэл зохиолын хүрээлэн. Орчин цагийн монгол хэл зүй. 1966. 206 тал

<sup>2</sup> ШУА.Хэл зохиолын хүрээлэн. Орчин цагийн монгол хэл зүй.1966. 207 тал

чинь хэзээ билээ дээ?(лавлан асуусан) гэх мэт.

Монгол хэлний ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үгийн өгүүлбэрт гүйцэтгэх утга, үүргийг илрүүлэх. ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үг нь хэлэхийн явцад үндсэн хэлбэр болох ХЭЗЭЭ болон бусад хэлбэрээрээ тохиолдож байгаа нь дараах утгуудыг илэрхийлсэн байна.

Үүнд:

1. **ХЭЗЭЭ** дангаараа илрэх бөгөөд энэ нь цаг хугацааг ерийн лавлан асуусан утга илтгэж байна. Тухайлбал: *Хоол унд хийхийн завсар дав дув цочин хонх хэзээ дуугарах бол гэхээс яс хавтайх шиг болно.* (Д.Намдаг., Цаг төрийн үймээн., 1990.22)

2. **ХЭЗЭЭ+үйл үг** (хэзээ дуудах, хэзээ хүрнэ, хэзээ дуугарах, хэзээ ирсэн, хэзээ дуусах, хэзээ олох... гэх мэт ) гэсэн хэлбэрээр илрэх бөгөөд эдгээр нь ерийн асуун лавлах утга илтгэж байна. Тухайлбал: *Хар Хорумын ордон харш өвгөрөн хуучирч, засан сэлбэх цаг аль хэдийнээ болсон боловч улсын сан хөмрөг нимгэн учир хэзээ зузаарч нэмэгдсэн хойно сая засаж сэлбэх ажлыг хийхээс өөр аргагүй гэж бодов.*(ХХ зууны утга зохиолын дээж суварга., IV боть.,18 )

3. **ХЭЗЭЭ Ч** гэдэг задлаг хам бүтэц нь мөн тодорхойгүй цаг хугацааг заах утга илтгэдэг байна. Энэ хорвоод хэзээ ч, хэдийд ч хүрээд ирэхэд өөрийн нь гэр орон энд байгааг сайн ойлгосон гэж бодож байна. (МУЗ-н дээжис.,43.,139)

4. **ХЭЗЭЭ Ч+үйл үг, тодотгон холбох хэлбэртэй+гүй** гэх хэлбэрээр илрэх бөгөөд энэ задлаг хам бүтэц нь тухайн үйлийг одоо болон ирээдүйд дахин хийж гүйцэтгэхгүй гэсэн утга илтгэнэ. Тухайлбал:

*Тэвэрт чинь түгшүүр баяр хослуулан хоносон шөнөөс хойш*

*Тэвдэхдээ бугуйнаас минь ширүүхэн атгачихаад*

*Хэн хэн нь эвгүйцсэн ч бөөн баяртай байсан*

**Хэзээ ч давтагдахгүй сайхан мөч** (Б.Энхтуяа., Алсын одын бүдэг гэгээ.,1983.,200), *Нийслэл хүрээнийхэн үйл олноороо хөхөн баяссан ийм сүртэй сайхан баяр ёслолыг урьд хожид хэзээ ч үзээгүй болохоор хүн бүрийн сэтгэл хөөрөн догдолж их чөлөөнд хуран цугласаар байлаа.* (Д.Намдаг., Цаг төрийн үймээн., 237)

5. **ХЭЗЭЭ Ч+гэсэн** хэлбэр өгүүбэрт хэрэглэгдэх бөгөөд энэ нь үргэлж дандаа гэсэн утга илтгэж байна. Тухайлбал: *Хараагүй болсон хүн хэзээ ч гэсэн Хайран нүдээ мартдаггүйтэй адил* (У.Шекспир., Эмгэнэлт жүжгийн түүвэр., 2001.16)

6. **ХЭЗЭЭ Ч+билээ** гэсэн задлаг хам бүтэц нь өгүүлбэрт эргэлзсэн утга илтгэдэг байна. Тухайлбал:

*Чи миний сэтгэлд тооноор унах цасан ширхэг адил буусан*

*Би чиний буух замаар гэртээ харьж явсан*

**Хэзээ ч билээ** нойрондоо сонссон үгийг минь чи шивнэж

*Хэлсэн үгнээс чинь миний тарьсан алимны цэцэг үнэртэж байсан* (Д.Багтогтох., Сарны охин., 1990.24)

7. **ХЭЗЭЭ Ч+юм** гэсэн задлаг хам бүтэц нь өгүүлбэрт өгүүлэгчийн өгүүлж буй зүйлдээ таагүй, бүтэхгүй санааг илэрхийлсэн сөрөг утгыг илтгэнэ. Тухайлбал: *Түмэн олон эрх жаргалыг эдлэх нь хэзээ ч юм миний зүгээс л лавтай итгэл төрөхгүй байна.* (Д.Намдаг., Цаг төрийн үймээн., 1990.243)

8. **ХЭЗЭЭ Л** гэх хэлбэр нь тухайн болж буй үйл явдал урд нь огт болж байгаагүй гэсэн утгаар хэрэглэгдэж болно. *Өдий хавраар хэзээ л тэнгэр дуугарч байлаа даа.*

(МУЗД. 90.14), *Ер тэр цагт монголчууд бид хэзээ л “Төрсний гэрчилгээ” бичиж байлаа даа.* (Д.Хатанбаатар. Тэртээх жилүүдийн хүүрнэл. 1992)

9. **ХЭЗЭЭ Л+билээ, юм, бол** гэсэн задлаг хам бүтэц нь өгүүлбэрт ихэвчлэн тодорхой биш хугацааг заах утга илтгэдэг байна. Тухайлбал: *Дамдин хүүгээ гөлрөн ширтэж, хэзээ л билээ нүдний доод зовхи сүрхий татсан юм. Уйлах гэж тэгж байж дээ гэж бодов.* (С.Дашдооров., Говийн өндөр., 2004. 23)

10. **ХЭЗЭЭ Л бол ХЭЗЭЭ** гэсэн задлаг хам бүтэц нь өгүүлбэрт дурийн цаг хугацааг сонгох утгатай бөгөөд энэ нь ихэвчлэн зөвшөөрсөн эерэг утга илтгэж байна. Тухайлбал: *Хэзээ л бол хэзээ, өнөөдөр ч гэсэн болно. -Хаана юм бэ дээ. -Долоон буудлын тэрээд шүү.* (Монголын шилдэг өгүүллэг. 1981. 97), *Эрт орой хэзээ л бол хэзээ нүд аних хүүхэд байна.* (Л.Түдэв. Дайрлага дайравзай. 1996. 45)

11. **ХЭЗЭЭ ЯЗААНЫ** хэмээх задлаг хам бүтэц нь өгүүлбэрт тухайн зүйлийг сайн мэддэг гэсэн утга илтгэнэ. *Дондог хэзээ язааны аав хүн шиг хүүхдүүдэд сургаал айлдаж байв.* (МУЗД., 90 боть.,120), *Цэдэн тэгэхээс тэгэх гэж хөрөөгөө байдаг тэнхээгээрээ шигтгэн дарж заримдаа угз угз татсан авч Байгалмаа огтхон ч мөчөөгөө өгөхгүй хэзээ язааны сурмаг байдлаар хөрөөдөж байлаа.* (Д.Мягмар., Нийлэх замын уулзварт., 1962)

12. **ХЭЗЭЭД** гэдэг хэлбэр нь тухайн үйл болон байдал нь үргэлж байх хувьсан өөрчлөгдөхгүй гэсэн утга илтгэж болно. *Тэр хэзээд Индиан удирдагчийн хүү байсан.* (МУЗД.,79.,181)

13. **ХЭЗЭЭДЭЭ** хэмээх хэлбэр нь өгүүлэмжийн агуулгаас хамааран өвөрмөц утгыг үүсгэдэг тухай эрдэмтэн Ю.Мөнх-Амгалан, М.Алтанцэцэг, А.Эрдэнэ нар дурдсан байдаг. Үүнд: *А.тухайн үйлийг хийсэн цаг хугацааны тухай, Б.тухайн үйлээ хурдан шалмаг хийж гавшгай байгааг магтан сайшаасан эсвэл хам хум, дутуу дулимаг зүйл хийчихээгүй байгаа гэж эргэлзсэн, гайхсан, сэтгэл зовсон байдлыг ч илэрхийлсэн байж болно* хэмээн бичжээ.

Харин бидний ажиглалтаас үзэхэд **ХЭЗЭЭДЭЭ** хэмээх үг нь өгүүлбэрт орохдоо хам бүтэц үүсгэж буй үгээсээ шалтгаалан дараах утгуудыг илтгэж болно. Үүнд:

А. Тухайн болж буй үйл, болц, байдал нь гэнэтийн санаанд оромгүй зүйлд хандсан сэтгэлийн аяс илтгэсэн утгатай. Тухайлбал: *Чи минь хэзээдээ ирээ вэ? Надад хэлэхгүй дээ би чинь тосоод угтах байсан юм.*

Б. Мөн хэзээдээ хэмээх хэлбэр нь **ХЭЗЭЭДЭЭ+үйл үг+билээ, байлаа** гэх мэт хэзээдээ чаддаг байлаа, хэзээдээ уншдаг байлаа, хэзээдээ мэддэг байлаа гэсэн хэлбэрүүдийг үүсгэх бөгөөд энэ нь тухайн өгүүлбэрт голсон, чамласан сөрөг утгыг илтгэнэ. Тухайлбал: *Чи хэзээдээ чаддаг байлаа би л хоол хийдэг биз дээ.* (Аман ярианаас)

14. **ХЭЗЭЭ ХЭЗЭЭГҮЙ, ХЭЗЭЭ ЯЗААГҮЙ** хэмээх хам бүтэц нь өгүүлбэрт удахгүй болох цагийн утга орчуулсан үгийн үүргээр хэрэглэгддэг байна. Тухайлбал: *Очир...ямархан нэгэн зүлэг хар санаа цээжиндээ зангируулан бухимдаж явна уу гэлтэй, хэзээ хэзээгүй аадар цутгах гэж байгаа тэнгэр адил баргар царайлан, эмээл дээрээ сөөжилдээд бодлогширон исгэрч явна.* (Ю.Мөнх-Амгалан., 2007., 59), *Батаагийн хүүхэн залуу сайхан хүүхэн харагдана. Бас бие давхар хэзээ язаагүй нярайлах ажээ.* (С.Бадарч., Нисэгч., Амьдрал [Арван өгүүллэг] 1965)

15. **ХЭЗЭЭ+үйл үг+БОЛ** (...хэзээ харах бол, хэзээ дуулах бол, хэзээ дуудах

бол...) хам бүтэц нь өгүүлбэрт

А.тодорхой бус хугацаа заан лавлан асуух утга илтгэнэ. Тухайлбал: *Би хэзээ дуулах бол та хараад өгөөч.* (МУЗД., 60 боть., 56)

Б.хүсэн санагалзах утгатай. Тухайлбал: *Чинийхээ гэгээн тунгалаг дүрийг хэзээ харахсан бол доо.*

В.тухайн үйл явдал, хэрэг байдалд түвэгшээн залхсан утга илтгэнэ. Тухайлбал: *Та манай гэрээс хэзээ явахсан бол.*

16. **ХЭЗЭЭ ЯМАГТ** гэсэн хам бүтэц нь өгүүлбэрт байнга, үргэлж гэсэн утга илтгэнэ. Тухайлбал: *Дүү чинь хэзээ ямагт хичээлээ давтан их сургуульд орохоор шамдаж байгаа.* (МУЗД. 2 боть. 87)

17. **ХЭЗЭЭ ХЭЗЭЭНЭЭС** хэмээх хам бүтэц нь урд хожид тохиолдоогүй зүйлийн цаг хугацааг заах утгатай. *Өнөөдөр яагаад ч юм хэзээ хэзээнээс илүү ганцаардаж байгаагаа мэдрэн сэтгэл минь тавгүй болж, элдвийг сэтгэнэ.* (МУЗДээж., 43.,34)

18. **ХЭЗЭЭ МӨДГҮЙ** хэмээх хам бүтэц нь өгүүлбэрт тодорхой бус цагийг заах утгатай. Тухайлбал: *...Тату шиг үнэнч боолыг олоход бэрх, бас түүнийг үхүүлэхийг Бат хэзээ ч үл зөвшөөрөхийг сая анзаарч мэдсэн тул... тулгар байсан бөгөөд одоо төрөх нь хэзээ мөдгүй болсон тул хөвгүүн төрүүлээд байгаасай гэж ихэд хүсч байлаа.* (С.Жаргалсайхан, Л.Удвал., Чингис хааны нууц түүх., 2005.473)

19. **ХЭЗЭЭ НЭГ(ЭН) ЦАГТ** хэмээх задлаг хам бүтэц нь өгүүлбэрт цагийн утгат нэр, тодорхойгүй цагийн утга заана. Тухайлбал: *Тогшилт байн байн үргэлжилсээр, худалдаачны сэтгэлд гучаад жилийн өмнөх нэгэн аймшигт явдал сэрхийж, зүүд мэт мартагдсан бурангуй ёст тэртээ орны ихэс дээдсийн өмнө ам өгч байсан тэр бүхнийг агшнаа санаж, үргэлж биедээ авч явдаг жижигхэн гар чийдэнгээ гаргаад “хэзээ нэг цагт хэрэглэнэ гэсэнсэн”... гэж бодоод хаалгаа нээж шинэ холбоочныг оруулан хариу өгөв.* (З.Баттулга., Хөх тэнгэр.,1962.)

20. **ХЭЗЭЭНИЙ, ХЭЗЭЭНЭЭС** хэмээх хэлбэр нь өгүүлбэрт эртний, урьдны, аль эрт гэсэн утгаар хэрэглэгддэг байна. Тухайлбал: *Цанлигдорж, дэлэг гуай хоёр хэзээний танил тул амар мэнд мэдэлцэж, аяганы амсар зуух зуур эс бусын юм эрээ цээргүй ярьж эхлэв.* (А.Дашням., Өлзийнарангийн өчил., 1974), *...Манайхан хэзээнээс эмс охид сайхантай, дуунд дуртай. За, дүү охин, би нэг ая бариач, сонсьё.* (С.Эрдэнэ., Хөх хулгана жил., 1970)

21. **ХЭЗЭЭД** хэмээх хэлбэр нь байнга, үргэлж гэсэн утгаар хэрэглэгддэг байна. Тухайлбал: *Үзэсгэлэнт сүмбэр уул үл хөдлөх мэт*

*Үнэн сайн чанарт хүн хэзээд тогтуун явах*

*Өчүүхэн хөвөнгийн хэсэг тогтворгүй хийсэн мэт* (Эрднийн сан Субашид., 1990. 49)

**ХЭЗЭЭ** гэх асуух төлөөний үг нь өгүүлбэр болон эхийн дотор холбох үгийн үүргээр хэрэглэгдэх нь тохиолдож байна.

1. Энэ хэлбэр нь энгийн өгүүлбэрүүдийн хооронд тохиолдохдоо аль нэг өгүүлэмжийн болох цаг хугацааг илэрхийлэх утга зааж болно. Тухайлбал: *Бат: Чи миний дээлийг хэзээ дуусгах вэ? Ямаахай: Эсгэх нь эсгэсэн хэзээ дуусахыг мэдэхгүй одоо би гутал уллаж байна.*



2. Энэ хэлбэр нь өгүүлбэрийн эхэнд тохиолдвол тохиолдох хэлбэрээсээ шалтгаалан илэрхийлэх утга нь ялгамжаатай байна. Тухайлбал ХЭЗЭЭ гэх асуух төлөөний үг дангаараа тохиолдвол өгүүлбэртээ өгүүлэгдэж буй өгүүлэмжийн цаг хугацааг тодруулах утгатай байна. Тухайлбал: *Хэзээ бичиж дуусах вэ?*

3. Ажиглалтаас үзэхэд ихэвчлэн ярианы хэлэнд ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үгийг вэ хэмээх асуух сул үгтэй хам бүтэц үүсгэн тухайн өгүүлбэрийн төгсгөлд хэрэглэн нэхэн шаардсан утга итгэдэг байна. Тухайлбал: *Чиний энэ тавиур засна гэсэн чинь хэзээ вэ хэзээ?*

### Дүгнэлт

1. Монгол хэлний ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үг нь өгүүлбэрт орохдоо үндсэн хэлбэрээрээ тохиолдвол ерийн асуух утгатай.

2. Монгол хэлний ХЭЗЭЭ- хэмээх асуух төлөөний үг нь өмнөө болон ардаа авах үгээсээ шалтгаалан байнга, үргэлж, тодорхойгүй гэх зэрэг цагийн утгат харьцааны утга илэрхийлсэн байдаг нь тодорхой байна.

3. ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үг нь хам бүтэц үүсгэж буй үгээсээ шалтгаалан янз бүрийн баймж утгыг илэрхийлдэг нь хэлний баримтаас харагдаж байна.

4. ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үг нь өгүүлбэр болон эхийн дотор хэрэглэгдэхдээ хоёр өгүүлбэрийг холбох үүрэг гүйцэтгэдэг байна.

5. ХЭЗЭЭ хэмээх асуух төлөөний үгийг өгүүлбэрт олон тооны хэлбэрээр хэрэглэх нь ховор юм.

### НОМ ЗҮЙ

1. Алтанцэцэг М, Эрдэнэ А. “Хэзээ” хэмээх асуух төлөөний үгийн утга, үүрэг, хэрэглээний зарим онцлог, “Монгол хэл шинжлэл”. ШУА.Хэл зохиолын хүрээлэн. Боть IX(XXXI). Уб. 2006.
2. Базаррагчаа М. “Орчин цагийн монгол хэлний энгийн өгүүлбэр”. Уб.1993.
3. Базаррагчаа М. “Монгол хэлний нэгжүүдийн харьцаа холбоо”. Гурван-Эрдэнэ БДС-ийн ЭШБ №2. Уб. 2000.
4. Базаррагчаа М. “Монгол хэл”. Уб. 2000.
5. Базаррагчаа М. “Монгол хэлний өгүүлбэр судлал”. Уб. 2005.
6. Балдан Л. “Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал”. Уб. 1987.
7. Бямбасан П. “Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг”. Уб.1975.
8. Мөнх-Амгалан Ю. “Монгол хэлний АЛЪ хэмээх асуух төлөөний үгийн үүрэг-утга зүйн онцлог”. МУИС.МХХСЭШБ №226. XXVI. Уб. 2006.
9. Мөнх-Амгалан Ю. “Монгол хэлний ХЭ- язгуурт асуух төлөөний үгийн үүрэг-утга зүйн онцлог”. МУИС.МХХСЭШБ №285. XXVII. Уб. 2007.
10. Мөнхдолгор Ө. “Монгол хэлэн дэх өгүүлбэр зүйн зэрэгцсэн гишүүдийг ерөнхийлөн товчлох арга”/Докт.Дисс./УБ. 2001.
11. ШУА. ХЗХ. “Орчин цагийн монгол хэлний зүй”. Уб. 1966.
12. Өнөрбаян Ц. “Орчин цагийн монгол хэлний зүй”. Уб. 1998.
13. Өнөрбаян Ц. “Орчин цагийн монгол хэлний үг зүй. Уб. 1994.
14. Пүрэв-Очир Б, Мөнх-Амгалан Ю, Гулираанз З. “Монгол хэлний энгийн

өгүүлбэр-эхийн онол практикийн зарим асуудал”. III дэвтэр. Уб.1995.

### **SUMMARY**

Issues of pronoun in Mongolian language indicate meaning of demonstrative pronoun, interrogative pronoun and distinguishing pronouns. Interrogative and distinguishing pronouns haven't been studied much thus we emphasize form and function in sentences.

**АНГЛИ ХЭЛНИЙ УГТВАР ҮГИЙН БҮТЭЦ ХИЙГЭЭД ҮГИЙН  
САНГИЙН НЭГЖИЙГ БҮТЭЭХ ЧАДАМЖ**

Ц.Отгонсүрэн  
Д.Түвшинтөгс  
/МУИС/

**Abstract: *The morphological structure of English prepositions and their capacity to derive lexical words***

This article, a sequel study of “The structural - functional systems of English prepositions” [7], discusses the morphological structure of English prepositions. It focuses on correlation between syntactical positioning and functional use, rather than semantic capacity.

Historically, English used to possess grammatical cases, which were eventually replaced by emerging prepositions. Prepositions in modern English are common and numerous, whereas we collected 145 prepositions from the Oxford dictionary for the ultimate purpose of this study - the morphological classification of prepositions as simple, complex and marginal.

Although English prepositions are considered to be grammatical words, they are also able to derive new lexical formations. Particularly, simple prepositions are highly versatile elements to form nouns, adjectives, adverbs, verbs, prepositions and conjunctions, but other two are limited in this process.

**Оршил**

Өгүүлбэрт үг болон гишүүдийн хоорондын харьцааг заасан нэгж буюу хэл зүйн үг хэмээн нэрлэгддэг угтвар үг нийт “150 орчим” [4:6] байдаг гэж үзэх бөгөөд англи хэлний хамгийн ээдрээтэй, маргаантай асуудлуудын нэг юм. Тэдгээрийн бүтцийг нарийвчлан судлах нь илэрхийлэх утгаас гадна өгүүлбэр дэх байр хийгээд гүйцэтгэх үүргийг судлахын суурь гэж хэлж болно. Өмнө нь “*Англи хэлний угтвар үгийн бүтэц-үүргийн тогтолцоо*” өгүүлэл [7] хэвлүүлсэн бөгөөд энэ удаад уг өгүүллийн “Англи хэлний угтвар үгийн бүтэц” хэсгийг дэлгэрүүлж, угтвар үг хэрхэн бүтэх хийгээд үгийн сангийн бусад нэгжийг хэрхэн бүтээдэг талаар илүү гүнзгийрүүлэх зорилгоор судалгааны тулгуур хэрэглэгдэхүүн болгож, англи хэлний тайлбар толь бичиг [8]-ийн хүрээнд нийт 145 угтвар үг, мөн 380 гаруй угтвар үг бүрдүүлбэртэй үгийг түүж, нягтлан үзлээ.

Түүхэн үүднээс авч үзвэл, эртний англи хэлнээ ихэнх угтвар үг нэг үетэй байсан агаад дундад үеийн англи хэлэнд тоо нь нэмэгдэж, ойролцоо утгатай угтвар үгээс гадна зэрэгцсэн нийлмэл угтвар үг (Compound Preposition) олноор бий болсон аж.

Үүний нэг шалтгааныг өвөг-Герман хэл (Proto-German)-ний өргөлттэй ойртсон гэж үздэг бөгөөд нөгөө шалтгаан гэвэл эртний англи хэлний үеэс үгийн эцсийн үеийн өргөлт аажимдаа суларсантай холбож үздэг. Англи хэлний утгвар үгийн хөгжил дэх хамгийн том өөрчлөлт бол 1500 оноос хойш зөв бичих зүй (The Orthography)-г хэвшүүлсэн явдал бөгөөд чухам энэ үеэс л орчин цагийн англи хэлний үе эхэлдэг. Энэ үед англи хэлийг стандартчилах болж, эртний болон дундад үеийн англи хэлэнд байсан энгийн (Simple) болон зэрэгцсэн нийлмэл (Compound) утгвар үгээс гадна шинээр утгвар үг үүсэж, угсарсан нийлмэл утгвар үг (Complex Preposition) шинээр бий болсон тухай Д.Вебер (D.Weber) судалгаандаа өгүүлжээ [3:10]. Мөн түүнчлэн англи хэлний үгийн санд шинэчлэл хийх оролдлого 1650-1800 оны үеэс улбаатай бөгөөд Жорж Харрис (George Harris) нэг утга санааг хэд хэдэн үгээр илэрхийлэх үзэгдлийг анхааран судалжээ. Тухайлбал, *unto, until, selfsame, foursquare* гэх мэт үг нь *to, till, same, square* зэрэг үгсийн утгыг илэрхийлдэг байж. Энэ мэт ижил утгатай хэд хэдэн үгийг зохиолчид түгээмэл хэрэглэх болж, зарим нь нэг үе бүхий үгийг хэрэглэх сонирхолгүй, олон хувилбараас сонгохыг эрмэлзэх болжээ [1:282].

Дээрх мэт учир шалтгааны улмаас англи хэлний утгвар үг бүтцийн хувьд өөрчлөгдөж, өргөжин хөгжсөөр өнөөгийн хэмжээнд хүрчээ.

## I. АНГЛИ ХЭЛНИЙ УГТВАР ҮГИЙН БҮТЭЦ

Бүтцийн ангиллын хувьд эртний (450-1150) болон дундад үе (1150-1500)-ийн англи хэлнээ [1:50,154] утгвар үгийг энгийн (Simple) болон зэрэгцсэн нийлмэл (Compound) гэж ангилан үздэг байв. Өөрөөр хэлбэл энгийн утгвар үгэнд дан бүрдүүлбэр бүхий (*æfter, æt, fram, geond, of, ofer, on, op, samod* etc.) үгс хамаарагдах бөгөөд зэрэгцсэн нийлмэл утгвар үгэнд бие даасан хоёр үг зэрэгцсэн буюу эхний бүрдүүлбэр нь утгвар үг, хоёр дахь бүрдүүлбэр нь утгвар үг (*æt+foran, be+geondan, be+innan, be+neofan, in+to, on+butan, on+innan, to+foran, wið+innan* etc.)-ээс гадна дайвар үг (*be+æftan, be+ufan, on+ufan*), холбоос (*to+eacan*), тэмдэг үг (*and+lang*) эсвэл тооны нэр (*be+tweone*)-ийг багтаан үздэг байв [3:10]. Эдгээр зэрэгцсэн нийлмэл утгвар үгийг зөв бичих зүйн үүднээс салангид бичдэг байснаа хэлний хөгжлийн явцад буюу тодруулбал, дундад үеийн англи хэлний үеэс нийлүүлэн бичих болсон. Тиймээс орчин цагийн англи хэлний судлаачид дээрх хоёр бүтцийг нэг ангилалд багтаан, энгийн (Simple) гэж нэрлээд дундад үеийн англи хэлний сүүл үед үүсэн бий болсон хоёр болон түүнээс дээш бүрдүүлбэр бүхий утгвар үгийг угсарсан нийлмэл (Complex) гэж тус тус салган нэрлэх болжээ. Англи хэлний утгвар үгийг судалсан олонх эрдэмтэд уг ангиллыг баримталдаг бол Квөрк нар (*Quirk. et al*) [10:667] захын (Marginal) утгвар үг гэсэн ангиллыг нэмж оруулснаар С. Гранат (S.Granath) [12:54-7], Д.Вебер (D.Weber) нарын зарим судлаачид дээрх ангиллыг баримталжээ.

Англи хэлний утгвар үгийн бүтцийн ангиллын тухай асуудлыг нягтлан үзэж, эл гурван өөр бүтэц бүхий утгвар үг нь өгүүлбэрт үг болон гишүүдийг холбож, тэдгээрийн хоорондын харьцаа заадаг ижил үүрэгтэйг нь үндэслэн, бид сүүлийн ангиллыг баримталж байна.

### I.1. Энгийн утгвар үг (Simple Preposition)

Энэ хэсэгт үндсэндээ дан үгсийг хамааруулах агаад тэдгээр нь дараах хэдэн

онцлогтой байна.

I.1.1. Нэг бүрдүүлбэр бүхий энгийн угтвар үг: Энэ ангилалд *about, at, as, for, from, in, like, on, near, since, with* гэх мэт дан үг бүхий угтвар үгийг хамааруулдаг. Энэ нь нийт угтвар үгийн дотор хамгийн олон тохиолддог бөгөөд бусад бүтэц бүхий угтвар үгтэй харьцуулахад харьцангуй хийсвэр шинжтэйгээс гадна нэг өгүүлбэрт давтагдах боломжтой. Өөрөөр хэлбэл, энэ нь эдгээр угтвар үгнүүд хэл зүйн үүрэг (grammatical function) болон үгийн сангийн ай (lexical category)-н хувьд ялгаатай байдагтай холбоотой юм. Тухайлбал: өгүүлбэр (1)-т буй гурван *to* байгаагийн эхний болон гурав дахь *to* нь *turn* болон *fuel* үйл үгийн эс тухайлах хэлбэр ('TO' infinitive), харин хоёр дахь нь чиглэхийн угта илтгэх харьцаа заасан нэгж (grammatical word - preposition) болж байгаагаараа хэл зүйн үүргийн хувьд ялгаатай байдлыг харуулж байна. Харин өгүүлбэр (2)-т буй үгс үгийн сангийн айн хувьд ялгаатай байна. Тухайлбал: *around* нь *be* үйл үгтэй нийлж хэлц үйл үгийг үүсгэх нэмэлт (particle of phrasal verb) бөгөөд *for* нь үргэлжлэх хугацааг заасан угтвар үг (preposition), харин *over* нь 70 жил гэх тоо хэмжээг баримжаалан заасан дайвар үг (adverb) болж байна.

(1) *Compared with its neighbors, Dubai had limited reserves, prompting its rulers to turn to other industries to fuel their bold economic aspiration* [14:23].

(2) *After all, GEICO has been around for over 70 years* [14:12].

I.1.2. Хоёр бүрдүүлбэр бүхий энгийн угтвар үг: Энэ ангилалд *alongside, around, besides, between, throughout, towards, unlike, upon, within, without* гэх мэт зэрэгцсэн нийлмэл угтвар үгнүүд багтана. Эдгээр нь угтаа дундаа зураас (hyphen (-))-тай бичигддэг байсан бөгөөд хөгжлийн явцад зөв бичих зүй болон хэлний хэмнэх зарчим (The Principle of Economy)-ын үүднээс тэрхүү зураасыг хэрэглэхээ больж, нийлүүлэн бичиж тэмдэглэснээр дан үгийн түвшинд авч үзэх болсон тухай өмнө нь дурдсан билээ. Энэ талаар К.Бөржерс, К.Бурриж нар (K.Börjars, K.Burridge) “Зэрэгцэн нийлүүлэх арга нь үгийг хувилгах бус шинээр үг үүсгэх нэгэн арга бөгөөд эхний үгэндээ өргөлттэй байна. Хэв шинжийн хувьд салангид бичигдсэн нийлмэл үгийг салангид үг (separate word), харин зураасгүйгээр нийлүүлэн бичсэнийг нь энгийн үг (single word) гэж үзнэ” хэмээн өгүүлжээ [5:22].

Англи хэлний тайлбар толь бичгээс түүсэн энгийн бүтэц бүхий 78 угтвар үгээс зэрэгцсэн нийлмэл бүтэц (compound prepositions)-тэй үгсийг тусгайлан нягталж үзвэл ихэнх угтвар үг нь аль нэг үедээ угтвар үг бүрдүүлбэртэй байхад цөөн хэд нь хоёр үедээ угтвар үгээс өөр нэгж бүрдүүлбэртэй байна (Хүснэгт-1).

**Хүснэгт-1. Хоёр бүрдүүлбэр бүхий энгийн угтвар үгийн бүтэц**

№	Үг		Жишээ
	I үе	II үе	
	Угтвар үг (Prep)	Угтвар үг (Prep)	<i>in+to, on+to, through+out, up+on, with+in, with+out</i>
	Угтвар үг (Prep)	Нэр үг (N)	<i>along+side, in+side, out+side, de+spite</i>
	Угтвар үг (Prep)	Дагавар (Suf)	<i>to+ward, to+wards</i>
	Үйл үг (V)	Угтвар үг (Prep)	<i>be+twixt</i>
	Үйл үг (V)	Тэмдэг нэр (Adj)	<i>be+fore, be+hind, be+low</i>

	Үйл үг (V)	Тооны нэр (Num)	<i>be+tween</i>
	Угтвар (Pref)	Угтвар үг (Prep)	<i>un+like, un+till</i>
	Угтвар (Pref)	Нэр үг (N)	<i>a+board, a+round, a+cross, a+top</i>
	Угтвар (Pref)	Тэмдэг нэр (Adj)	<i>a+long</i>

Энэ ангилал дахь нэгэн өвөрмөц нэгж бол *notwithstanding* (*not+with+stand+ing* буюу үгүйсгэл+угтвар үг+үйл үг+залгавар) билээ. Хэдийгээр дөрвөн нэгж бүрдүүлбэртэй ч нийлүүлэн бичдэг учраас нэг үг хэмээн үзэж энэхүү ангилалд багтаадгийг орхигдуулж болохгүй юм.

### 1.2. Нийлмэл угтвар үг (Complex Preposition)

Уг ангилалд угсарсан нийлмэл угтвар үгийг хамруулав. Өмнөх ангиллын нийлмэл угтвар үгээс ялгаатай нь бүх бүрдүүлбэр нь нийлээд нэг утга санааг илтгэж, нэг үүрэг гүйцэтгэдэг ч хоорондоо салангид бичигддэг онцлогтой. Бүтцийн хувьд С.Гранат (S.Granath)-ын тодорхойлсноор "...Хоёр бүрдүүлбэртэй бол «**дайвар үг/тэмдэг нэр/холбоос+угтвар үг**», гурван бүрдүүлбэртэй бол «**угтвар үг+нэр үг+угтвар үг**»" [12:56] байх агаад үүнийг цааш лавшруулан судалж, нягтлах учиртай.

Мөн М.Махмузаде (M.Mahmoodzadeh)-ын бичсэнээр англи хэлний угтвар үгийг хэлбэр, үүрэг, утгаар нь ангилж болно. "Хэлбэрийн хувьд энгийн (Simple), нийлмэл (Complex) угтвар үг гэж хоёр ангилах бөгөөд энгийн угтвар үг нь хаалттай болсон ангилал". Өөрөөр хэлбэл шинээр ийм угтвар үгийг үүсгэх боломжгүй гэсэн үг. Харин "нийлмэл угтвар үг нь нээлттэй ангилал бөгөөд шинээр үүсгэх боломжтой" [6:734–40] аж. Тиймээс цаашид нэмэгдэх, зохион хэрэглэхийг үгүйсгэх аргагүй юм. Юутай ч бид өнөөгийн хэмжээнд хоёр бүрдүүлбэр бүхий дөч гаруй, гурван бүрдүүлбэр бүхий гуч орчим, нийт дал гаруй угсарсан нийлмэл бүтэцтэй угтвар үгийг тайлбар толь бичгээс олж тэмдэглэсэн бөгөөд одоогийн байгаа баримтандаа түшиглэн, тэдгээрийн үүссэн бүтцийг ажиглавал дараах онцлогтой байна.

### Хүснэгт-2. Нийлмэл угтвар үгийн бүтэц

	1-р үг	2-р үг	3-р үг	Жишээ
<b>Хоёр бүрдүүлбэртэй угтвар үг</b>				
	Дайвар үг	Угтвар үг	=	<i>across from, ahead of, astern of, instead of, regardless of, together with</i>
	Холбоос	Угтвар үг	=	<i>because of, but for, except for</i>
	Угтвар үг	Угтвар үг	=	<i>along with, as against, as for, as per, in between, save for, up against</i>
	Тэмдэг үг	Угтвар үг	=	<i>irrespective of, other than, preparatory to, regardless of, prior to</i>
<b>Гурван бүрдүүлбэртэй угтвар үг</b>				
	Угтвар үг	Нэр үг	Угтвар үг	<i>by means of, in accordance with, in virtue of, on behalf of, on account of, with reference to</i>

Энэхүү судалгаагаар С.Гранат (S.Granath)-ын үзсэнээс зөрөөтэй нэгэн зүйл бүтэц ажиглагдсан нь "**Угтвар үг+Угтвар үг**" юм. Үүнийг хоёр бүрдүүлбэр бүхий угсарсан нийлмэл угтвар үгийн бүтэцэд багтаасны шалтгаан бол энэхүү бүтцийн



эхний бүрдүүлбэр болох *along* (Prep, Adv), *as* (Prep, Adv, Conj), *in* (Prep, Adv, Adj, N), *save* (V, N, Prep, Conj), *up* (Adv, Prep) үгнүүд нь *save* -ийг эс тооцвол бүгд угтвар үг болон дайвар үг гэсэн давхар үүрэгтэй. Мөн бүгд хэлц үйл үгийн нэмэлт (Particle of Phrasal Verb)-ийн үүрэгтэй байгааг тайлбар толь бичгээс багатгаж болно. Тиймээс эдгээр үгсийг дайвар үг гэж үзэх үндэс болж чадахгүй. Мөн түүнчлэн хэлц үйл үгийн бүрдүүлбэр болсон үг нь эл үгийн үндсэн үүрэг биш учраас үүнээс цааш угтвар үг үүсэх логик хамаарал байхгүй хэмээн үзэж болно. Хэдийгээр В. Буллокар (W.Bullokar) “Хэлц үйл үгийн нэмэлт болон угтвар үг хоёр угтаа ижил” [3: ] гэж үзэж байсан ч энэхүү ойлголт орчин цагийн англи хэлэнд аль алиныг үүсгэсэн гэж гарал зүйн хувьд бага сага зөрчил үүсгэх талтай.

### 1.3. Захын угтвар үг (Marginal Preposition)

Энэхүү ангилал бол харьцангуй сүүлд үүссэн бас судлагдсан бөгөөд эл ангилалд хэлбэр, бүтцийн хувьд угтвар үг бүрдүүлбэргүй ч аль нэг угтвар үгтэй ижил утгыг илтгэх үйл үг болон түүний төгсгөл (Present болон Past Participles) бүхий бүтэцтэй *concerning*, *excepting*, *regarding*, *considering*, *compared*, *given* гэх мэт үгнүүд хамаарагдах бөгөөд ийм угтвар үгс харьцангуй цөөхөн ч найруулгын дээд өнгө аясыг илэрхийлдэг тул ялангуяа эрдэм шинжилгээний болон албан бичгийн найруулга буюу бичгийн англи хэлэнд түлхүү хэрэглэгддэг онцлогтой.

1) *She has said nothing regarding your request.* [9]

Тайлбар толь бичгийн хүрээнд угтвар үг гэсэн тэмдэглэгээтэй, ийм бүтэц бүхий найман үг бүртгэж авсан. Гэхдээ эл бүтцийг бүрдүүлж буй үйл үгсийн *-ed/-ing* төгсгөл нь ижил учраас *based on*, *depending on*, *depended on* гэх мэт үгстэй андуурагдах тал бий. Өөрөөр хэлбэл, “Захын үгс дангаараа бие даан угтвар үгийн үүрэг гүйцэтгэдэг бол энэ мэт цөөн хэдэн үйл үг шаардлагатай угтвар үгийг давхар авснаар энэхүү захын бүтэцтэй угтвар үгээс өөр бөгөөд энэхүү ангилалд оруулах боломжгүй” [11:135] аж.

## II. УГТВАР ҮГ ҮГИЙН САНГИЙН НЭГЖИЙГ БҮТЭЭХ ЧАДАМЖ

Англи хэлний угтвар үг хэл зүйн үг хэдий боловч үгийн сангийн бусад нэгжийн бүрдүүлэгч болдгоороо ихээхэн онцлог байна. Энэ талаар анх XVI зууны үеэс хөндөж эхэлсэн бөгөөд В. Буллокар (W.Bullokar) *up*, *down*, *in*, *before*, *beneath*, *behind*, *beyond*, *under* гэх мэт угтвар үгс нь *up-upper*, *upermost/upmost*; *down-downer*, *downermost/downmost*; *in-iner*, *innermost/inmost* гэх мэтээр тус бүртгээ өөрийн харьцуулсан болон давуу зэргийг үүсгэдэг<sup>1</sup> гэжээ. Мөн зарим энгийн бүтэцтэй угтвар үг нь *-ward/-wards* залгаврыг авч тэмдэг нэр болон түүнээс үүссэн дайвар үгийг үүсгэдэг талаар судалжээ [3:16–7].

3) *Shortly afterwards he met her again.* [9]

4) *It is about time we updated our software.* [9]

Ер нь шинэ үг үүсэх (Derivation) нь үгийн үндсэнд залгавар залгах аргаар шинэ үг үүсгэх бөгөөд англи хэлний хувьд “... хэлбэр ижил, үүрэг өмнөө залгаварууд

<sup>1</sup> -Буллокар (W.Bullokar) нарын бусад судлаачдын “угтвар үгс өөрийн харьцуулсан болон давуу зэргийг үүсгэдэг” хэмээснийг К.Бөржарс, К.Бурриж (К.Бөгжарс, К.Бурридж) нар өөр байр сууринаас тайлбарладаг. Өөрөөр хэлбэл тэд *near*→*nearer*→*nearest* гэж үүсгэдэг *near*-ийг угтвар үг гэхээсээ илүү тэмдэг нэр гэж үзэх үндэстэй гэж үзсэн [5:68]-ийг энд оруулах нь зүйтэй биз ээ.

олон ажээ” [5:21]. Олонх нь угтвар үг бөгөөд дан гагц угтвар үгийн үндсэн үүргээс гадна тэмдэг нэр (**Adjective: inside, near, minus, round, under**), нэр үг (**Noun: like, minus, over**), дайвар үг (**Adverb: over, towards, under**)-ийн үүргийг давхар гүйцэтгэж, харьцаа зааж байна. Гэхдээ зарим тохиолдолд, тухайн үүсгэж буй үгийн үндсийн өмнө эсвэл ард нь байрлах ба цөөн хэсэг нь нийлмэл үгийн дунд тохиолдож буй учир эдгээрийг угтвар үг (Preposition), угтвар (Prefix), дагавар (Suffix)-ын аль нь болохыг тодруулах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Бидний түүвэрлэсэн хэрэглэгдэхүүнд **about** (prep, adv), **above** (prep, adv), **across** (prep, adv), **after** (prep, conj&adv), **against** (prep), **along** (prep&adv), **before** (prep, conj&adv), **by** (prep, adv, N, pref), **down** (adv, prep, adj, V, N), **for** (adv, prep, conj, pref), **in** (prep, adv, adj, pref, suf, combining form), **like** (prep, conj, adj, adv, V, N, combining form), **off** (adv, prep), **of** (prep, pref), **on** (prep, adv, N), **out** (adv, prep, adj, N, V), **over** (prep, adv, N, pref), **round** (adj, N, adv, prep), **till** (prep&conj, adv), **through** (prep&adv, adj), **under** (prep, adv), **up** (adv, prep, adj, N, V, pref), **upon** (prep), **with** (prep) [13] гэсэн бүрдүүлбэрээр л шинэ үгс үүсэж байгаа нь тодорхой ажиглагдаж байна. Түүнээс гадна бүгд энгийн бүтэцтэй байгаа нь бүх угтвар үг шинээр үг үүсгэх чадамжгүй болохыг давхар харуулж байна. Үүний шалтгаан нь үе болон бүрдүүлбэрийн тоо нэмэгдэх тусам угтвар үгийн хийсвэрлэц багасаж, бодит шинж нь давамгайлан, тодорхой утгыг илтгэж, тогтсон нэг үүрэгтэй болдог бол харин энгийн бүтэцтэй угтвар үг нь харьцангуй хийсвэр шинжтэйн хэрээр илэрхийлэх утга, заах харьцаа, гүйцэтгэх үүрэг нэмэгддэгтэй холбоотой ажээ.

Үүнээс үзэхэд, дээр дурдсан угтвар үгс дангаараа үгийн сангийн зарим нэгжийн үүргийг давхар гүйцэтгэж байгаагаас, зөвхөн *by-, for-, in-, of-, out-, over-, under-, up-* гэх найм нь угтвар (prefix) болж байна. Мөн түүнчлэн шинээр үг үүсгэсэн дээрх үгсээс зарим нь тухайн үгийн үндсийн ард байрлах боловч тэдгээрийг дагавар (suffix) гэж үзэхэд бас учир дутагдалтай юм. Учир нь *on-*оос бусад үгс ийм үүрэг гүйцэтгэдэггүй. Тиймээс энэ төрлийн угтвар үг нь дан угтвар болж хувирсан уу гэсэн асуудал хөндөгдөх нь дамжиггүй.

Эдгээр цөөн хэдэн үгс герман гаралтай гэх бөгөөд эртний англи хэлний үед холбогдож байна [13] (Хүснэгт-3).

**Хүснэгт-3 Угтвар (Prefix)-ын үүрэг бүхий үгс**

Words	Угтвар үг (Preposition)-ийн гарал	Угтвар (Prefix)-ийн гарал
<b>By</b>	Герман гаралтай, эртний англи хэлний <i>bī, bi, be</i> . Голланд- <i>bij</i> , герман- <i>bei</i> .	—
<b>For</b>	Эртний англи хэлний <i>in</i> (угтвар үг) бөгөөд <i>before</i> гэсэн утгатай герман хэлний угтвар үгийн хураасан хэлбэр гэж үзэх боломжтой.	Эртний англи хэлний үед холбогдоно.
<b>In</b>	Герман гаралтай, эртний англи хэлний <i>in</i> (угтвар үг), <i>inn</i> (дайвар үг). Голланд, герман- <i>in</i> (угтвар үг), герман- <i>ein</i> (дайвар үг). Энэтхэг-Европ язгуурын үг бөгөөд латин хэлний <i>in</i> , грек хэлний <i>en</i> .	Латин хэлний <i>in</i> угтвар үгийг зааж байна.

<b>Of</b>	Герман гаралтай, эртний англи хэлний үг. Голланд- <b>af</b> , герман- <b>ab</b> . Энэтхэг-Европ язгуурын үг бөгөөд латин хэлний <b>ab</b> , грек хэлний <b>apo</b> -ээр дамжин бусад хэлэнд орсон.	<b>f</b> -ээр эхэлсэн үгийн өмнө орсон <b>ob</b> -ийн хувилбар аж.
<b>Out</b>	Герман гаралтай, эртний англи хэлний <b>ūt</b> ( <i>Adv</i> ), <b>ūtan</b> ( <i>V</i> ). Голланд- <b>uit</b> , герман- <b>aus</b> .	–
<b>Over</b>	Энэтхэг - Европ хэлний үг. Герман гаралтай, эртний англи хэлний <b>ofer</b> . Голланд- <b>over</b> , герман- <b>über</b> .	–
<b>Under</b>	Герман гаралтай, эртний англи хэлний үг. Голланд- <b>onder</b> , герман- <b>unter</b> .	–
<b>Up</b>	Герман гаралтай, эртний англи хэлний <b>up(p)</b> , <b>upper</b> үг. Голланд- <b>op</b> , герман- <b>auf</b> .	–

Дээрх хүснэгтээс үзэхэд, тодорхой нэг угтвар үг үүсэж байх тэр цаг үетэй зэрэгцсэн түүнтэй ижил хэлбэр бүхий угтвар (тухайлбал *in*) харь хэлнээс орж ирсэн байх магадлалтай. Иймийн тул, эл хоёр нэгжийг нэг нь нөгөөгөө үүсгэжээ гэж үзэхээсээ илүүтэй зарим угтвар үг нь угтварын үүрэг хүлээж, шинээр үг үүсгэсэн гэж үзэх талтай. Үүнийг Давид Веберийн судалгаа дахь “Зарим угтвар үг нь үг бүтээх явцад угтварын үүрэг гүйцэтгэдэг байсан. Эдгээр үгнүүдэд эртний болон дундад үеийн англи хэлэнд холбогдох *after-*, *aet-*, *betweon-*, *bi-*, *for-*, *foran-*, *forþ-*, *fram-*, *gegn-*, *in-*, *mid-*, *neah-*, *nīþer-*, *of-*, *ofer-*, *on-*, *op-*, *þurh-*, *under-*, *wið-*, *wīder-*, *ymb-* зэрэг багтана” [3:10] гэх өгүүлбэр ч давхар нотолж байна.

Үгийн сангийн аль нэг нэгж үүргээр шинэ үг үүсэж байгааг тогтоон тодорхойлоход нэн бэрхтэй бөгөөд “угтвар үг нь нэр үгийн өмнө байрладаг” гэсэн үндсэн зарчимд тулгуурлан, угтвар үг бүрдүүлбэртэй хэмээн үзсэн үгийн сангийн дараах нэгжийг бүтээжээ гэж үзэх боломжтой.

**II.1. Нэр үг бүтээх чадамж:** Дээрх үгнүүдээс үүссэн хоёр зуу гаруй нэр үгийг тэмдэглэснээс угтвар үг бүрдүүлбэртэй хэмээн үзсэн хэдэн үг дараах хэдэн бүтцээр үүсгэсэн байна.

- Verb+Prep+Noun: *fly-by-night* (*найдваргүй хүн*), *play-by-play* (*шууд дамжуулалт*), *sell-by-date* (*хадгалах хугацаа*), *stay-at-home* (*гэрсэг хүн*);
- Noun+Prep+Noun: *father-in-law* (*хадам аав*), *meals-on-wheel* (*нийгэм хангамжийн ажил*), *morning-after-pill* (*жирэмснээс хамгаалах эм*), *mouth-to-mouth* (*амаар хийх хиймэл амьсгал*);
- Prep+Noun: *afterbirth* (*эхэс*), *aftershave* (*сахлын ус*), *downfall* (*уналт, доройтол*), *onrush* (*дайралт*), *percent* (*хувь, хэмжээ*), *tonight* (*орой, үдэш*);

**II.2. Тэмдэг нэр бүтээх чадамж:** Энэ хэсэгт ийм аргаар бүтсэн ер орчим тэмдэг нэр бүтээснийг ажиглавал, өөр өөр байранд тохиолдож байна.

- Prep+Noun: *down-market* (*борчуудын, ядуусын*), *indoor* (*дотоорхи*), *inflight* (*нислэгийн үеийн*), *on-field* (*спортын талбайн*), *onscreen* (*дэлгэцийн*), *overage* (*нас хэтэрсэн*);
- Adv+Prep+Noun: *down-to-earth* (*амьдралд ойр*);
- Noun+Prep+Noun: *day-to-day* (*өдөр тутмын*), *heart-to-heart* (*илэн далангүй*), *house-to-house* (*өрх нэг бүрийн*), *matter-of-fact* (*сэтгэл хөдлөлгүй*);
- Num+Prep+Num: *one-to-one* (*хоёр хүний, хоорондын*);
- Adj+Prep+Noun: *good-for-nothing* (*залхуу, чадваргүй*) гэх мэт.

II.3. Дайвар үг бүтээх чадамж: Энэхүү нэгж тавь гаруй байгаагаас угтвар үг бүрдүүлбэр нь өөр өөр байранд тохиолдож байна.

- Prep+Suf: *afterward* (дараа нь, хожим), *downward* (уруудсан, доош харсан), *forward* (урагш);
- Prep+Noun: *alongside* (зэрэгцсэн), *downstairs* (доошоо), *inwind* (домогш), *upstairs* (шам өөд, өөдөө);
- Adv+Prep+Prep: *heretofore* (өмнө нь), *thereinafter* (доор), *thereupon* (даруй, тэр дор нь) гэх мэт.

II.4. Үйл үг бүтээх чадамж: Энэхүү ангилалд хамаарагдах гуч гаруй үйл үг тэмдэглэснээс угтвар үг үйл үгтэй нийлж, хоёр бүрдүүлбэрийн аль алиных нь дундын утга илэрхийлж байгаагаараа онцлогтой юм. Ялангуяа *perform* (үзүүлэх), *withdraw* (*mamax*) үйл үгийн бүрдүүлбэр болох *per*, *with* нь угтвар үгээс өөр үгийн сангийн өөр нэгжийн үүрэг гүйцэтгэхгүй.

- Prep+Verb: *perform* (үзүүлэх), *withdraw* (*mamax*), *withstand* (*тэсч гарах*) гэх мэт.

Гэхдээ эл бүтэц дэх зарим үйл үг нь дайвар үг бүрдүүлбэртэй байхыг үгүйсгэхийн арга бас үгүй. Тухайлбал Маккарти нийлмэл үйл үг (compound verb): *underestimate* (дутуу үнэлэх), *overcook* (хэтэрхий болгох), *outrun* (түрүүлэх, хөөж гүйцэх); нийлмэл тэмдэг нэр (compound adjective): *overactive* (хэт идэвхитэй), *undercover* (нууц, нууцлагдсан); нийлмэл нэр үг (compound noun): *in-group* (нийтлэг ашиг сонирхолтой бүлэг хүмүүс), *outpost* (алслагдсан суурин), *overcoat* (эрэгтэй хүний хүрэм) [2:60–4] гэж үзсэн ч эдгээр үндсүүдийг сайтар нягтлууштай.

II.5. Угтвар үг бүтээх чадамж: Угтвар үг нь доорх таван бүтцээр арван хоёр угтвар үг бүтээснийг харж болно.

- Prep+Noun: *alongside* (дагуу), *inside* (домор), *underneath* (доогуур);
- Prep+Prep: *into* (домогшоо), *onto* (руу), *throughout* (даяар), *upon* (дээр), *within* (домор);
- Prep+Suf: *toward* (руу, тийш);
- Pref+Prep: *around* (хүрээлсэн, тойрсон), *until* (хүртэл);
- Verb+Prep: *be+twixt* (хооронд, завсар, дунд) гэх мэт.

II.6. Холбоос үг бүтээх чадамж: Түүнчлэн угтвар үг бүрдүүлбэртэй холбоос үг байгааг энд тэмдэглэв.

- Adv+Prep: *whereupon* (тэгээд, дараа нь, тэгснээр) гэх мэт.

## ДҮГНЭЛТ

Англи хэл анх тийн ялгалтай хэл байсан агаад угтвар үг гарч ирснээр тийн ялгалын үүргийг угтвар үг гүйцэтгэх болсон. Тэр цаг үеэс англи хэлний угтвар үг хэлний хөгжлийн явцад бүтцийн хувьд нэлээд өөрчлөгдсөн байна. Үүний учир, англи хэлний угтвар үгийг тодорхой хүрээнд бүтцийн талаас нь ажиглаж үзсэнээр дараах дүгнэлтэд хүрлээ.

- Хэл шинжлэлийн олон онол, арга зүйн үүднээс англи хэлний угтвар үгийг судалдаг бөгөөд гол төлөв энгийн бүтэцтэй угтвар үгэнд тулгуурладаг нь ажиглагдсан. Энэ нь бусад бүтэц бүхий угтвар үгийн хязгаарлагдмал хэрэглээ, үүрэгтэй холбоотой байж болох ч тухайлан судалж, судалгааны

эргэлтэд оруулах нь зүйтэй болов уу.

- Хэл зүйн үгийн хувьд англи хэлний угтвар үг гурван өөр бүтэцтэй байхаас гадна үгийн сангийн бусад нэгжийг ч үүсгэх чадамжтай ажээ. Өөрөөр хэлбэл, энгийн угтвар үгс (Simple preposition) нэр үг, тэмдэг үг, үйл үг, дайвар үг, угтвар үг болон холбоосыг бүтээдэг байна. Харин нийлмэл болон захын угтвар үг ийм чадамжгүй бөгөөд энэ нь харин үе болон үгийн тоо нэмэгдэхийн хэрээр хийсвэрлэц багасаж, илүү тодорхой болдогтой холбоотой бололтой.
- Англи хэлний угтвар үг нэлээд олон үүргийг гүйцэтгэх болсон. Тухайлбал угтвар үг орчин цагийн англи хэлэнд өгүүлбэрийн холбоос (conjunction), угтвар үг (preposition), хэлц үйл үгийн нэмэлт (particle of phrasal verb), тусагдахуун (adverbial) болон угтвар (prefix) болж байна. Энэ бүхэн нь англи хэлний угтвар үгийн бүтэцтэй холбоотой бөгөөд онцгойлон энгийн бүтэцтэй угтвар үг өгүүлбэрт дээр дурдсан бүхий л үүргийг гүйцэтгэдэг. Харин нийлмэл бүтэцтэй угтвар үгийн хувьд гол төлөв арын үг, хэлхэцийг гол өгүүлбэртэй холбох гол үүргийг гүйцэтгэж байхад захын угтвар үгийн хувьд хэрэглээ харьцангуй хязгаарлагдмал байна. Ялангуяа дээд найруулгад хэрэглэгддэг гэж үзэж болно.

### НОМ ЗҮЙ

1. Albert C. Baugh. 1993 (2001). *A History of the English Language*. 4th ed. Foreign Language Teaching and Research Press & Routledge. Beijing.
2. Andrew, Carstairs-McCarthy. 2002. *An Introduction to English Morphology: Words and Their Structure*, Edinburgh University Press.
3. David Weber. 2012. *English Prepositions: A Historical Survey*, Master's Diploma Thesis. Masaryk University.
4. Josef Essberger. 2012. *English Preposition List*, EnglishClub.com. <http://www.englishclub.com>
5. Kersti Börjars & Kate Burridge. 2010. *Introducing English Grammar*, 2nd ed. Hodder Education. An Hachette UK company.
6. Masoud Mahmoodzadeh. April 2012. A Cross-linguistic Study of Prepositions in Persian and English: The Effect of Transfer. *Theory and Practice in Language Studies*. Vol2. No4. pp734-740.
7. Отгонсүрэн, Ц. 2014. *Англи хэлний угтвар үгийн бүтэц-үүргийн тогтолцоо*. МУИС. ШУС. ХУС-ын “Монгол Судлал” ЭШБичиг. Боть XXXVIII (412). Улаанбаатар.
8. *Oxford Advanced Learner's Dictionary*, 4th ed. 1989. Oxford: Oxford University Press.
9. *Oxford Advanced Learner's Dictionary*, 8th ed. 2010. Oxford: Oxford University Press.
10. Randolph Quirk, Sidney Greenbaum, Geoffrey Leech & Jan Svartvik. 1985. *A Comprehensive Grammar of the English Language*, London and New York: Longman.
11. Rodney Huddleston & Geoffrey K. Pullum. 2007. *A Student's Introduction to*

- English Grammar*, Third printing. Cambridge University Press.
12. Solveig Granath. 1997. *Verb complementation in English. Omission of Prepositions before THAT clauses and TO infinitives*, Acta Universitatis Gothoburgensis. Göteborg Sweden.
  13. *The New Oxford Dictionary of English*. 1998. Oxford. The UK.
  14. *TIME*. 2009 (Dec 14).



**БЯМБЫН РИНЧЕНИЙ “ҮҮРИЙН ТУЯА” РОМАН ДАХЬ ДЭД  
БҮТЭЭВЭР, ТҮҮНИЙ НАЙРУУЛГЫН ҮҮРЭГ**

М.Энхжаргал  
/МУБИС/

**Түлхүүр үг:** бүтээвэр зүй, монгол хэл, үгийн утга, роман

**Товч агуулга:**

Орчин цагийн монгол хэлэнд үг бүтэх олон арга байдаг бөгөөд үндсэн аргын нэг нь “Дагаврын аргаар үг бүтэх ёс” юм. Энэ нь үгийн язгуур үндсэнд үг бүтээх дагавар залгаж шинэ үг бүтэх аргыг хэлдэг. Гэтэл хэлний энэ зүй тогтлыг зөрчиж, тухайн язгуур үндсэнд дагавар нэмэн залгавч шинэ утга бүхий үг бүтээхгүй байгаа сонирхолтой үзэгдэл ажиглагдаж байна. Үг зүй буюу бүтээврийн түвшинд үүнийг субморф (дэд бүтээвэр) хэмээн нэрлэдэг.

Уг өгүүлэлд Б.Ринчений “Үүрийн туяа” роман дахь дэд бүтээврийн илрэх хэлбэр, хэмжээ, найруулгын үүргийг жишээ баримтаар баяжуулан тайлбарлахыг оролдсон болно.

**1. Дэд бүтээврийн тухай**

Хэл шинжлэлд дэд аялгуу, дэд өргөлт, дэд утга гэх зэрэг олон ойлголт байдгийн нэг нь энэхүү бидний авч үзэж байгаа “дэд бүтээвэр” хэмээх ойлголт юм. Субморф буюу дэд бүтээвэр нь хэлний бүтээврийн түвшний дэд нэгж бөгөөд тухайн үндэснээ дэд бүтээврийг нэмж залгавч утга төдий л нэмэгдэхгүй, зөвхөн үл ялих найруулга, хэрэглээний ялгаа бий болгож буй хэсэг бүлэг бүтээврийг хэлнэ. Энэхүү бүтээврийн түвшинд илрэх дэд нэгжийг нэрлэсэн нэршил нь янз бүр байна. Үүнд: Е.А.Земская, Е.С. Кубрякова “дэд бүтээвэр” (субморф), Н.М.Шанский “залгаваранцар”(аффиксоиды), Д.С. Ворт “утгын агуулгагүй бүтээвэр”(не семантическое содержание морфем), В.В. Лопатин “жийрэг, илүүдэл маягийн бүтээвэр” (“избыточные” с формальной морфем), Г.О. Винокур “үндсийн хувилбар” (передюю вариацию)-г үүсгэж байгаа бүтээвэр”, А.И. Моисеев “хуурмаг бүтээвэр” (квазиморфема) гэж тус тус ялгаатай боловч уг дэд бүтээврийн үндсэн шинж, утгыг агуулсан нэрээр тодорхойлжээ. Монгол хэлний дэд бүтээврийг тусгайлан судалсан бүтээл ховор бөгөөд энэ тухай өөрсдийн санал дүгнэлтийг М.Базаррагчаа, Ш.Туяа, Б.Идэрбаяр, оросын монголч эрдэмтэн Г.Ц.Пюрбеев нарын эрдэмтэд дэвшүүлсэн байдаг.

Оросын эрдэмтэн В.Г.Чурганова<sup>1</sup> 1967 онд хэвлүүлсэн нэгэн өгүүлэлдээ дэд

<sup>1</sup> В.Г.Чурганова “О предмете и понятиях фонемологии” (Известия АН СССР .Серия литературы и языка.4.1967.стр.366-367)

бүтээврийн шинжтэй хэлний үзэгдлийг “бүтээвэр-авиалбар зүйн ялгаварт хэсэг” гэж нэрлэжээ. Тэрээр “Сүүлийн үед дэд бүтээврийг үгийн хэлбэрийн бүтээвэр-авиалбар зүйн ялгаварт хэсэг (морфонологический релевантные отрезки слов) гэж үзэж байна. Жишээ нь: *зубец, чепец* гэх мэт үгийн *-ец, -ц* гэсэн багасгасан утгатай дэд бүтээврийг авч *зубчик, чепчик* ( бяцхан шүд, бяцхан оройвч) гэсэн үгсийг бүтээж байна” гэжээ.

Орос хэлний бүтээвэр судлаач Е.А Земская<sup>2</sup> “Авианы бүтцээр ба янз бүрийн сэлгэцээр тухайн бүтээврээс ялгарч байвч утгын ялгаа гаргахгүй байгаа тийм хэсгийг дэд бүтээвэр (субморф) гэнэ. Дэд бүтээврийг өгүүлбэрийн бүтцээс ялгах нь чухал. Учир нь дэд бүтээвэр нь үг бүтэх ёсонд (словообразовательное поведение) нөлөөлдөг” гээд *ларь-ларец, сын-сынок*, нож-ножик гэх мэт үгэнд орсон *-ец, -ок, -ик* гэсэн дагавруудаар жишээ авсан байна. Харин *чепец-чепчик, чулок-чулочек, колпак-колпачок* зэрэг үгсэд орсон *-ик, -ок* дагаврыг үндэс бүтээхэд оролцож байгаа дэд бүтээвэр хэмээн ялгажээ.

Д.С Ворт<sup>3</sup> Олон улсын хуралд тавьсан нэгэн илтгэлдээ: “Бидний бодоход одоогийн бүтээврийн бүтэх хэсэгт олон ойлголт багтдаг. Үүнд: бүтээврийн хэсгүүд, авиалбар зүйн хэлбэртэй байх, утгын агуулгагүй бүтээвэр гэх мэт” гэжээ. Эдгээрээс “Утгын агуулгагүй бүтээвэр” гэдэг нь дэд бүтээврийн тухай дурджээ.

Дэд бүтээврийн тухай Оросын эрдэмтэд судалгааны ном, бүтээлүүддээ дээрх маягаар үзсэн бол О.С.Ахмановагийн тайлбар толийн 460-р талд: “*Субморфемный*” (анг.submorphemic) гэсэн үгийг “Не дифференцированный на уровне морфем” буюу “бүтээврийн түвшинд утга үл ялгах бүтээвэр”<sup>4</sup> хэмээн тайлбарласан байна.

Монгол хэлэн дэх дэд бүтээврийг тусгайлан судалсан судалгаа ховор бөгөөд М.Базаррагчаа, Ш.Туяа, Б.Идэрбаяр, Оросын нэрт монгол судлаач Г.Ц. Пюрбеев зэрэг судлаачид өөрсдийн бүтээлүүддээ дараах байдлаар дурджээ.

Эрдэмтэн М.Базаррагчаа монгол хэлний гарал судлалын тухай “Га...хэмээх үе-утгалбар” өгүүлэлдээ га... үе-утгалбарын хийсвэр шинжийг тоочжээ.

Мөн судлаач Ш.Туяа<sup>5</sup> “Хэлбэрээрээ бүтээвэртэй адил боловч бүтээвэр биш үүсмэл үгийн хэсгүүдийг хуурмаг бүтээвэр (квазиморфемы) буюу гол бус бүтээвэр (субморфемы) гэж нэрлэх нь бий” гээд суб-аренда, нем-ец зэрэг жишээг дурджээ.

## 2. Оруулбарын аргаар монгол хэлний үг бүтэх нь

Монгол хэлний үг бүтэх ёсны үндсэн ойлголтуудын нэг бол үг бүтэх арга юм. Үг бүтэх аргыг дотор нь нийтлэг шинжээр нь үг бүтэх үндсэн арга, туслах арга гэж хуваан үзэж болно. Үг бүтэх үндсэн аргад дагаврын арга, үг нийлэх арга багтах бөгөөд эдгээр нь монгол хэлний үгийн сан баяжих хамгийн түгээмэл, гол арга зам юм. Монгол хэлний үг бүтэх эдгээр аргаас оруулбарын аргаар үг бүтэх арга нь дэд бүтээврийн илрэх хэлбэртэй холбогдож байгаа юм. Тухайлбал: ноор/н/хой, цоор/н/хой, шив/г/нэх, ич/г/үүр, таглаа/с/тай, чигжээ/с/тэй, баглаа/с/тай гэх мэт үгэнд буй -н, -лд, -с, -г бүтээврүүд нь тухайн үгэнд нэмэгдсэн ч утгын ялгамжаа төдий л

<sup>2</sup> Е.А.Земская “Современный русский язык”, М.,стр.81-82

<sup>3</sup> Д.С.Ворт “Морфология славянского словообразования”, American contributions to the VII International congress of Slavists I.The Hague, 1973., p.387.

<sup>4</sup> О.С.Ахманова “Словарь лингвистических терминов”, М., 1969, стр.460.

<sup>5</sup> Ш.Туяа “Үг бүтэхүйн утга зүй”, Уб., 2005, 28 тал.

гаргахгүй байгаа учир оруулбар шинжтэй дэд бүтээвэр гэж үзэж байна.

Харин монгол хэлэнд оруулбар бүтээвэр бий эсэх талаар эрдэмтдийн санал зөрүүтэй байдаг ч дараах эрдэмтэд монгол хэл болон түүний төрөл бусад хэлэнд оруулбар бүтээвэр байдаг талаар өөрсдийн саналыг дэвшүүлсэн байдаг.

Т.А.Бертагаев оруулбарын талаар дурдахдаа “Монгол хэлний дуньсан, баоань аялгуунд оруулбар байдаг гээд *хулан-хулуулаган (улаан-маш улаан), шыра-шыпураган (шар-шав шар)* гэхэд “-ну” оруулбар нь хүч нэмэгдүүлсэн утгатай байгаа бол баоань хэлэн дэх *фелан-фабалган (улаан-улаавтар),шира-шибэргү (хар-харавтар)* гэхэд “-ба” оруулбар нь багасгасан утга илэрхийлж байна” гэжээ.

Мөн доктор, профессор М.Базаррагчаа<sup>6</sup> “«Б» хэмээх оруулбар утгалбар нь утгвар бүтээврийн бүрэлдэхүүнд багтсан нь” өгүүлэлдээ “Монгол хэлнээ CV гэсэн язгуур ка-ка-( хахах ), кө-кү-( хөхөх ), кө-ки-( баясах ), ко-ку-ий-( хохойх ), ку-ка/у-ий-(хухайх), кэ-кэ-ий-( хэхийх-ихэмсэглэх) гэх мэтээр давтан үг бүтээдэг. Энэхүү давтамал язгуурын завсар “б, г(э), р, л, м, н, (нг)” гийгүүлэгч буюу авиа-утгалбар шурган орж, нэлээд өөр утга бүхий үг бий болдог” хэмээн монгол хэлэнд оруулбарын аргаар үг бүтсэн жишээг дурьджээ. Үүнд: ховх, хавх, хав, хаван, хөвх (хөндий, ухмал газар) Цааш нь “орүүлбар “б” утгалбар нь өнгө зүс заасан үгсийн язгуурыг давтахдаа хоосон зайг алгасан “у-б у-ла-га-н” (ув улаан ), “кө-б кө-кэ” (хөв хөх) гэхчлэн утгварын үүрэг гүйцэтгэнэ” гэжээ.

### 3. Б.Ринчений “Үүрийн туяа” роман дахь дэд бүтээвэр, түүний найруулгын үүрэг

Их зохиолч Б.Ринчений “Үүрийн туяа” роман бол Монголын орчин үеийн уран зохиолын сор болсон бүтээлүүдийн нэг бөгөөд түүх, хувьсгалын сэдэвтэй, хэл найруулга, үг хэллэгийг урнаар ашиглан найруулгын өндөр түвшинд бичигдсэн зохиол болно.

Уг роман дахь дэд бүтээвэр бүхий үгсийг шүүн үзэхэд ачаастай, баглаастай, бичээстэй, бөглөөстэй, бүрээстэй, дүрс, дүүжлээстэй, золиос, өлгөөстэй, өрөөстэй, сөхөөстэй, татлаастай, чанаастай, хавчуулаастай, хадгалаастай, үйлс, хүлээстэй, хэрээстэй, шулмас, зүдрэх, бүгдээр, цайвгар, амьдралгатай, даруулга, тойруулга, бодлого, дамнуурга, ичгүүр, тэвээрэг, цулгай, шивэгнэх, шургуулга, барилдлагаатай, аливаа, аргамжаа, төсөө, гудамж, далдуур, зүсэм, инээдэм, ором, манаач, сүүлч, тагнуулчин, тонуулчин, хулгайч, хонжоо, тохиолдох, тааралдах гэх мэт 48 үг давхардсан тоогоор 255 удаа давтагдан оржээ.

Эдгээр дэд бүтээвэр бүхий үгсийг дэд бүтээвэргүй хувилбар буюу утгын хувьд ихэд зөрөөгүй, ижил утга илтгэж байгаа нөгөө үгтэй нь харьцуулан шүүхэд дараах үгс хоёр хувилбараар зохиолд хэрэглэгджээ. Үүнд: ачаатай-ачаастай, баглаатай-баглаастай, дүр-дүрс, золио-золиос, үйл-үйлс, шулам-шулмас, зүдэх-зүдрэх, эдгэх-эдгэрэх, бүгд-бүгдээр, дамнуур-дамнуурга, бодол-бодлого, ичүүр-ичгүүр, тэвээр-тэвээрэг, цул-цулгай, шивнэх-шивэгнэх, алив-аливаа, аргамж-аргамжаа, төс-төсөө, гудам-гудамж, далд-далдуур, зүс-зүсэм, инээд-инээдэм, ор-ором, манаа-манаач, сүүл-сүүлч, тонуул-тонуулчин, тагнуул-тагнуулчин, хулгай-хулгайч, хожоо-хонжоо, тохиох-тохиолдох, таарах-тааралдах гэх мэтээр 31 үг нь дэд бүтээвэртэй,

<sup>6</sup> “МУИС-ийн МСС-ийн эрдэм шинжилгээний бичиг” XIV боть.1999.5-р дэвтэр ( 36-39 )

бүтээвэргүй хоёр хувилбараар романд орсон бөгөөд давхардсан тоогоор 493 удаа байна. Эдгээрээс хамгийн их хэрэглэгдсэн үгс нь бодол-бодлого, бүгд-бүгдээр, хулгай-хулгайч, гудам-гудамж байна. Хамгийн цөөн хэрэглэгдсэн буюу тус бүр 1 удаа орсон нь бөглөөтэй-бөглөөстэй, золио-золиос, зүдэх-зүдрэх, таарах-тааралдах, шулам-шуламс гэсэн үгс байна.

Дэд бүтээврийг илрэх хэлбэрийн хувьд авч үзвэл –га<sup>4</sup>, –с, –р, –ээр, –аа<sup>4</sup>, –ж, –уур, –м, –ч (чин), –н, –лд, –ц, –д гэсэн 13 дагавар болон оруулбар бүтээврүүдээр илэрч байна. Үгийн тархцаар –га<sup>4</sup>, –с дэд бүтээвэрт хамаарах үгс хамгийн их байна.

Дэд бүтээвэр бүхий үгсийг утгын хувьд авч үзвэл, найруулга хэрэглээний бага зэрэг ялгаа үүсгэж байгаа бөгөөд голдуу үйлийн үр дүн, эзэн, явц, хэрэглүүр, багаж хэрэгслийн утга заасан нэр үүсэж байна. Жишээ нь: дүр-дүрс, золио-золиос, үйл-үйлс, дамнуур-дамнуурга, бодол-бодлого, аргамж-аргамжаа, тонуул-тонуулчин, тагнуул-тагнуулчин, хулгай-хулгайч гэх мэт.

Оруулбарын аргаар дэд бүтээвэр илрэх нь голдуу нэр, шинж тэмдэг, үйл заасан үгсэд тохиолдоно. Жишээ нь: шив/г/нэх, эдгэ/р/х, цоор/н/хой, ноор/н/хой. Мөн энэ аргаар илрэх нэг хэлбэр нь харьцангуй тэмдэг нэр бүтээх үед дэд бүтээвэр тохиолдож байна. Жишээ нь: татаа/с/тай, өлгөө/с/тэй, бичээ/с/тэй, овоолоо/с/той, дүүжлээ/с/тэй.

“Үүрийн туяа” романд хэрэглэгдсэн дэд бүтээвэртэй, дэд бүтээвэргүй үгийг утгаар нь харьцуулбал тухайн хоёр үг нь утгын ялгаагүй буюу тухайн хоёр нөхцөлд нэг утга илтгэж байгаа үгс, найруулгын хувьд маш бага утга ялгаж байгаа дараагийн бүлэг үгс, утгын ялгаа их байгаа гутгаар бүлэг үгс гэж ялгаж болохоор байна.

### Нэг. Утга ялгахгүй байгаа дэд бүтээвэр бүхий жишээ

1. “Ардын хүзүүн дээр зайдалж мордоод мөлжиж байдгийг бүр мөсөн хөөж, ард амьтныг хүн шиг **амьдралгатай** болгохын арга зам ер байдаг бол уу?” (Б.Р, Уб, 1993, 141 тал) гэсэн жишээ болон “Тэндээс Ширчин, дайн байлдааны түгшүүрт цэргийн эрийн хэрэн бядаж явах **амьдралтай** болж олон удаа харьтан дайсны цусаар мялаасан, Магсаржавын дайчин тугийн дор өмнө хязгаарын туушид явж хятадын цэргийн харгис эрхтний хар цэрэг, янз бүрийн бүлэг цүлэг дээрэмчидтэй байлдан тэмцсээр, бярууны билчээрээс холдож...” (Б.Р, Уб, 1993, 304 тал) гэхэд байгаа амьдралгатай-амьдралтай гэсэн хоёр үгийг харьцуулахад хоёул “амь зуух үйл ажиллагаа” (Я.Цэвэл, 42 тал) гэсэн утгаар оржээ.
2. “Одоо үжвээс, гэнэн чагаан сэтгэлээр **алив** юмыг хэтэрхий сайнаар бодож байсан байна” (Б.Р, Уб, 1993, 274 тал) болон “Богдын зарлигаар **аливаа** хэргийг ерөнхийлөн шийтгэх түр засгийн газар болж, эрхийг баривал зохино” (Б.Р, Уб, 1993, 178 тал) гэхэд байгаа алив-аливаа гэсэн үгс нь “хамаг” (Я.Цэвэл, 39 тал) гэсэн утгаар оржээ.
3. “Гэвч миний бодоход баян хүний гадаа **аргамжаатай** морь шиг, төрлийн хэлхээгээр аргамжаатай ураг төрлийн хүнээс огт хамаагүй, явъя гэсэн цагтаа явчих, хөндлөнгийн ядуу хүн дээр дэг ээ гэж ярилцсаар зангийнд

- хүрвээс...” (Б.Р, Уб, 1993, 149 тал) болон “Чөлөө олодохгүй гэж, чи **аргамжтай** морь болсон юм уу?” (Б.Р, Уб, 1993, 204 тал) гэхэд байгаа аргамж-аргамжаа гэсэн үгс нь “морь малыг татах урт сур, оосор” (Я.Цэвэл, 50 тал) гэсэн утгаар оржээ.
4. “Чийрэг банди, суугаа чигээрээ, Цэрэнгийн зүг эргээд, айн бишүүрхэж уйлан бархирсан Төмөрийг бянтай гараараа цааш нь түлхээд, хонь шиг, дөрвөн мөч **баглаастай** атиран хэвтэж байгаа Цэрэнг татаж эргүүлээд, хүлээсийг яаралгүй тайллаа” (Б.Р, Уб, 1993, 375 тал) болон “Цагаан эргээр цувж яваа машины өөдөөс, **баглаатай** ноос, арьс шир, зээр гахайн мах, бас брезентэн бүтээлгийн дор чухам юу байгаа нь мэдэгдэхгүй...” (Б.Р, Уб, 1993, 596 тал) гэхэд байгаа баглаатай-баглаастай гэсэн үгс нь “хэсэглэн багласан байдал” гэсэн утгаар оржээ.
  5. “Эгчмэд хүүхэд, **бодлого** болсон эхийн зүг харж асууруун” (Б.Р, Уб, 1993, 9 тал) болон “**Бодол** болж суугаа нь, монгол хүн жар хүрээд ухаан орж, жаран нэгэндээ үхдэг гэж Бизъяагийн ламын хэлсэн үг санаанд нь орж, би төвөд эцэг эхтэй боловч...” (Б.Р, Уб, 1993, 428 тал) гэхэд орсон “хүний ухаандаа сэтгэх, эргэцүүлэх” (Я.Цэвэл, 87 тал) гэсэн утгаар оржээ.
  6. “Хол газар явж, сонин сайхан юм үзнэ гэж бид **бүгд** маш баярлаж байна” (Б.Р, Уб, 1993, 528 тал) болон “Хаан харц, хамаг **бүгдээр** дагадаг эртний эрхэм нэгэн ёс бий” (Б.Р, Уб, 1993, 409 тал) гэхэд байгаа бүгд-бүгдээр гэсэн үгс нь “цөм, бүгд, бүхэн” (Я.Цэвэл, 114 тал) гэсэн утгаар оржээ.
  7. “Хүрээний зүгээс төрийн жагсаалаар явж яваа хүн үзэгдэж, эхэнд нь хоёр морьтой хүн жагсаалыг удирдаж, тэдний хойноос найман чийрэг эр улаан арал **дамнууртай** тугалган жинст, ногоон өнгийн хөшиг дээвэрт сүүх дамнажээ” (Б.Р, Уб, 1993, 256 тал) болон “Бараа бологч нар машинаас яаран гарч, генералын тэрэгний хаалгыг нээж, хятад офицерууд, цагаан хуйтай урт сэлмийг газар чирэн цувж автогоор авчирсан, торгоор ороон чимсэн **дамнуурга** дээр ерөнхийлөгчийн том зураг залаад, гуулин бүрээ үлээх, хэнгэрэг цохих их дуу шуу болж **дамнуургыг** дамнан их хаалганы зүг давшин алхлав” (Б.Р, Уб, 1993, 342 тал) гэхэд байгаа дамнуур-дамнуурга гэсэн үгс нь “юмыг дамнан явахад хэрэглэх хэрэгсэл” (Я.Цэвэл, 196 тал) гэсэн утгаар оржээ.
  8. “Тэрнийг бодоход баахан айдас хүрэх байна гэж хэлээд, нэгэн ядуу үйлчин эмгэн олноос **ичүүрсхийн**, нүүрээ дээлийн ханцуйгаар бөглөвөөс, өвгөн Чамбай...” (Б.Р, Уб, 1993, 538 тал) болон “Чи тэдний хоньчин хүү, чамайг өргөсөн Жамба, Жантайтай суугаад хөөж орхисон юм биш үү, чамайг? хэмээвээс, Ширчин баахан **ичгүүрсхийв**” (Б.Р, Уб, 1993, 149 тал) гэхэд байгаа ичүүрсхийн-ичгүүрсхийв гэсэн үгс нь “ичих үйлийн нэр” (Я.Цэвэл, 311 тал) гэсэн утгаар оржээ.
  9. “Эцэнгэр хүрэн биед нь зодуулж нүдүүлсний **ор** хөх няц үзэгдэн, толгойд нь энд тэнд булдруутсаныг үзвэл, оргож босохын өмнө ч их л зодуулсан байдал илэрхий” (Б.Р, Уб, 1993, 391 тал) болон “Тансаг, хүүгийн ясан дээр ирээд, тэмээнээс гулган бууж, аяархан, хүүгийн толгойн өмнө сөгдөж, тэр хатуу харгис сэтгэлтэй ламын зодуурын **ором** сорви, овгор товгоры нь

өвдүүзэй гэсэн адил, гараараа зөөлхөн гэгчээр илэн барьж үзээд...” (Б.Р, Уб, 1993, 400 тал) гэхэд байгаа ор-ором гэсэн үгс нь “ичих үйлийн нэр” (Я.Цэвэл, 311 тал) гэсэн утгаар оржээ.

10. “Цагаагчин гахай жилийн намрын **сүүлээр** Ширчингийн ахыг Хөлтгөний хөндийд намаржаад байх үес, Ширчин, хээр хонь хариулж байгаад, нэгэн өдөр үзвээс, олон тэмээтэй аянчин ажиглалал, Соном зангийн авгай явалцжээ” болон “Өвлийн дунд сарын **сүүлчээр** шуурга хөдөлжээ” гэхэд байгаа сүүлээр-сүүлчээр гэсэн үгс нь “алив юмын хойд, адаг, бөгс” (Я.Цэвэл, 498 тал) гэсэн утгаар оржээ.
11. “Синин хотод Самданжамба гэдэг, далаад хүнтэй уулзаж сонсвол төвөд газар монгол үгээр хэлэлцдэг шар уйгар, мөн Синьзяны уйгартай **төсөөтэй** үгээр хэлэлцдэг хар уйгар гэж байдаг юм гэж сонссон” (Б.Р, Уб, 1993, 30 тал) болон “За, Батбаяр гуай энэ бол уйгар үсэг танай монгол үсэгтэй нэлээд **төстэй** биз? Энэ хятад үсэг” (Б.Р, Уб, 1993, 31 тал) гэхэд байгаа төс-төсөө гэсэн үгс нь “байдал, маяг ойролцоо” (Я.Цэвэл, 552 тал) гэсэн утгаар оржээ.

#### **Хоёр. Найруулгын хувьд маш бага утга ялгаж байгаа дэд бүтээвэр бүхий жишээ**

1. “Харин энэ танигдахгүй, хятад байшинд яагаад орчихлоо гэж байгаа байшин бол, хөл үймээн багатай Юн Хо гүнгийн **гудам** дахь буурчийн байшин бөгөөд зүүд биш, ёстой үнэн байдал ажээ” (Б.Р, Уб, 1993, 83 тал) болон “Манж хааны нийслэлд хүрч ирэхийн өмнө хэчнээн олон хошуу, гацаа хүй, их бага хот дамжсан билээ гэж бодоод, Чуулалт хаалга гэдэг хотонд анх хүрч ирээд, нутагтаа Улиастай хотод танилцсан Жан овогт мужаантай **гудамжинд** уулзсанаа санажээ” (Б.Р, Уб, 1993, 83 тал) гэхэд байгаа гудам-гудамж гэсэн үгс нь “эгнэсэн хашаа, байшин, түүний доторх завсрын шулуун чөлөө” (Я.Цэвэл, 186 тал) гэсэн утгаар орсон боловч гудам нь арай ерөнхий, тодорхой бус утгатай байхад гудамж нь “Жан овогт мужаантай гудамж” хэмээн тодорхой утгыг зааж буйгаараа найруулгын хувьд утгын ялгаа бага зэрэг гаргаж байна.
2. “Юу ч **далд** хийсэнгүй гэжээ” (Б.Р, Уб, 1993, 49 тал) болон “Да хүрээний манж ноёд амбас, та бүхэнд юм битгий зааж өг гэж **далдуур** тушаажээ” (Б.Р, Уб, 1993, 31 тал) гэхэд байгаа далд-далдуур гэсэн үгс нь “илийн эсрэг, нууц” (Я.Цэвэл, 184 тал) гэсэн утгаар орсон боловч далд гэсэн үгийн хэрэглээг авч үзвэл хийх, орох гэсэн үйл үгстэй хамт хэрэглэгдэж байна.
3. “Ховдын амбан, Магсаржавыг оргон боссоноос хойш монголчууд гэнэт халдаж болзошгүй гэж Сангийн хот гэдэг цайзын тойрон дахь гууг гүн болгож, хэрмийг сэлбэн засаад цайзанд суух дарангуй цэргийн хүчнийг зузаатган, дөрвөн зүг, найман зовхист харуул **манаа** гаргажээ” (Б.Р, Уб, 1993, 281 тал) болон “Аав гайхаж дээ хар үүрээр тэр лүү чиглэдэг ямар лам билээ гэж дотроо бодсоор, ордны ойр очоод, харц хүний мориноос буудаг газар хүрээд, морио хантайран тушиж хаалганд дөхтөл, ер хүн амьтан боссон чимээ шинж алга, хаалганы **манаач** үзэгдэхгүй шиг, тэгэхэд нь, ноёд



язгууртан хүртэл Богдод бараалхахдаа эмээн ордог тэр хаалга аюумшиггүй тогших зүрх хүрсэнгүй” (Б.Р, Уб, 1993, 566 тал) гэхэд байгаа манаа-манаач гэсэн үгсийг харьцуулахад манаа нь ерөнхий, манаач тодорхой утгыг зааж байгаа бөгөөд харуул манаа гэж хоршиж хэрэглэгдэж байгаа нь их байна. Харин манаач гэвэл хаалганы манаач, тогооч манаач хоёр гэх мэтээр утга илүү тодорч байна. Үүнтэй адил жишээ тагнуул-тагнуулчин, хулгай-хулгайч, тонуул-тонуулчин гэсэн үгс дээр мөн илэрлээ.

4. “Онц чухал явдал **тохиож**, улсын дээд ба доод хурлыг би зарлан хуралдуулав” (Б.Р, Уб, 1993, 334 тал) болон “Тэгээд миний охиныг бас, тийм гай зовлон **тохиолдуузай** гэж захихад нь, сэтгэл зовж, бүлх залгисан шиг болж байна хэмээвээс, өвгөн Чамбай унтууцаж...” (Б.Р, Уб, 1993, 437 тал) гэхэд байгаа тохиох-тохиолдох үгсийн жишээг харьцуулан харахад тохиох мөн хүндэтгэлийн, дээд найруулгад ерөнхий утгаар, тохиолдох гэсэн үг нь ерийн найруулгад тодорхой утгаар хэрэглэгдэж байгаа ялгаа харагдаж байна. Хэрэглэгдсэн хэмжээний хувьд авч үзвэл тохио- язгуурт нийт 31 үг давтагдан орсноос тохиолд- нь 29, тохио- нь 2 удаа оржээ.

#### **Гурав. Найруулгын хувьд утгын ялгаа гаргаж байгаа дэд бүтээвэр бүхий жишээ**

“Зүс царай, хүзүү, гар нь хөв хөх өнгөтэй болж, нүдний нь цагаан улайжээ” (Б.Р, Уб, 1993, 542 тал) болон “Жантай, хүү бэр хоёргоо өмч тасалж, малы нь **зүсэм** зүсмээр зааж гүйцээд сурган өгүүлрүүн...” (Б.Р, Уб, 1993, 554 тал) гэхэд зүс-зүсэм гэсэн үг нь “хүн ба амьтны нүүрний өнгө, дүр” (Я.Цэвэл, 291 тал) гэсэн утгаар орсон боловч зүс нь хүний дүрийг, зүсэм нь амьтны дүрийг заадгаараа ялгарч байна.

#### **ДУГНЭЛТ**

Гадаад хэлбэрээрээ үгийн нэгэн утгат хэсэг буюу бүтээвэр болон харагдах боловч үнэндээ утга үл ялгах, эсвэл маш бага утга ялган найруулга, хэрэглээнд тодорхой үүрэг гүйцэтгэх, нэмэлт бүтээвэр шинжтэй, үгийн хувилбар үүсгэж байгаа тийм хэсгийг дэд бүтээвэр хэмээн тодорхойлж болно.

Уг өгүүлэлд Б.Ринчений “Үүрийн туяа” роман дахь дэд бүтээврийн илрэх хэлбэр, хэмжээ, найруулгын үүргийг жишээ баримтаар тайлбарлалаа. Уг роман дахь дэд бүтээвэр бүхий үгсийг шүүн үзэхэд ачаастай, баглаастай, бичээстэй, бөглөөстэй, бүрээстэй, дүрс, дүүжлээстэй, золиос, өлгөөстэй, өрөөстэй, сөхөөстэй, татлаастай, чанаастай, хавчуулаастай, хадгалаастай, гудамж, дамнуурга гэх мэт 48 үг давхардсан тоогоор 255 удаа давтагдан оржээ. Дэд бүтээвэртэй, бүтээвэргүй хоёр хувилбараар романд орсон 31 байгаа бөгөөд давхардсан тоогоор 493 удаа байна. Эдгээрээс хамгийн их хэрэглэгдсэн үгс нь бодол-бодлого, бүгд-бүгдээр, хулгай-хулгайч, гудам-гудамж байна. Хамгийн цөөн хэрэглэгдсэн буюу тус бүр 1 удаа орсон нь бөглөөтэй-бөглөөстэй, золио-золиос, зүдэх-зүдрэх, таарах-тааралдах, шулам-шуламс гэсэн үгс байна.

Дэд бүтээврийг илрэх хэлбэрийн хувьд авч үзвэл –га<sup>4</sup>, –с, –р, –ээр, –аа<sup>4</sup>, –ж, –уур, –м, –ч (чин), –н, –лд, –ц, –д гэсэн 13 дагавар болон оруулбар бүтээврүүдээр илэрч байна. Үгийн тархцаар –га<sup>4</sup>, –с дэд бүтээвэрт хамаарах үгс хамгийн их байна.

“Үүрийн туяа” романд хэрэглэгдсэн дэд бүтээвэртэй, дэд бүтээвэргүй үгийг утгаар нь харьцуулбал тухайн хоёр үг нь утгын ялгаагүй буюу тухайн хоёр нөхцөлд нэг утга илтгэж байгаа үгс, найруулгын хувьд маш бага утга ялгаж байгаа дараагийн бүлэг үгс, утгын ялгаа их байгаа гутгаар бүлэг үгс гэж ялгаж болохоор байна.

### НОМ ЗҮЙ

1. Ахманова О.С. “Словарь лингвистических терминов”, М., 1969.
2. Бадамдорж Д. “Монгол хэлний утга судлал”, Уб., 2001, 1-р дэвтэр МУИС-МСДС, ЭШБ №13 (139), Уб., 1998.
3. Базаррагчаа М. “«Б» хэмээх оруулбар утгалбар нь утгвар бүтээврийн бүрэлдэхүүнд багтсан нь” МУИС, ЭШБ, XIV боть, (V дэвтэр), Уб., 1999.
4. Базаррагчаа М. “Утгын чуулган”, Уб., 2002.
5. Бертагаев Т.А. “Морфологическая структура слова в монгольских языках”, М., 1972.
6. Бэшэ Л. “Монгол хэлний үйл үгийн утварын тухай”, *Studia Mongolica*. TomVI, Fasc12.
7. Бямбасан П. “Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгийн аймаг”, Уб., 1975.
8. Ворт Д.С. “Морфонология славянского словообразование”, *American Contributions to the VI International congress of slavists, I. The Hague.*, 1973.
9. Земская Е.А. “Современный русских язык”, М., 1973.
10. Идэрбаяр Б. “Монгол хэлний төсөөт үг”, Уб., 2005.
11. Кубрякова Е.С. “О типах морфологической членимости слов, Она же. Основы морфологического анализа”, М., 1974.
12. Лопатин В.В. “Русская словообразовательная морфемика проблемы и принципы описания”, М., 1977.
13. Ринчен Б. “Үүрийн туяа” роман, Уб, 1993.
14. Моисеев.А.И “Основные вопросы словообразования в современном русском литературном языке”.
15. Өнөрбаян Ц. “Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс”, Уб., 2000.
16. Пюрбеев Г.Ц. “Об одном типе синонимов в современной монгольской терминологий”, ШУА, ХЗХ, “Нэр томъёо судлал” №8, Уб., 2006.
17. Туяа Ш. “Үг бүтэхүйн утга зүй”, Уб., 2005.
18. Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь”, Уб., 1966.
19. Чурганова В.Г “О предмете понятия фонеморфологий” («Известия АН СССР. Серия литературы и языка» вып.4), М., 1964.
20. Шанский Н.М “Исследования по современному русскому языку” (Издательство Московского университета), М., 1970.

## **SUMMARY**

### **The stylistics function and feature of the sub morphs in novel “The Uuriin Tuya” by B.Rinchen**

There are many methods for forming new words in the contemporary Mongolian language and one of them is word formation by suffixes. New word is formed with connected suffix to its root. However, the exciting phenomenon that new word has no semantic meanings is emerged when suffix connected to word roots. In morphology, it is called sub morph.

In the scope of this paper, we considered that sub morph, especially focused on the sub morph in novel “Uuriin tuya” by B.Rinchen. We compared with words which has sub morph and studied their usage. At the result of this survey, almost 48 words such as damnuur-damnuurga, baglaatai-baglaastai,, gudam-gudamj, zolio-zolios, bodol-bodlogo and bugd-bugdeer are same to each other in view of stylistics usage.

**ОБУЧЕНИЕ СПЕЦИАЛЬНОЙ ЛЕКСИКЕ ПРИ  
ОБУЧЕНИИ ИНОСТРАННОМУ ЯЗЫКУ**

Л.Туул  
/СЭЗДС/  
Д.Уранбилэг  
/МУИС/

**Abstract**

In professionally-oriented teaching foreign languages at university level it has become traditional to describe the goal of teaching a foreign language in terms of professional communicative competence. It is not possible to communicate in a particular professional area without extending the amount of productive and receptive vocabulary minimum through lexical units describing new topics, problems and situations of communication. Any field of study has vocabulary terms that are necessary for understanding ideas within the field. Special attention is paid to the role of texts on specialization. This contributes to enhancing professional specialization of students and motivates them to learn foreign languages.

**Ключевые слова:** профессиональная подготовка, мотивация, специальная терминология, литература по специальности, обучение лексике, тексты по специальности

Современное общество предъявляет высокие требования к студентам высшего профессионального образования в овладении иностранными языками. Владение иностранным языком необходимо, чтобы быть конкурентоспособной личностью на рынке труда. Раньше знание иностранного языка определяло лишь уровень образованности личности, а сегодня назрела необходимость знать его в качестве языка новой технологии и коммерции. Инженеры, конструкторы, рабочие, которым необходимо пользоваться инструкциями на иностранном языке, врачи и педагоги, которые нуждаются в литературе, изданной на иностранном языке – вот небольшой перечень специалистов, которым нужен иностранный язык. Он стал не просто предметом желания, а предметом необходимости и требования жизни. Отсюда вытекают и требования по применению новых технологий при обучении и изучению иностранного языка при подготовке студентов на разных специальностях: иностранный язык для одной группы специалистов отличается от иностранного языка другой группы специалистов. Необходимо ставить цель обучения и в соответствии с этим строить процесс обучения. В этой связи возникает необходимость связывать обучение иностранным языкам с будущей профессией студента.

2. Д.Сэнгээ, “Далан насад ч даруулга хэрэгтэй” шүлэг, *Үнэн*, 1953, №300.
3. “Доктор Ринченгийн сүүлийн үеийн зохиолууд дахь зарим харш үзэл санааны тухай” өгүүлэл, *Намын амьдрал*, 1959, №7.
4. “Бидний эгнээнд хөрөнгөтний үзэлтэнд байр байхгүй” өгүүлэл, *Үнэн*, 1959, №289.
5. С.Дашдэндэв, Ш.Нацагдорж, Т.Пагва, Ж.Пүрэв, Г.Чимэд нар, “Үндэсний явцуу үзлийн элдэв илрэлтэй эвлэршгүй тэмцье” өгүүлэл, *Үнэн*, 1959, №194.
6. С.Лочин, “Зохиолчийн үзэл санаа, хариуцлага” өгүүлэл, *Утга зохиол урлаг*, 1974, №32.
7. А.Лувсандэндэв, “Шүүмжлэлийн шүүмжлэл” өгүүлэл, *Үнэн*, 1975, №51.
8. “Эрдэмтэн хүний өндөр үүрэг” өгүүлэл, *Намын амьдрал*, 1976, №3.

Г.Аким дээрх өгүүлүүдийн дотор “Намын амьдрал” сэтгүүлийн 1976 оны 3 дугаарт нийтлэгдсэн “Эрдэмтэн хүний өндөр үүрэг” өгүүллийг “бичсэн эзэнгүй тэрхүү булай өгүүлэл” гэж дурдаад тодорхой баримтаар дэлгэрэнгүй шүүмжилсэн байна. Б.Ринчен болон түүний эцэг эх, төрөл садангийн түүх намтрыг гуйвуулан дайрч давшилсан тус өгүүллийг зарим хүн монгол хэл шинжлэлийн эрдэмтэн, академич А.Лувсандэндэв (1927-1997) бичсэн мэт ярьдаг. Үнэн худлаа бүү мэд. Харин Г.Акимын тус өгүүлэл нийтлэгдсэний дараа академич А.Лувсандэндэвийн ““Хэлмэгдсэн” болгон дүрсэлжээ”<sup>4</sup>, Москвагийн Нэхмэлийн дээд сургуулийн оюутан Г.Болд гэгчийн “Гэрэлтүүлэх гээд сүүдэртүүлжээ”<sup>5</sup> зэрэг шүүмжлэлтэй хандсан хоёр эсэргүүцлийн өгүүлэл, өлгөц хэвлэгдэн гарчээ. Тэгэхэд Г.Аким хариуд нь “Эмтлэх гээд эвдэрснээ илчилжээ”<sup>6</sup> гэдэг эсэргүүцлийн хариу өгүүллийг нийтлүүлж, дээрх хоёр өгүүлэл, өлгөцийг баримтаар эрс няцаасан нь буй.

### 3

Г.Аким дараа нь 1991 онд тус өгүүллийн агуулгыг улам баяжуулж, “Идүүлсэн бут ургадаг” хэмээсэн Б.Ринчений дурсгалд зориулсан баримтат киног туурвиж, Монгол Телевизийн уран бүтээлийн “Өлзий” нэгдлээс гаргасан.

<sup>4</sup> А.Лувсандэндэв, ““Хэлмэгдсэн” болгон дүрсэлжээ”, *Үнэн*, 1989, №54.

А.Лувсандэндэв, ““Хэлмэгдсэн” болгон дүрсэлжээ”, *Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь*, Эмхэтгэн редакторласан Л.Болд, “Онги Бээс” хэвлэлийн компани, Улаанбаатар, 2002, 443-449-р тал.

<sup>5</sup> Г.Болд, “Гэрэлтүүлэх гээд сүүдэртүүлжээ”, *Үнэн*, 1989, №91.

<sup>6</sup> Г.Аким, “Эмтлэх гээд эвдэрснээ илчилжээ”, *Утга зохиол урлаг*, 1989.V.19, №21.

Профессор Г.Акимын “Эмтрээ нь үгүй эрдэнэ” өгүүлэл бол Б.Ринчений нэр төр сэргэн мандахад чухал хувь нэмэр оруулж, “Идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут ургадаг” гэсэн монгол ардын зүйр үг нь үнэн болохыг нотолсон байна.

Энэ дашрамд дурдахад, Г.Акимын “Эмтрээ нь үгүй эрдэнэ” өгүүллийг илтгэгч миний бие дэлгэрэнгүй зүүлт, тайлбарын хамт япон хэлээр орчуулж, “Bulletin of Japanese Association for Mongolian Studies” сэтгүүлийн 1989 (1990) оны 20 дугаарт<sup>7</sup> нийтлүүлсэн болно.



<sup>7</sup>ゴトビーン・アキム（岡田和行訳）「砕けることなき宝石—ビヤムビーン・リンチェン」 [Gotovyn Akim (Kazuyuki Okada yaku), “Kudakeru koto naki hōseki: Byambyn Rinchen”] Готовын Аким (Орчуулсан Казүюки Окада), “Эмтрээ нь үгүй эрдэнэ: Бямбын Ринчен” 『日本モンゴル学会紀要』 [Nihon Mongoru Gakkai kiyō] Японы Монголч Эрдэмтний Нийгэмлэгийн мэдээ [Bulletin of Japanese Association for Mongolian Studies], №20, 1989 (1990), 68-86-р тал.

Тус орчуулгын тухай танилцуулга Г.Аким гуайн доорх веб сайтад бий.

<https://goakim.wordpress.com/2011/02/22/unbroken-jewel-byambyn-rinchen/#more-118>

Бас Б.Ринчений товч намтрыг Японд анх бичиж танилцуулсан бүтээл нь 二木博史「B.リンチェン」 [Hiroshi Futaki, “B.Rinchen”] Хироши Фүтаки, “Б.Ринчен” 『東洋文庫書報』 [Tōyō Bunko shohō] Дорно дахины номын сангийн мэдээ, №14, 1982, 89-91-р тал болно.







**ДАРХАД ЯРУУ НАЙРГИЙН ОНЦЛОГ**

Д.Батжаргал  
/МУИС/

Яруу найраг гээч гэнэт асгаран буух тэнгэрийн хур лугаа адил. Талд нумран татах солонго лугаа үзэмж төгс. Гайхамшигт сэтгэл хөдлөлийн урлаг. Яруу найрагч Б.Мягмаржавын шүлэг онгод, цуурай, агсамнал бардамнал ихтэй юм.

*...Тэнгэр эцгийн хурц хөх хадуур  
Тэнхээ заан эргэлдэж  
Торгон ирэнд нь өвс ногоо өртөх шиг  
Тоолиггүй олон ургаа модод хиаран  
Уруугаа харан урсаж  
Амь эрсэн үндэс нь шороотой хөрсийг базаж  
Олон моддын хугараан  
Орь дуу тавих нь  
Чихэн дээр буу тавихаас нааш  
Чимээ эс дуулдана  
Арсайн гол үерлэж байна  
Ай саваа нэг цэвэрлэж байна /“Нүүнэ” 15-69/*

Энэ нь дархад бөөгийн онгод шиг, Ардын уран зохиолч Ш.Сүрэнжавын нэгэнтээ хэлсэнчлэн “Найргийн онгод орсон үед шүлгийн мөрүүд тэнгэрийн гараар бичигддэг”<sup>1</sup> гэсэн тэр санаа гарч байна. Ийм шүлэг яруу найргийн түүвэрт олон бий.

Яруу найраг бол толгой холбосон үгсийн цуваа биш. Мөн цагаан магтаал, цэцэрхэл, сайхан ерөөл ч биш юм. Ойлгомжгүй хэлцийн бөөгнөрөл, хэт бодлогошрол, ганган үгсийн цуглуулга ч биш. Сэртгэхийлгэх уран санаа, харанхуйд гялсхийн зурсхийх оч цахилгаан, мэлсхийн ассан гэрэл юм. “Долоон сарын цас” /2001/ номд

*Уруулын будагтай самрын ясыг  
Удаан ажвал  
Би өөрөө байлаа /72 дугаар тал/  
Нартай бороо ширүүн хэдий ч  
Дусал бүр нь  
Сүүдрээ онодог /74 дүгээр тал/  
Толгойгүйдээ би малгайгүй явдаггүй  
Тогосны өд ч бай тоож би өмсөхгүй  
Тэргүүн дээр минь өнө мөнхөд орших*

<sup>1</sup> Д.Батжаргал “Шүлэг яаж бичих вэ?” Уб, 2005,

*Тэнгэрийг би дуртайяа өмсөж явдаг /51 дүгээр тал/*

Хар ярианы хэлээр бол “Овоо онгирч байгаа биз” Гэхдээ зөв. Яруу найрагчид аархал бардамнал байж гэмээ нь, өнөөгийн биднээс арай өөрөөр харж, сэрж, мэдэрч гэмээнэ сая сайн шүлэг бичнэ. Тэрнийг нь бид уншиж хөөрнө. Нацагдоржийн шагналт яруу найрагч А.Эрдэнэ-Очир “Манай хүний яруу найраг уулсын эрмэг салхины эрч гогцоотой, цэнхэр хотгорынхоо намуун сэвшээ шиг хөг аялгуутай заримдаа хачин энгийн тод борог зурагтай, эмзэг болоод цөлх ухаантай байдаг юм. Яруу найраг сэтгэл оюуны алсад их ачаатай, тэр нь холоос бараатай найрагч даа”<sup>2</sup> \Б.М-15-521\ гэж үнэлсэн нь сэтгэл их ойртож цаад цар хүрээгий нь харсан хэрэг.

Нэг үгээр хэлбэл тэрхүү бардамнал дотор, аархал дунд нь уран санаа, эрч хүч, хөдөлгөөн хэмнэл яваад байгаа юм. Манай уран зохиолын нэрт судлаач профессор Д.Галбаатар “Үг үгийн салхи нийлж найруулга бүтдэг” \МУИС. Утга зохиол урлаг судлалын тэнхим. 2014.04.09\ гэж хэлсэн. Тэгэхээр эрч хүч гэдэг үгийн сонголт. Яруу найрагч Бороохойн Батхүү нэгэнтээ “Бэгзийн Явуухулан “Дуулим” гэдэг үгийг Монголын яруу найрагт оруулж ирсэн. Тэр нь эргэлтэд олон найрагч хэрэглэх болжээ” \2015.06.18 Пүрэв гариг. МУИС\ гэж саяхан ярьсан билээ. Тэгвэл яруу найрагч Б.Мягмаржав олон шинэ үгийг оруулж ирсэнээрээ гавьяатай найрагч аа.

*Амьдрал бүрэлдүүлснийхээ төлөө  
Ад үзэгдэн оддын дунд ганцаардаж  
Зодуулж хашираагүй дэлхийн  
Зоо нуруун дээр  
Гүвдрүү болон тогтсон  
Гүргэр хөх уулс минь /Б.М-15-33/*

Ийм үгсийг хэд хэдээр олж болно. “Оргомчилмоор”, “багар мод”, “гүвдэж” гэх мэт эртний монгол хэлний болон нутгийн аялгууны сайхан сайхан үгс зөв газраа байраа олоод хэрэглэгдэхээр яруу найргийг хүчтэй сонсголонтой болгож байна. Үүнд, дархад ардын дууны нөлөө, аман билгийн ач тус үлэмж бий. Яруу найрагч өөрөө ч үүнийгээ мэдэрч шилмэл шүлгийн түүврээ 2007 онд “Дархад яруу найраг-1” гэж гаргаж байсан юм. Тиймээс Мягмаржавын яруу найргаас дархад ардын дууны сайхан дүрслэл нэвт шувт харагдана. Дархад дуу цэцэн үгтэй оновчтой хэллэгтэй. “Тайгыг түнхэлж ирсэн морийг минь бодоортой хоё”, “Хоёр Логшийн өвсийг холин иддэг шаргал маань” гэх мэт.

Аль ч яруу найрагчаас төрөлх нутаг ус нь харагддаг. Тэгвэл Хөвсгөлийн хөх тайгын эрхэм “дууч”-ийн бүтээлээс нэрстэй хүрэн тайга үнэртэж, ногоон навчин дээр сувдран тогтсон долоон сарын цас харагдаж, хүн байтугай үнэг төөрөм балар шигүү хөвч сарьдаг, зүрх муутай хүн явах нь битгий хэл сонсуут толгой нь эргэж унамаар ганц хүний цайвар, хальт гишгэсэн чулуу харанхуй хясаа руу бөмбөрөн өнхрөх боом хавцал элбэг үзэгдэнэ. “Хачимын боом” \Б.М-15-51\ шүлэгт,

*Тэнгэр гэмээнэ хаяагаа мартсан  
Далай гэмээнэ хөвөөгөө мартсан  
Уул гэмээнэ хормойгоо мартсан  
Мартсанаар дүүрэн энэ газар  
Мартагдахгүй ...*

Албархсан, дургүй хүргэсэн аймгийн төлөөлөгчийг уйлуулаад мөлхүүлж

<sup>2</sup> Б.Мягмаржав “Нүүнэ” Уб, 2015, 521 дүгээр тал

байсан газар дархад нутагт олон бий шүү дээ. Тэдгээрийн нэг дүр зургийг найрагчийн бичжээ.

Түүний бүтээлд эсрэгцэл, харьцуулал, эерүүлэл, ихэсгэл, багасгал зэрэг үгийн хөдөлгөөн сайн, дүрслэх яруу хэрэглүүр баян. “Уулан дээрээс” шүлэгтээ уул өөд өгсөх тусам хир буртагнаасаа салж, арц сэнгэсэн салхиар нь амьсгалж явахдаа цэвэршин, уушгин дотроо сан тавиулан ариусаж бодол гуниг бүрээ гээн гээсээр

*Өндөр хар уул өөдөө*

*Өгсөж явахдаа чөтгөр байдаг*

*Буурал их уулсынхаа өврөөс*

*Буцаж явахдаа би бурхан болдог* гэж бичсэн байна.

Энд өндөр уул гэдэг хүний адыг гүвж, амьсгалыг сэлбэж хийморь сүлдийг сэргээдэг өнө эртний ойлголтыг тодорхойлон тунхаглаж байгаль ертөнцийн жам, уялгатай хүйн холбоотой хүний гэрлэн бие, гэгээн орчныг эх нутаг нь ариусган авч явдаг дам холбоог ойлгомжтой илэрхийлсэн байна.

Мөн нэгэн нэргүй шүлэгтээ орон хотод харанхуй шөнө ганцаар явахад машины чарлаан, нохдын хуцалт, хүнтэй таарах нь аймшгийн ад байдаг бол хөдөө хээр бүрхэг шөнөөр ганцаараа явахад малын чимээ, хүний дуу, нохойн хуцалт авралын од болдог зэрэг хотжил, нүүдэлчдийн эрс тэс ялгааг цөөн үгэнд ялгаруулан зурж, хүн хүнээсээ айж биргэж явах ямар ёрын цаг ирснийг харьцуулан үзүүлсэн байна. Ийм жишээ олныг олж болно.

Мягмаржав найрагч маань эргэцүүлэл бодомжоо үгийн хээ хуар өнгө будгаар далдлан бүрхэгдүүлж будлиу, туршлага муутай зарим шүлэгчин шиг орооцолдсон, ээдэрч гогцоорсон тийм утга гаргаж ирдэггүй, түс тас шуудхан хэлдэг үгийн туурвилч юм. Энэ нь анхны номноосоо тод харагдана. Редакторын тодорхойлсноор 1995 онд “Цэнхэр хотгор” ном гаргахаар зэхэж байснаа чамлан илүү чангаруулж зургаан жилийн дараа буюу 2001 онд “Долоон сарын цас” нэртэй анхны номоо гаргасан байна. Энэ номын төгсгөлд “Дэлхий ертөнц хэний шидсэн чулуу вэ? Дээр нь биднийг суулгах гэж хэн анх сэдсэн бэ?...” гэж эхэлсэн нэг шүлэг бий. Бодлогошрол цааш гүнзгийрч

*Ямар нэгэн газар дээр өндөг шиг бяц унах уу*

*Явсаар байх мөнх биет гэж байх уу*

*Үүрдийн болоод өөрийн юм шиг бид энд новиурсоор байх уу*

*Үгүй бол яах вэ?, мэдсэн нь дээр үү, мэдээгүй нь дээр үү /Б.М 01-78/*

хэмээн 1999 онд бичиж байсан бол яван чангарч илүү урнаар эргэцүүлэх болсон нь найрагчийн эрийн цээнд хүрсний нотолгоо.

*Хорвоо хэмээх энэ пянзыг*

*Хэн гээч нь мөнхөд эргүүлж*

*Ховилоор нь гүйх зүүний оронд*

*Хонгорхон зүрхийг минь тавиа вэ*

*Эхлэл төгсгөлгүй энэ гаж симфоныг*

*Эгэлхэн зүрхээ элээж дуулуулсаар*

*Эцэс нэгэн өдөр дуусахын цаг дор*

*Энэ ертөнц юугаа сонсох бол?*

Ер бусын уран ахиц дэвшил бардамнал харагдаж байна. Бас орчлон хорвоогийн онон баригдах нь үгүй зүй тогтол, хүмүүний амьдралын хөдөлгөөнт



ёс, яруу найрагчийн эмзэглэл, бусдын хувь заяаны төлөө дуусдаг төгсгөл, дараа нь харамсдаг халаглал хүртэл мэдрэгдэж байна.

*Мөхөл нь үгүй гэгээн наранд хамгийн ойрхон атлаа*

*Мөсөн дуулгат оргилд нь цасан шуурга исгэрэх*

*Хорвоог шарах нарнаас хамгийн хол атлаа*

*Хонхор хөндий талд нь цэцгэн сондор давалгаалах*

*Энэ хэний сэдэл вэ?*

*...Үдшийн тэнгэрт далайсан балт сүхэн сарыг*

*Үелзүүр нандин долгион дээрээ мөнгөн туулай шиг дэгдүүлж*

*Агшаан сунган хэдэнтээ хувааж гурил мэт дураар элдэх*

*Ариун усны хувилгаант чанарыг альхан талаас нь бод гээ вэ? /Б.М -15-151/*

Яруу найргийн “Болор цом”-ын тэмцээнд шандастай, авьяастай, тэнхээтэй найрагч гэдгээ олон удаа баталж тэргүүн шагнал хүртсэн найрагчийн бүтээлүүдээс МААЗ-ын туульсын бяд тэнхээтэй дайчин дүрслэл, яруу найргийн уян нарийн торгон мэдрэмж аль аль нь харагдана.

*Зандан эрхи шиг хүрэн тэмээд*

*Эрхий долоовор ууланд нүүнэ*

*Загасны нүд шиг тунгалаг хөсөг*

*Элэг зүрхний чанад нүүнэ / “Нүүнэ” номын 23 дугаар тал/*

*Хажуугаар дэгдэх хүүхдийн хөлнөөс өвсний шүүдэр харваж*

*Ханын нүдээр орж ширмэл тойруулга чийгтэх нутаг*

*/"Нүүнэ" номын 113 дугаар тал/*

*Цэнхэр хотгор нутаг минь*

*Цэцгэн жүнз л тулгаа даа / “Долоон сарын цас” номын 10 дугаар тал/*

Монголын их яруу найргийн олон хөг эгшиг урсгал дунд “Дархад яруу найраг” гэсэн нэгэн шинэ өнгө аяс нэмж, ямар энтэй, ямар түвшин, ямар онцлогтой яруу найраг байхын анхны түвшин тогтоосон хүн бол яах аргагүй Батгөрийн Мягмаржав юм. Зөвхөн төгсгөлд авсан хэдхэн шад дотор дорнын их найрагч Д.Нямсүрэнгийн “Цэцгэн дунд хөлөө өргөөд солонго адил зогсож байгаа марал буга”, судлаач А.Мөнх-Оргилын цохон тэмдэглэсэн “Хаан жүнз шиг алтрах бэлхүүс”<sup>3</sup> гэсэнтэй эн зэрэгцэх шинэлэг содон дүрслэл олон бий. Энэ нь туурвил зүйн ур чадварын томоохон илэрхийлэл юм.

## НОМ ЗҮЙ

1. Д.Батжаргал “Шүлэг яаж бичих вэ?” Уб, 2005
2. А.Мөнх-Оргил “Шүүмжлэлт сэтгэлгээний эрэл” Уб, 2009
3. Б.Мягмаржав “Нүүнэ” Уб, 2015
4. Б.Мягмаржав “Долоон сарын цас” Уб, 2001

## SUMMARY

B.Muyagmarjav who is a poet and the real man who added darkhad poetry in the Mongolian poetry with its many currents. He wrote many poems with rhetorical device, artistic conception and correct words like darkhad songs and Mongol shamanist incantation.

<sup>3</sup> А.Мөнх-Оргил “Шүүмжлэлт сэтгэлгээний эрэл” Уб, 2009, 145 дугаар тал



**“РИ БАГШИЙН ТҮНШҮҮР” ХУУЧ ЯРИАНЫ ХҮҮРНЭЛ ДЭХ  
ХОШИГНОЛ БҮТЭЭХ АРГУУД  
Humor techniques in Oral narrative about “RI teacher”**

Г.Нандинбилиг  
/МУИС/

Хууч яриа гэдэг бол бүх л цаг үеийн аман зохиолд байдаг жанр бөгөөд Ринчен багштаны тухай хошин хууч яриа нь монголын орчин үеийн аман зохиолын амьд уламжлалын тодорхой жишээ болно. Бид энэ удаад аман хүүрнэлийн хам сэдэв, хүүрнэн өгүүлэгчийн чиг үүрэг хийгээд аман зохиолын хошигнол бүтээх аргын талаар Ри багшийн тухай хошин хууч ярианы жишээн дээр авч үзэхийг зорьсон бөгөөд ардын уран зохиолч Тангадын Галсан гуайн хэвлүүлсэн “Ри багшийн түншүүр” ном болон академич Б.Ринчений мэндэлсний зуун жилийн ойд зориулан гаргасан “Домогт Ринчений домгууд оршивой” эмхэтгэлд орсон олон жишээнээс цөөн хэдийг авч судална.

Ард түмнийхээ дунд “Ри” багш гэж алдаршсан Бямбын Ринчений тухай хууч ярианы олонх нь эх хэлнийхээ баян тансаг үгсийн сангаа мэдэхээ больж, бичиг соёлоо гэжж байгаа шинэ цагийнхныг тэрээр хэрхэн шоглон сургадаг байсан талаар хүүрнэдэг. Тухайлбал монголын нэрт сурган хүмүүжүүлэгч, сэтгүүлч Н.Цэвэгээ гуайн ярьсан хуучаас Т.Галсан гуайн найруулан авсан нэгэн жишээг авч үзвэл:

*“Гэгээрлийн яамны орлогч сайд Шагдарсүрэн гавьяатаар тодорхойлогдсон залуухан эмэгтэй багшийн хичээлд суужээ. Тэрхүү хичээл нь эх хэлний хичээл байв. Багш эелдэг дуугаар:*

*-За хүүхдүүд ээ, та нар эдэлж хэрэглэж байгаа хувцсаа нэрлэ дээ! гээд самбарт үзүүлэн хадсанд цовоо нэг охин:*

*- Форма, фартук, юбка, куурчик, лээнт, гялстуг гэжээ. Багш:*

*- Хэн нэмэх вэ? гэхэд өөр нэгэн хөвгүүн:*

*- Пальто, майк, түрсийк гэхэд хүүхдүүд инээлдэв гэнэ. Багш яльгүй ичингүйрэн:*

*- Одоо хичээлийн хэрэглээ нэрлэцгээе гэхэд нэг сэргэлэн хүү:*

*- Авторучка, пеналь, үсгийн касс гэжээ. Энэ мэтээр өрнөсөөр шинэ хичээл өндөрлөж гэнэ.*

*Сайд, хичээлд суусан өвгөн хоёр ангиас түрүүлэн гарлаа. Хичээлд суусан идэвхтэй өвөө нь хэл шинжлэлийн ухааны эрдэмтэн Б.Ринчен гуай байв гэнэ. Сайд:*

*- За, Ринчен гуай. Манай багшийн заасан монгол хэлний хичээл ямар санагдав? гэсэнд:*

*- Эрхэм сайд минь нүгэлтэй ч юм даа. Энэ чинь эх хэлний хичээл биш эрлийз, хэлний хичээл байна гэжээ (Домогт Ринчений домгууд оршивой, 2005, 22)*

Энэ мэт нэгэн бүлэг хошин хууч ярианы хүүрнэлийн чиг үүрэг илэрхий бөгөөд тэр үеийн нийгэм дэх орос хэлний нөлөөг шүүмжлэн харуулахын зэрэгцээ “Бид монгол хэлээрээ ярьж буй гэж бодовч харь хэлээр ярьдаг болчих вий дээ” гэсэн айдас болгоомжлолыг өнөө, хойч үеийн монголчуудад ямагт өгч байх далд утгат мөн чанарт эдгээр хууч ярианы үнэ цэн оршино.

Хууч яриа гэдэг бол дүрслэн бодох авьяасын үүрэг оролцоотойгоор ертөнцийг ойлгож мэдрэх нэгэн арга зам билээ. Ри багшийн тухай эдгээр бүлэг хууч яриа нь нэг талаас эх хэлнийхээ оновчтой хэрэглээг эрхэмлэгч гол баатар, нөгөө талаас шинэ соёлыг даган орж ирэх харь хэлний үгсийн хэрэглээг ухамсартай ухамсаргүйгээр идэвхжүүлж байгаа сөрөг баатар гэсэн хоёр талын үзэл бодол, үг хэл, үйл хэргийг эсрэгцүүлэн харуулахдаа хууч хөөрөгчийн эрхэмлэн бахдах хийгээд хошигнон шоглох аргыг хэрхэн чадмаг хослуулан өгүүлэх байдлаас хамаараад хууч ярианы хүүрнэлийн үнэт чанар нь нэмэгдэж байдаг.

Мөн бидний эдгээр хууч яриаг таашаан сонсдог өөр нэг шалтгаан бол эх хэл соёлоо өмөөрөн тэмцэгчийн **хөрөг бэлгэдэлт дүр (icon)** болсон Ри багшийн сэхээлэг оюун санаа болоод онч мэргэн, цэцэн цэлмэг үг хэлэнд оршино. Социализмын үеийн үзэл суртлын хүлээсийг илчлэн харуулсан нэгэн бүлэг хошин хууч ярианаас бид сонгож болно. Жишээлбэл: Ардын уран зохиолч Тангадын Галсан “Ри багшийн түншүүр” хэмээх номын тэргүүн дэвтэрт хэвлүүлсэн “Асуултаар багалзуурдсан нь” хэмээх хууч ярианд:

*“1945 оны тавдугаар сарын наймны өдрийн “Үнэн” сонинд “Зөвлөлтийн ялгуугсан улаан арми Гитлерийн фашизмыг бут ниргэлээ” гэсэн мэдээ нийтлэгджээ. Тэр үед Ц.Дамдинсүрэн, Б.Ширэндэв, өвгөн бичээч Г.Навааннамжил зэрэг манай сэтгүүлчид нам төрийн гол хэвлэл “Үнэн” сонинд ажилладаг байжээ. Харин дээрх мэдээг Б.Ринчен гуай бичсэн юмсанж. Гэтэл өглөөгүүр хэн нэгэн том дарга утастаж:*

*-Та нар яасан эргэлзээтэй юм бичдэг этгээдүүд вэ? “Ялгуугсан” гэдэг чинь феодализмын хэллэг биш гэх үү? Энэ мэдээ нэг л ойлгомжгүй байна гээд л банга буулгаж эхлэв гэнэ. Ийнхүү аянга цахилуулж байгаа эрхэм хэн болохыг албархаг ааш, нутгийн аялга хоёроор нь таниад авсан Ринчен гуай:*

*- Ялгуугсан гэдэг бол ялж төгс дийлсэн гэсэн утгатай монгол үг. Манай буриадад ч, танай ойрдод ч бас тийм л утгатай. Зөвлөлтийн баатарлаг улаан арми дайснаа дарсныг итгэхгүй, эргэлзээд байдаг та ер нь хаанахын хэн гээч байна? гэж асуултаар багалзуурдсанд үл үзэгдэгч эрхэм утсаан бушуухан тасалж орхижээ. Ри гуай элгээ хөштөл инээсэн гэдэг. Хурын үүлгүй тэнгэрээс хуурай аянга буулгагч тэр эрхэм нь угтаа Ю.Цэдэнбал байсан гэдэг. Эрдэмтэн дарга хоёрын эв энэ өдрөөс хойш бүр ч цавтсаныг түүх гэрчилнэ” (Т.Галсан, 1990, 11-12)*

Энэхүү хошин хуучийн хүүрнэлийн чиг үүрэг нь өмнөх хуучийн адил тийм ч шууд ил тодорхой биш байж болно. Нарийвчлан ажиглавал тус хуучийг хүүрнэгч утасны цаадах том даргын мөхөс байдлыг илчлэн шантлах хүслээ Ри багшийн зан төрхөөр дамжуулан илтгэж буй нь мэдэгдэнэ. Магадгүй зарим нь үүнийг омог бахдал, эсвэл бардам зангийн тухай өөр арга замаар үзүүлсэн гэж ойлгож болно. Эсвэл бүр харилцан ярианы нь тоглолт, мэтгэлцэл солбицолд нь илүү татагдан дурлаж байж ч болох юм.

Ерөөс хууч ярианы судлалд хам сэдвийг сайтар анхаарах хэрэгтэй юм. Дээрх хууч ярианд хоёр хам сэдэв байна. Нэг нь илт утгаараа монгол хэл соёлын хам сэдэв байна. Ри багшийн тухай энэ мэт хошин хууч ярианууд нь хэл соёлоо хадгалах, эсвэл шинэ соёлыг дагаж орж ирсэн харь үгсийг хэрхэн эх хэлэндээ буулган орчуулах талаар зөвлөж байдгийг бид мэднэ. Энэ бүхэнтэй зэрэгцээд соёлын хам сэдвийн чинадад нийгмийн хам сэдэв байна. Ри багштаны намтрын хам сэдвээр дамжаад тэр цагийн нийгмийн үзэл суртал, дарамт шахалтыг мэдэх нэгэнд нь сануулж, мэдэхгүй нэгэнд нь таниулж байна.

Хошин хууч яриа гэдэг бол ямар нэг хэмжээгээр бичил үнэлгээ юм. Тодруулж хэлбэл, Ри багшийн тухай хошин хууч ярианы эдгээр хам сэдвийн тусгай аспектиуд нь социализмын үеийн үзэл суртлын тухай мэдүүлэх гэсэн уншигч сонсогчдод зориулсан нэмэлт зүйлс болно. Хууч ярианы хам сэдвийг ойлгосноор уншигч сонсогчид түүхэн цаг үеийн нөхцөл байдлыг танин мэдээд зогсохгүй шүүн тунгааж, үнэлж дүгнэхэд тусалдаг.

Хууч ярианы хүүрнэлийн бүдүүвч нь маш товч, цөөн үгийн хүрээнд байдаг нь сонсогчийн анхаарал сонирхол төвлөрөх богино хугацаанд гол санаагаа хүргэх гэсэн зорилготой нь холбоотой. Ри багшийн тухай хошин хууч яриаг хүүрнэл зүйн задлан шинжилгээний сонирхдог гол сэдвүүдээр авч үзвэл:

### 1. **Үйл явдлын зөрчил ба утга санааны тогтмол**

Ри багшийн тухай хууч ярианы зөрчил нь өнгөц харахад гадаад зөрчил мэт боловч дүр хоорондын үзэл бодол үйл хэргийн эсрэгцлээр дамжин илэрч буй монголын нийгэм соёлын дотоод зөрчил байдаг. Бүр тодруулбал олонх тохиолдолд эх хэл соёлын ариун байдал зэрэг нийгэм соёлын хам сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлээд, эсрэгцэн буй хоёр хүчний зөрчил маргааны өрнөл нь Ри багшийн эх хэлээ эрхэмлэх үзлийн ялалтаар төгссөн байдаг онцлогтой. Энэхүү бардам төгсгөлөөр нь хүүрнэн өгүүлэгчийн үзэл хандлагыг мэдэж болох ба уг хууч яриаг хүүрнэгчид нь сонсогч олонд нөхцөл байдлыг тунгаан цэгнэх замаар хэрэг явдалд дүгнэлт хийх, хэрвээ иймэрхүү үг үйлдэлтэй тулгарах юм бол та ч бас ингэх хэрэгтэй гэсэн зурвас санааг илгээж байна.

### 2. **Хүүрнэлийн дотоод эмх цэгц дараалал буюу хүүрнэлийн боловсруулалт**

Хууч ярианы хүүрнэгч нь хүүрнэлийн туршид Ри багшийн хэлсэн үг, хэрэг явдлыг мэдээлэх нэг л чиг үүрэгтэй. Ри багшийн зан төрх нь нэлээд хэмжээгээр бэлгэ тэмдгийн шинжтэй болсноор Ри багш гэсэн нэрийг хэлэнгүүт хүүрнэлийн баатрын үзэл бодол жанжин шугамыг сануулж эхэлнэ. Хүүрнэгчийн хүсэлтээс шалтгаалан өөрчлөлт орох боломж бараг байхгүй. Өөрөөр хэлбэл, уншигч сонсогчийн хяналт нь хэт зохиомол зүйлийг эсэргүүцэж, хүүрнэн өгүүлэгчийн зүгээс өөрийн дураар шинэ санаа нэмж оруулахыг зөвшөөрөхгүй тийм тогтмол бүтэцтэй болжээ.

Хүүрнэлийн боловсруулалтыг тодруулахын тулд хүүрнэлийн янз бүрийн түвшинд маш анхааралтай хандах хэрэгтэй. Хүүрнэлийн залгаа буюу хүүрнэх ба илэрхийлэх гарцын хооронд анализ хийж үзвэл, хоёр хүүрнэл нэгдэж байгаа тохиолдолд эхний хүүрнэлд гол баатар болж байсан хүн хоёрдугаар хүүрнэлд хүүрнэгч болж болно.

3. **Зан төрхийн жишиг загвар.** Өгүүлэгч гэдэг бол тухайн хүүрнэлийнхээ дүр болоод үйл явдлыг тодорхойлдог ч монгол аман хууч ярианы төрөл зүйлд Ри

багшийн дүр нь хэл соёлоо өмөөрөн тэмцэгчийн **хөрөг бэлгэдэлт дүр (icon)** болон тогтсон байна. Дүрийг задлан шинжилнэ гэдэг бол зан төрхийг нээнэ гэсэн үг. Ри багшийн тухай хууч ярианд Ри багшийн зан төрхийг бүтээхдээ харилцан ярианы аргыг өргөн хэрэглэсэн байна. Харилцан ярианы солбицолд Ри багш олонхдоо бусдын алдаатай яриа, зөрүүтэй үзэл бодлын эсрэг оновчтой эсрэг хариуг өгөх маягаар шийдвэрлэсэн байна. Жишээ нь: Эх хэлний хичээл биш, эрлийз хэлний хичээл байна гэх мэт

Өөрийн нэр нь дүрийг бодит бие хүн гэдгийг тунхаглахын зэрэгцээ нийгэм ба соёлын сэдэвт татаж байна. Бидний судлан буй бүлэг хууч ярианд гол баатар болох Ри багшаас гадна тэр цагийн эрх мэдэлтэн их бага дарга нараас эхлээд залуу багш, гэнэн багачуул гээд өгүүлэгчийн сонгосон хэн ч байсан ямагт Ри багшийн үзэл бодол үйл хэрэгтэй харшилдаж буй хүчнийг төлөөлж байдаг юм. Ри багшийн түншүүр хууч ярианы өгүүлэгч нь түүний бэлэн цэцэн егөө үг, онч мэргэн ухааныг бусад дүрийн байр байдалтай эсрэгцүүлэн үзүүлдэг.

4. **Хүүрнэлийн далд санааг илэрхийлэх ялгаатай дуу хоолой \voices\.** Нарратологи буюу өгүүлэгчээр нь дамжуулан өгүүлэмжийг судлах аргын үүднээс авч үзвэл аливаа аман хууч яриа нь аливаа хүүрнэл зохиолын нэгэн адил нэгдүгээр биеэс буюу өгүүлэгч нь өөрөө тухайн зохиолын аль нэг баатар мэтээр үйл явдлыг хүүрнэдэг, эсвэл өгүүлэгч нь гуравдугаар биеэс буюу өгүүлэмжийн гадна талд байгаа нэгний үүргээр хүүрнэдэг. Харин “Ри багшийн түншүүр” нэрт нэгэн бүлэг хууч ярианы хүүрнэлийн онцлог бол **өгүүлэгч** нь үйл явдлыг өгүүлэхдээ гол баатар буюу гэрч баатрын дүрээр нэгдүгээр биеэс өгүүлэх бус, харин **гуравдугаар биеэс** буюу Ри багшийн хэрхэн хэлж ярьж байсныг дамжуулж буй, хүүрнэлийн гадна орших нэргүй хүүрнэгчийн байдлаар, эсвэл Ри багштан хэн нэгэнтэй ярьж байгаа **хоёр биеийн харилцан яриагаар** үзүүлсэн байна.

Ри багшийн тухай хууч ярианы хүүрнэл бүтээх аргыг ангилж үзвэл дараах гурван арга маяг байна. Үүнд:

А. Хүүрнэн өгүүлэгч өөрөө **бүхнийг мэдэгч маягаар гуравдугаар биеэс хүүрнэж**, дүрийн үзэл бодол болоод бүх мэдээллийг өгөх арга маяг

Б. Хүүрнэн өгүүлэгч үйл явдал өгүүлэмжийг хөтөлж явснаа гэнэт зайгаа тавьж өгөөд, бусдаас дам сонссон маягаар “...тэгсэн гэнэ, тэгж гэнэ” гэхчлэн, **хариуцлагаа өөр нэгэнд түлхэх** арга маяг

В. Хүүрнэн өгүүлэгч хөндлөнгөөс ороод яриад тайлбарлаад байх боломжгүй, драмын маягаар өгүүлэмжийг зохион байгуулж, **баатруудын үйл хөдлөл, хэл яриагаар дамжин, зан төрх нь өөрөө илрэн гарах** арга маяг. Тодруулж хэлбэл, баатрууд нь хэрэг явдалд өөрсдөө шууд орж, харилцан ярилцаад, тэрхүү яриан дунд нь үзэл ухамсрын нь ертөнц аажимдаа ялгаран тодорч ирэх арга маяг

Эдгээрийн эхний хоёр нь Ри багшийн тухай хууч ярианы хүүрнэл бүтээх шалгарсан арга болно. Ийм төрлийн хүүрнэлд хүүрнэгч нь алга болсон мэт сэтгэгдэл төрүүлдэг. Гэвч сэтгэл хөдлөл, үнэлэлт шүүлт зэрэг янз бүрийн хүчин зүйлс түүний байгааг гэрчилж өгдөг.

Хүүрнэн өгүүлэгчийн хэл яриагаар мөн өгүүлэгчийн зүгээс зохиолын гол баатарт хэрхэн хандаж харьцаж байгаа, юу гэж үнэлж сэтгэж байгаа **хандлага** нь илэрч байдаг. Бидний ажигласнаар, олонх хууч ярианы дотор хүүрнэн өгүүлэгч

нь гол баатрынхаа буюу Ри багшийн **дуу хоолойгоор** ярьдаг. Чухам үүгээрээ хууч яриаг хүүрнэн өгүүлэгч ба хэвлэн нийтлэгчид нь өөрийн үзэл үнэлэлтээ илтгэж байдаг байна. Жишээлбэл, бидний судалж буй энэ бүлэг хууч ярианд өгүүлэгчийн яриагаар олон жил эх хэл соёлынхоо дархан манаанд зогссон өвгөн эрдэмтний үзэл бодол, үг хэл, үйл хэргийг илэрхийлэн гаргахын зэрэгцээ гадаад хэл суртлаар хоосон чамирхсан ухваргүй нэгэнтэй тулгаруулж тийм нөхцөл байдалд татан оролцуулах замаар баатаргаа хандах хандлага болон мөн өгүүлэгчийн эх хэлдээ хандах хандлага “**дуу хоолойгоо**” дам илэрхийлсэн байна.

#### 5. Уран сэтгэмж ба бодит явдлын харилцан нэвтрэлцэл.

Түүх өрнөн болж өнгөрөх цаг ба орныг утга зохиол урлаг судлалд орчин гэх бөгөөд энэ нь зөвхөн бодит орчин тойрныг оруулаад зогсохгүй тэр цагийн зонхилох үзэл санаа, ёс заншил, үнэт чанар болоод итгэл үнэмшлийг агуулдаг. Ри багшийн талаарх хошин хууч ярианы хэрэг явдлын орчин нь орос хэлний нөлөөт, социализмын үеийн Монгол орон болно.

Социалист дэглэмийн үеийн эх хэл соёлын асуудалд бараг цорын ганц сөрөг хүчин болж байсан бие хүн бол Бямбын Ринчен байсан бөгөөд тэрээр өөрийн тэмцлээ хошигнолоор илэрхийлдэг байжээ. Ри багшийн тухай хошин хууч ярианы хэрэг явдлууд нь тодорхой түүхэн бодитой байсан хэдий ч басхүү хууч яриаг хүүрнэн өгүүлэгчид болоод эмхэтгэн нийтлэгчдийн зүгээс нэмэрлэж хачирласан уран сэтгэмжийн зүйлс ч буй. Энэ нь хууч ярианы тогтмол нэг шинж чанар болох амаас ам дамжин хүүрнэн ярих аман шинжтэй нь холбоотой билээ. Ам дамжин хүүрнэх явцад болсон явдлын дээр уран сэтгэмжийн зарим шинж орж эхлэх нь зүй ёсны хэрэг билээ.

Манай зарим сэхээтнүүд Ри багшийн цэцэн цэлмэг үгийг хойч үеийнхэнд хүргэх, улмаар өнөөгийн нийгмийн адил мөн чанартай үзэгдлийн эсрэг сөрөг хариулт, дуу хоолой болгон барих зорилгоор эмхэтгэн хэвлүүлж, олны хүртээл болгож байна. Чингэхдээ орчин нөхцөлийн өөрчлөлтөөс болоод зарим талаар илүү үнэмшилтэй болгохын тулд бодит зүйлийг нарийвчлан дүрслэх, бодит хүмүүсийг нэрийг олноор оруулж өгөх зэргээр баяжуулсан байдаг.

Бодит хэрэг явдал болоод уран сэтгэмжийн аль нь ч байсан эдгээр хууч яриа нь орчин цагийн аман зохиолын нэгэн гол жанр болох хошин хууч ярианы бодит жишээ мөн болно. Ри багшийн түншүүр хууч ярианы хошигнол бүтээх аргыг авч үзвэл дараах мэт байна. Үүнд:

**А. Үг хэлний хошигнол** Хошигнол бол эцсийн бүлэгт хэлний тусгай хэрэглээгээр үүсэж бий болдог. Үүнд: Авиа ижилсүүлэх юм уу дуутай дуугүй эгшиг гийгүүлэгчийг олон давтах маягаар ижилсүүлэл болоод эсрэгцүүллийг бүтээж инээлгэх, үг хэлийг зориуд гажуудуулж алдаатай ярих үгсийн наадгай \каламбур\ юм уу Далан худалчийн маягийн учир зүйг гажуудуулсан үг хэллэг, тонгоргон яриагаар наадах зэрэг байдаг. Жишээлбэл: “Хүн хүний шүтээн өөр” гэсэн шог ярианд

- *Ном ном гээд л гандангаар гүйгээд байна уу гэж асуусан нэгэнд Ринчен гуай*
- *Та нам нам гэдэг хүн байсан, одоо лам лам гэдэг хүн болоо шив дээ гэж хэлсэн,*

*Алтай Бээжин Туулын өндөр сайхан ресторанууд*

*Алтанбулаг, Орхон, Сэлэнгийн хүйтэн сайхан пивонууд... (Т.Галсан, 1990,18)*

*"...Цэдэнбал нэрийг орчуулбал юу гэсэн утгатай бол гэж шивнэн асуусанд*

*Нэрийн дунд орсон Б үсгийг нь хасчих, тэгээд л болох нь тэр гэжээ"* (Т.Галсан, 1990, 22) гэсэн үгийн наадам зэргийг дурдаж болно.

**Б. Нөхцөл байдлын хошигнол** бол үл ойлголцол болоод голдуухан зохиогчийн дүрслэн бодож олсон сэдэл хатгаасын дундах нөхцөл байдлыг үүсгэдэг. Сонсогчид тухайн дүрийг их хөгийн байдалд байгааг нь үзээд инээхээс аргагүй болдог. Жишээ нь: нэгэн эрх мэдэлтний Ринчен гуайг феодализмын хэллэг хэрэглэсэн гэж буруутгах гээд өөрөө эцэст нь мэдлагдаж буй нөхцөл байдал.

**В. Зан төрхийн хошигнол.** Дүрийн зан төрх бол мөн ялгаагүй хошигнолын эх булаг болдог. Нэг хэсэг нь алиалж наргиж, нөгөө хэсэг нь гэнэн тэнэгээрээ хүний инээд хүргэж байдаг. Жишээ нь: Монгол хэлний хичээл дээр форма, фартук, юбка, куурчик, лээнт, гялстуг гэхчлэн нэрлүүлж буй залуу багшийн гэнэн үйлдэл болон зочин хүнийг их багаар алагчлах гэрийн эзэгтэйн зан төрх зэргээр хошигнол бүтээжээ.

#### **Энэ бүхнээс дүгнэвэл**

Ри багшийн тухай хууч яриа нь цаг цагийн ном бичгийн хүмүүсийн хууч хөөрөх сэхээлэг нэгэн гол сэдэв болж өрнөсөөр, улмаар монгол аман зохиолын Далан худалч бэлэн Сэнгээгийн үлгэрийн адил нэгэн гол баатартай орчин цагийн богино хүүрнэл аман зохиолын цуврал хэлбэрийг олсон байна.

1. Эрдэмтэн зохиолч Бямбын Ринчен нь монголын орчин цагийн аман зохиолд монгол хэл соёлоо өмөөрөн тэмцэгчийн хөрөг бэлгэдэлт дүр (icon) болсон байна.
2. Хүүрнэл зүйн онол шинжилгээний үүднээс авч үзвэл эдгээр хуучийг өгүүлэгчид нь Ри багшийн тухай хууч яриагаар дамжуулж, өөрийн үзэл хандлага дуу хоолой (voice)-гоо илэрхийлдэг байна.
3. Ри багштаны тухай хошин хууч яриаг үгийн урлагийн хошигнол бүтээх аргын үүднээс авч судалбал үг хэлний хошигнол болоод зан төрхийн хошигнол, нөхцөл байдлын хошигнолыг чадварлаг эзэмшсэн байна.

#### **ABSTRACT**

Oral narrative of teacher Ri has been extended as main intellectual topic of narration for writers from generation to generation. In others words, it has already taken place on oral narrative series with a main role as Dalankhudalch story.

1. Professor and writer Rinchen Byambiin is considered as an icon, who fights to protect Mongol language and culture in Mongolian modern oral literature.
2. According to narrative theory analysis, writers used to express their voice through oral narrative of teacher Ri.
3. If we look at the oral narrative of teacher Riin the sentence styling for humor, it is sophisticated with lexical humor, behavioral humor and conditional humor.



## НОМ ЗҮЙ

1. Билгүүн номч Бямбын Ринчен (1990). Наян тавны нь сүүдэр зэрэгцэх жилд зориулбай. Эмхэтгэж эрхэлсэн Г.Аким. УБ.
2. Галсан, Т. (1990) Ри багшийн түншүүр (Ёж, егөө, шог). УБ.
3. Галсан, Т. (2005) Домогт Ринчений домгууд оршивой. Академич Б.Ринчений мэдэлсэний 100 жилийн ойд. УБ., 2005
4. Fennigan Ruth (1991) Oral traditions and Verbal Arts. *A Guide to Research Practices*. Routledge

**МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО ЗОХИОЛ ДАХЬ  
ТОДОСГОГЧ НЭГЖИЙН УТГА, ҮҮРЭГ**

Г.Бямбацэрэн  
/МУБИС/

**Товч агуулга:**

Монголын нууц товчоо (МНТ) дахь тодосгогч нэгжийг шүүн үзэхэд утгыг хязгаарлах үүрэгтэй, ерөнхий ба тодорхойг ялгах үүрэгтэй, жишин адилтгасан, утгыг эрчимжүүлсэн үүрэгтэй, хандсан үгийн үүрэгтэй, онцолбор гишүүний үүрэгтэй, найруулгын үүрэгтэй, баймж утгыг илэрхийлэх үүрэгтэй гэж ангилж болох бөгөөд хэлбэрийн хувьд үг, нийлмэл үг, өгүүлбэр, эхийн бүтцээр илэрч буйг эш татах боломжтой бөгөөд зарим нэг өвөрмөц ялгаа бүхий тодосгогчийн “хэрэглээ” байгааг хэл-сэтгэлгээг түшиж тайлбарлахыг зорилоо. МНТ зохиолд урнаар шүлэглэж дүрслэн тодосгосон жишээ цөөнгүй байх ба энэ нь монгол хэлний яруу, баялаг шинжийг тодотгохын сацуу ихэвчлэн ойролцоо зэргэдийн шинжтэй.

**Түлхүүр үг:** тодруулах, лавшруулах, өргөмж нэр, оноосон нэр, хорших, монгол сэтгэлгээ, онцолбор, ялгах ёс

Монгол хэлний хийсвэр шинжтэй хэлэх ба ухаарах нь төсөөлөл, уран сэтгэмж, зөн совин, таамгаас эх үүдэлтэйг, түүнчлэн Ч.Эрдэнийн тодорхойлсон “Хаос нь хосолмол чанарыг агуулж байдаг”, хэлний их нэгж нь бага нэгжээ багтаадаг нь ёс боловч үүнээс урваж бага нь ихийгээ багтаадаг байна. Үүнийг хэлэн дэх эмх замхгүй ёс (хаосизм) гэнэ. Энэ нь хэлний хөдлөнги шинжээс үүсэж буй урвуу үзэгдэл гэснээс тодосгуулагч, тодосгогчийн харьцаа хэлэн дэх хаосизмыг харуулах, монгол хэлний тодосгогч, тодосгуулагчийн харьцаа мөн хэлэн дэх тэгш хэм (симметрия) гэдгийг харуулах нь өгүүлбэр судлалын чухал зорилтуудын нэг болж байгааг сонгодог бүтээл дээр жишээлэн тайлбарлахыг зорилоо.

Монгол хэлний тодосгогч нэгжийн утга, үүргийг бичгийн болон аман эхийн хэрэглээнд үндэслэн Т.А.Бертагаев, Ш.Лувсанвандан Ш.Барайшир, М.Базаррагчаа, Б.Пүрэв-Очир нар судлан тодочлогч, тодотгол, тодруулагч зэрэг хэл шинжлэлийн ойлголтуудаас ангид авч үзэн, хэлний цуваа бүтэц дэх нэгжүүдийн утга, санаа, хэлбэрийг өөрчлөн давтсан давталт гэж тодорхойлжээ.

Тодосгогч нь мэдэгдэхүүн ба хэлэгдэхүүн талаасаа хэлц бус (бүхэл зүйжсэн) холбоо үүсгэдэг. Нэг утга, хоёр өөр хэлбэр гэсэн харьцаа үүсгэдгээрээ хаослаг шинжтэй хэлэхүүн үзэгдэл юм.

Монголын нууц товчоо (МНТ) дахь тодосгогч нэгжийг шүүн үзэхэд утгыг хязгаарлах үүрэгтэй, ерөнхий ба тодорхойг ялгах үүрэгтэй, жишин адилтгасан, утгыг эрчимжүүлсэн үүрэгтэй, хандсан үгийн үүрэгтэй, онцолбор гишүүний үүрэгтэй, найруулгын үүрэгтэй, баймж утгыг илэрхийлэх үүрэгтэй гэж ангилж

болох бөгөөд хэлбэрийн хувьд үг, нийлмэл үг, өгүүлбэр, эхийн бүтцээр илэрч буйг эш татах боломжтой бөгөөд зарим нэг өвөрмөц ялгаа бүхий тодосгогчийн “хэрэглээ” байгааг хэл-сэтгэлгээг түшиж тайлбарлахыг зорилоо. МНТ зохиолд урнаар шүлэглэж дүрслэн тодосгосон жишээ цөөнгүй байх ба энэ нь монгол хэлний яруу, баялаг шинжийг тодотгохын сацуу ихэвчлэн ойролцоо зэргэдийн шинжтэй. Тухайлбал:

Харь улсыг үл тэмцэн,  
Хацар гоо охидыг  
Хаан болсонд та нарын  
Хасаг тэргэнд унуулж  
Хар буур хөлгөж  
Хатируулж одож  
Хатан сууринд  
Хамт суулгамуй, бид.  
*(Улс иргэнийг үл тэмцэн  
Өнгө сайд охидоо өсгөж  
Өлжигтэй тэргэнд унуулж  
Өл буур хөлгөж  
Үүсгэж одож  
Өндөр сууринд  
Өрөөл этгээд суулгахуй, бид)*<sup>тодосгогч</sup>

Ойролцоо утгатай зэргэдүүд дэх утга ч бас нэгэн хэлбэрийн давталт бөгөөд хэлэхийн нэг санааг өөр хэлбэрээр давтсан давталт юм. Зэргэдүүд нь ойролцоо утгатай нэгжүүд хоршсон нэгжүүд үүсгэдэг ба мэдээлэх, харилцах утга нь ижил. Гэхдээ зэргэд болгон тодосгогч болохгүй бөгөөд зүйрлэсэн зэргэдүүд тодосгогч, тодосгуулагчийн харьцаа үүсгэхгүй. Ойролцоо утгатай үгийг МНТ-д хоршин хэрэглэсэн нь цөөнгүй бөгөөд ийнхүү хорших нь шууд ба буцах холбоотой байнга хувьсан өөрчлөгдөх (динамик) шинжтэй бөгөөд нөгөө талаас аяндаа цэгцрэх (өөрийгөө зохицуулах) шинжтэй.

Гадаад ертөнц хэлэн дэх ертөнц нь эх болохдоо байж болох бүх шинжүүдээр дэлгэрч сэтгэхүйн ертөнцөд боловсрогдоно. Тэр үед хэлэгдэхүүний нэг хэлбэр-дохио хосолдог байна. Сэтгэхүй дэх энэ боловсруулалт хоршсон хэлэгдэхүүний нэгжийг бий болгож хэлийг баяжуулдаг. Хоршсон үг, нэгж аажмаар “сонгогдох” зарчмаар битүү бүтцээ алдан харилцах, мэдээлэхэд онцлогдсон, чухалчлагдсан бүрдүүлэгч нь үлдэнэ. Энэхүү үлдсэн дохио хэлэгдэхүүний нэг нэгж дахин болж улмаар дахин дэлгэрүүлэх, тайлбарлахтай холбоотойгоор дахин хоршсон битүү цэгцтэй бүтэц үүсгэж болно. Үүнээс үндэслэн тодосгогч, тодосгуулагчийн хосолсон хэрэглээ (сэтгэлгээ) ойролцоо утгатай хоршоо үгийг бий болгосон. Хоршоо үгийн утгын ойролцоо болон авианы ойролцоо байдлыг харгалзан тухайн эхийн үг өгүүлбэр, цогцолборыг харшуулан ойртуулах, толгой сүүл холбох, мөр бадаг тэнцүүлэх зэрэг найруулах эрдмийг монголчууд чадамгай ашигладгийн жишээг МНТ-ны хэлээс харж болно.

МНТ тодосгогчууд, тоогоор тодосгосон, оноосон нэр, өргөмж нэр, ойролцоо зэргэд (хоршсон хэлбэр), оруулбар шинжтэй тодосгогчууд олонтоо. Хураан

тодосгосон жишээг авч үзвээс... Алтан ээмэг, дөрөвчит булгаар доторлосон таж *торгон* элгэвчит өчүүхэн хөвүүхнийг авчирч Чингис *хаан* Өгээлүн *эхэд сауха* өгөв. (МНТ, 81т)

Ялган, хурааж тодосгосон, тодосгохдоо тодосгуулагч онцолбор гишүүдийг илрүүлсэн. Түүнчлэн Чингисийн байлдан дагууллын үе дэх саухаг тоочиж утгыг дэлгэрүүлж, хураан тодосгосноор тодосгогч гишүүн дэлгэрүүлэх бус хураах үүрэг гүйцэтгэдгийг, монголчуудын эрхэмлэх ёс, эдлэл чимэглэл, түүгээр дамжуулан язгуур гарвалийг харуулсан байх.

Жамуха өгүүлрүүн: “Тэмүжин *анд, анд!*

Уул шахан бууя.

Адуучин, бидний

Алагчугаа хүртүгэй

(*Голд шахан бууя.*

*Хоньчин хургачин бидний*

*Хоолойяа хүртүгэй*”) <sup>тодосгогч</sup> хэмээв.

Тэмүжин Жамухын энэ үгийг сонсоод ухаж ядаж, сэмээр байж хоцорч, нүүр думд тэргэдээн хүлцэж, (дүрсэлж тодруулан тодосгосон)

Булган дахын хариу

Бутарсан улсыг чинь

Бүгдгэлдэж өгсү

(*Хар булган дахын хариу*

*Хагацсан улсыг чинь*

*Хамтатгалдаж өгсү.*) <sup>тодосгогч</sup>

Ойролцоо утгатай зэргэдээр тодосгогч тодосгуулагчийн харьцаа үүсгэж, эрчимжүүлсэн утгатай. Утгын ойролцоо болон авианы ойролцоо байдлыг харгалзан тухайн эхийн үг өгүүлбэр, цогцолборыг харшуулан ойртуулах, толгой сүүл холбох, мөр бадаг тэнцүүлэх зэрэг найруулах эрдмийг чадамгай ашиглаж тодосгогч нэгжийг ашигласан. МНТ-ноос оноосон нэр, өргөмж нэр, газар усны нэрийг хоршин давтсан жишээ олонтоо харж болно. Хоршсон бүтцийг холбоостой ба холбоосгүйгээр харж болох ба олонтоо хэрэглэсэн холбоос нь “хэмээх” гэсэн холбох үг. Охин *Бархаг*, Бартан *баатар*, Хутугту *Мөнгүр*, Хутулу *хаан*, Төдөгэн *Отчигин* (МНТ, 21т) Тэмүжин Гарсу хэмээх *морио* хөтөлж айсахуйд..., ах дүү чинь амаан, *шүдээн* билүүдэн айсуй. (41т)

Үжин *эх* хоёр хүүхдийнхээ царай ухаж, \хэлний бус хэрэглүүр\

өгүүлрүүн:.. ижлээ идэгсэд, *ханиа барагсад*...(МНТ,37т)

хань ижил – *идэгсэд, барагсад*

... дайр, бор хоёр хүлэг *агтаст* бүлгээ. \Хоёр гэсэн тооны нэр холбох үгийн үүрэгтэй\

(Агта-агталсан морь, адуун сүрэг, хүлэг - алдартай, цуутай, “морь, агт” гэсэн үг хураагдаж, хүлэг морь, хүлэг агтас, хүлэг морь гэсэн хоршоо үг үүсэж, “хүлэг” гэсэн үгэнд зөвхөн морины утга үлдсэн байна) Ой инү орж амуй, *сэтгэл инү сэнхэрч амуй* \ой ухаан нь хурц, *бодол санаа нь бузгайрч буй* \97 тал\ Хоёр залуус та үзэлдэдхүн\ үргэлж бие биенээ үзэж нөхөрлөгтүн (МНТ,3 76т) хоёр гэсэн тодотголтой үгэнд “с” олон тооны дагавраар тодосгосон, та гэсэн эртний

монгол хэлний биеийн төлөөний олон тоот хэлбэрээр тодосгосон. Энэ нь хандсан утгатай.

Бурхан халдуны өвөрөө *Хүрэлхү дотор Сэнгүр горхины Хар зүрхний Хөх нүүрт нутаглаж ахуйд* (МНТ, 43 т) *давхар тодосгосон*. Онон мөрний тэргүүнээ <sup>бүхэл</sup> Бурхан халдунаа <sup>хэсэг</sup> нутаглаж төрсөн Батачихан ажгуу. (*Тодруулан, дэлгэрүүлж тодосгосон. Ихэвчлэн монголчууд бүхлээс хэсэгчилдэг сэтгэлгээний соёл газар усны нэрэнд олонтоо ажиглагддаг.*)

Оруулбарт шинжтэй тодосгуулагч тодосгогчийн харьцааг авч үзвээс: Бас Алангоо таван хөвүүндээн сүюгэр үг өгүүллрүүн: *Та таван хөвүүн миний гагц хэвлээс төрөв...* гэх мэт оруулбарт шинжтэй эхээр тодосгосон жишээ 254 нүүрийн 38% -д байгаа нь уг зохиол дэлгэрүүлэн тодосгосон эхийн бүтцийг ашигласан. Энэ нь төдий хэр хүний хэлсэн үгийг эш татсан гэсэн үг. Давхар баймж утгын илэрхийлэмжийг ч тэмдэглэсэн байна.

### ДҮГНЭЛТ

Тодосгогч нэгж өөрөө хэл, хэлэхүйг холбосон үзэгдэл бөгөөд МНТ хэлний нөгөө талаас хэлэхүйн чухал дурсгал. Тиймээс эртний үг хэллэгийн түгээмэл тайлбар бүхий эхээс ашигласан тодосгогч тодосгуулагчийн харьцааг эрсэн. Нүүр бүрт тодосгогч нэгж илэрсэн. Тодосгогч нэгжийг бүтээврээс эхлэн эхийн түвшинд авч тайлбарлах боломжтой.

Гадаад ертөнц хэлэн дэх ертөнцийн эх болохдоо байж болох бүх шинжүүдээр дэлгэрч сэтгэхүйн ертөнцөд боловсрогдоно гэж Н.Чомский хэлсэн байдаг. Тэр үед хэлэгдэхүүний нэг хэлбэр-дохио хосолдог байна. Сэтгэхүй дэх энэ боловсруулалт хоршсон хэлэгдэхүүний нэгжийг бий болгож хэлийг баяжуулдгийн жишээ МНТ-д олонтоо байгаа нь харагдаж байна.

### НОМ ЗҮЙ

1. Актуальные проблемы текста, Улаан-Үдэ., 2004
2. Бабайцева, В.В., Максимов, Л.Ю., Современный русский язык, Синтаксис пунктуация, М., 1981
3. Базаррагчаа, М., Монгол хэлний өгүүлбэр судлал, Уб., 2005
4. Базаррагчаа, М., Монгол хэлний хоршоо үгийг хэрэглэх тухайд, Уб., 1990
5. Бат-Ирээдүй, Ж., Структура, семантика и функция синонимов в монгольском языке, (автореферат), Уб., 2004
6. Бат-Ирээдүй, Ж., Монгол хэлний хэлц үг хэллэгийн утга хэрэглээ, Уб., 2007
7. Барайшир, Ш., Өгүүлбэрийн тодосгогч гишүүний тухай асуудал, (ОУМЭ-ийн 4-р их хурал, 2-р боть) Уб., 1984
8. Монголын нууц товчоо (сонгомол эх)
9. Прагматик хэл шинжлэлийн онолын үндэс, хамтын бүтээл, Уб., 2007
10. Пүрэв-Очир, Б., Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй, Уб., 2001

### ABSTRACT

The Mongolian Language is rich in unit modifier and their function is immense. “The Secret History of the Mongols” is a literary and significant work of Mongolian history and culture. Many scientists and researchers of the world have been studying it in various aspects.

This paper was written for the purpose of briefly clarifying some usage modifiers related to parallel structure of the Secret History of Mongols. Parallel structure means using the same pattern of words to show that two or more ideas have the same level of importance. This can happen at the word, phrase or clause level. For example:

Khari ulsiig ul temtsen	(Uls irgeniig ul temtsen
Khatsar goo okhidiig	Ungu sait okhidoo usguj
Khasag tergend unuulj	Uljigtei tergend unuulj
Khar buur khulguj	Ul buur khulguj
Khatiruulj odoj	Uusgej odoj
Khatan suurind	Undur suurind
Khamt ssulgamui bid	Uruul etgeed suulgakhui bid) <sup>modifier</sup>

Another issue addressed in this paper is the usage of different modifiers in “The Secret History of the Mongols” has been explained from the point of psycholinguistics.



**Б.РИНЧЕНГИЙН “МОНГОЛ ШҮЛГИЙН УЧИР” (1970)  
ӨГҮҮЛЛИЙН ШИНЭЛЭГ ҮЗЭЛ САНАА**

Г.Галбаяр  
/МУИС/

Монгол түмнийхээ соёл иргэншил, аж амьдрал, эрдэм ухааны үнэт зүйлийн охь дээжээс суралцаж, сурвалжлан цуглуулж, судлан шинжилж, хойч үеийн бидэнд үнэ цэн, үнэн учрыг нь нээн өгсөн нэгэн бол эрдэмтэн Б.Ринчен билээ. Б.Ринченгийн монголын уран зохиол судлалын хүрээнд бичсэн бүтээлүүдийн нэг нь “Монгол шүлгийн учир” өгүүлэл юм. “Монгол шүлгийн учир” өгүүллээ ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛ сэтгүүлийн 1970 оны VII (17-102 дугаар тал), VIII (5-50 дугаар тал) ботид хэвлүүлжээ. Шүлэг нь туурвигч үндэстнийхээ хэл-сэтгэхүйн цөм ухагдахууныг уран сайхны сэтгэлгээний дээд эрэмбэт төгс дүрслэлээр илэрхийлж биелэлээ олдог зүйл. Монгол шүлгийг монгол үндэстний уран сайхны сэтгэлгээ (дүрслэл), монгол хэл бичгийн зүй тогтол (найруулга)-ын илэрхийлэл гэж онцлон авч үзээд цогцоор нь судлан шинжилснээрээ “Монгол шүлгийн учир” өгүүлэл чухал ач холбогдолтой. Иймээс монгол шүлгийг ямар нэг хэмжээгээр судлан шинжилж, зарим талын онцлог, мөн чанарыг үнэн мөнөөр нь нээн буй энэ цаг үед Б.Ринченгийн “Монгол шүлгийн учир” өгүүллийн судалгааны арга зүй, ололт амжилт, шийдсэн шийдлийг бататган гүнзгийрүүлж, лавшруулан судлах нь чухал ач холбогдолтой ажлын нэг болоод байна.

Б.Ринченгийн “Монгол шүлгийн учир” өгүүлэл I. Ерөнхий тэмдэглэл, II. Авиа үсэг хоёрын учир, III. Монгол хэлний үеийн бүтэц, IV. Шүлгийн хоёр ёсны учир, V. Холбоц, VI. Монгол бичгийн шүлгийн зарим байдлаас гэсэн үндсэн зургаан хэсэгтэй ажээ. Монгол шүлгийн ерөнхий онцлогийг монголчуудын түүхэн замнал, соёл иргэншил, аж амьдрал, сэтгэлгээний онцлогтой уялдуулан авч үзэхдээ монгол хэлний авиа үсгийн харьцаа, үеийн бүтэц, зүй тогтолтой давхар холбож хүн төрөлхтний нийтлэг шүлгийн тогтолцоо, бүтэцтэй харьцуулан судалсан байна.

**НЭГ: ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Гол өгүүлсэн зүйл:** Б.Ринчен “Монгол шүлгийн учир” өгүүллийнхээ эхэнд “Монголын Нууц Товчоо” тэргүүтэй монголын түүхэн сурвалж бичгүүдээс үзвэл “монголчууд толгой холбосон үг, шүлэглэл их хэрэглэдэг байсан байна. ... одоо хүртэл манай ардууд уран цэцэн үгэнд их дуртай, толгой сүүл холбон хэлэлцдэг нь нийтийн заншил байгааг дурдаж болно” /VII. 17 дугаар тал/ гэж монголын ард түмний зан заншил, соёл сэтгэлгээний онцлогийг тэдний туурвин үлдээсэн шүлэг найрагтай уялдуулан өгүүлээд гадны бусад улс үндэстний шүлэг найргийг монгол хэлнээ хөрвүүлэх ёс уламжлал дүрэм журмын тухай тодруулан авч үзжээ. Тухайлбал, төвөд хэлнээс монгол хэлнээ шүлэг орчуулахад баримтлах ёсны тухай

өгүүлсэн “Мэргэд гарахын орон” гэдэг төвөд монгол нэр томъёоны толь бичигт “Бус бас монголын хэлэндүр шүлэглэсэн хийгээд үргэлжилсэний ялгал ба шүлэгтүр ч бадаг урт охор тэгш болох тэргүүтэн төвөдийн хэл ямбарчлан эс болбаас бээр, шүлэглэснүүдий нь яруу найртай утга төгс, мэдэхүйеэ хялбар бадгийн урт охорыг ч олонхиныг тэгш үйлдэх бөгөөд магтаал хийгээд залбирал мэт заримуудтур монгол хэлэндүр адилхсан толгой холбох мэт үйлдвээс бээр харигүй боловч, их голнуудтур тэр мэт үл үйлдэх бөгөөд бусцар болбаас олон илүү үгс орсноор утга далдлагдахын тул болой.

Бус бас дохио найруулахын гол энэ хийгээд бусдаа эс гарсан дохиог шинэ найруулах хэрэгтэй болбаас, өөр өөрийн газраа дураар зориг мэдэн нэрийдэл үгүүеэ орчуулахын хүрээндүр тулгаж, гол ба учир шалтгаан лугаа харишуулал үгүүеэ орчуулагдахуй. Тэдгээр ину шалтгаан өгүүлэх хийгээд ном орчуулах ёсыг цаазлан тогтоосон товчийн төдий болой” /VII. 17-18 дугаар тал/ гэснийг тусгайлан авч тайлбарласан байна. Энэ нь төвөд монгол үгийн дэс дараа нь өөр учраас монгол хэлнийхээ ёсонд нийлүүлж, үгийн байрыг солихын мөн чанарыг өгүүлжээ. Энэ мэтээр гадаадын хэлнээс тэдний шүлэг найргийг монгол хэлнээ хөрвүүлэхдээ үнэ цэнтэй онцлог шинжийг нь алдагдуулалгүй хэрхэн буулгах арга зарчмийг тодорхой болгоход монгол шүлгийн өөрийнх нь зүй тогтлыг нэн тэргүүнээ судлан шинжилж тодорхой болгох ёстойг асуудал болгон дэвшүүлжээ. Уг асуудалтай холбоотойгоор монгол шүлгийг судлан шинжилсэн Габеленц, Ковалевский, Владимирцов, Крюгер, Туденов, Б.Содном нарын зэрэг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын судалгаа шинжилгээний үр дүнгээс танилцуулжээ.

**Шийдэл:** Гадаадын бусад орны шүлэг найргийг монгол хэлнээ орчуулахад тухайн шүлгийн онцлогийг алдагдуулахгүй байх ямар арга зарчим байж болохыг авч үзэх, улмаар монгол шүлгийн гадаад, дотоод зүй тогтлыг тодруулахын чухлыг асуудал болгон дэвшүүлсэн байна.

### **ХОЁР: АВИА ҮСЭГ ХОЁРЫН УЧИР**

**Гол өгүүлсэн зүйл:** Хүн төрөлхтөн “утга үсэг, авианы үсэг –ийм хоёрхон зүйлийн үсэг хэрэглэн буй” /VII. 30 дугаар тал/ Утга үсэг гэгч нь нэг үгийг нэг тэмдэгтээр тэмдэглэдэг бол авианы үсэг гэгч нь нэг үгийг хэд хэдэн эгшиг, гийгүүлэгчийн хослолоор тэмдэглэдэг. Эгшиг, гийгүүлэгчүүдийн хослолоор бүтэх авианы үсэг нь үндэстний сэтгэлгээ, соёл, зан заншлаас хамааралтай шинжлэх ухааны үндэслэлтэй үсгийн, зөв бичих зүйн, зөв дуудах зүйн дүрэмтэй байдаг байна.

Судлаач Б.Ринчен “Авиа үсэг хоёрын учир” гэсэн энэ хэсэгтээ монгол хэлний үсгийн дүрэм, зөв бичих зүйн зүй тогтол, зөв дуудах зүйн уялдаа холбоо, учир шалтгааныг тайлан тайлбарлажээ.

Үсгийг хэрхэн зөв дэс дарааллаар бичихийг үсгийн дүрмээр шийдвэрлэдэг бол үгийг хэрхэн зөв бичих ёсыг зөв бичих зүйгээр шийдвэрлэдэг. Зөв бичих зүй нь тухайн хэлний онцлог мөн чанар, зүй тогтолд үндэслэгдсэн байдаг байна. Монгол хэлнээ үсгийг хэрхэн зөв бичих үсгийн дүрэм, түүнээс урган гарсан үгийг зөв бичих зөв бичих зүй нь гурван янз байна. Нэгдүгээр зарчим нь авиан зүйн зарчим. “Тэр ёсоор нэгэн хэсэг үгийг өгүүлэхийг баримтлан бичих журам болно. Ганц үеэр бүтсэн үг, үгийн үндэс, язгуурын зүйлд хэрэглэнэ. Гар, хөл гэх мэтийг авиан зүйн зарчим баримтлан(х) зөв бичих зүйн ёс буй.” /VII. 41 дүгээр тал/ Хоёрдугаар зарчим нь хэлбэр судлалын зарчим. “Соёл өндөр улсын зөв бичих зүйд үг дахин бүтдэгийг хэлний шинжлэлтэн, тухайн хэлэнд ямар утгаар, дагавар

зэргийн үг бүтээгч зүйл буйг шинжлэн ялгаж, тус бүрийн зөв бичих журмыг тогтоон, тогтмол тэр угтвар, дагавар зэргийн залгавар нь язгуурт хойно урд нь орохдоо шинэ үг бүтээдэг нь цөм хэлбэр судлалын үүднээс дүрэмтэй байдаг тул, эл хоёрдугаар журам нь зөв бичих зүйн гол зарчим байдаг байна.” /VII. 41 дүгээр тал/ Авиа сэлгэн үг бүтээх ёсыг энэхүү хэлбэр судлалын хүрээнд шийдвэрлэдэг болохыг тодруулан жишээ баримтаар баталгаажуулан тайлбарлажээ. Гуравдугаар зарчим нь уламжлалт зарчим. “Бусад хэлнээс орсон үгийг тэдгээр хэлний журмыг нь уламжлан бичих зүйл болно.” /VII. 42 дугаар тал/ Сайн боловсорсон хэлний зүй тогтол тэр дундаа авиа үсэг хоёрын зарчимтай холбоотойгоор үсэг яаж тэмдэглэх үсгийн дүрэм, үг яаж бичих зөв бичих зүйгээс урган зөв дуудах зүйн тухай ойлголт гардаг. Хүн хэдий чинээ боловсрол мэдлэгтэй болно төдий чинээ бусадтай харилцах шаардлага урган гарна. Тэрхүү шаардлагыг хангахад харилцах хэлнийхээ зөв дуудах зүйд сайн суралцах хэрэгтэй. Энэ нь зөв дуудах зүй шинжлэх ухааны үндэслэлтэй боловсрогддогийн гэрч. Харин монгол хэлний зөв дуудах зүйн асуудлыг манай хэлний шинжлэлийн эрдэмтэд даруй шийдвэрлэхийг асуудал болгож сөхөн тавьжээ.

**Шийдэл:** Үсгийг зөв бичих үсгийн дүрэм, үгийг зөв бичих зөв бичих зүйн дүрэм, үгийг зөв дуудах зөв дуудах зүйн асуудал харилцан холбоо хамаарал бүхий тус тусдаа үүрэг зорилго бүхий зүйлс ч тухайн хэлээр шүлэг бичих суурь хөрс болох учир шүлэгч хүн өөрийн хэлнийхээ зүй тогтол, онцлогийг язгуур мөн чанараас нь сайн судлан шинжилж мэдэх, төгс сайн суралцах шаардлагатай байдгийг өгүүлжээ. Үсгийн дүрэм, зөв бичих зүй, зөв дуудах зүй нь дотооддоо шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн зүй тогтолтой байх тул шүлэгч, орчуулагч хүн түүнийг сайн мэдсэн байх нь сайн шүлэг бичих, сайн орчуулга хийх гол үндэслэл болно.

## **ГУРАВ: МОНГОЛ ХЭЛНИЙ ҮЕИЙН БҮТЭЦ**

**Гол өгүүлсэн зүйл:** Үг үеэр бүтнэ. Үгийн үеэр бүтэх зүй тогтол хэл хэлэнд өөр өөр байх ч нийтлэг шинж нь эгшиг, гийгүүлэгч хоёрын хоорондын найран орох байдлаас шууд хамааралтай. Монгол хэлний үеийн бүтцийн тогтолцоог эрдэмтэн мэргэд судлан шинжлээд доорх 4 зүйлийн зүй тогтол байна гэж тогтоосон байна. Үүнд:

- |  |        |
|--|--------|
| 1. Эгшгээр бүтсэн үе                               | -Э     |
| 2. Эгшиг гийгүүлэгч хоёроос бүтсэн үе              | -Э+Г   |
| 3. Гийгүүлэгч эгшиг хоёроос бүтсэн үе              | -Г+Э   |
| 4. Гийгүүлэгч, эгшиг, гийгүүлэгч гурваас бүтсэн үе | -Г+Э+Г |

“Энэ дөрвөн зүйлийн үеэр манай хэлний эрт одоогийн бүх монгол үг, монголын эрт одоогийн бүх хэл аялгуунаа бүтсээр иржээ.” /VII. 50 дугаар тал/

Эгшгээр бүтсэн үе (Э)-д ганц ерийн эгшиг юмуу ганц урт эгшиг байж болдог. “Чингэхдээ монгол хэлний нэгэн онцлог нь гэвэл, нэгэн үгнээ чанга буюу эр эгшиг, эсвэл сул буюу эм эгшиг орохоос, эр эм эгшиг нэгэн үгэнд хутгалдан ордог журам үгүй тул үгийн эхний үеийн эгшиг нь эр байвал цаашаа дан эр эгшиг болно. Үгийн эхний үеийн эгшиг нь эм эгшиг байвал тэр үгийг найруулан бүтээсэн бүх дагаврын эгшиг нь цөм эм эгшиг байдаг журамтай. Чингэхдээ саармаг буюу эрс гэдэг и эгшиг бүхгүй үе, эр эгшигт үеэр эхэлсэн үгнээ оролцож болно. Мөн эм эгшигээр эхэлсэн үгийн дараачийн үед ч эл саармаг и эгшиг эгшигтэй үед орж болно. ... Энэ бол монгол хэлний эгшиг зохицохын хууль болой” /VII. 51 дүгээр тал/ Монгол хэлний хос эгшиг эр, эм гэж байх тул дээрх хуульд шууд захирагдана. Хоёр өөр үг угсрах аваас энэ хууль үйлчлэхгүй. Учир нь хоёр өөр үг угсрах нь өгүүлбэр зүйн

асуудал юм.

Монгол шүлэг монгол бичгийн хэлний зүй тогтлоор бичигддэгийн хувьд олон монгол хэл аялгууны дундын хувилбараар бичигдэж, зөвхөн тэдний дуудах дуудлагаар ялгарах энэ онцлогтой нарийн холбоо хамааралтай. “Учир нь юувэ? гэвэл шүлгийн хэм хэмжээг нь алгасалгүй нарийн баримталж бичсэн буюу орчуулсан бол цаад уг хэлний шүлгийн хэм хэмжээг ширхэгийн төдий өөрчлөлгүй нарийн буулгаж орчуулсан зүйл цөөнгүй тохиолдмуй. Чингээж нарийн хэм хэмжилтэй зохиосон монгол шүлэг бол орчин үеийн европын сайн яруу найрагч нарын хэрэглэдэг нарийн журамтай яг нийлэх өндөр боловсролтойн гэрч бөгөөд бусад хэлнээс орчуулсан шүлгийн зохиолд уг эх хэлний сайн зохиосон нарийн хэм хэмжээг нь шад тутамд алдалгүй буулгаж чадсан нь бас л манай яруу найрагч нарын сүрхий чадал, өндөр боловсролыг нь харуулж, олон улсын одоо хэрэглэж журам болгодог сонгодог нарийн арга барилгыг аль хэдийн мэдэн эзэмшсээр ирсэний бахархалтай гэрч болой.” /VII. 57-58 дугаар тал/ Монгол хэлний үеийн бүтэц, эгшиг зохицох хуультай уялдаатайгаар монгол шүлгийн олон янзын онцлог бий болсон байдаг байна.

Монгол хэлний үеийн бүтэц үүсэх Э+Г, Г+Э+Г гэсэн зарчимтай холбоотой үүсэх монгол хэлний гийгүүлэгч дэвсгэрлэх ёс, улмаар үеийн төгсгөлийн “дэвсгэр” авиа монгол шүлгийн урлалд хэрхэн нөлөөлснийг авч үзжээ.

Дэлхийн олон орны хэлэнд түгээмэл байх үеийн бүтцийн онцлогийг дэлгэрэнгүй тайлбарлаж, тэрхүү үеийн бүтцээр бичигдсэн шүлэг зохиолыг хэрхэн монгол хэлнээ орчуулах тухай авч үзсэн нь бий.

**Шийдэл:** Монгол хэлний үеийн бүтэц дөрвөн янзаар үүсэх ч эгшиг зохицох хуулинд захирагддаг онцлогтой. Монгол хэлний эгшиг зохицох хууль шүлэгт нэг мөрийн хэмжээнд үйлчлэх зүй тогтол үүсгэдэг. Энэ нь монгол шүлгийн гол онцлогуудын нэг болно. Монгол шүлэг монгол хэлний үеийн бүтцийн зүй тогтол, монгол бичгийн хэлний зөв дуудах зүй /Владимирцовын ажигласнаар монгол бичгийн хэлний дуудлага гурван янз байна/-н журмын дагуу хэм хэмнэл үүсдэг байна. Өөрөөр хэлбэл монгол шүлгийн нэг онцлог нь мөр хоорондоо нарийн хэм хэмнэлтэй байх явдал юм. Мөр хоорондын хэм хэмнэл жигд байх нь шүлгийг уянгалаг сайхан сонсогдуулах төдийгүй олон янзын үнэт шинжийг агуулж оршдог билээ. Монгол хэлний гийгүүлэгч дэвсгэрлэх ёс нь монгол шүлгийн мөр хоорондох үеийн тооны тэнцэл, холбоцын зарчимд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

## **ДӨРӨВ: ШҮЛГИЙН ХОЁР ЁСНЫ УЧИР**

**Гол өгүүлсэн зүйл:** “Энэтхэг төвөд номын хэлтэй монгол бичгийн хүмүүсийн шүлэгт хэм хэмжээний тухайд маш нарийн зохион байгуулалттай байдаг нь европ зүгийн яруу найргийн онол, шүлэг зүйтэй нийцэх зүйл үлэмж учир энэ бүлэгт европын шүлгийн ёс, түүнээ хэрэглэдэг нэр томъёог нь шүлгийн тухай сонирхох монгол уншигчдаа танилцуулж өгвөл зохих байнам. Үүнд европ шүлэг зүйн нэр томъёо нь грек-латин номын хэлээр занисан зуришл грек-латин соёлын хүрээний европ зүгийн улс түмнээ буй. Үүнд энэтхэг, төвөд номын хэлний уламжлал бүхүй монгол хэлнээ грек-латин нэрийг нь орчуулж нэгэн мөр болговол үл болох газар үгүйн дээр бусад улс, тэдгээр нэрийг өөрийнхөө хэлэнд орчуулан хэрэглэсээр ирсэн. Үүнд цөмийг нь монгол үгээр орчуулахад эртний грек буюу латин үгтэй онолдох үг монгол хэлнээ нэгэнт буйн учир үг нь монгол, утга санаа нь нийтийн байвал зүйтэй бий гэж монгол болгон буулгаж хэрэглэлээ.” /VII. 89 дүгээр тал/ Грек-латин хэлний өрнөдийн сонгодог шүлэг үеийн урт богиноор хэмжээ болгодог учир энэ шүлгийг хэмжээт шүлэг гэж нэрлэж заншжээ. Нэг богино эгшиг бүхий үеийг дуудахад

зарцуулах цагийг үндэс болгож *хронос* буюу *язгуур цаг* гэж үздэг байна. Хоёр язгуур цаг нийлээд нэг урт үеийг үүсгэнэ. Энэ үндсэн хэмжээг латинаар *мора* буюу монголоор *түдэл* гэж нэрлэдэг байна. Өрнөдийн шүлэг урт богино үе найран орж тусгай хэмжээ үүсгэдэг байна. Үүнийг грекээр *поус*, латинаар *пес* гэж нэрлэдэгийг англиар *Foot*, францаар *Pied*, оросоор *стопа* гэж нэрлэдгийг монголоор *өлмий* гэж орчуулж заншжээ. Богино урт үе нийлж өлмий үүсгэх тул энэ нь шүлгийн үндсэн нэгж болдог гэсэн үг.

Шүлгийн хоёр дахь ёс нь өргөлтөт шүлгийн ёс юм. Энэ шүлгийн ёсоор бол шад хоорондын үеийн тоо тэнцүү байхыг гол болгох ч шадын хоорондох өргөлттэй, өргөлтгүй үеийн тоог жигдлэхийг чухалчлах ажээ. Монгол хэлнээ өргөлттэй өргөлтгүй үе байх тул энэ шүлгийн ёс давамгайлдаг талтай. Тиймд монгол шүлгийг үе өргөлтөт шүлэг гэж судлаач Б.Ринчен үзсэн байна.

Энэ бүлэгт цааш нь өрнөдийн хэмжээт шүлгийн үндсэн нэгж болох дэвхцэл, бүжил, сацаль, пириг гэх хоёр үет өлмий, хуруун, хосмолжин, тонгорол, хөлчил, тонгоруу хөлчил, гурван уртат, гурван богино, крит гэх гурван үет өлмий, зөрүүлбэл, йоны, бадранга, гурамсан, бүжил дэвхцэл гэх дөрвөн үет өлмий, уужим гэсэн таван үет өлмийн бүтэц зүй тогтлыг тайлбарлаж жишээ баримтаар үзүүлсэн байна.

**Шийдэл:** Шүлэг бол тогтолцоотой хэм хэмжээт зохиол. Хэм хэмжээтэй зохиолыг хүн төрөлхтөн ерийн ярианы адил уншдаггүй заавал уянгалуулан эгшиглүүлж хэлдэг байна. Энэ нь шүлэг найраг хүний сэтгэл зүрхэнд хурцаар хүрч, тэдэнд хүчтэй нөлөө үзүүлдэгтэй холбоотойг илрүүлсэн хэрэг.

Монгол хэлээр шүлэглэхэд өрнөдийн хэмжээт шүлгийн бүхий л бололцоо нөөцийг тусгах боломж байгааг судлаач ажигласан байна. Өөрөөр хэлбэл монгол шүлэгт өрнөдийн хэмжээт шүлгийн бүхий л үнэт зүйлсийг тусган орчуулах, бас шинээр хэмжээт шүлэг зохиох бололцоотой аж. Судлаачийн үзсэнээр бол монгол шүлэг нь үе-өргөлтөт шүлгийн ёсыг түгээмэл хэлбэрээр хадгалдаг байна.

## **ТАВ: ХОЛБОЦ**

**Гол өгүүлсэн зүйл:** Монгол шүлэг бичихэд, улмаар гадны шүлгийг эх хэлнээ төгс сайн орчуулахад шүлэгч, орчуулагч хүний мэдвэл зохих асуудлын нэг бол шүлгийн холбоц гэдэг нэгэн ёсны чимэлгэн буйг бодолцох учиртай. *“Хоёр шад холбох нь наад зэргийн зүйл бөгөөд олон шад шүлэгт олон арга хэрэглэн холбодог тэр холбоц болбол, шадын эх буюу сүүлийг дуудлага адил төслүү байдлаар холбох чимэг болно. Үүнд монгол хэлнээ үлэмжид дэлгэрсэн нь шадын толгой холбох холбоц ажээ. Тэр учраас, зарим европ хүний монгол шүлгийн тухай бичсэн зүйлд монгол шүлэгт гагцхүү толгой холбох холбоц буй гэж бичсэн зүйл ч бий”* /VIII. 12 дугаар тал/ гэж бичээд *“Толгой холбох эл чимгийг тэр байдлаар нь нэрлэвэл, наад зах нь хошоод шадын толгой холбосныг толгой холбоц хэмээмүү. Хоёр буюу хэд хэдэн шадын сүүлийг холбосон зүйл бас монгол шүлэгт байдаг, түүнийг уг байдлаар сүүл холбоц хэмээмүү”* /VIII. 12 дугаар тал/ гэж монгол шүлгийн толгой, сүүл холбох ёсыг тодотгон өгүүлсэн байна.

Монгол шүлгийн толгой, сүүл холбох ёс нь шүлэгт чимэг оруулах давхар үүрэгтэй. Гадны олон улс орны шүлэгт толгой, сүүл холбох ёс өөр өөрийн гэсэн үүрэгтэй байдаг. Тэднийг монгол шүлэгт орчуулахдаа холбоцын төрөлх онцлогийг нь хадгалж монгол хэлнээ хөрвүүлэх бүрэн бололцоотойг орос, франц зэрэг шүлгийн жишээ баримтад тулгуурлан авч үзжээ. Монгол шүлэгт толгой холбох ёс тэргүүлдэг. Европ дахины шүлэгт сүүл холбох ёс тэргүүлдэг. Монгол, Европ



дахины шүлгийн ёсны холбоц ийм ч европ шүлгийг монгол хэлнээ орчуулахдаа тэргүүлэх үүрэгтэй сүүл холбоцыг толгой холбоц болгож, монгол шүлгийг европын хэлэнд орчуулахдаа тэргүүлэх үүрэгтэй толгой холбоцыг сүүл холбоц болгон хувиргаж орчуулах боломжтойг жишээ баримтад тулгуурлан тайлбарлажээ. Шүлгийн холбоцыг байрлалаар нь ялган нэрлэдэг уламжлалт аргын дагуу:

-Зэрэгцэх холбоц

Байр	Тодорхойлолт	Томъёолол
толгой	Зэрэгцээ байгаа хоёр шад нэгэн холбоцтойг тийнхүү нэрлэх бөгөөд, хэд хэдэн ч шад дараа дараагаар, завсар дунд нь өөр төрлийн холбоц ороогүй, цөм нэгэн холбоц бүхийг цөм зэрэгцэх холбоц хэмээмүй. Зэрэгцэх холбоц толгой, сүүл холбоцонд адил тохиолдоно.	- АА
сүүл		- АААА - ААВВ

-Салаавчлах холбоц

Байр	Тодорхойлолт	Томъёолол
толгой	Нэг шад алгасан холбох холбоц. Дөрвөн шад бүхий шүлгээс эхлэн үзэгдэнэ. Салаавчлах холбоц толгой, сүүл холбоцонд адил тохиолдоно.	- АВАВ
сүүл		

-Хаших холбоц

Байр	Тодорхойлолт	Томъёолол
толгой	Дөрвөн шад шүлгийн эх адгийн шадыг нэгэн холбоцоор холбох холбоц. Хаших холбоц толгой, сүүл холбоцонд адил тохиолдоно.	- АВВА
сүүл		

-Оодон холбоц

Байр	Тодорхойлолт	Томъёолол
толгой	Нүднээ үзэгдэж, чихнээ сонсогдох нэг эгшиг юмуу нэг гийгүүлэгчээр ил өнгөн холбосон холбоц. Оодон холбоц зэрэгцэх, салаавчлах, хаших холбоцын бүх онцлогийг хадгална.	- АА
сүүл		- АААА - ААВВ - АВАВ - АВВА

Б.Ринчен өгүүллийн энэ хэсэгтээ монгол шүлэг дэх авиа давтах үзэгдлийн тухай товч тайлбар хийжээ. Авиа давтан шүлгийн утга санаанд хүч нэмэгдүүлэхийн зэрэгцээ шад хоорондын хэм хэмнэлийг тэгшитгэх үүрэгтэй хэрэглэгддэг онцлогтой ажээ.

**Шийдэл:** 1. Монгол шүлэгт толгой холбох ёс тэргүүлэх үүрэгтэй. Европ дахины шүлэгт сүүл холбох ёс тэргүүлэх үүрэгтэй. Гэхдээ монгол шүлгийг европын хэлэнд орчуулахад тэргүүлэх үүрэгтэй толгой холбоцыг тухайн хэлний шүлгийн тэргүүлэх үүрэгтэй сүүл холбоц болгож, европын хэлний шүлгийг монгол хэлнээ хөрвүүлэхдээ тэргүүлэх үүрэгтэй сүүл холбоцыг монгол хэлний шүлгийн тэргүүлэх үүрэгтэй толгой холбоцоор дүйлгэн орчуулж болохыг жишээ баримтад тулгуурлан авч үзсэн ч яагаад монгол шүлэгт толгой холбоц чухал вэ? Яагаад европын хэлний шүлэгт сүүл холбоц чухал юм бэ? Эдгээр хэлний шүлгийг харилцан бие биений хэл рүү нь орчуулахад урвуу хамаарал үүсэж байгааг судалсангүй. Тиймд монгол шүлэг судлалд судлах ёстой асуудлын нэг нь энэ асуудал байна.



## 2. Монгол шүлгийн холбоцыг байрлалаар нь:

- Зэрэгцэх
- Салаавчлах
- Хаших
- Оодон гэж нэрлээд байр, үүргийг тодруулсан ч

яагаад заавал ийм холбоцууд байгааг тодруулж судалсангүй. Энэ нь монгол шүлэг судлалын бас нэг судлууштай асуудал ажээ.

**ЗУРГАА: МОНГОЛ БИЧГИЙН ШҮЛГИЙН ЗАРИМ БАЙДЛААС**

**Гол өгүүлсэн зүйл:** Б.Ринчен энэ хэсэгт шүлгийн бадгийн тухай эхлээд авч үзжээ. Тэрбээр *“Шүлэг яруу найргийн зүйлд бадаг гэдэг нэр бол тухайн шүлэглэлийн санаа гүйцэд нэгэн зүйл биеэ даасан хэсгийг нь нэрлэдэг нэр болой. Шүлгийн бадаг бол хамгийн наад захын хэмжээ нь хоёр шадаар бүтсэн байдаг. Учир иймд, монгол шүлэглэлд шүлгийн хамгийн бага хэмжээ нь хоёр шадаар бүтсэн бадаг байдаг бөгөөд эл хэлбэр нь манай ардын аман зохиолд зүйр цэцэн үгийн зүйлд хошоод хошоод шүлэглэл шадаар бүтсэн: хүн ахтай, дээл захтай, хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа гэх зэргийн цэцэн үгэнд арвин тохиолдох ажээ”* /VIII. 31-32 дугаар тал/ гэж монгол шүлгийн бадгийн тухай судалсан байна. Улмаар *“ардын аман зохиолын эл уламжлал нь бичгийн зохиолд мөн тусаж, хоёр шадат бадаг шүлэг монгол бичгийн зохиолд мөн цөөнгүй хэрэглэдэг ажээ. Энэ сонин онцлог болбол, үг товч, утга дэлгэр болохыг нэн эрхэмлэдэг байсан монгол найруулга зүйн уламжлалаас гарчээ.”* /VIII. 32 дугаар тал/ Монгол шүлгийн үг товч, утга гүн хоёр шад бүхий нэг бадаг шүлгийг хос уянга хэмээн нэрлэж заншжээ.

Монгол бичгийн шүлгийн өөр нэг онцлог нь цэглэл юм. Цэглэл гэж шадын дунд түр завсарлан түдэх үйл хэрэг. Судлаач уг асуудлыг *“Цэг гэж бичигт одоо . тэмдэг тавьж байгаа утгаас гадна ер нь цэг гэж завсарлах гэсэн утгатай тул, цэглэл гэдэг нь шүлэг дуудахад хооронд нь завсарлан дуудах гэсэн утгатай, үүнд, эл цэглэл гэдэг нэрийг орос хэлнээ латин хэлнээс цезура гэж авсан үгтэй утга дүйх монгол нэр ажээ”* /VIII. 34 дүгээр тал/ гэж тодорхойлсон байна. Улмаар монгол шүлгийн бадаглал, цэглэлийн уялдаа холбооны тухай *“нэгэн шадыг монгол шүлэглэлд хоёр тал болгож, нэг бодоход хоёр шадаар бүтсэн хос уянга нь, дөрвөн шад мэт, цэглэлээр тасалсан тал шад нь урьдах тал шадтайгаа сүүлийн тал шад нь толгой холбоостой байдаг зүйл цөөнгүй тохиолдмуй. Үүнээс болж, бас монгол шүлэгт хос уянгын хоёр шад нь дөрвөн шад мэт байдалтайн улмаас, хоёр шад шүлгийг нэгэн бүтэн зүйл гэж уншаад, дотор нь хоёр тал шадаар цэглэн хуваасны нь дөрвөн шад гэж үзэж, хоёр шадыг нь нэгэн бадаг мэт, тэгээд тэр хоёр шадыг цэглэж, дөрвөн шад болгосныг нь бас нэгэн бадаг гэж үзэн, хоёр янзаар дуудан унших зүйл болгодог шүлгийн нэгэн арга байдаг ажээ”* /VIII. 34 дүгээр тал/ гэж монгол шүлгийн бадаглал, шад үүсгэн шүлэглэх аргын онцлог, бололцоог олж харжээ. Монгол шүлэг дэх энэ өвөрмөц арга, бололцооны илэрхийлэл болгож *“Гүнж”* туурь-өгүүлэгийнхээ оршилд шүлэглэл зохиосон байдаг.

Монгол шүлэгт байх өөр нэг онцлог нь шадын дундах үеийн тоо тэнцүү байх асуудал юм. Б.Ринчен *“Монгол шүлгийн учир”* өгүүлэлдээ монгол шүлгийн шад хоорондох үеийн тооны асуудлыг тусгайлан авч судлаад монгол шүлэгт шадуудын үеийн тоог тэнцүүлэх нь *“чухал”* гэсэн шийдэлд хүрчээ. Үүний эсрэг нь үг найруулгын хэмнэлийг чухалчлах ч утга санааг тэргүүлэх үүрэгтэй чөлөөт шүлэг (vers libre, /свободный стих/) ч монгол шүлэгт цөөнгүй бичигдсэнийг судалсан байна.

Б. Ринчен “Монгол шүлгийн учир” өгүүллийнхээ сүүлийн хэсэгт Эрдэнийн сан Субашидийн монгол орчуулгын тухай тусгайлан авч үзээд энэ асуудлыг миний багш Владимирцов 1927 онд судлаад “энэ тухай юм бичээрэй” /VIII. 44 дүгээр тал/ гэж захисан захиасыг биелүүлж уг өгүүллийг бичлээ. Бичихдээ “монгол шүлгийн тухай, мөн европын олон хэлнээс шүлэг яруу найргийг монгол болгон буулгах яруу найрагчин орчуулагч нартаа эл хоёр ёсны шүлгийн зүй тогтоолд нийцэх юм олон буйн учир, монголоор шүлэг бичихдээ ч гэсэн, нийтийн ёсонд шүлгийн хэм хэмжээ, холбоц зэргийн чимэг нийлэх зүйл бий, монгол сонгодог шүлгийн зүйлд ч гэсэн, сайн дуун хөрвүүлэгчийн орчуулсан яруу найрагч ч гэсэн, олон улсын шүлгийн ёсны зарчим журам бийг цухас үзүүлэх гэсэн өгүүлэлдээ дурдан гаргах завшаан гарлаа” /VIII. 44 дүгээр тал/ гэж энэ өгүүлэлдээ юуны тухай бичсэнээ товч дүгнэж өгүүлжээ.

Эцэст нь “Европ зүгийн шүлгээс одоо манайхан орчуулдаг болсонд, шүлгийн утгыг орчуулахын зэрэгцээгээр, сайн орчуулагч хүн, шүлгийн бүтэц хэмнэл тэргүүтнийг анзааран нягталж, монголоор буулгахад тэдгээр арга чимгийг нь буулгах чадал манай монгол хэлнээ буйг анзааран бодууштай. Яруу найраг байгаа цагт шүлгийн хэм хэмжээ, бадаг зэргийн олон хэлбэрийг хэрэглэх нь хэзээд байх бий гэж өрнө зүгийн яруу найргийг судлагчин болон яруу найрагчин үздэг, үүнд, монгол яруу найргаа орчуулгын зүйлээр олон улсын сонин хэлбэрийг буулган хэрэглэж монгол яруу найргийг баяжуулахын хамтад монголоороо найруулан бичих шүлгийн зүйлд ч тэдгээр арга барилыг ухамсарлан хэрэглэх цээнд бид хэдийн хүрсэнээ бодууштай” /VIII. 37 дугаар тал/ гэсэн анхааруулга бичсэнийг өгүүлбэ.

**Шийдэл:** 1. Монгол шүлгийн бадаг, түүний үндсэн нэгж болсон бадгийн тухай судалсан ч яагаад монгол шүлэг заавал хос уянгаар бадагладаг зүй тогтол, мөн чанарыг нарийвчлан судалсангүй. Монгол шүлгийн үндсэн нэгж болох хос уянгын мөн чанар, утга учрыг монголчуудын уламжлалт соёл сэтгэлгээ, иргэншил, ертөнцийг үзэх үзэлтэй холбож нарийвчлан судлах нь монгол шүлэг судлалын чухал ажлын нэг гэдэг гаргалгаа гарч байна. Улмаар монгол шүлэг дэх бадаглал зүйн тухай цогц асуудал эндээс урган гарч ирэхийг үл марталтай.

2. Монгол шүлгийн нэг шад дундаа нэг ба хэд хэдэн цэглэлтэй байдаг байна. Цэглэл ямар нэг үеийн дунд бус заавал үг утга төгссөн газар үүсдэг онцлогтой. Үүний учир холбогдлыг нарийвчлан судлууштай нь илэрхий байна.

## ДҮГНЭЛТ

Б.Ринчен “Монгол шүлгийн учир” өгүүлэлдээ монгол хэлнээ гадаадын шүлэг найргийг орчуулахад цаад эх хэл дээрээ байгаа ая айзам, хэм хэмнэл зэрэг үнэт шинжийг нь алдагдуулахгүй буулгах боломж байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Хэдийгээр монгол шүлэгт гадаадын шүлэг найрагт байх ерөнхий арга зарчим байх ч өөрийн гэсэн өвөрмөц онцлог байгааг онцлон авч үзсэн байна. Монгол шүлэг судлалд тулгараад байсан олон асуудлыг монгол ахуй соёл, хэл, уран сайхны сэтгэлгээний хослолын үүднээс тодорхой хэмжээгээр шийдвэрлэж чадсан нь энэ өгүүллийн гол ололт юм. Цаашид энэ өгүүлэлд шийдвэрлэсэн онолын асуудлуудыг практикаар баталгаажуулах, сүүлийн үеийн техник технологийн дэвшлийг ашиглаж улам гүнзгийрүүлэн судлах нь чухал билээ.

Оросын их найрагч А. С. Пушкины “Цаг үе ахиж болном, шинжлэх ухаан, гүн ухаан, иргэншил боловсрон өөрчлөгдөж болном. Яруу найраг нэгэн хэвээрээ аж, үл хуучран эс хувирнам. Түүний зорилго нэгэн, арга барил нь өнөөх л хэвээрээ амуу. Чингээд эртний тэнгэрийн утга, бодис зүй, анагаахуй ухаан, гүн ухааны үлэмжийн

*их төлөөлөгчдийн ухагдахуун, бүтээл, нээлт нь хэдийн хуучраад тухай бүр өөр зүйлээр солигдон халагдах ахул, үнэнхүү яруу найрагчийн бүтээл нь хэзээд сонихон шинэхэн бөгөөд үүрд орь залуу хэвээрээ ажам” /Орчуулсан Б. Ринчен/ гэж шүлэг найргийн мөн чанар, онцлог шинжийг хэлсэн энэ үг нэгийг бодогдуулж, хоёрыг сануулах биз ээ. Иймд Б.Ринченгийн “Монгол шүлгийн учир” өгүүлэл монголын судлал тэр дундаа монгол шүлэг судлалд дэвшүүлсэн асуудлаа шийдвэрлэж чадсан чухал ажил болсон нь харагдаж байна.*

## RESUME

### **Novelty aspects in article “Etiology of Mongolian verse” by B.Rinchen**

As a scholar, who was raised through both the official education system as well as the traditional way of learning cultural, domestic and intellectual wisdom of Mongolian civilization, B.Rinchen remains the main figure for later generation as an embodiment of these values preserved and studied. His article “Etiology of Mongolian verse”, dedicated to the field of Mongolian literature studies, is a towering example of his lasting achievements. It was first published in academic journal “Literature studies”, volume VII, (pages 17-102) and volume VIII (pages 5-50), released by the Academy of Sciences, in 1970.

Verse are artistic means of supreme representation of the national language and mentality. Thus, this article has a great significance as a complex research work done on Mongolian national artistry (descriptive) as well as Mongolian lexical system (particularly, the stylistics). Hence, today, when there are numerous studies done in various fields of poetry, the significance of “Etiology of Mongolian verse” by B.Rinchen is on a rise, whereas a demand for follow-up sophisticated study on its research methodology, academic findings and outcomes, and applied solutions is actual more than ever.

The article “Etiology of Mongolian verse” contains six parts:

I. **Overview.** General teaching about verse composition, special features of Mongolian verse study, comments and tips for potential scholars.

II. **On sounds and words.** General structure of Mongolian language, its phonetic system, how the phonological and lexical unity can enhance the Mongolian verse.

III. **Structure of Mongolian syllables.** 4 ways of syllable formation are discussed, then, compared and correlated with main methods of syllable formation in the world verse.

IV. **On two types of verse.** The Grecian-Latin and Sino-Indian poesy methods are compared with Mongolian verse, and their influences are revealed.

V. **Rhyming.** Various types of rhyming are discussed as distinguishing features of Mongolian verse. Moreover, their qualities are shown on detailed examples and documents.

VI. **Some facts about Mongolian verse.** Selected verse recorded in ancient Mongolian scripts and historic monuments are exemplified.

The scholar aimed to provide a comprehensive outlook on Mongolian verse, as well as to highlight its several distinctive traits. Thus, B.Rinchen correlated features of the Mongolian verse to the historical, cultural, domestic, and psychological background of Mongolians, then, analyzed the phonetic and lexical content, syllable structure and formation, finally, compared them to systems and structures of world poetic practices. The main achievement of the article rests on facts that it provides some urgent issues of the Mongolian study of verse with their resolutions within a unity of Mongolian life, culture and artistic sense. Furthermore, these theoretical outcomes must be practically approved with aid of latest high technology, which shall promote more sophisticated studies to come.

## НОМ ЗҮЙ

1. Владимирцов В. Я. *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия*. Л., 1929
2. Гаадамба М. *Утга зохиолын онолын үндэс*. Уб., 1989
3. Галбаатар Д. *Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл. Нэвтэрхий толь*. Уб., 2012
4. Галбаяр Г. *Уран зохиол шинжлэлийн лекц*. Уб., 2002
5. Герасимович Л. К. *Монгольское стихосложение*. Л., 1975
6. Гуляев Н. А. *Теория литературы*. М., 1985
7. Дамдинсүрэн Ц. *Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай*. “Шинэ толь” сэтгүүл. №2(14). Уб., 1938
8. Дамдинсүрэн Ц. *Олег цэцний орчуулгын тайлбар*. “Монгол хэл бичгийн тухай” эмхэтгэлд. Уб., 1957
9. Дашдорж Д., Даваасамбуу А. *Монгол шүлгийн дотоод холбоц*. Хэл зохиол судлал. Том-ХІХ. Уб., 1987
10. Жамба Д. *Монгол шүлгийн хэлний тухай*. “Монгол түүх хэлбичиг” сэтгүүл. №3. Уб., 1958
11. Жамбалсүрэн Н. *Монгол шүлэг*. “Утга зохиол” сонин. №8. Уб., 1956
12. Поппе Н. Н. *Халха-монгольский героический эпос*. Л., 1936
13. Ринчен Б. *Монгол шүлгийн учир*. Хэл зохиол судлал. Том-VII-VIII. Уб., 1970
14. Содном Балданы *Монгол шүлгийн арга маяг*. Зохиол судлал. Уб., 2008-2009
15. Туденов Г. *Бурятское стихосложение*. Улан-Удэ., 1958
16. Түдэв Лодонгийн *Шүлэглэсэн туульс*. Бүтээлийн чуулган VI. Уб., 2002
17. Хамгашалов А. *Опыт исследования бурят-монгольского стихосложения*. Улан-Удэ., 1940
18. Хүрэлбаатар Л. *Сонгодог уламжлал, монгол яруу найраг*. Уб., 1989
19. Цэдэв Д. *Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл*. Уб., 1974
20. Цэнд Д. *Монгол шүлгийн тогтолцооны асуудалд*. Хэл зохиол судлал. Том-ХІ. Уб., 1975
21. Цэнд Д. *Монгол шүлгийн онцлог*. Хэл зохиол судлал. Том-ХІІ. Уб., 1977
22. Цэрэнсодном Д. *Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал*. Уб., 1977
23. Чимэд Д. *Монгол шүлгийн тогтолцоо*. “Үгийн ид шид” эмхэтгэл. Уб., 1968
24. Энхбаяр С. *Утга зохиолын онол-туурвил зүй*. Уб., 2000
25. Kathleen Morner, Ralph Rausch *Dictionary of Literary Terms*. McGraw Hill. 1998

**МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ, УРЛАГТ VIII БОГД ЖИБЗУНДАМБА  
ХУТАГТЫН ДҮРИЙГ БҮТЭЭСЭН ТУРШЛАГА, ОЛОЛТ, ДУТАГДАЛ**

Б.Хишигсүх  
/МУИС/

Монголын утга, соёлын хагас зуун жилийн түүхийн цаг хугацаанд ихээхэн ээдрээтэй хувь тавилангаар холбогдсон бие хүн бол VIII Богд Жибзундамба /Жавзан-Агваанлуvsанчойжинямданзанванчигбалсамбуу/ Богд дээд хэлний оюун сайт номын наран шашныг баригч эрхт сайн цогт Агваанлуvsан /1869-1924/, хутагт билээ.

Манзуширийн хувилгаан гэж үе улиран нэрлэгдсэн Манжийн хаан Бүрэн Засагч /Түн Жи/ итгэмжит шинжээч, туршуулуудынхаа мэдээллээр Агваанлуvsанг Монголын бурханы шашны тэргүүн Богд Жибзундамбын дүр мөн<sup>1</sup> гэж зарлигаар батламжилжээ.

Судлаач Хөвдүүд овогт Г.Жамсранжав: “Богд хаан” /УБ.1988.6-7/ Жавзандамба хутагт бол хорин таван зууны тэртээх бурхан багшийн таван зуун шавийн нэг гэдэг. Тэгээд ертөнцөд дахин тодорсноос хойш 23 удаа хувилжээ. Түүний 10 нь Энэтхэгт, 15 нь Түвдэд, 2 нь Монголд тодорчээ. Тодрогчдын 6 нь бага балчраасаа Монголд аж төрж байсан тухай дурдсан байна. 1875 оны 10 сарын 3-ны өдөр VIII Богд Их хүрээнээ морилон ирэв. Мөн сарын шинийн 5-ны өдрийн луу цагт түүнийг хутагтын ширээнээ залав. Агваанлуvsангийн гурван ахыг Лувсанхайдав, Лувсанбалдан, Бадамцэрэн, дүүг нь Норов гэнэ. Лувсанхайдав шагай харвах дуртай наргианч хүн аж. Догшин сахиусуудыг шүтсээр яваад чойжин болжээ. Түүний байгуулсан “Өршөөлийг хөгжүүлэгч” сүм Чойжин ламын сүм /12/ гэж алдаршижээ. Лувсанхайдав Наймаа /Амгалан/ гацааны зайсан Дамдины охин Сүрэнхоролтой дэр нийлүүлжээ. Түүний охин нь Ж.Лхагвасүрэн жанжны эхнэр Дашцэдэн юм /13<sup>2</sup>.

1891 он Агваанлуvsан 22 сүүдэртэй. Оросын монголч эрдэмтэн, жуулчин А.Позднеев түүнтэй нүүр учран золгож тухтай ярилцав. Хөрөг зургийг нь хальснаа буулгаж авав. Хутагт бол нуруугаар дунд зэрэг, туранхайвтар. Улбар шинж ергүй, бор хөх царайтай залуу байсан /30<sup>3</sup>.

Агваанлуvsан бурханы гүн ухаан, ёс суртахууны сургаал, винайн ёсноос гадна нийгэм, түүх, уран зохиол, анагаах ба одон орны ухаан, хэл бичгийг сонирхон

---

<sup>1</sup> О.Батсайхан., “Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба”/УБ.2008/

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> Мөн тэнд

судалж байсан тухай /48/<sup>4</sup>

Эрдэмтэд, судлаачдын үзэж байгаагаар “Оройн дээд”, “Түмэн наст” хэмээн өргөмжлөгдсөн Жавзан-Агваанлуvsанчойжнянданзанванчигбалсамбуу нь 1874 онд Монгол нутгийн газар шороон дээр хөл тавьж 1924 онд таалал төгстлөө аж төрсөн ажээ.

Та бид VIII Богд Жибзүндамба хутагтын тухай өнгөрсөн арваад жилийг эс тооцвол ихээхэн өрөөсгөл ойлголттой явж ирсэн байдаг. Ингээд VIII Богд Жибзүндамба хутагтын дүрийг Монголын уран зохиол, урлагт хэрхэн бүтээж ирсэн тухайд өгүүлэхийг зорьсон болно.

Монголчууд түүхийн бүтээлд VIII Богдын тухай тэмдэглэж өгүүлээд зуун дөч гаруй, уран зохиол, тайз, дэлгэцийн урлагт Богд хааны дүрийг дүрслэн, бүтээж ирснээс хойш эдүгээ хүртэл зуу гаруй жилийг үдсэн байна.

Оросын монголч эрдэмтэн, жуулчин А.Позднеев VIII Богд Жибзүндамба хутагттай нүүр учирч золгож тухайгаа тэмдэглэж үлдээсэн төдийгүй Богдын гэрэл зургийг хальснаа буулгаж авсан нь уламжлагдаж ирсэн ажээ. Тэрээр, “Хутагт бол нуруугаар дунд зэрэг, туранхайвтар. Улбар шинж ергүй, бор хөх царайтай залуу байсан” /30/<sup>5</sup> байсан гэжээ..

Их хүрээнд байсан Манжийн сүүлийн амбан Сань До /Сандо/, удаа дараа тулган шаардсаны дагууд 1911 оны 12 сарын 3-нд нутаг буцжээ.

VIII Богд Жибзүндамбыг Монгол Улсын хаан ширээнд залах ёслол Цагаагчин гахай жилийн өвлийн дундад сарын шинийн есний /1911. 12. 29/ баасан гарагт хүрээний Төвийн шар ордонд болсон ажээ. Уул ёслолыг нүдээр үзсэн монголын томоохон сэхээтэн, угсаа залгамжилсан ноён Г.Навааннамжил “Өвгөн бичээчийн өгүүлэл” дурдатгал номондоо: “... Богд, эх дагина хоёр, хар үнэг гэдэг үнэт үстэй малгайд очир жинс хадаж, эрээн дээл, булган цоохор хүрэм өмсөж, явганаар шадар ноёд, сойвон, донир нарыг дагалдуулан хойноо шар торгон ба алтан саа луу хээт шүхэр хоёр, тогосны өдөн шүхэр нэг, ийм гурван шүхрийг бариулж, өмнө нь донир ба улаан хуйт сэлэм зүүсэн хар ноён хоёр хүн удирдан, мөнөөхөн бэлтгэсэн шар торгон зам дээгүүр алгуухнаар алхуулан явахад шадар ноёд дөрвөн хүн Богд, эх дагинын хоёр талаас нь түшиж хүндэтгэн явна. Ордны дотор байсан аймтгай шадар хүмүүс нь цочиж уулга алдаж бархирна... Богд, эх дагинын хамт Очирдар гэдэг дуганд ороод хойш явж төрийн ордонд орж очив... Тэндээс Богд хаан ба эх дагиныг төрийн ордонд хаан хатан өргөмжилж, элдэв ёслолоо дуусгаж, цогчин гэдэг том дуганд торгон зам засуулж, бишгүүр хөгжим зэргийг үлээлгэн олон сайд, ноёд, лам нар тойрон жагсаж, мөнхүү цогчин дуганд оруулав. Энэхүү дуганы төв хоймор байдаг Богдын олбог түшлэгийг хоёр адилхан зэрэгцүүлэн засаж, Богд, эх дагина нарыг залж суулган, лам нар даншиг гэдэг хурлыг хурж, мандал өргөн дуусмагц эргэж ордонд ороод, орой болоход мөн их ёслол жагсаалаар дээд сүмийн зүг буцаж, энэ өдрийн ёслол дуусаж тарав...”/УБ.1956.184-186 тал/<sup>6</sup> гэж тэмдэглэн бичсэн байдаг.

<sup>4</sup> Мөн тэнд

<sup>5</sup> Д.Цэдэв., “Шүлэг аялгууны шүтэлцээ” /УБ.2005/

<sup>6</sup> Г.Навааннамжил “Өвгөн бичээчийн өгүүлэл” /УБ.1956/



“Зуун лангийн жороо луус” хэмээх Богд хааны тухай дууг зарим судлаачид Олноо өргөгдсөн хаант Монгол улсын сүлд дуу хэмээн үзсэн нь бий. Уг дуунд:

**Зуун лангийн жороо луусыг  
Жуузан дундаа хөлөглөнөө, хө  
Зураг болсон Богд ламыгаа  
Зонховын ширээнд залнаа, хө**

**Түмэн настай Богд эзэн минь  
Шар тугдамдаа залраваа, хө  
Төрийн тулгуур олон сайдууд  
Төвшин ордондоо цуглаваа, хө**

**Наран гэрэлт Богд эзэн минь  
Алтан жуузандаа залраваа, хө  
Наян түмэн шавь нар нь  
Амь насаа даатгаваа, хө**

**Алтан амтай бүрээ бишгүүрээ  
Асарын үүдэнд хангинуулнаа, хө  
Аврал ихтэй Богд ламыгаа  
Авралын ширээнд залнаа, хө**

**Мөнгөн амтай бүрээ бишгүүрээ  
Мөргөлийн үүдэнд хангинуулнаа, хө  
Мөрөөдөл болсон Богд ламыгаа  
Мөрний эхэнд залнаа, хө**

**Далай ламын зарлигтай  
Дайсан хортон дарагдах болтугай  
Дар эх бурханаа адистай**

**Даяар хамт жаргах болтугай** /УБ.2015. 547/ хэмээн дууны талаар дотоод, гадаадын цөөнгүй эрдэмтдийн судалгаа гарсан байна. Богд хааны тухай “**Зуун лангийн жороо луус**” хэмээх дууг хэрхэн зохиогдсон талаар Можарын нэрт монголч эрдэмтэн Д.Кара мэдээлж, Америкийн Индианы Их Сургуулийн номын сангаас монгол судлаач А.Рудневын “Магистрын диссертаци” болох “Материалы по говорам Восточной Монголии” номыг үзэж түүний хуудсуудын хооронд цагаан цаасан хавчуулга хийж, шинэ мэдээ сэлтийг нөхөн бичдэг байсны дундаас Оросын “Огонёк” сэтгүүлийн нэгэн өгүүллийн хайчилбарыг олж Америкийн “Монголын нийгэмлэгийн сэтгүүл” Mongolian studies (joirnal of the Mongolia Society) цувралын 1991 оны volume XIV-г хэвлүүлж тайлбар судалгаа хийжээ./УБ.2005.,162/ Түүнд хавсралт болгосон “Огонёк” сэтгүүлийн 1914 оны 4 сарын 6-19ний 14дүгээрт нийтлэгдсэнийг эрдэмтэн Д.Цэдэв хуулбарлан толилуулжээ.

**ЗУРАГ №1**



Сүлд дууны аялгууг бичсэний төлөө Хутагтын дэд зэргийн дөрөвдүгээр “Эрдэнийн очир” одонгоор хөгжмийн зохиолч А.В.Кадлецийг шагнасан байдаг.

Полшийн эрдэмтэн Фердинанд Оссендовский бичиж 1922 онд АУН-д хэвлүүлсэн “Амьтад, хүмүүс, бурхад” хэмээх номдоо: “...Уурын тэрэг, эгшигт хайрцаг, харилцах утас, болор шаазан эдлэл, гар зураг, үнэртэй ус, хөгжмийн зэмсэг, ховор амьтан заан, цаст Гималайн баавгай, сармагчин, Энэтхэгийн могой, тоть зэрэг амьтад бас бус зүйл хааны ордонд байна...”/Ferdinand Ossedowski.Beasts,Men end Gods.New York,E.R.Dutton Company,1922,pp.145-154/7 гэснээс үзвэл Богд хаан ордондоо элдэв сонин зүйлийн цуглуулгатай байсан гэдгийн нэг жишээ болж байна.

Оросын монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов “Улаан туг” / 1927., стр 7-8/ дууны нэгэн хувилбарыг олж судалгааны өгүүлэл бичсэн нь 1927 онд Ленинградд хэвлэгдсэн байна.

Улаан тугийг мандуулаад  
 Улсын сүрийг бадруулаад  
 Урвасан хулгай Найдан ванг  
 Уухай хийгээд дарав аа хө

Шар тугийг мандуулаад  
 Шажны сүрийг бадруулаад  
 Шавь нар болсон биднүүс  
 Шамбалын дайнд мордов оо хө

Цагаан бүрээг үлээж  
 Цог заль хийморийг жигдрүүлээд  
 Жагсаал ёсыг гүйцэтгээд  
 Чанадын сүрийг дарав аа хө хө

Түмэн сумтай пулемёт нь  
 Төрийн цэргийн зэвсэг ээ хө

<sup>7</sup> Ferdinand Ossedowski.Beasts,Men end Gods.New York,E.R.Dutton Company,1922,pp.145-154/

Түйтгэр болсон муу сайчуудыг  
Төрийн ёсоор устгав аа хө

Галтай тусдаг гаржаамыг  
Гартаа бариад мордов оо хө  
Гандан чойжингийн авралаар  
Гамингийн үндсийг таслав аа хө

Бодьтой тусдаг винтовыг  
Болно гэж барив аа хө

**Богд хааны авралаар**

**Бароны үндсийг таслав аа хө...** хэмээн дуулдаг байна.

Нэрт зохиолч Д.Намдаг “Шинэ Монголын шинэ театр” номдоо С.Буяннэмэхийн “Усгүй хар архи” буюу “Эд нар ингээд үхнэ” гэдэг жүжгийг авч тоглуусан тухайд “1931 оны намар С.Буяннэмэхийн “Усгүй хар архи” хэмээх зохиолыг авч тоглов...” /УБ 1988 35/<sup>8</sup> гэж тэмдэглэжээ. Нийт арван зургаан удаа тоглогдсон “Усгүй хар архи” хэмээх жүжигт (БНМАУ-ын соёлын түүхийн тойм) хар, шар ихэс дээдэс шинэ тулгар ардын засгийг хэрхэн унагаах тухайд Богд хаанд айлтгал өргөж, шинэ засгийн талаар худал хийдэм цуурхал дэгдээж, үр дүн гарахгүйгээр үл барам Богд хаан насан эцэслэдэг. Дөрвөн бүлэг бүхий уг хошин жүжигт Богд хааны дүрийг ийн дүрсэлж, Богд хаан хүзүүндээ том лүү өлгөөд хөлчүүрсэн байдалтай. Богдын хүзүүнээс өлгөсөн лүүнд лонхоор лонхоор архи цутгах хэдий ч өнөөх лүү ёроолгүй учраас архи нь гоожиж сүсэгтэн олон тэр архианаас хүртэх гэж улайран зүтгэж байна. Богдын шадар туслах хогийн шүүрэнд хөсрий шаахай углан түүнээ “Богдын сунтаг” болгон цугларсан олонд сунтгийн адис хүртээж байгаа тухай өгүүлжээ. С.Буяннэмэхийн “Усгүй хар архи” хэмээх жүжигт бүтээсэн VIII Богд Жибзундамбын дүрийг Монголын тайзны урлагт анх дүрсэлж үзүүлсэн Богд хааны дүр хэмээн судлаачид үздэг. Уг жүжгийн найруулагчаар театрын сургагч А.Ефремов ажилласан байна.

Ши.Аюушийн “Хатан Долгор, харц Дамдин” аялгуут жүжиг 1934-1935 онд бүтээгджээ. Халх даяар амьд бурхан хэмээн алдаршсан Богд Жибзундамба хутагт тэргүүтэй хар, шар ихэс дээдсийн бусармаг хуйвалдаан, эгэл ард харц ядуусын сэтгэлээр хэрхэн тоглож байгааг, тухайлбал, хоёрдугаар үзэгдэлд Богдын ногоон ордны хаалгаар хоёр хаалгач гарч ирээд:

... Наран гэрэлт, түмэн наст эзэн хаанаас зарлиг буулгаж

Боол хар /харц/ Дамдины гэргий Долгорыг Ногоон дарь эх цол өргөмжилж

Ван ноён Таяд хатан болгож шилжүүлсүгэй

Долгор Ногоон дарь эх нааш ирж эзний хишгийг хүртсүгэй... гэж эзэн хааны зарлигийг өндөр дуугаар уншиж байна. Энэ нь харц Дамдин, хатан Долгор нарын сэтгэл рүү зүү шивэх шиг болжээ. Долгор:

Боол миний бие чинь

Богд эзний хишгийг хүртэхгүй..., гэж байна. Уг жүжгээр Богд хааны зүгээс нэр

<sup>8</sup> Д.Намдаг “Шинэ Монголын шинэ театр” /УБ.1988/

алдар, эрх мэдлээрээн бүхнийг шийдэж эгэл ардыг хэрхэн хагацуулж сэтгэлийн тамд унагаж байгаа бусармаг үйлийн тухай өгүүлжээ.

Д.Нацагдоржийн “Их авхай” /1934/ хэмээх жүжигтээ Богд хааны нүдийг илааршуулахын тулд амьд хүнээр барам гаргах аврал буулгасан гэдэг үйл явдлыг баримталж Ринбүүч, Жибзундамба, Базарваань, Дэжид, Амгаасэд, Оюунчимэг нарын дүрийг бүтээжээ. Энэхүү жүжигт Богд гэгээн, Ринбүүч, Базарваань нар хувийн өш хонзонгийн сэтгэл өвөрлөж арван наймтай залуу бүсгүй Оюунчимэгийг амьдаар нь барамд гаргаж байна.

### Агваанлуvsан /5 настай үеийн зураг/



Гончигцэрэнгийн Агваанлуvsанг Манжийн хаан Бүрэн Засагч /Түн Жи/ Богдын хойд дүрээр тодорсныг батламжилан зарлиг гаргасан ажээ. Нийтийн он тооллын 1875 оны 10 сарын 3-ны өдөр Их хүрээнд ирсэн түүнийг шинийн тавны өдрийн луу цагт түүнийг хутагтын ширээнээ залсан байна

Ши.Аюушийн “Хатан Долгор, харц Дамдин” аялгуут дуулалт, Д. Нацагдоржийн “Их авхай” /1934/ хэмээх жүжгийн Богд хааны дүрийг Богд Жибзундамба хутагт тэргүүтэй хар, шар

ихэс дээдсийн бусармаг хуйвалдаан, эгэл ард харц ядуусын сэтгэлээр хэрхэн тоглож байгааг, тухайлбал, хоёрдугаар үзэгдэлд Богдын ногоон ордны хаалгаар хоёр хаалгач гарч ирээд:

... Наран гэрэлт, түмэн наст эзэн хаанаас зарлиг буулгаж

Боол хар /харц/ Дамдины гэргий Долгорыг Ногоон дарь эх цол өргөмжилж

Ван ноён Таяд хатан болгож шилжүүлсүгэй

Долгор Ногоон дарь эх нааш ирж эзний хишгийг хүртсүгэй... гэж эзэн хааны зарлигийг өндөр дуугаар



VIII Богд Жавзандамба хутагтын зураг хэмээн танив

уншиж байна. Энэ нь харц Дамдин, хатан Долгор нарын сэтгэл рүү зүү шивэх шиг болжээ. Долгор:

Боол миний бие чинь

Богд эзний хишгийг хүртэхгүй.., гэж байна. Уг жүжгээр Богд хааны зүгээс нэр алдар, эрх мэдлээрээн бүхнийг шийдэж эгэл ардыг хэрхэн хагацуулж сэтгэлийн тамд унагаж байгаа бусармаг үйлийн тухай өгүүлжээ.

“Их авхай” жүжигт Богд хааны нүдийг илааршуулахын тулд амьд хүнээр барам гаргах аврал буулгасан гэдэг үйл явдлыг баримталж Ринбүүч, Жибзундамба, Базарваань, Дэжид, Амгаасэд, Оюунчимэг нарын дүрийг бүтээжээ. Энэхүү жүжигт Богд гэгээн, Ринбүүч, Базарваань нар хувийн өш хонзонгийн сэтгэл өвөрлөж арван наймтай залуу бүсгүй Оюунчимэгийг амьдаар нь барамд гаргаж байна.

Зохиолч, найруулагч Э.Оюун, В.Варшавский, А.Боршаговский, нарын хамтын бүтээл “Талын баатар” жүжгийн VIII Богд хаан ухаан сохор, харах мэлмий нь бас сохроор дүрслэгдсэн байдаг. Уг жүжгийн тухайд Б.Ринчен шүүмждээ: *“Биеэ худалддаг ноёд, дээд лам нарын тоглоом болсон сохор Богд ба бялдууч ноёдод өөрийн хүслийг тулгагч гамингийн түрэмгийлэн эзлэгч жанжин Сүй-Шюй-Жан, харгис балмад Барон Унгерн нар гарна”* гэжээ.

Б.Ринчен “Үүрийн туяа” гурамсан романд Богд хааны дүрийг дүрсэлсэн нь /1947-1955 /, анхны түүхэн роман хэмээн судлаачид үздэг болно. “Үүрийн туяа” роман дахь Богд хаан болоод Далай лам нарын тухай өгүүлсэн “Богд Далай лам хоёрын учирсан зүйл үнэн байдалд үл тохирмуй. Чухам ямар учир богдыг буруушаан далай ламыг сайшааж үнэн явдлыг гуйвуулсан учрыг мэдэхийг хүсмүй. /243/” Ц.Дамдинсүрэн “Туяа” романыг 1950.08.16. Сонгино., гэж тэмдэглэсэн байна. Учир нь “Үүрийн туяа” романд “Богд хаан нэг шар хүүхнээ дагуулан ихээхэн согтчихоод Ганданд буусан далай лам дээр очоод элдвээр агсагнан буурь суурьгүй, замаа алдсан ааш араншинтай, согтуу хөлчүү дүрээр дүрслэгдсэн”-ийг хэлсэн байна. Жишээлбэл, тус романы тэргүүн дэвтэр 71-р талд “...Урьд Цэ гүн, хутагтад Туул голд давхарлаг модон тагт байшин босгож өргөөд, хутагтын шадар хүн болж мандтал, Цэ, гүнгийн бага хатан Норов гэгчийн гялалзсан хар нүд нь дээрхийн таалалд нийлээд, Цэ гүн сүнсний огиу болсон хатнаа алджээ. Хорвоо ертөнцөд мөнх юм байдаггүй учир, дээрхийн таалах хүсэл санаа ч хурднаа хувьсаж, Норов хатны бие шалтгаантай болон хоцорчээ. Норов хатны орныг дээрхийн сэтгэлд Очирвань бурхны хувилгаан, уртлаг царайтай залуу Жалханз хутагт эзлээд, хөдөө нутгаасаа дээрхийн дуудсан таалалд нийлүүлэн ирж, хатны халааг авсан байжээ.” гэсэн байна. “Үүрийн туяа” романы 73-р талд “... Өнгө дарсанд хэтэрхийеэ шунаж эрт өтөлсөн овор ихтэй царай нь архаг суусан шар өнгөтэй бөгөөд тачаангуйт зузаан уруул нь, бүлтийсхийсэн нүдний хүйтэн харцтай нийлээд, эзэрхэг шинжтэй, нүд ам нь улам ч хүйтэн харагдах ажээ. Дэргэд нь, хоргой гадаргатай хурган хөнжлөөр толгойгоо битүүлэн хучсан залуу банди, алиа салбадайг орж ирэхэд зүйлсэн толгойгоо хөнжил дороос гаргаж, улцгар ягаан хацар, чавга улаан уруул нь эрх танхи эм хүний шинжтэй ажээ.” гэсэн нь цэл залуугаараа нүхэн гянданд тарчилж үхсэн Лэгцэг болно. “Үүрийн туяа” романы 225 талд “... Ширчин нүүр дээр нь батгана суусан юм шиг ярвайсхийгээд хариу дуугарсангүй. Бяцхан Ленинмаа, мойл хар нүдээрээ үл таалах зочныг ширтэн, үл ойшоох байдал үзүүлж.



- Аавын сонин гэж дуугарахад нь Дүйнхар,
- Чиний муу аав! гэжээ.
- Миний аав муу биш, та муу гэж Ленинмаагийн хэлэхэд.

- Хүүхээ тэгдэггүй юм шүү гээд Цэрэн, жаал охиноо өвөр дээрээ суулгаад, илүү дутуу, хатуу ширүүн үг битгий хэл дээ гэсэн шиг, нөхрийнхөө өөдөөс зовнин харжээ...” гэсэн байхад 254-256 талд “..., Дээрхийн гэгээн, Наймаа хотоос хөлчүү шиг заларч яваад, ордны хаалган тус Цэцэнхан аймгийн нэг эхнэр, Богдод мөргөх гэж жаал охиноо дагуулж ирсэнтэй яг дайралддаг байжээ. Тэр охин нь, нарт ертөнцөд хосгүй сайхан хүн байж, Богдын нүдэнд тун ч таатай үзэгдэж л дээ. Тэгэхэд нь тэр дороо мутрынхаа адис тавиад, охиныг нь ордондоо үлдээж, ном хүртээнэ гэж гэнэ. Эх нь магнайгаа хагартал баярлаж, өөрөө Богд гэгээний мутрын адис хүртээд, охиноо ном авшиг хүртэх нь гэж сэтгэл нь хөөрч баярлан гялайж л дээ. Тэгтэл, өнөөх согтуу Богд, тэр жаал охиныг хүчирхээд, нас бие гүйцээгүй хөөрхий тэр жаалыг гэмтээчихжээ. Цус нь тогтдоггүй сандрааж, ..., охиныг шуудайд хийж чулуу чихэлцээд Туул голын “ухаахум” гэдэг цүнхээлд үйхэд, шуудай дотроос ёолж билээ...” гэсэн нь ёстой л бүхэл бүтэн улсын эзэн хаан, бүр ухаант хүмүний үйлдэх аймшигт, гутамшигт үйл мөн үү, хэмээн дотор жихүүцэм, жигшин үзэхэд хүргэж байдаг. Б.Ринченгийн “Үүрийн туяа” романы тэргүүн дэвтрийн зарим хэсгийг эс тооцвол уг бүтээлээр VIII Богд Жибзундамбын дүрийг гаргахдаа хэт нэг талыг барьж, өрөөсгөл хандаад зогсоогүй Жалханз хутагыг /Жалханз хутагт Дамдинбазар болов уу/ хүртэл зүй бусаар харуулсан нь нэн эмзэглүүштэй санагдана. Хэдийгээр бүх зүйлийг үзэл суртлын хүлээс, дарамтын дор бичсэн гэдэг ч дэндүү туйлширч, дан хар бараан талаас нь үзүүлсэн нь даанч харамсалтай аж.

Зохиолч Ж.Пүрэвийн дурсамжаас: “Миний аавыг “Бөхөөн” Жамба гэж нутгийнхан нь дууддаг байсан. Ямагт мал руугаа бөхийж харж явдаг байсан болохоор нь тэгж дууддаг байсан биз. Бөхөөн гэдэг чинь бөхөн зээр гэсэн үг шүү дээ. Аав минь бүүр багаасаа Сайн ноён хан Намнансүрэнгийн гарын зарц нь байсан гэдэг. Сайн ноён хааны тухай их сонин юм аав минь ярьж, тэр хүнийг их магтдаг байлаа...” хэмээн зохиолч Ж.Пүрэв өгүүлж, “Аянга” /1961/ романдаа Сайн ноён хан Төгс-Очирын Намнансүрэнгийн тухай бичихийн зэрэгцээ бас Богд хааны дүрийг дүрсэлсэн бөгөөд хожим “Их хааны удам” уран сайхны кино бүтээхэд уг зохиолоос сэдэвлэсэн байдаг. Д.Маам “Газар шороо” романдаа монголын эзэн хаан Богд Жибзундамбын дүрийг гаргахдаа эрдэм билигтэй, сэргэлэн хараатай Дондогдоржийн мэдрэлийг хятад аргаар хордуулан, Лхамсүрэнг зайлуулж, монголоо гэсэн Ханддорж, Намнансүрэн нарыг хөнөөн, хааны ордон Агваанбадам мэтийн хорон санаатны үүр болж байна. Мөн Богд Жибзундамба хутагт зүүдээрээ төр, шашны бодлогын мөн чанарыг ойлгож ухаарч байгаа мэтээр дүрсэлжээ. Богд Жибзундамба бээр хатан Дондогдуламдаа хандаж: “Чиний бодол хумсны толио мэт бачуу давчуу биш, далай мэт уужим, газарт орхисон шүлс мэт охор гүехэн бус, мөрөн адил гүн байх ёстой сон доо./1982.19/., гэж байгаа зэргээс нь ажиглахад тэрээр дотоод сэтгэлдээ ихээхэн зөрчилтэй, туйлбаргүй нэгэн гэдэг талаас нь дүрсэлсэн байна. Д.Намдаг “Цаг төрийн үймээн” романдаа: “... дорд ард усанд чанасан будаагаа тавтай идэхэд ч бэрх, эзэн дээдсүүд ч ... Сэтгэл түгшүүртэй. Товчхон хэлэхэд хоолойд дүүжлүүр, хонгонд шулуур... Монгол орон уул тал, хүн, малынхаа



хамт хар тогоонд үйгдэн, дээр дороо орон буцалж буй юм шиг” 1919 оны эцэс 1921 оны эхэн, 40 гаруй дүр., Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” романдаа Заяын гэгээний зальхай явдал, ужид цэнгэл /Заяын хүрээнд өөрийн цэрэгтэйгээ очсон Хатанбаатар Магсаржав Зая гэгээнийг олны өмнө ташуурдаж байдаг/, сүсэгтэн олны дотор амьд бурхан гэж алдаршсан Богд хаан, төв шударга, бас ч ертөнцийн наадах цаадахыг гүнээ ухаарсан анги Ренчинг хэрхэн хороолгож байгаа, Жибзундамбын дампуурал, бурханы шашнаар түрээ барьж, ард түмний эсрэг, хувьсгалын эсрэг бослого гаргаж, Л.Түдэвийн “Бүгд найрамдах улсын анхдугаар он” Богд Жибзундамба хутагтыг насан эцэслэснээс хойших долоо, найман сарын дотор болсон түүхэн үйл явдлуудыг 35 бүлэгт багтаан товчоолж /1925 онд болсон үйл явдлууд/ дүрсэлсэн байдаг. Зохиолч Д.Цэнджав “Цагаагчин гахай жил” түүхэн роман /УБ.2011, 2015/ Монголын уран зохиолын түүхэнд анх удаа монголын эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө, ноёд ихэс, язгууртан дээдсүүдийн эх оронч халуун сэтгэл, гавьяа зүтгэлийг түүхийн баримт түшиглэж, урт удаан хугацааны судалгаа шинжилгээний үндсэн дээр гаргаж тавьсан явдал нь түүхэн чухал их үйл хэргийн тухай, түүхэн чухал үйл хэргийг зангидаж Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө сэтгэлзүрхээрээнийлэнгэджихүйлийгэхлүүлсэнМонголУлсынсүүлчийнхаанVIII Богд Жибзундамба хутагтын дүрийг илүү бодитой өнцгөөс нь харж дүрсэлсэн нь ач холбогдолтой болсон юм. Зохиолчийн “Цагаагчин гахай жил”, “Тал сар” роман, тууж дахь Богд хааны дүрийг тодруулж гаргахад Наваан оточ, “сарьсан багваахай” Жамсан, “шор” Гунгааням, Говь түшээ гүн Чагдаржав нарын үг, яриа үйл хөдлөл их чухал байна.

**Тайз, дэлгэцийн урлагт бүтээсэн VIII Богд Жибзундамба хутагтын дүр**

“Сүхбаатар” УБ.1942., 171 тал /ЗХУ хуучнаар/ Ташкентын ЦОКС, Ленинградын “Ленфильм” студи., Найруулагч А.Г.Зархи., И.Е.Хейфиц

Зохиогч Б.Лапин, З.Л.Хацревин., А.Г.Зархи., И.Е. Хейфиц., /Зураглаач А.И.Гинзбург., Балдангийн Дэмбэрэл., Зураач А.Босулаев., Лувсангийн Гаваа., Хөгжмийн зохиолч Б.Арапов., В.Пушков /

Сүхбаатар - Л.Н.Свердлин

Ленин - М.М.Штраух

Чойбалсан - Гэлэгдож

Янжмаа- Өлзийбаярын Рэнцэнноров

Гомбо В.В.Грибков

Эрдэнэ гүн, Сю Шүй Жан Цагааны Цэгмэд

Баяр гүн Чимидийн Цэвээн

Барон Унгерн Н.К.Черкасов

**Богд хааны дүр - Нямын Цэгмэд**

Бадам эмч, галзуу өвгөн Банзрагчийн Равдан

“Нямын багш” хэмээн алдаршсан Ардын жүжигчин Нямын Цэгмэд тэрбээр тайз, дэлгэцийн/1942-1992/ урлагт 50 жилийн туршид Богд хааны дүрийг бүтээсэн байна.



“Өглөө”. УБ.1968., 153 тал  
Ерөнхий найруулагч Дэжидийн  
Жигжид  
Зохиогч Ламжавын Ванган,  
Чойжилийн Чимэд  
“Төгсгөл” 1967., 188 тал  
Ерөнхий найруулагч Жамъянгийн  
Бунтар., А.Боброский  
Зохиогч Базарын Ширэндэв.,  
Ю.Семенов.,  
“Тэмцэл” УБ.1971.,199  
Ерөнхий найруулагч Дэжидийн  
Жигжид  
Зохиогч Ламжавын Ванган.,  
Чойжилийн Чимэд.,

“Өглөө”. УБ.1968., 153 тал  
Ерөнхий найруулагч Дэжидийн Жигжид  
Зохиогч Ламжавын Ванган, Чойжилийн Чимэд  
“Хатанбаатар”.., УБ.1981., 227 тал  
Ерөнхий найруулагч Гомбожавын Жигжидсүрэн  
Зохиогч Сономын Удвал., Гомбожавын Жигжидсүрэн  
Богд хаан Нямын Цэгмэд  
“Гарьд магнай” 1983 УБ..., 71 тал  
Ерөнхий найруулагч Жамъянийн Бунтар,  
Зохиогч Дэмидийн Хишигт., Шаравын Сүрэнжав



Богд хааны дүр Дарьсүрэнгийн Байдий

Далайцэрэн Даваагийн Батдорж  
Молиго Очир Дашдэлэгийн Алтангэрэл.,  
Дондогдулам хатан Т.Чойжилсүрэн /СТА/  
Үйл явдал 1910-аад оны эхэн үеэс эхэлнэ.

“Мандах нарны туяа” УБ.1987., 102 тал  
Ерөнхий найруулагч Халгарын Дамдин  
Зохиогч Пүрэвийн Хорлоо  
Бадамдорж Дэндэвийн Чимэд-Осор  
Сүй Шү Жан Цэгмэдийн Төмөрбаатар  
Догсом Чойн Хүрэл

“Солонгын таван өнгө” УБ.1978., 165 тал  
Ерөнхий найруулагч Бадамсүрэнгийн Нагнайдорж  
Зохиогч Түдэвийн Чимэд

### **Богд Дарьсүрэнгийн Байдий**

Эх дагина Алтангэрэлийн Бүтэд

VIII Богд хаан Жибзундамба хутагтын дүрийг тайз дэлгэцийн урлагт хэрхэн бүтээснийг ажиглавал, “сохор богд”, “сохор төвд”, “бэлгийн бузар амьдралтай”, “яр тэмбүү тараагч”, “үлбэгэр, сул дорой, туйлбаргүй”, “архичин, завхай”, “шалиг, хорон мууг үйлдэгч”, “алуурчин” гэх зэргээр бүтээж ирсэн байх юм.

“Газар шороо мину зэ” 1997  
Найруулагч И.Нямгаваа  
Зохиогч Д.Маам  
Богд хаан Дамбаринчингийн Хүрлээ

Энэхүү бүтээлд VIII Богд Жибзундамба хутагтын дүр маш тодорхойгүй бүрхэг дүрслэгдсэн /зүүдний ертөнцөөсөө сэрж буй/ төдийгүй зурвасхан гараад өнгөрдөг. Ёндонгийн Цог /МУГЖ/ Монголын тайз, дэлгэцийн урлагт Богд хааны дүрийг бүтээсэн.

“Чин ван Ханддорж” 1995., 270 тал  
Найруулагч Лхагвын Эрдэнэбулган  
Зохиогч Дамбын Төрбат., Жигжидийн Болдбаатар., Даваасүрэнгийн  
Чинзориг

“Цагаан дуганы гэгээ” УБ.1995., 260 тал  
Найруулагч Дагвын Содном  
Зохиогч Пүрэвжавын Батсайхан  
“Хааны сүүлчийн хатан” УБ.2000., 218 тал  
Найруулагч Жамбын Солонго  
Зохиогч Ламжавын Равдан., Чимидийн Гомбо  
Энэнпил /Гэнэнпил/ Нацагдоржийн Батцэцэг  
“Төрийн сүлд өршөө” УБ., 2005  
Найруулагч Бадраагийн Бадар-Ууган

*Б.Хишигсүх*

Богд хаан бага хатан Гэнэнпилийн тухай түүхэн эмгэнэлт кино  
Жүжигчин Уухааны Батбаатарын тайз, дэлгэцийн урлагт бүтээсэн  
Богд хааны дүр

Найруулагч, АЖ Б.Мөнхдорж “Эцсийн шийд” жүжигт Богдын дүрд, залуу  
жүжигчин У.Батбаатар тоглосон. Энд Богд хааны дүрийг нэлээд ухаалаг, ихийг  
бодож тунгаадаг, төрийн зүтгэлтэн талаас нь бүтээсэн байна.

“Их хааны удам”

Найруулагч Г.Жигжидсүрэн

Зохиогч Ж.Пүрэвийн “Аянга” романаас сэдэвлэсэн.

“Долоон бурхан харвадаггүй” ., 2012

Найруулагч А.Мөнхсүх

Зохиогч Ж.Мөнхбат

Богд хаан /Уухааны Батбаатар/-ы дүрийг маш хүлээцтэй, шийдэмгий,  
туйлбартай байдлаар үзүүлсэн.

Жүжигчин Чоймболын Болдын бүтээсэн Богд хааны дүр

“Богд хаан” ., 2012

Киноны зохиолыг төрийн шагналт зохиолч Д.Батбаяр

Ерөнхий найруулагч Б.Цогтбаяр

Ерөнхий зураглаач З.Ганхуяг, Б.Зундуй

Ерөнхий зураач О.Нямдаваа

Хөгжмийн зохиолч Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин, хөгжмийн  
зохиолч Н.Жанцанноров

Богд хаан /жүжигчин Чоймболын Болд/-ы дүр их шинэлэг, энгийн /эзэн хаан,  
язгууртан гэхээсээ илүү/, зарим хэсэгт орж ирсэн дэгс хэтрүүллийг эс тооцвол  
харьцангуй залуу Богд хааны дүрийг бүтээжээ. Богдын багшийн дүрийг анх удаа  
дэлгэцийн урлагт харуулсан болно.



/жүжигчин Чоймболын Болд/

Дунгаа /Дондогдулам/ Батдоржийн Батсумъяа

**Монголын дүрслэх урлагт бүтээсэн Богд хааны хөрөг** Монгол зургийн нэрт зураач “марзан” хэмээх Балдуугийн Шарав /1869-1939/. “Бизьяа цорж лам”, “Балдан гачин”, “Ёндон Балданчоймбол”, “Богд хаан” түүхэн хөргүүд, “Нэгэн өдрийн амьдрал” буюу “Монголын нэг өдөр”, “Үрс гаргаж байгаа нь”, “Богдын ногоон ордны амьдрал”, “Зуны ордны амьдрал”, “Лхас хот”, “Жанжин Сүхбаатар”, “Хувьсгалын бүрээч” 1911-1913, 1923 онд “В.И.Ленин” зэрэг хөрөг тус тус туурвисан нь шинэ цагийн монголын дүрслэх урлагт үнэт өв болон хадгалагдаж үлдсэн билээ.



Монгол зургийн нэрт зураач  
“марзан” хэмээх Балдуугийн  
Шаравын зурсан VIII Богдын хөрөг

ҮДБЭЧ-ын уран бүтээлчид Ардын уран зохиолч, СГЗ П.Бадарч, Төрийн соёрхолт СГЗ Д.Төрбат нарын цомлоор “Оройн дээд” түүхэн дуулалт жүжгийг үзэгч түмэндээ хүргэсэн. Энэхүү бүтээлд 70 гаруй жилийн турш монголын түүхийг гуйвуулснаас болж бүдгэрсэн 1911 оны 12 сарын 29-нд болсон эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх үндэсний хөдөлгөөний үнэн түүхийг өгүүлжээ. Энэхүү түүхэн дуулалт жүжгийн гол дүрүүд нь харийн түрэмгийлэгчдийн эрхэнд 200 гаруй жил зовж шаналж туйлдаа хүрсэн монголын ард түмэн, эрх чөлөөг эрхэмлэгч дэвшилтэт үзэлт ноёд тайж нар болон ҮШ Богд Жавзундамба гэгээн нар болох юм. Түүхэн дүрүүдэд Ардын жүжигчин, тус чуулгын дуучин Д.Самбуу, МУГЖ.Н.Амгалан, С.Эрдэнэцэцэг, Д.Ширмэнтуйа, МУСТА Д.Амаржаргал, Б.Батмэнд, Ц.Түмэнжаргал, Х.Энхбаатар нар дуулж, жүжиглэсэн болно.

Уг тайзны бүтээлд 200 гаруй уран бүтээлчид, жүжгийн найруулагч зураачаар Д.Ганболд, хөгжмийн зохиолчоор М.Бирваа, удирдаачаар Н.Буянбаатар, хормейстр Ц.Буян-Орших, бүжиг дэглээч Х.Хашхүү, О.Цэцгээ нар ажиллажээ.



### Summary

Agvaanluvsanchoyjinyamdanzanvanchigbalsamuu /1869-1924/,

Bogd Jebsundamba Khutuktu VIII, set his feet in the territory of Mongolia in 1874 when he was five.

Mongolian historical mazy time or the period of Mongolian national liberation revolution of 1911-1912 and Bogd Khaanate of Mongolia was the special stage in history. Historical figure Bogd Jebsundamba Khutuktu VIII, who played a significant role in the history of Mongolian Independence, has been described as a dark/sinister in the history, literature and art except over last ten years.

When Mongolia declared independence on the 29<sup>th</sup> of February in 1911, Bogd Jebsundamba was elevated to theocratic ruler and given a state seal, national flag and tribute. Moreover, the year was titled “Elevated by all” and historical statement to establish the government with five ministries was made.

In Mongolian literature, writer B.Rinchen described Bogd Jebsundamba Khutuktu VIII from one side in his historical trilogy “Uriin tuya” (Dawn break). The character of Bogd Khan, the king of Mongolia, an resolute protagonist for Independent Mongolian liberty, initiator and leader of Mongolian people’s revolution of 1921 and Mongolian eminent statesman, was studied and created realistically in the novel “Tsagaagchin gakhai jil” by D.Tsendjav which tells the historical truth, different from the character of Bogd Khan in the novels “Tungalag Tamir” /1961, /1962/ by Ch.Lodoidamba and “Ikh khuvi zaya” /1978/ by S.Udval.

In stage and screen arts such as, “Sukhbaatar”, “Ugluu”, “Temtsel”, “Tugsgul”, “Khatanbaatar”, “Garid Magnai”, “Turiin suld urshuu”, “Khaani sulechiin khatan”, “Doloon burkhan kharvadagui”, “Bogd Khan” and libretto or musical play “Oroin deed” /2014/ by D.Turbat /which hasn’t been played at stage yet/, actors from all generations created the character of Bogd VIII with different tempers.

Here, the achievement, rights and wrongs of the works by the writers and actors who created the character of the last throne Bogd Jebsundamba Khutuktu VIII in Mongolian literature and art are characterized.

### НОМ ЗҮЙ

1. О.Батсайхан., “Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба” /УБ.2008/
2. Н.Ганхуяг “Нүд” /УБ.2010/
3. Дурсамж, дурдатгалууд
4. Г.Жамсранжав “Роман урлах эрдэм” /УБ.1986/
5. “Монгол киноны нэвтэрхий толь”/УБ.2004/
6. Г.Навааннамжил “Өвгөн бичээчийн өгүүлэл” /УБ.1956/
7. Д.Намдаг “Шинэ Монголын шинэ театр” /УБ.1988/
8. Д.Цэдэв., “Шүлэг аялгууны шүтэлцээ” /УБ.2005/
9. Д.Цэнджав “Цагаагчин гахай жил” /УБ.2010, 2015/
10. Ferdinand Ossedowski. Beasts, Men end Gods. New York, E.R.Dutton Company, 1922, pp.145-154
11. Эх зохиолууд
12. Тайз, дэлгэцийн бүтээлүүд



## НАЙРУУЛГА БА АФОРИЗМЫН СЭТГЭЛГЭЭ

Ж.Бат-Ирээдүй  
/МУИС/

Найруулга зүй гэгч юу болох талаар олон талаас нь тайлбарлаж бичдэг. Найруулга зүйг түүхэн үүднээс авч үзвэл эхнээсээ зөвхөн уран зохиол болон илтгэх урлагтай холбож тайлбарлаж ирсэн байдаг. Тийм учраас илтгэх урлаг бол тухайн цаг үедээ маш хүчтэй хөгжиж байсан юм.

Найруулга зүй гэж юу болох талаар эрдэмтэн судлаач бүр янз бүрээр тодорхойлдог. Олон хүний бичсэн тодорхойлолт дундаас ажиглан үзвээс санаа бодлоо зөв, оновчтой, эмх цэгцтэй, уран яруу, энгийн ойлгомжтой, тодорхой илэрхийлэх арга бол найруулга бөгөөд үүнийг судлах нь найруулга зүй юм. Найруулга гэхээр ганц бичих буюу найруулах хэлний тухай бус дээр дурдсанчлан ярих буюу уран илтгэх тухай ч багтах нь мэдээж хэрэг билээ. Судлаач Г.Сүхбатын тодорхойлсоноор найруулга зүйг олон талаас нь авч үзвэл найруулга зүй гэдэг бол “нэгдүгээрт уран зохиолын яруу хэрэглүүрийг судлах ухаан, хоёрдугаарт, хэлний хэрэглүүрийг зөв зохистой хэрэглэх ухаан, гуравдугаарт, хэлний прагматик олон үүргээс хамааран хэлний хэрэглүүрийг харилцааны янз бүрийн хүрээнд ашиглах, хэрэглэх ухаан, дөрөвдүгээрт, хэлний хэрэглүүрийн хувилбарын тухай түүнээс зөв сонгох тухай ухаан”<sup>1</sup> гэсэн маш өргөн утгаар ойлгох ёстой юм. Өөрөөр хэлбэл найруулгыг зөвхөн зөв бичих тухай биш, найруулгын энгийн алдаануудын тухай биш утга зохиолын сэтгэлгээний маш өргөн талбарт авч үзэх ёстой өргөн ойлголт билээ.

Монголын нэрт зохиолч Дармын Батбаяр “Бүтээхүйн зүй тогтол, сайхныг бүтээх нууц” номдоо “Урлаг уран зохиол бол үлэмж сайхныг бүтээх үйл. Алив сайхан юмны хэрхэн, яагаад сайхан байгаа нь нууц байдаг. Энэ утгаараа зохиол бүтээл туурвина гэдэг бол нууцыг бүтээхүй юм. Уран зохиолыг бичих тусгай жор байдаггүй гэдэг. Нийтээр үүнийг баримталдаг. Ямарваа тодорхой уран бүтээлийг хэрхэн яаж бүтээх бэлэн жор байдаггүй нь үнэн ч, уран бүтээлийг бүтээдэг ерөнхий зүй тогтол байдаг гэдэгт бат итгэсэн учраас би энэхүү зүй тогтлын эрэлд гарч, эрсэнийхээ хүчинд тодорхой зүй тогтлыг олж, түүнээ тодорхой зүй тогтлоор байрлуулан бичсэн юм. ...”<sup>2</sup> хэмээн бичжээ. Тэгэхээр тэрхүү үлэмж сайхныг хэрхэн бүтээх тухай яриа нь бидний найруулгын сэтгэлгээ болон хэрхэн зөв оновчтой найруулах тухай өргөн асуудал байх болно. Хэдийгээр энэ нь зөвхөн бичгийн уран зохиолын хувьд ярьж байгаа ч өргөн олон түмэнд хамгийн их нөлөөлдөг

<sup>1</sup> Г.Сүхбат нар, (2007) “Найруулах эрдэм, хэл ярианы соёл 1”, 22 дах тал.

<sup>2</sup> Д.Батбаяр, (2007) “Бүтээхүйн зүй тогтол, сайхныг бүтээх нууц”Уб.,

найруулга бол сэтгэлгээний зөв утга учиртай, бичгийн буюу хэм хэмжээг сахисан зөв оновчтой найруулах асуудал юм.

Хэлний зөв оновчтой байх тухай асуудал бол найруулгын шаардлагын хүрээнд авч үздэг тодорхой асуудлуудын нэг юм. Проф. Ц.Сүхбаатар “Хэл ярианы ямарваа найруулга, тэр ч байтугай хүн бүрийн найруулга өөр өөрийн өвөрмөц онцлогтой. Гэхдээ найруулга зүйн нэгэн ерөнхий шаардлагыг заавал хангасан байх учиртай байдаг гээд хамгийн чухал шаардлагуудад “өгүүлж байгаа зүйл тодорхой байх, үг хэллэг оновчтой байх, үгийн баялаг арвин байх, нуршсан зүйлгүй товч байх, өөрийн гэсэн арга барилтай байх, уншигчдад нэгэн цэгц ойлголт өгөх, гоёж чамирхсан зүйлгүй энгийн байх, ойлгомжтой, сонирхолтой, яруу сонсголонтой, гоо зүйн хэм хэмжээн харгалзсан байх”<sup>3</sup> –ыг багтаасан байдаг. Харин энэхүү ончлох-ыг зөвхөн нэг найруулгын шаардлага болгоод орхих бие ерөөсөө аливаа урт богино найруулгад утгыг хэрхэн ончлох тухай сэтгэлгээний асуудал болгон үзэлтэй. Бид энэ хичээлд энэ тухай л авч үзэх юм.

Найруулгын хувьд зөв байх гэдэгт бид хэлний хэм хэмжээний тухай ойлголтыг авч үзэх ёстой байх. Зөв байна гэдэг нь тэр хэлний хэм хэмжээг чиг баримжаа болгож мөрдөж дагана гэсэн үг юм. Хэлний хэм хэмжээ гэдэг маань аливаа хэлний хувьд нийгэм хамт олноороо нэгэн мөр ерөнхий үлгэр загвар болгон баримталж байгаа хэлний тодорхой загвар билээ. Эрдэмтэд найруулгын тухай ярихдаа хэлний хэм хэмжээний тухай заавал дурддаг. Тухайлбал, проф. Ц.Сүхбаатар, “Найруулга зүй хүний бодол санаа, юм үзэгдлийг хэрхэн уран яруу товч тодорхой цэгцтэй чадамгай илэрхийлэх аргыг олон зорилгоор хэлэнд байгаа тэрхүү учир зорилгод нийцэхүйц арга хэрэглүүрийг задлан шинжилж, нягтлан тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, хэлний хэм хэмжээний хүрээнд хэрхэн зөв товч тодорхой ойлгомжтой хэлж ярьж бичиж туурвиж болохыг судалдаг гэсэн үг”<sup>4</sup> гэж бичсэн бол судлаач Б.Бямбадорж, “Хүний яриа болон бичгийн авиа, үсэг, дуудлага, бичлэг, үгийн утга, хэлбэр бүтэц, хувилал, өгүүлбэрийн утга санаа, бүтэц, дараалал, найруулгын төрөл зүйлийн онцлог аль ч талаараа алдаа дутагдалгүй байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл зөв дуудах зүй, үсэг зүй, хэл зүй буюу үг зүй, өгүүлбэр зүй, найруулга зүйн ухааны үүднээс зөв тэдгээрийн хэм хэмжээ, жам ёсонд нийцсэн байх шаардлага юм. Хүний яриа, бичиг, энэ бүх талаараа зөв байхгүй бол бид санаа бодлоо эмх цэгцтэй, учир утга төгс илэрхийлж бусдад нэвтрүүлэх аргагүй болно.”<sup>5</sup> хэмээн хэлний хэм хэмжээ гэдэг ойлголтыг хэл шинжлэлийн бүхий салбараас зөв тэгш хэрэглэхгүйгээр сайн найруулга болох боломжгүйг дурдан бичжээ.

Найруулгын оновчтой байх тухайд энэ бол зөвхөн гадаад үг хэллэгийн орчуулгын оновчтой байх тухай асуудал бус харин тухайн санааг илэрхийлэх арга маяг нь хэр оновчтой байх тухай ч багтах ёстой асуудал гэж үзэж болно. Монгол хэл судлаач зарим хүмүүс найруулгын оновчтой байхыг зөвхөн орчуулгатай холбож тайлбарласан нь учир дутагдалтай билээ. Оновчтой үг хэлэхийн тул утга санаа тодорхой болох учиртай. Францын нэрт яруу найрагч классизмын онолч Н.Буало нэгэн шүлэгтээ, “Утга санааг урдаар бод, тэгээд бич. Угаас хэлэх гэсэн юм

<sup>3</sup> Ц.Сүхбаатар, (2009) “Монгол хэлний найруулга зүй”, Уб.,42-43 дахь тал.

<sup>4</sup> Ц.Сүхбаатар, (2009) “Монгол хэлний найруулга зүй”, Уб.,

<sup>5</sup> Б.Бямбадорж, (2014) “Монгол хэлний найруулга зүй”, Уб., 38 дахь тал.

чинь тодорхой бус бол учир утгатай үг эрээд нэмэргүй ээ, ухаан бодолд утга санаа тунараад ирвэл уран яруу үг урсаад ирнэ ээ танд” хэмээн бичсэн нь сэтгэлгээнд утга санаа төвлөрөн үүсэхэд уран яруу үг аяндаа урсаж гарна гэдгийг хэлсэн хэрэг байна. Тийм учраас сэтгэхүй ямар байна хэл тийм байна гэсэн үг бөгөөд хэлний хэр ончтой байх нь сэтгэхүйгээс шалтгаалдаг. Гэвч монгол хүмүүс яг энүүхэн энд байна хэлж чадахгүй байна гэж их хэлдэг энэ нь үнэн чанартаа цаад сэтгэхүйдээ хангалттай төвлөрч боловсорч чадаагүй байгаа хэрэг юм.

Одоо онч буюу ончлох сэтгэлгээний тухай дэлгэрүүлэн үзье. Аливаа зүйлийг хүнд хүргэхийн тулд, хэлэхийн тулд үгээр илэрхийлж бичих юм уу ярих шаардлагатай болно. Асуудлыг хэдий чинээ уран яруу ончтой илэрхийлнэ төдий чинээ хүнд хүрнэ. Тийм учраас уран зохиолын төрөл бүрийн хэлбэрээс богино хэлбэрээр ончтой зөв илэрхийлэх нь ямар ч цаг үед чухал байсаар ирсэн одоо ч хэвээр байна. Ялангуяа монгол ардын аман зохиол ийм төрлөөр баян бөгөөд үүнийг нүүдэлчний сэтгэлгээний онцлог, ахуй байдал зэрэг олон зүйлтэй холбон тайлбарласан зүйл их байдаг билээ. Үүнд монгол ардын оньсого, монгол ардын зүйр цэцэн үг, өвөрмөц хэлц, хэвшмэл хэллэг, ардын дууны яруу найраг, мөр бадаг гээд бүгд багтах учиртай.

Монгол хэлний найруулгын уламжлалыг бид нэн эртний үеэс өвлөн уламжилж ирсэн. Эртний мэргэдээс авахуулаад өнөөдрийн бидний үед хүртэл найруулгад суралцах гурван чухал үндэс бол авьяас билиг, эрдэм мэдлэг, уйгагүй хөдөлмөр гэж үзсээр байна. Арван есдүгээр зууны Монгол утга зохиолын онолч Агваантүвдэн бээр “Зохист аялгууны толийн тогтоосон тэмдэглэл дурдлыг тодруулагч” номдоо “Үг утга хоёулаа яруу аялгуу сайхан төгсвөөс бал бурам мэт яруу сайхан амтаараа сэтгэлийг баясгана. Яруу найраг лугаа нөхөрлөх нь үзэсгэлэнт залуу хүүхэнтэй ханилсан идэр мэт зрхэнд баяртай, биед жаргалтай. Сэтгэлийн далайд эрдмийн лянхуаг дэлгэрүүлэхийг хүсэвч, яруу найргийн нарны гэрлээр эс тэтгэвээс мэргэдийн сэтгэл зохист гэсэн цэцэг хаанаас мишээх вэ” гэж бичжээ.

Монголчууд бол ончлон сэтгэдэг ард түмэн гэдэг нь ардын аман зохиол, зүйр цэцэн үг, ардын дуу хөгжмийн үг хэллэг, үлгэр домог, оньсого, туульс, хаад ноёдын зарлиг, захиа, даалгавар, элчийн үг хэллэг, дуун бариулах арга зэрэг олон зүйлээр батлагдах бөгөөд энэ бүхэнд хэлсэн, бичсэн, тэмдэглэсэн аман яруу найргийн жишээ баримтууд нь монголын эртний уран зохиол, түүх, соёл, бичгийн гайхамшигт өв болсон “Монголын нууц товчоон”, “Чингисийн билэг сургаал”, “Аргусан хуурчийн домог”, “Өнчин хүүгийн цэцэлсэн шашдир”, “Хоёр загалын тууж”, “Алтан ордны үйсэн дээрх бичээс”, “Оюун түлхүүр”, “Субашид”, “Ардыг тэжээхүй рашааны дусал”, “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу хэмээх сургаал”, “Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг”, “Тоть шувууны сургаал” зэрэг утга зохиолын бүтээлүүдэд уламжлагдан ирсэнийг бид мэднэ. Сургаалын шүлэг яруу найраг зохиол нь тэр чигээрээ цэцлэн ончилсон сэтгэлгээний баримт болох бөгөөд Дулдуйтын Равжаагийн “Бурхан ч сэтгэлээс гарна, буг ч сэтгэлээс бүтнэ, буян хилэнц сэтгэлээс булт хоосон сэтгэлд буй” гэх буюу Нагаржунайгийн “Ардыг тэжээхүй рашааны дусал” зохиолд буй “Учиргүй бусдын гэмийг өгүүлж бүү үйлд, урьд авсаар бусдын гэмийг хэлбэл удалгүй гэдрэг өөрөө хэлэгдэхүй болох нь ухамсаргүй эхнэр үнэгэнд

нь хэлэгдсэн мэт”<sup>6</sup> хэмээн цэцэлсэн нь бүгд аливаа зүйлийг өөрөөс бүү зайлуулж, өрөөл бүү чих, өрөөлийг бүү дайрч давшил, өөрийнхөө сайн мууг эхлээд бод гэсэн шиг утга санаа илэрхийлж байна гэж ойлгож болно. Ийнхүү монголын үе үеийн онч мэргэн сургаалтны үг хэллэгийг ажиглахуй З.Агваанбалдангийн “Бүхний суурь хэмээх тийн мэдэлд агуулагдсан хамгийг айлдагч мөнх авьяас боловсорсноос ертөнц тэргүүтэн хамаг юм буй болдог”, Инжинашийн “Нэгэн үзүүрт сэтгэлээр эцэст хүрнэ”, “Хэлсэн бүхэн худал, хийсэн бүхэн үнэн”, “Мянган оны учир шалтгааныг бийр бэхсээс асууж, мяралзан эрээлжлэх үйл явдлыг судар бичиг лүгээ хэлэлцмүй.” зэрэг онч үгсийг хэлсэн нь хүний амьдралын утга учир, сэтгэхүй, түүх намтраа мэдэж танихын утга учрыг таниулан сургасан аястай байна. Энд жишээ болгон Ванчинбалын Инжиннашийн "Нойр гэгч биеийг тэжээх бөгөөтөл унтаж хэтэрвэл өвчин болно. Жаргал гэгч хүний эрэлт бөгөөтөл жаргал хэтэрвэл зовлон ирнэ." хэмээх онч (мэргэн) үгийн утгыг задлан тайлбарласан байдлыг авч үзье. Энэхүү онч үг нь өгүүлбэр зүйн хувьд тус бүр ижил бүтэц, байгууламжтай холимог нийлмэл бүтэцтэй хэлц өгүүлбэр бөгөөд утгын хувьд авч үзвэл нойр бол хүний алдагдсан эрчим хүчийг нөхдөг, биеийн алжаал ядаргааг тайлж эрүүл байхыг зохицуулж байдаг биологийн амин чухал зүйл бөгөөд нойр хэтэрвэл бүр өвчин болдог гэсэн үнэнийг ард түмэн амьдралынхаа ажиглалт, туршлагаар шалгаж нотолсон үнэн билээ. Их нойртой хүн л их залхуу байдаг, нойрыг унтаж бардаггүй, сэрж бардаг гэсэн ардын мэргэн үг бий.

Орчин үеийн утга зохиол, соёл иргэншлийн түүчээ болсон нэртэй эрдэмтэд, уран бүтээлчид Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Д.Нацагдорж, Ш.Лувсанвандан нарын зэрэг хүмүүсийн хэлсэн үг цагийн шалгуурыг даван онч үг буюу афоризм болж нийгэмд “мөнхрөн үлдэх” нь их байдаг. Тэд хүний ажил амьдралын тухай, амьдралын мөнх бусын тухай, цаг хугацааны тухай, хайр сэтгэлийн тухай, найз нөхөрлөлийн тухай, шударга ёсны тухай, эрх чөлөө эв нэгдлийн тухай бичсэн нь түүхийн явцад гайхамшигтэй сайхан онч мэргэн үг болон хувирсан байдаг. Тухайлбал, Ц.Дамдинсүрэнгийн “Номын утга тэнгэр мэт агуу, дэлхий мэт өргөн, далай мэт гүн юм. Номыг унших нь тэнгэрт нисэж, дэлхийг тойрч, далайд шумбах мэт.”, Д.Нацагдоржийн “Эрүүл явбал улсын наадам үзнэ.”, “Өсөхөөс сурсан үндэсний хэл, мартаж болшгүй соёл”, Б.Ринчений “Аяа, мунхагуудын дунд суухад нас даан ч урт, аяа мундашгүй эрдэм сурахад нас даан ч богино.”, Ч.Лодойдамбын “Сайхан хайр байдаг юм шүү олдвол алдаж л болохгүй.” гэх зэрэг онч үгс буюу афоризм байдгийг мэдэхгүй хүн бараг үгүй.

Гэтэл хүн өөрөө тэр бүр өөрийгөө анзаардаггүй болохоос биш афоризм хэлье гэж бодоогүй байхдаа үгийн хачирт афоризм хэлж л байдаг байна. Бүр сэтгэлгээний дасгал болгон зориуд зохиож хэлэх хүмүүс ялангуяа зохиолч, сэтгүүлч, улс төрч, нийгмийн зүтгэлтэн нарын дунд их байдаг. Афоризм гэдэг бол хүний бүтээлч сэтгэлгээ, амьдралын туршлага, эрдэм боловсрол зэрэг олон зүйлээс үүдэн бий болж байдаг “нийгэмд үлдэж тогтох чанартай, нийгмийн гишүүдэд хандсан үг хэллэг” юм. Өнөөдөр жишээлбэл Монголын нийгэмд зориуд афоризм буюу онч үг дагнан бичдэг зохиолч, яруу найрагч, нийгэм улс төрийн зүтгэлтэн олон бий. Тухайлбал, улс төрч Ц.Элбэгдорж, Н.Энхбаяр, зохиолч Д.Батбаяр, Л.Дашням,

<sup>6</sup> Л.Хүрэлбаатар, “Огторгуйн цагаан гарди”, Уб., 1996, 102 дах тал.

Д.Урианхай, До.Цэнджав, Б.Лхагвасүрэн, Ү.Хүрэлбаатар, нийтлэлч Б.Баабар, их эмч М.Шагдарсүрэн, Д.Өлзийбат зэрэг хэлсэн үг болгон нь бараг онч үг болж хувирч байдаг ийм бодгаль хүмүүс манай нийгэмд олон байна. Сүүлийн үед онч үгс буюу афоризмаар дагнасан болон дайвар бүтээлүүд ч хэвлүүлсээр байна. Тухайлбал, Н.Өлзийбатын “Оногдохуйн тавилан” (2006), Л.Дашнямын “Бор дэвтэр” (2005), Б.Лхагвасүрэнгийн зохиолын түүврүүд, Д.Урианхайн түүвэр, Ү.Хүрэлбаатарын “Чөдөр гурвалжин, Тархины фитнес, Гандирсан”, (2015) До.Цэнджавын “Мянган цэн үг” (2010), “Асар тэнгэрийн дор”, Б.Лхагвасүрэнгийн “Ангир уураг” (1991), Ж.Бат-Ирээдүйн “Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, түүний үг сэтгэлгээний ертөнц” (2011), Ж.Бат-Ирээдүйн “Ирээдүйн ертөнц” (2010), “Цахиагийн Элбэгдоржийн онч үгс 1”(2012) зэрэг бүтээлүүдийг энд жишээлж болно. Эдгээр номууд болон бусад эх сурвалжаас авсан онч үгийн сэтгэлгээг ажиглан үзээд монгол онч үгийн сэтгэлгээний талаар судалгаа хийх, түүний утга уянга, найруулах ур маяг, сэтгэлгээ зэрэг олон талаас нь тусгайлан судлан шинжлэх цаг нэгэнт болсныг бас дурдалтай. Мөн нийгэмд нэр төр нь алдаршсан хүмүүсээс эхлээд энгийн хүмүүсийн онч үгсийг түүвэрлэн афоризмоор дагнасан бүтээл гаргасан туршлага ч байна. Тухайлбал Д.Боролзой, Д.Анхбаяр нарын эмхэтгэсэн “Энгийнээс энгүй хүмүүсийн үнэн үгс” номыг энд дурдаж болох бөгөөд эл номд Платоны “Огт юу ч мэдэхгүй байна гэдэг тийм ч айхтар хортой зүйл биш, харин дутуу дулимаг эзэмшсэн мэдлэг л түүнээс аюултай”, Парис Хилтоны “Өөрийнхөө хүссэн чиг хандлагаараа л хувцасла. Амьдрал дэндүү богинохон. Бидэнд бусдаас ичиж эмээх цаг зав ч олдохгүй шүү”, Дашийн Мундаа “Хамгийн зөв зам бол гэртээ харих зам”, Б.Тунгалагийн “Хэчнээн ядуу хүнд ч савангийн мөнгө олддог л байхгүй юу” гэх зэрэг энгүйгээс энгийн хүмүүсийн ... хий хоосон цэцэрхэл биш, цэцэн мэргэн үгийн цуглуулга бүр ч биш”<sup>7</sup> харин ард түмний дунд афоризм болсон олон үгс эл номд орсон байна.

Өнөөгийн орчин үеийн онч сэтгэлгээ буюу афоризмын талаар зарим судлаачдын байр суурийг товчхон авч үзье.Тухайлбал орчин цагийн онч үг хэллэгийн тухай Төрийн соёрхолт, судлаач Цэвэлийн Шагдарсүрэн бээр, “... тийм үгийн олон түмнийг дагуулан ам дамжих хүч нь тухайн “зохиогчийн” ухааны цар, хэл найруулгын торгон мэдрэмжтэй нь шууд холбоотой байх тул санасан бүхэн түүний зохиогч болж чаддаггүй байна. ...Европ дахинаа афоризм буюу quotation хэмээх оносон үг хэллэг гэдэг бол хоёр чухагийн нэгдэл. Нэгэн талаас, утга санааны хувьд ертөнцийн нийлэг үнэн мөн хийгээд учир холбогдлын төгс төгөлдөр илэрхийлэл, нөгөө талаас хэл найруулгын хувьд илүү дутуугүй, товч тодорхой туйл, өөрөөр хэлбэл утга санаа хийгээд хэл найруулга төгс төгөлдөр байхын аль нэг нь дутагдах бөгөөс түмний санаанд хүрч сэтгэлд хоногшин, ам дамжина гэж үгүй. Хэн бүхний хэлсэн бүхэн “ёстой” оносон үг хэллэг болж чаддаггүй, тэгээд цөөн байдгийн цаад учир тэр.”<sup>8</sup> хэмээн бичжээ.

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, эрдэмтэн, зохиолч Долгорын Цэнджавын “Мянган цэн үг” номын удиртгалд профессор Ж.Баянсан бичихдээ, “До.

<sup>7</sup> Д.Боролзой, Д.Анхбаяр, “Энгийнээс энгүй хүмүүсийн үнэн үгс”, Уб., 2012, 4-5 дах тал.

<sup>8</sup> Ц.Шагдарсүрэн, “Мянган цэн үг” хэмээх номд оршил бичихийн учир”, До.Цэнджав, (2010) “Мянган цэн үг”, Уб., 8 дах тал

Цэнджавын энэ “цэн үг” гэдэг нь монгол ардын зүйр цэцэн үг, өвөрмөц хэллэг зэрэг хэлж сэтгэх дээд эрэмбийн хийсвэрлэлийн үлгэр жишээг боловсролоо болгосон уран зохиолчийн туурвил зүйн сэтгэлгээнийх нь нэгэн өвөрмөц илэрхийлэл мөн гэж хэлж болно.” хэмээн тэмдэглэсэн байдаг юм. Энэ бол юу гэсэн үг вэ гэмээн түүний нэрлэж буй цэн үг буюу афоризм бол “хүний сэтгэлгээний хийсвэрлэлийн хамгийн дээж буюу дээд зэргийн сэтгэлгээний үр дүн” гэж хэлж байгаатай агаар нэгэн хэмээн ойлгож байна. Профессор Ж.Баянсан энэ номд цааш нь хэлний авалцуулан холбох сэтгэхүй буюу хэлээр үүтгэн цогцлоох сэтгэхүй-н тухай үзэл баримтлалыг зохиолч До.Цэнджавын хэлсэн цэн үгийг түшиглэн гадаадын нэртэй сэтгэгч нарийн хэлсэн онч үгээр авалцуулан тайлбарласан байдаг юм. Жишээ нь тэрбээр бичихдээ, “Аливаа хэлний метафор, өвөрмөц хэллэг, зүйр цэцэн үг зэрэг тогтвортой хэллэгийн зүйлс нь цөм энэхүү “хэлээр үүтгэн цогцлоох” сэтгэхүйн үйл ажиллагааны үр дүн болдог. Сэтгэхүйн энэ хэлбэрийг До.Цэнджавын энэ бүтээлээс тодорхой ажиглаж болохоор байна. Жишээлбэл “Холын бурхан тус хүргэж дийлэхгүй үед, ойрын чөтгөр дэм болно.” гэсэн нь монгол ардын “Хүний газрын бурхнаас өөрийн газрын чөтгөр дээр” гэх буюу “харийн өдрөөс халууны шөнө дээр” гэдэг уламжлалт хэллэгтэй утга санаагаараа дүйх хэллэг байна. Эдгээрийг хооронд нь харьцуулбал холын, хүний хоёр, ойрын өөрийн хоёр тус тус эсрэгцсэн нь сонин байна. Монгол сэтгэлгээний үүднээс Би, Бусад хоёр, (харин би өөрөө гарцаагүй Хүн мөртлөө) Хүний юм, Миний юм хоёрыг тус тус эсрэгцүүлэн ухаардаг нь сонирхолтой билээ. Чингээд өдөр, шөнө хоёр эсрэгцэхдээ өдөр нь эерэг үнэлэмжийн утга тээж, шөнө нь далддаа сөрөг үнэлэмжийн утга агуулдаг учраас харь л бол “сайн”, “гэгээн” өдөр ч гэсэн халууны “муу”, “харанхуй” шөнөөс доор гэсэн үнэлэмжтэй байдаг нь монгол сэтгэлгээний тогтвортой хэв шинжийн нэг юм. Тэгвэл саях ишилсэн цэцэн үгээс зохиолчийн “авалцуулан холбох сэтгэхүйн” онцлог мэдрэгдэж байх шиг байна. Зохиолч, өөр нэг газар “Хамгийн аюултай өвчин бол “Би” гэснийг дээрх тэмдэглэгээний агуулгатай холбон үзэж бас болно. Ер нь ижилдүү агуулгатай өгүүлэмж, төстэй уран дүрслэл уран зохиолд ч, эрдэм шинжилгээний бүтээлд ч дайралдаж л байдаг “бүтээлчээр суралцахуй” хэмээн тайлбарлаад өнгөрдөг нь танин мэдэхүйн хувьсал хөгжилт, уламжлал шинэчлэлийн үүднээс сонирхууштай ч, нягтлууштай ч зүйл байж болох. Тухайлбал, “Кихот ноён”-г зохиосон Мигэль Дэ Сэрвантес “хана туурга ч нүдтэй байдаг” гэсэн цэцэн үгээ монгол ардын “бут буландаа нүдтэй, уул оройдоо нүдтэй” гэдгээс бүтээлчээр суралцсан гэх юм уу, “Талд туссан өглөөний нар, харгана бутадын оройн завсраар үзэсгэлэнт бүсгүйн мөөм шиг булхалзана” гэсэн шиг дүрслэл, “говьд туссан өглөөний нар, хэвтээ тэмээдийн бөхөн дунд хэлгий уураг шиг цэлцэгнэнэ” гэсэн дүрслэл хоёрыг хоёр зохиолчийн нэг бүтээл гэж хэлэх зүрхтэй хүн гарахгүй гэдэгт үл эргэлзэнэ. Тэгвэл В.Шекспирийн “Эргэлзэл бол урвагч мөн” гэсэн цэцэн үгийг яруу илэрхийлэх, сэтгэл оргиох чадамжаар нь До.Цэнджавын “хязгааргүй эрх мэдэл эрх чөлөөн дээр гишгэсэн хөлийн сүүдэр мөн”, “Аз сохор тул хэн рүү очихоо ер мэддэггүй.”, “урт наслах сайхан ч, ухаан урт наслах л улам сайхан”, “замдаа төөрсөн нь биш, зам заасан нь бурууддаг” гэсэн цэцэн хэллэгүүдтэй харьцуулж



үзвэл тун сонин байна.”<sup>9</sup> гэжээ.

Афоризмын бас нэг онцлог бол үнэнийг ил шууд эсвэл егөө ёж утгаар өгүүлэх чадвар юм. Өөрөөр хэлбэл уран зохиолын төрөл дундаас афоризм бол үнэнийг танин мэдүүлэх хамгийн төд зам мөн гэж хэлэлтэй. Гэвч үнэн гэж юу вэ гэсэн асуулттай холбоотой учраас үүнийг философийн талаас нь авч үзвэл харьцангуй ойлголт юм. Энэ тухай Д.Батбаяр, “Урлаг уран зохиолоос бусад танин мэдэхүйн бүх төрлүүд үнэнийг шууд үгүүлдэг. Энэ нь үнэнийг шууд мэдээд авчих сайн талтай ч үнэнийг эрэхэд оролцох хувь хүний оролцоо хязгаарлагдмал байдаг. Дамаан үнэнийг олохоосоо эрэх нь эрхэм байдаг амьдралд урлаг, уран зохиол шиг чухал нь үгүй. Үнэнийг эрэх нь үнэнийг ойлгох хамгийн дөт зам. Энэ дөт замд уншигч үзэгчийг хүргэхийн тулд урлаг уран зохиол худлыг өгүүлдэг. Худал хэлэх нь уран зохиолын үндсэн арга. Үндсэн арга учраас энэ хэрэглэглэдэггүй, хэрэглэхийг эрхэмлэдэггүй, зайлшгүй хэрэглэх ёстой хэмээх зарчим баримталдаггүй зохиолч уран бүтээл ховор. Жинхэнэ урлаг, уран зохиол чухамхүү үүн дээр л суурилсан байдаг”<sup>10</sup> гэжээ. Ийнхүү үнэнийг урнаар илэрхийлэхийн нэг төрөл нь афоризм буюу онч сэтгэлгээ бөгөөд хэдий чинээ богино байх тусмаа энэхүү утга санааг гаргах ур маяг нь улам нарийн байдаг байна. Тухайлбал, Дарамын Батбаяр гуайн өөрийнх нь зохиосон зарим онч үгсийг авч үзвэл, “Амьдрал гэгч жингийн цуваа. Хэтэрхий хурдан явбал урдхынхаа өсгий дээр гишгэж хилэнг нь хөдөлгөнө, хэтэрхий удаан явбал арын чинь хүн өсгий дээр чинь гишгэж чиний хилэнг хөдөлгөнө.”, “Зайлшгүй ирэхэд бурхан ч чөтгөрийн талд ордог.”, “Ертөнцийн төгс төгөлдөр нь гагцхүү дутуу юмгүй, илүү юмгүй байдаг л оршино.”, “Миний зовлон бусдын зовлонгоос илүү гэж боддогт зовлонгийн хүнд нь оршино.”, “Жигүүр хайх хэрэггүй. Гагцхүү оргилын зүг эцэж цуцахыг умартан авирах хэрэгтэй. Оргилд дөхөх тусам өөртөө жигүүр буйг мэдрэх болно.”,

<sup>9</sup> Ж.Баянсан, “Мянган цэн буюу арван лан үгийн учиг”, До.Цэнджав, “Мянган цэн үг” Уб., 2010, 13-14 дэх тал.

<sup>10</sup> Д.Батбаяр, (2007) “Бүтээхүйн зүй тогтол, сайхныг бүтээх нууц”, 13-14 дэх тал

## НОМЗҮЙ

### Судалгааны бүтээлүүд:

1. Д.Отгонсүрэн, (1975) “Монгол хэлний найруулга зүй” Уб.,
2. Ц.Сүхбаатар, (1998) “Монгол хэлний найруулга зүй”, Уб.,
3. Д.Отгонсүрэн, (1998) “Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй”, Уб.,
4. Ц.Сүхбаатар, (2003) “Монгол хэлний найруулга зүйн нэр томъёоны тайлбар толь”, Уб.,
5. М.Базаррагчаа, (2005) “Монгол хэлний өгүүлбэр судлал, Уб.,
6. Ц.Сүхбаатар, П.Увш, (2004) “Илтгэх урлаг суралцах бичиг”, Уб.,
7. Ц.Сүхбаатар, (2006) “Найруулга зүйн судалбар”, Уб.,
8. Г.Сүхбат нар, (2007) “Найруулах эрдэм хэл ярианы соёл”, Уб.,
9. Ч.Чимэгбаатар, (2011) “Монгол хэлний яруу найруулга 1 Б.Ринчен”, Уб.,
10. Г.Буянтогтох, (2012) “Монгол хэлний чөлөөт найруулга судлалын удиртгал”, Уб.,
11. “Найруулга зүйн тухай ойлголт”, (2012) “Орчин цагийн монгол хэл”, хамтын, МУБИС-ийн МСС-ийн МХШТэнхим, Уб.,
12. Ц.Дашдондов, (2014) “Үзгэн шилбүүр барьж үгийг сүрэг гилж, утгын таяг тулж туулсан он жилүүдийн ойллого”, Уб.,
13. Б.Бямбадорж, (2014) “Монгол хэлний найруулга зүй”, Уб.,
14. “Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичиг”, (2014), хамтын, Уб.,
15. Ж.Бат-Ирээдүй, “Монгол хэлбичиг: утга, соёл, хэрэглээ” (2013), Уб.,

### Уран зохиолын бүтээлүүд:

1. Д.Батбаяр, “Саахалтын нууранд ангир дуугарна.” Уб., 1990
2. Б.Лхагвасүрэн, “Ангир уураг”, Уб., 1991
3. Н.Өлзийбат, “Оногдохуйн тавилан”, Уб., 2006
4. Л.Дашням, “Оонтий-Моонтий миний мөнхий тоолол”, Уб., 2007
5. Л.Дашням, “Бор дэвтэр”, Уб., 2008
6. Ж.Бат-Ирээдүй, “Ирээдүйн ертөнц”, Уб., 2009
7. До.Цэнджав, “Мянган цэн үг”, Уб., 2010
8. Д.Боролзой, Д.Анхбаяр, “Энгийнээс энгүй хүмүүсийн үнэн үгс” Уб., 2012
9. Д.Урианхай, “Түүвэр зохиолууд”, УЗСТӨв, Уб., 2013
10. До.Цэнджав, “Асар тэнгэрийн дор: 500 рубай буюу дөрөвтүүд”, Уб.,
11. “Цахиагийн Элбэгдоржийн онч үг 1”, Уб., 2013
12. “Эртний сургаалын зохиолууд”, Болор судар Хэвлэлийн Газар, Уб., 2015

**XX ЗУУНЫ МОНГОЛЫН ЯРУУ НАЙРАГ ДАХЬ**  
**УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ**  
(Яруу найрагч Д.Нацагдоржийн уран бүтээлийн жишээгээр)

Р.Бигэрмаа  
/МУИС/

Аливаа улс үндэстний утга зохиолын хөгжлийн төрх төлөв нь тухайн улс орныхоо түүх, нийгэм, соёлын хөгжил, дэвшилтэй салшгүй холбоотой байдаг. Монголын бичгийн уран зохиол, түүний дотроос хамгийн гүн уламжлалтай, өргөн дэлгэрсэн төрөл бол яруу найраг юм.

Яруу найраг нь тухайн үндэстний ард түмний оюун сэтгэлгээний хэр хэмжээ, зүрх сэтгэлийн дотоод ертөнц, түүний анир чимээ хийгээд хөг аялгуу, соёл урлагийн өвөрмөц тансаг чуулбар байдаг. Иймд монголын яруу найргийн хөгжлийн зүй тогтлыг илрүүлэхийн тулд тодорхой манлайлагч найрагчдын уран бүтээлийг харьцуулан судлах нь тохиромжтой юм.

Яруу найргийн хөгжлийн тодорхой үе бүхэн өөрийн өвөрмөц өнгө аястай тэргүүлэх найрагчдыг төрүүлэн, бичлэг сэтгэлгээний өвөрмөц шинэчлэл хийж, хэвшиж тогтсон хуучин хэв загварыг эвдэн, цаг үеийн шаардлагаар хувьсан шинэчлэгдэж байдаг жамтай. Тэрхүү шинэтгэлийг дараа дараагийн авьяас билэгт яруу найрагчид өөрийн дуу хоолой, өвөрмөц содон нээлт, тансаг дээд дүрслэлээр баяжуулан шинэчилж, шүлэглэх барил хийгээд тэнд бий болсон тогтонгишлыг эвдэн өөрчилж, дараагийн шинэ үеийг дэвшүүлэн гаргаж ирдэг зүй тогтолтой. Яруу найрагчид өөрийн цаг үед нийцтэй шинэ арга барил, шинэ дүрслэл, сэтгэлгээ, урлал зүйн хэв маягуудыг бий болгон тогтоохдоо өмнөх үеийн гарамгай яруу найрагч, зохиолчдын туршлагаас суралцахын сацуу түүнд дөрөөлөн, өөрийн гэсэн өвөрмөц содон сэтгэлгээ, урлахуй арга барилаа бусдаас ялгарахаар гаргаж ирэх, өөрийн шүлэглэх арга барилыг нийтэд хүлээн зөвшөөрүүлэх, өөрийн аяс хандлага, дэг барилыг шүтэн биширч дагасан залгамжлагчдыг төрүүлж нэгэн үеийг үүсгэж байдаг. Харин тэрхүү урлал зүйн шинэчлэлийг үргэлжлүүлэн хөгжүүлж баяжуулагч тухайн цаг үеийн уран бүтээлчид болон түүний дараа дараа үеийн найрагчдын туурвил зүйн үндэс суурь болсон өмнө үеийнхний туршлагыг “уламжлал” гэнэ.

Уламжлал шинэчлэл хоёр нь нягт уялдаа холбоотой, салшгүй нэгдэл бүхий ойлголт бөгөөд энэ уламжлалт бат бэх холбоогүйгээр яруу найрагт уран сайхны нээлт, шинэчлэл хийх, цаашдын хөгжлийн тухай ярих бололцоогүй билээ.

Өөрөөр хэлбэл, өмнөх үеийн дэвшилтэт зохиолчдоос дараа үеийн дэвшилтэт зохиолчдын ялгарч буй гол ялгаа, нэг нь нөгөөгөөс ялгарч буй гол ялгаа нь шинэчлэл болж буй юм.

Хөгжлийн урт хугацааны туршид нийгэм, түүхийн хөгжлийн тодорхой үе шатанд, өөрийн цаг үеийг манлайлан хошуучлагч уран бүтээлчид төрж өөрийн үеийн зохиолч, яруу найрагчдаас бичлэг, сэтгэлгээ, урлах арга маягаараа илт ялгаран, уран зохиол, яруу найргийн хөгжилд бие даасан шинэ үзэгдэл болохын хамт аяндаа тухайн зохиолчийн дэг сургууль бүрэлдэж, утга зохиолын түүхэнд үнэтэй хувь нэмэр оруулах үзэгдэл алив үндэстний утга зохиолд байдаг.

Энэ утгаар нь энэхүү илтгэлд бид ХХ зууны эхэн үеийн уран зохиолын нэрт төлөөлөгч Д.Нацагдоржийн уран бүтээлийн уламжлал, шинэчлэлийн холбоог зарим жишээгээр харуулахыг зорилоо.

Монголын уламжлалт яруу найраг нь монголын ард түмний ахуй амьдрал, аж төрөл, байгаль, сэтгэлийн ертөнцөөс үүсгэл сурвалжтай тул голдуу сургаал, гүн ухаан, сэтгэлийн аяс хандлага шингэмэл юм. Эртнээс инагш дорно дахины уламжлалт туурвил зүйн хүрээнд өөрийн онцлогтой хөгжиж, харин ХХ зууны эхээр өрнийн уран зохиолын онол, туурвил зүйг түлхүү ашиглах болсон нь нийгэм, улс төрийн амьдралтай холбоотой байв.

Монгол уран зохиол, ялангуяа яруу найраг өөрийн тогтсон таалал, хэв маяг, уран сайхны найруулга, тухайн цаг үеийнхээ гоо сайхны сэтгэлгээний онцлогийг хадгалсан уламжлалт сонгодог бичгийн хэлээ хадгалан хөгжиж иржээ. Тухайлбал: “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Хоёр загалын тууж”, “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шашдир”, “Дуутын хадны шүлэг” зэрэг дурсгалт бичгээс эхлэн, ХIХ зууны хуульч Сандаг нарын “Үг”, Агваанхайдав нарын “Яриа”, Б.Гэлэгбалсан нарын ерөөл, Инжинаш, Гулиранс болон бусад иргэний, шашин, гүн ухааны томоохон мэргэдийн олон тооны зохиолоор нотлогддог билээ.

ХХ зууны 20-иод оноос хойших монгол уран зохиол нь бичгийн сонгодог уран зохиолын уламжлал гэхээс илүү ардын аман зохиолын уламжлалд илүү суурилсан, шинэ залуу уран зохиолчдын бичгийн уран зохиолын шинэ хэлбэршил, хувьсгалт үзэл санаа, агуулга бүхий бичгийн уран зохиол руу богино богино хугацаанд шилжсэн нь анхаарал татдаг.

Түүний дотроос Д.Нацагдоржийн уран бүтээлийн ур хийц, зохиолын хэлбэр, бичлэг, сэтгэлгээний хэв маяг онцгой ялгардаг, цоо шинэ үзэгдэл байв. Тэрээр 1906 онд Төв аймгийн Баяндэлгэр сумын Мэлзэй хэмээх газар хохь тайжийн гэрт төрөөд, Монголын орчин үеийн уран уран зохиолыг үндэслэгч, яруу найрагч, үргэлжилсэн үг, жүжгийн нэрт зохиолч, орчуулагч, соён гэгээрүүлэгч, түүхч, нийгэм улс төрийн нэрт зүтгэлтэн (1906-1937) болж төлөвшжээ.


### **Д.Нацагдоржийн яруу найраг дахь онч үгс нь ур чадварын нэг илэрхийлэл мөн**

Хувь хүмүүсээс амьдралыг үзэх үзэл, түүнд хандах хандлага, хүн болон байгаль, нийгмийн мөнхийн холбоо, түүний жам ёсыг гүн ухааны үүднээс уран сайхны аргаар нээн илэрхийлсэн, хүмүүсийн өдөр тутмын амьдрал ахуйд түгээмэл тохиолддог үзэгдлийг гүн ухааны үүднээс тунгааж илэрхийлсэн хоёр ба түүнээс дээш холбоо үг, өгүүлбэр, хэлц хэллэгийн түвшинд илэрхийлсэн гүн утга, уран санаа, өргөн агуулга бүхий хураангуй цогц уран хэллэгийг онч үг (aphorism) гэнэ.

Монголчуудын үгийн урлагт эртнээс боловсорсон уран сайхны сэтгэлгээний

дээд хэлбэрийн нэг онч мэргэн үгийн сан нь аман ба бичгийн уран зохиолын хоёр гол эх сурвалжаар тэтгэгдэн баяжиж, хөгжсөөр иржээ. Ардын аман зохиолд онч мэргэн үгсийн бие даасан “мэргэн үг”, “цэцэн үг”, “зүйр үг” зэрэг хэлцийн баялаг сан бий. Монгол хүний гүн ухаан, уран санаа, сэтгэхүйн онцлогийг гүн гүнзгий илэрхийлсэн, монгол ахуй, амьдралын гүнээс эхтэй учраас нийтэд ойлгомжтой, амьдралын жам ёсонг гүн гүнзгий танин мэдэхэд зохицсон, түүнийхээ хэрээр үндэсний оюун санааг баяжуулдаг уран сайхан, гүн ухааны үлэмж ач холбогдолтой жанр юм. Үе үеийн бичгийн мэргэд, зохиолч, яруу найрагчид тэрхүү урын санг өөрсдийн туурвисан зохиол бүтээлээрээ цаг ямагт баяжуулан арвижуулсаар иржээ.

**Д.Нацагдорж шүлэгтээ өөрийн сэтгэлгээний цар хүрээг илтгэсэн, жинхэнэ монгол ёс заншил, соёл суртахуун, гүн ухаан, ард нийтийн амьдрал, аж төрөхүйн онцлогийг онч үгийн тусламжтай гайхамшигтайгаар нээж үлдээсэн нь шүлэг зохиолыг нь баялаг сайхан, гүн гүнзгий утга агуулгатай болгож, өнө мөнхийн настай болгох үндэс нь болжээ.** Иймээс энэ хэсэгт түүний уран сайхны үүрэг, ач холбогдлыг тодруулахыг хичээсэн билээ. Д.Нацагдоржийн яруу найрагдахь онч (мэргэн) үгсийг үндсэн 3 хэв шинжид хувааж үзэв. Үүнд:



Дээрх ангиллын дагуу зарим жишээг үзье.

1. Монгол ардын зүйр цэцэн үгийг өөрийн уран бүтээлийн шаардлагатай хэсгүүдэд зохистойгоор ашигласан баримт нь:

“Дугар хөвгүүн юм үзэж, нүд тайлав” (“Берлин явсан замын тэмдэглэл”, 1926., Бүрэн зохиол 1., 55 тал)

“Ааль үгүйгээс хамаргүй” (“Ааль үгүйгээс хамаргүй”, 1931., Бүрэн зохиол 1., 80 тал)

“Эртний үг буй гэлээ, “Өр үгүй бол баян

Өвчин үгүй бол жаргал” гэж үнэн биш үү” (“Эрүүл”, 1935., Бүрэн зохиол 1., 147 тал)

“Эр хүний жаргал эзгүй хээр” гэж гайгүй юу (“Би биш” жүжиг, Бүрэн зохиол 1., 48 тал)

“Асман ламаас ахисан чавганц”, “Бор гэртээ богд, хар гэртээ хаан”, “Бурхан үгүй газар бумба галзуурна” (“Их авгай” жүжиг, Бүрэн зохиол 2., 105 тал)

**2. Зохиолчид өөрсдийн билиг, уран сэтгэмжээр болон ардын зүйр цэцэн үгийн хэлбэр, бүтээх арга маяг, загварыг ашиглан зохиолын агуулга, уран сайхныг тэтгэх зорилгоор онч үгийг шинээр найруулах, тухайн зохиолынхоо хэрэг явдалд нийцүүлэн онч үг шууд хэрэглэх, улмаар хувилбар, хувиргалтын аргыг хэрэглэх, эсвэл зохион найруулж зохиол бүтээлийнхээ ур зүйд өргөн хэрэглэдэг нь зохиолын агуулга, уран сайхныг тэтгэдэг.** Тухайлбал, Д.Нацагдорж өөрийн зохиолдоо:

“Хээрээр гэр хийх, хэцээр дэр хийх” (хэсүүл, босуул амьдралаар явах) гэдэг хэвшмэл хэлцийг “Соёлыг гайхав” өгүүллэгийнхээ хэрэг явдал, утга санаанд зохилдуулан, Лувсангийн дүрийг тодорхойлохдоо “Лувсан хэдийгээр өсөх наснаас **үхэр тэргээр нөхөр хийж, эзгүй талаар гэр болгож...**” хэмээсэн нь нэг хувилбар үүсгээд зогссонгүй уйтгарт амьдрал, үхэр малын зүдгүүрт удаан хөдөлгөөн, эл хуль уудам газар нутгийн талаарх мэдээлэл, шинэ мэдрэмж мэдрэхүйн сэдлүүдийг үүсгэж зохиолын хэрэг явдал, дүрийн амьдрал, орчин ахуйн байдлыг нээхэд нэн зохицсон уран дүрслэл болжээ.

Мөн зохиолч “Хөлөө хүрэх газар явж, хэлээ хүрэх газар хүртэл заргалдах” гэсэн ардын зүйр үгийн загвар дээр “...**хөл хүрэх газар явж, ухаан хүрэх юмыг үзвэл** эрдэм соёл гэгч их сайхан юм байна...” зэргээр шинэ бүтэц үүсгэсэн нь зарга заальхайн тухайд бус харин эрдэм ном сурахын төлөө “ухааны туйл” хүртэл зүтгэвэл сайн гэсэн эсрэг шинэ санааг илэрхийлсэн байна. Онч үг энгийн нэг дүрслэх хэрэглүүрийн үүрэг гүйцэтгээд зогсдоггүй зохиолын хэрэг явдлын шинж байдал, эрчим, хувирал зэргийг тодруулж, уран дүрслэлд бүрэлдэж буй уран санааг гүн ухааны аяс хандлагатай болгодог ач холбогдолтой.

“Хүсэхэд хясах” гэх түгээмэл хэлцийн утгыг баяжуулан “**Хүсэлдээ хүлэгдээд, хүлээсэндээ тээглэж буй**” (“Феодалын янаглал (Үзэв үү)”, 1931., Бүрэн зохиол 1., 82 тал) “хүсэхэд” хөндлөнгийн зүйл “хясах” байдлыг бус харин ч өөрөө өөртөө хүлэгдэн “тээглэж” буй дүрийн үйлийн ялгаа, сэтгэл зүйн дотоод мөн чанарын зөрүүг ялган нээсэн нь зохиолчийн ур чадварын хэр хэмжээг илтгэх билээ. Нөгөө талаас их зохиолч өөрийн ард түмний үгийн урлагийн баялаг өв санг сайтар эзэмшсэн төдийгүй чадварлаг ашигладаг уран найруулгын нэг онцлогийг харуулж байна. Үүний нотолгоо нь:

“Сайн явах цагт садан олон, сандарсан цагт саад олон” ардын зүйр үгийн утгыг шоронд байхдаа бичсэн нэгэн сентименталь шүлэгтээ:

**“Өнгөт орчлон дор явахуй дор**

**Үерхэх нөхөр олон оо**

**Өмхий зоорин доор хэвтэхүй дор**

**Үтэр орхидог нь үнэн ээ**” (“Орчлонгийн жамыг танихуй”, 1932., Бүрэн зохиол 1., 116 тал) хэмээн яг адил үйл ба тодорхой орон зай руу татан оруулж, өнгөт орчлонгийн авир араншин нэгэн мөн чанарт болохыг уянгын баатар-Би-гийн өчиг-ухаарлаар яруу сайхан илэрхийлсэн бол дараагийн:



“Зовох цагт нөхрийн чанар танигдана  
Ядрах цагт янагийн тар танигдана” ардын зүйр үгийн үндсэн утгыг эерүүлэн  
“Гадна сайн явахуй дор

**Хайртай амраг олон оо**

**Харанхуй гяндан дор орохуй дор**

**Харж үзэх нь ганцхан аа** (“*Орчлонгийн жамыг танихуй*”, 1932., *Бүрэн зохиол 1., 116 тал*) хэмээн орчлонгийн авир, хүний явдал хэдий хуурмаг, “хайртай амраг” гэгч олон байдаг ч, ядрахын цагт хажуудах авааль ганц нь буюу “харж үзэх нь ганцхан аа” мөрөөр антитез (эсрэгцүүллийн уран маяг) үүсгэн санаагаа гүнзгийрүүлсэн нь орчлонгийн жам ёсон хийгээд түүний дунд аж төрөгч хүний мөн чанарыг гүн ухааны үүднээс тайлсан нь гайхалтай уран шийдэл, шинэчлэл болоод зогссонгүй түүний бие сэтгэлийн шаналал зовлон уншигчдад илт мэдрэгдэхүйц шингэжээ.

**3. Түүний уран бүтээлд уран сэтгэмжээр амилж, зохиолоороо дамжин** уншигчдын дунд өргөн хэрэглэгдэх болсон онч уран үгсийг үе үеийн монгол уншигчид амнаас ам, бичгээс бичигт дамжуулан хэрэглэсээр байгаа онч хэллэгүүдийг агуулгаар нь хэд хэд ангилж болно. Үүнд:

*Эрдэм ном сурахын чухлыг сургамжилсан:*

1. Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас

Хүний хөвгүүн тийнхүү эрдэнэ өвөртөлж харина (“Алс газар сурахаар явагч” 1927., *Бүрэн зохиол 1., 59 тал*)

2. Хөх монголын ач нар, түмэн түмэн эрс,

Хөдөөгийн уул талаар соёлыг тарих үрс (“Бидний сурагчид” 1927., *Бүрэн зохиол 1., 60 тал*) Хүндэт нэрээ дуудуулсаар хойчийг залгамжлах залуус

Хөдөөгийн уул талаар соёлыг тарих үрс (“*Сэхээтэн*” 1934., *Бүрэн зохиол 1., 129 тал*)

Хөдөөгийн уул талаар соёлыг тарих үрс (“*Сэхээтэн*” 1934., *Бүрэн зохиол 1., 129 тал*, “*Бидний сурагчид*” 1927., *Бүрэн зохиол*)

*Хайр дурлалын нандин сайхныг илэрхийлсэн:*

1. Идэр хоёр насны

Эвийг хэн ч эвдэхгүй

Өргөж босгосон тооно нь

Үүрд мөнх мандана (“*Идэр хоёр*” 1933., *Бүрэн зохиол 1., 123 тал*)

2. Сэтгэлийн амраг гэдэг нь

Шижир алтнаас үнэтэй юм

Шилж түүнийг авах нь

Хямдгүй хэрэг дээ (1934., “*Янаг шүлэг*”, *Бүрэн зохиол 1., 130 тал*, “*Учиртай гурван толгой*” *жүжжээс.*, *Бүрэн зохиол 2., 7 тал*)

3. Өөрийн гэрээ бариач ээ

Өрхний чинь оосрыг татъя (1934., “*Учиртай гурван толгой*” *жүжжээс.*, *Бүрэн зохиол 2., 7 тал*)

*Эхийн агуу хайрын элбэрлийг илэрхийлсэн:*

1. Монголын үзэсгэлэнт саран гуа намайг төрүүлсэн ээжий

Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн ээжий

Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн ээж

Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн ээж (1935., “Миний ээж” шүлэг., Бүрэн зохиол., 133 тал)

Хүний амьдралын жам, үхэх төрөх ёс, ертөнцийн эгэл үнэнийг тусган харуулсан:

1. Мөнх тэнгэрийн доор мянган мянган хавар

Монголын сайхан оронд жил жил дэлгэр

2. Хүн бүр өтгөсийг үдэж нялхасыг угтан

Мянга мянган жил өчүүхэн ч чөлөө зав үгүй

3. Өндөр газрын хүйтэн тасхийм тасхийм, ясхийм ясхийм

Монголын залуус нүүртээ цогтой, нүдэндээ галтай (1935., “Дөрвөн цаг” шүлгээс., Бүрэн зохиол., 136 тал)

Эрүүл энх байх нь хүний амьдралын учир утга болохыг харуулсан:

1. Жаргалан жаргалан жаргалан

Энэхүү ертөнцийн түмэн жаргалан

Түүний доторх чухам жаргалан

Эрүүл энхийн нэгэн жаргалан

2. Жаргалыг хүсвээс эрүүлийг хүс

Эрүүлийг хүсвээс эмнэлгийг хүс (1935., “Өргүй бол баян, өвчингүй бол жаргалан”, Бүрэн зохиол., 158 тал)

3. Эрүүл явбаас улсын наадмыг үзнэ (1935., шүлгийн нэр., Бүрэн зохиол 1., 170 тал)

Дээрх үгс нь санаагаа товч тодорхой илэрхийлсэн, батлах, нотлох анхааруулгын чанартай, гүн гүнзгий бясалган хэлсэн (Галбаатар.Д., Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь., Уб., 2002., 196 тал) учраас онч мэргэн үг болж чаджээ.

## ДҮГНЭЛТ

Ингэж аман уран бүтээлээр дамжин уламжилсан онч уран үгс (афоризм)–ийг Д.Нацагдорж өөрийн зохиол бүтээлд шинэчлэн ашиглаж, уншигчдын дунд ихэд алдаршсан нь түүнээс монголын орчин үеийн яруу найргийн урын санг баяжуулахад оруулсан хувь нэмэр, аман зохиолын уламжлалыг орчин үеийн бичгийн уран зохиолд шинэ маягаар боловсруулан, дүрслэх хэрэглүүрийн үүргээр ашиглах боломжийг нээсэн урлахуйн томоохон туршлага, түүний ур чадвар, уран бүтээлийн уламжлал шинэчлэлийн диалектикийн нэг онцгой тал гэж болно. Дээрх уран дүрслэлүүдийг нэгтгэн үзвэл:

- Бүх насны уншигчдын дотор нийтлэг хэрэглэж, нийгмийн дотор канончлагдаж \канончлал. Үз, нэвтэрхий толиос\, ардын зүйр цэцэн үг мэт эш жишээ болж хэвшсэн нь зохиолчийн ур чадварын өндөр түвшинг илтгэдэг.

- Монгол хүний язгуур чанар, тэдний амьдралын онцлог, жаргал зовлон, аж төрөхүйн бодит түүх, амьдрал, оюун санааны асар их туршлагыг өөрийн зохиол бүтээлдээ шингээн чадамгай нээсэн ур чадвар нь түүний бүтээлд шингэсэн үнэт зүйлсээр тодорхойлогдоно.

- Ингэж өөрийн гэсэн онч мэргэн үг бүтээхийн зэрэгцээ ардын аман зохиол

дахь зүйр цэцэн үгийг шууд авч ашиглан, тэрчлэн зүйр үгийн загвараар өөрийн бүтээлд шинэ үг хэллэгийг бий болгосон нь нүүдэлчин монголчуудын ахуй байдал, сэтгэхүйн онцлог, аж амьдралын өвөрмөц байдалд тохирч, тэдний оюун сэтгэхүйд хоногшин үлдэх чухал ач холбогдолтой юм.

### **ABSTRACT**

Generally, the literature of any nation evolves in a similar way with development of its history, society and culture. The history of written literature in Mongolia accounts over 1000 years and the poetry is rightfully acclaimed as having the deepest roots of tradition and widest popularity among people.

Poetry is a sumptuous merit of the national mentality, the inner world of the human soul, its desires, goals as well as its cultural and artistic world.

The poetry in lives of Mongolians is as important as everyday speech, so the study of its development and evolution is important. In particular, the study of the poetry evolution by representative works by the main poets is much needed.

Every period of the poetry development has its own unique features, inimitable poets, recognizable specialties in writing and thinking, ubiquitous desire of breaking the existing rules and evident change over the time. This evolution is always upheld by newer generation of poetic talents with their distinct voices, grand discoveries and unseen before inspirational images. Moreover poetic methods are on a constant move towards an improved, more precise and vivid template. The Mongolian poetry has undergone this path as well.

“Innovation” in literature is seen as a process where young poets enrich the poetic legacy of the predecessors with their thinking, skills of representation, rhyming style, methods and rules, which ultimately results in creation of a new approach, image, thought and artistic shapes that are accredited by public and has own successors.

However, the experience of previous poets and the anthological base that they leave for next generations to start their work onto and to continue the poetry succession is called “tradition”.

Tradition and innovation are two inseparable sides of a whole integration, where any loose ties between them can eliminate any possibility to further advancement or poetic invention and prevent the essential development and periodic rearrangements.

Tradition and innovation exist in a tight nexus, where the differences between previous and present generations of creators become the very innovation.

There is a common pattern in the world history, where a certain writer, with his or her distinct writing, thinking and creative abilities, appears at a certain stage of the social and historical developments and becomes a self-sufficient phenomenon in the world of literature and poetry, then it starts an own school, which is known for later generations.

In this article, defining stylistic method, form, feature and style of a certain poem of D.Natsagdorj have been analyzed and explained in a wide range.

To put out the peculiarity or differentiation of D.Natsagdorj’s ability, studying the feature and form of his poetry has a significant theoretic and practical role. Here, to discover his poetry’s formation, we tried to determine his poetry’s characteristic from the result of some specific poems’ analysis which chosen for the study of how appear the

main concepts of rhythm, verse and prosody that are the basic units of the poem study, in his works.

From the D.Natsagdorj works, especially his poems of, there are no fixed ideas, traditional written form and stylistic influence of ancient written works which had a quiet influence to the literature of the early of the revolution. It is seen that he wrote his poems in literature language, stylistic and formation of modern Mongolian and it is quite different from the written style, way of thinking and the classic and oral Mongolian language stylistics influence of present writers and poets.

### **НОМ ЗҮЙ**

1. Галбаатар.Д., “Уран зохиол:Онол, түүх, шүүмжлэл” нэвтэрхий толь., УБ., 2012
2. Галбаатар.Д., “Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд”, УБ., 2001
3. Галбаатар.Д., “Урлахуйн галыг бадраагч, эндүүрлийн гэмийг арилгагч зул”, УБ., 2006
4. Галбаатар.Д., “Эрс эргэлтийн босгон дээр”, УБ., 1996
5. Галбаяр.Г., “XX зууны монголын уран зохиолын хөгжлийн үе шатууд”, УБ., 2004
6. Галбаяр.Г., “Уран зохиол шинжлэлийн лекц”, УБ., 2002
7. Монголын орчин үеийн уран зохиолын түүх-I боть (1921-1940)., УБ., 1985
8. Монголын уран зохиолын дээжис-29 боть., “1920-иод оны уран зохиол”, УБ., 1997
9. Нацагдорж.Д., Бүрэн түүвэр., (I боть)., УБ., 2006
10. Цэнд.Д., “Монголын орчин үеийн уянгын яруу найраг”, УБ., 1972

**МОНГОЛ НУУЦ ТОВЧООНЫ 234-Р ЗҮЙЛИЙН  
НЭГ ХЭЛЛЭГИЙН ТУХАЙ<sup>1</sup>**

Jens Christian Thomas  
/Лейпциг/

2007 онд Д.Отгонтуяа Монгол Судлал-д<sup>2</sup> МНТ-ны 234-р зүйлийн нэгэн хэллэгийн тухай бичиж санаагаа илэрхийлснээс үүдэн би энэ өгүүлэлийнхээ санааг авсан учраас талархлаа илэрхийлье. Д.Отгонтуяагийн өгүүлэлд олон орчуулгыг дурдсан тул би дахин тоочилгүй Гениш (Haenisch)<sup>3</sup> болон Таубегийн (Taube) герман орчуулгад ч үгчилсэн маягаар орчуулсан байдгийг нэмж хэлье.<sup>4</sup>

МНТ-ны энэ хэллэгийг хэрхэн ойлгох тал дээр орчуулагчдын ихэнх нь шууд үгчилсээр ирсэн бол Д.Отгонтуяа шилжсэн утгыг олоход анхаарч, шилжсэн утгаар орчуулахаас аргагүй гэж үзсэн нь зүйтэй юм.

Тийнхүү шилжсэн утгыг авч хэлэлцвэл ухаж ойлгох, илэрхийлэх хоёр боломж бий. Үүнд,

1. Зөвхөн хэллэгээс илэрч буй шилжсэн утга.

2. Хэллэгийг үгчлэн авахын хамтаар хам сэдвээс илэрч буй шилжсэн утга.

Д.Отгонтуяа эхний боломжийг дагасан бол миний хувьд хоёр дахь боломжийг

<sup>1</sup> Өгүүлэлийн тухай зөвлөлгөө өгч засаж тусалсан Доктор Э.Мөнх-Учрал ба Доктор Б.Даваасүрэнд би чин сэтгэлийн талархалаа илэрхийлье.

<sup>2</sup> Д.Отгонтуяа: “Монгол Нууц Товчоон”-ы нэгэн хэлцийн орчуулгын тухайд. Монгол Судлал XXVII (285), 2007. 171-176 т.

<sup>3</sup> “[...] dort von dem Abfallgemüse essen und ein Mistfeuer brennen lassen”; орч.: “тэнд хаягдсан ногооноос идэж өтөг бууцийн гал түлж” (Haenisch 1948, 111 т).

<sup>4</sup> Отгонтуяагийн иш татсан орчуулгууд хэвлэлүүд:

- “Ш.Гаадамба: Монголын Нууц Товчоон, УБ, 1990
- Кү.Дорба: Монголын Нууц Товчоон. Шинжааны Ардын хэвлэлийн хороо, 1987
- Монголын Нууц Товчоон. Ихмянгадай Иринчиний сэргээлт, Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо. Хөх хот, 1987
- Ч.Р.Намжиловай: Сокровенное сказание монголов. Элиста, 1990
- Д.Пүрэвдорж: Монголын Нууц Товчооны шинэ орчуулга тайлбар. УБ, 2006
- Д.Цэрэнсодном: Монголын Нууц Товчооны орчуулга тайлбар. Үндэстний хэвлэлийн хороо, 1993
- Ш.Чоймаа: Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал 1. УБ, 2006
- Элдэндэй Ардажав: Монголын Нууц Товчоон - Сийрүүлэл тайлбар. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн хэвлэлийн хороо. Хөх хот, 1996
- F. W. Cleaves: The Secret History of the Mongols Harvard University Press 1982
- N. Dorjgotov, Z. Erendo: The Secret History of the Mongols, Brill: London, 2004
- Paul Kahn: The Secret History of the Mongols, North Point Press 1984
- Urgunge Onon: The Secret History of the Mongols, London 2001”

дагаж үндэслэн тайлбарлая.

Дээр дурдсан хэллэгийг иш татвал:

*qoq idejü*

*qoma'ul tülejü yabutuqai*<sup>5</sup>

**Хог идэж**

**Хомоол түлж явтугай**

#### **А) Хэллэгийн хам сэдэв ба шийдэх асуудал**

Хэллэгийг анх уншихад хялбар, утга тодорхой мэт харагдах боловч хам сэдвийн хүрээнд уялдуулан үзвэл утга зохицохгүй байгаа нь тодорхой билээ.

МНТ-ны §225-§234 хүртэл Чингис Хаан хэшигтэнд холбогдох (*хэвтуул, хэшиг, хорчин гурав* гэсэн үг) зарим шийдвэр гаргадаг. Энэ дунд хэшигийн тоо хамгийн их байсан боловч (8 түмэн хишигтнээс 2 түм нь л хэвтүүл (§226)) хэвтүүлийг хамаардаг тушаал хамгийн чанга хатуу бөгөөд Чингис Хаан зөвхөн хэвтүүлээ магтан дуулсан (§230) зэргээс үзэхэд хэвтүүл хамгийн чухал гэдэг нь илэрхий болж байна.

Жишээлбэл, шөнийн хамгааллаар хан халдлагад өртөх аюултай асан учраас хэвтүүл үнэнч, баталгаатай, итгэж болохуйц байхаас аргагүй билээ (§227-д жагсааж дурьдсан шийтгэл үзнэ үү). Хэвтүүл орд өргөөний ойрхон эргэн тойрон сууж үүд хамгаалах,<sup>6</sup> шөнө болоод орд өргөөнд ойртож гэтэж явах хэнийг ч барих, орохыг завдсан хүний толгой авах гэх мэт тушаалтай байсан.<sup>7</sup> Мөн хэн ч шууд орох, хэвтүүлийн тухай асууж авах, хэвтүүлээс дээд суурь дээр сууж болохгүй бөгөөд эсрэг үйлдвэл баригдана (§229-ын эцэст). Бусад албаас гадна хэвтүүл бээр ордны зарц, тэмээчид, үхэрчдийг хамааран захирч өргөөний тэргийг<sup>8</sup> засаж туг хамгаалж хааны идээ ундааг “даргалж” (хаан хордуулагдахгүйг хянан харгалзах гэсэн үг) өргөөнд хэн орох гарахыг ажиглан шалгаж үүдний дэргэд сууж хаантай хамт ан авлах зэрэг үүрэг эрхтэй байсан (§232). Түүгээр барахгүй бас өдөр нь хэвтүүл хааныг хоцроон үлдээн байлдаанд явахыг хориглосон ба хааны алтан амь сахина<sup>9</sup> гээд ойрхон байх тушаалтай байсан (§233) бөгөөд заргад оролцож морь арчлах үүрэг оногдуулсан билээ (§234).

§230-д Чингис хаан удаан хугацаагаар алба залгуулсан хэвтүүлээ магтахдаа гэрээ ээрэн, эргэн тойрон хэвтэж тайвнаар унтуулж эсэргүү байдал, аюулаас дандаа итгэлтэй хамгаалсаар ирсэн хэмээнэ. Хэвтүүлийг тодотгосон үгс нь *өлзийт, чинг сэтгэлтэй, итгэлтэй, уриарах* (уриалаг)<sup>10</sup> байх бөгөөд үнэхээр хааныг амар амгалан байлгаж хаан ширээнд суулгасан (§230), өөрийн *nendü'üt qutuq* (сахиус мэт) хэмээжээ (§231).

<sup>5</sup> МНТ-ны бүх иш татсан газруудыг *Ligeti*-ээс авсан (Ligeti 1971, 203 т).

<sup>6</sup> § 229: *bidan-tur söni kekte'ül qonan atuqai; kekte'ül söni ordo horčin gebtejü e'üten daruju* (Ligeti 1971, 197 т).

<sup>7</sup> § 229: *naran šinggeksen-ü qoyina ordo-yin qoyina'un urida'un ketügeljen yabuqu gü'in-i bariju; kekte'ül söni oroqun haran-i ekit anu dalbaru müriis anu ba'utala čabčiju* (ibid.).

<sup>8</sup> Эх сурвалжид *ordo-yin ger tergen-i* бичсэн байна (Ligeti 1971, 201 т).

<sup>9</sup> § 233: *ta kekte'ül lü minu altan amin sakimui* (Ligeti 1971, 202 т).

<sup>10</sup> Уламжлалсан *uriyarqun* гэсэн үг *uriya* (урия) гэдэг үгээс *r*-дагавараар үүссэн *uriyar-* гэдэг үйл үгийн олон тоотой *-qu/kü* дагавараар бүтээсэн үүсмэл үйлт нэр юм. Чоймаа үүнийг уриархан гэж уншаад уриалаг гэж тайлбарласан (Чоймаа 2011, 193-т).



Товчхон хэлбэл хэвтүүл нь хааны алтан амийг сахиж, биеийг нь хамгаалах чухал үүрэгтэй, хааны найдаж итгэсэн хүмүүс байсан бол бүх хэшигтэн найдвартай оролдлогтой хүмүүс байх ёстой бөгөөд хэшигтний захирагч ер бусын чадвартай, чадалтай хүн байлтай.

Бүх хэшигтэн тургууд<sup>11</sup> (харуул анги)-ын захирагч бол Дөдэй чэрби байжээ. Мөн Дөдэй чэрби зарим талаар дээр дурьдсан хэвтүүлийг захирах үүрэгтэй хийгээд асарч байгаа ордны зарц, адуучин, хоньчин, тэмээчин, үхэрчнийг захирахдаа орд өргөөг эргэж тойрон, орд даран хамгаалах ёстой байснаас үзвэл бас хэвтүүлийг ч захирч байсан ажээ.<sup>12</sup> Гар бичмэлд “захирах” хэмээхийн оронд *uqaǰu* < *uqa-* гэсэн ба *mede-* гэсэн үгийн хэрэглээнээс үзвэл бас “захирах, удирдах” гэсэн утгатай байсан нь тодорхой байдаг.<sup>13</sup>

“Орд даран” (*ordo darun*) гэдгийн утгыг нягталбал, хятад орчуулгаар “дандаа” гэсэн байдаг нь үнэхээр оносон уу гэдэг асуудал гарч ирнэ. Хятад орчуулгын дагуу “*байнга, дандаа*” гэсэн утга илтгэх *darui* хэмээх үгтэй холбоотой байх бололтой.<sup>14</sup> Энэ хоёр үгийн үндэс нь *daru-* гэдэг үйл үг бөгөөд нэг талаар *-n* гэсэн үйл үгээс үг бүтээх дагавраар үүссэн нөхцөл үг (*converbum adverbiale*) нөгөө талаар *-i* гэсэн үйл үгээс үг бүтээх дагавараар бүтсэн үг байна (ж. МНТ-ны §56, *boli* < *bol-*).

Үүнээс үзвэл МНТ-ны §229 *e'üten daruǰu bayiǰsat kekte'ül* гэсэн хэлцтэй (үүд хамгаалж байсан хэвтүүл гэсэн үг) харьцуулбал, §234-ийн *ordo darun* гэсэн хэлц бас орд өргөөг хамгаалах гэсэн утгатай болохоор үгчлэх боломжтой юм.<sup>15</sup>

Энэ чухал үүрэгтэй, дээд алба хааж байгаа “Дөдэй чэрби даран аж ордын хойноос хог идэж, хомоол түлж явтугай хэмээн (Чингис Хаан) зарлиг болов”. (§234)

Дээр дурьдсан хам сэдвээс үзвэл Дөдэй чэрбид хандаж хэлсэн үгсийг доромжилсон шууд утгаар бус шилжсэн утгаар ойлгох нь зүй.

## Б) Орчуулга. Тайлбар.

Эрдэмтэдийн хийсэн орчуулгад, ялангуяа хятад хадмал орчуулгыг дагаж *goγ* гэсэн үгийг “*өвсний үлдэгдэл*” гэж үндэслэн орчуулж ирсэн. Onon, de Rachewiltz, Чоймаа нарын орчуулгадаа хийсэн тайлбар сонирхолтой юм.

1. Onon:<sup>16</sup>

*“grazing his herds on pastures  
already grazed by the herds of others,  
and burning cakes of dried horse-dung”*<sup>17</sup> гэж орчуулаад:

<sup>11</sup> Чоймаа турхагууд гэж галигласан (Чоймаа 2011, 196 т). Дунд үеийн монгол хэлэнд гийгүүлэгчийн дэргэд бүх төвөнхийн авиа дуугүй байдаг.

<sup>12</sup> § 227: *niken kešik kešikten-i medeǰü kešikten-i ǰasaǰu orotuqai* (Ligeti 1971, 195 т).

§ 234: *ordo-yin ger-ün kö'üd-i* (Ligeti 1971, 203 т).

§ 234: *bürin kešikten turqa'ud-i ordo horč'in ordo-yin ger-ün kö'üd-i adu'učin qonič'in temēc'in hükeč'in-i ordo darun Dödei-č'erbi uqaǰu atuqai* (Ligeti 1971, 203 т).

<sup>13</sup> Ж.: МНТ-нд -р зүйлд: *qamtuq Mongqol-i Qabul-qahan meden aba* (Ligeti 1971, 33 т) гэх мэт олон жишээ.

<sup>14</sup> Haenisch 1939, 33 т.

<sup>15</sup> Vide Cleaves-ыг зааж буй de Rachewiltz (2004, 841 т).

<sup>16</sup> Paul Kahn-ын орчуулга адилхан (ibid. 147 т).

<sup>17</sup> Орч.: “*бусад хүмүүсээр мал бүр идэшилүүлсэн бэлчээрт малаа идэшилж хатсан хомоол түлж*”.

“I.e., Dodai-cherbi will be so busy that he will have no time to look after himself properly. *Qoq*, translated here as ‘left-over scraps’, can also mean ‘bad quality grass’, ‘chaff’, ‘refuse’; as a fuel, dried horse dung was considered inferior to dried cow dung. Dodai-cherbi’s appointment was, nonetheless, an honour”<sup>18</sup> хэмээн тайлбарлажээ.

2. De Rachewiltz бээр *qoq* (*qoγ*) гэсэн үгийн жинхэнэ утга нь “‘sweepings, scraps, remnants of food, garbage’, which we find in the living languages and dialects as well as in the literary language”<sup>19</sup> гэж нотолж уйгур хэлнээс авсан үг мөн гэжээ. De Rachewiltz энэ хэллэгийн тайлбарт Onon-ын тайлбарыг ишилсэн аж. Onon, de Rachewiltz хоёр Дөдэй-чэрбийн ажил үүрэг их байснаас үнэхээр хог мэт хоол идэхээс аргагүй байсан гээд түүнчлэн энэ хэллэгийн хоёр дахь мөрд байгаа *хомоол* гэсэн үгийг *аргал* хэмээх үгийн оронд зөвхөн толгой холбох зорилгоор хэрэглэсэн гэж үзжээ.<sup>20</sup>

Түүний орчуулга нь:

“Eating scraps of leftovers,

Burning dried dung”<sup>21</sup> гэж шууд үгчлэн орчуулсан байна.

3. Ш.Чоймаа<sup>22</sup> бээр энэ хэсгийг “*хог итэж, хомоол түлж явтугай – Их нүүдлийн ард хаягдаж гээгдсэнийг бүрэн хамаарч яв гэсэн үг болой. «Итэж» - этэж, цугдуулж бөөгнүүлэх; эртний түрэг хэлэнд «итэ-» хэмээх нь мөн адил утгатай буй*” гэж тэмдэглэжээ.<sup>23</sup>

4. Д.Отгонтуяа *qoγ* гэдэг үгийн язгуурыг Сэцэнцогтын язгуурын толь бичгээс<sup>24</sup> иш таган “*qoγ* гэдэг үгийг *qay* үүсмэл гэж үзсэн байх”<sup>25</sup> бөгөөд энэ “*qay*” гэсэн язгуур “алтайн язгуурын бараг бүх хэлэнд ижилхэн байдаг гэж болно”. Тиймээс бас “*хатах*” гэсэн үг энэ язгуураас үүссэн бөгөөд “Чингэхлээр *qoq idejü* гэсэн хэллэг бол “аливаа юмнаас үлдэж хатаж хоцорсон юмыг идэх” гэсэн шиг анхдагч утга байна” гэсэн дүгнэлт хийжээ.<sup>26</sup> Түүнчлэн, “[...] орд гэрийн хамаг баг идээнд дарагдах хүн нь Додай чэрби болж таарлаа. Эндээс *qoq idejü* гэсэн хэллэгийн анхдагч шууд утга нь “үлдсэн хатсан юм идэж” гэсэн утга боловч шилжсэн утга нь орд өргөөний аж ахуй хамаг л ажлыг хариуцаж гэсэн утга мөн” бөгөөд орчин цагийн “баг идээнд баригдах” гэсэн хэллэгтэй харьцуулахуйц байна гэжээ.<sup>27</sup>

Энэ хэллэгийн хоёрдугаар хэсэг нь “сүүл барьж явах, ард явах, сүүлдэж явах, даруухан явах гэсэн шилжсэн утга болно” хэмээн тайлбарлаад “хомоол хамах”

<sup>18</sup> Орч.: “Додай-чэрби их ажиллаж огт завгүй байсан учраас биеэ асрах боломжгүй байна.” Үлдсэн нови” гэж орчуулсан *Qoq* гэдэг үг бас “муу чанартай өвс, хэрчсэн сүрэл, хаягдал” гэсэн утгатай болж байна. Түлш болгон хэрэглэхэд аргалаас хомоол муу гэж үзэж ирсэн. Тийм боловч Додай-чэрбийн тушаал нь хүндлэлтэй байсан”. (Onon 2001, 220 т).

<sup>19</sup> Орч.: “тоос шороо болсон хог нови, хоолны үлдэгдэл, хаягдал” гэдэг нь өнөөгийн хэл аялгуунуудад ч бичгийн хэлэнд ч байсаар байна” (de Rachewiltz 2004, 841 т).

<sup>20</sup> “The word for ‘dried dung’ (used for fuel) is hier *qota’ul*, which alliterates with *qoq* (de Rachewiltz 2004, 841 т).

<sup>21</sup> Орч.: “үлдсэн нови идэж, хомоол түлж” (de Rachewiltz 2004, 162 т).

<sup>22</sup> Dorjgotov/Erendo-гийн орчуулга адилхан буй (180 т).

<sup>23</sup> Ш.Чоймаа 2011, 196 т.

<sup>24</sup> Sečenčoytu: Mongyol-un üges-ün ijaγur-un toli. Öbör mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. 1988.

<sup>25</sup> Д.Отгонтуяа 2007, 174 т.

<sup>26</sup> Д.Отгонтуяа 2007, 175 т.

<sup>27</sup> Д.Отгонтуяа 2007, 175 т.

гэсэн хэллэгтэй харьцуулж болох бөгөөд “үхрийн аргал мэтийн том товир түлшийг биш, адууны хомоол мэт хөнгөн авсаар түли түлэх гэсэн”-тэй утга нь холбоотой аж” гэжээ.<sup>28</sup>

Д.Отгонтуяагийн англиар

“*He will be responsible for campsite's work*

*And follow the move modestly and quietly*”.<sup>29</sup> гэж орчуулав.

**Га) Дэвшүүлэх санал.**

Өмнө өгүүлсэн санаа, орчуулгыг нэгтгэн өөрийн саналаа хэлэхээс өмнө хэрэглэх онолын тухай нэг үг хэлье.

**Гаа) Үгийн гарлыг тэмдэглэхийн тухай.**

Аливаа үгийн гарал үүслийг тогтооход энэтхэг-европ хэлний харьцуулсан түүхэн хэл шинжлэл (Indogermanische Sprachwissenschaft, Indo-European Linguistics)-ийн зарим тохирох арга зарчмуудыг хэрэглэх нь чухал юм.

**Габ) утга зүй.**

Зарим үг хэлбэрийн хувьд тохирдог оос нэг гаралтай мэт харагдах боловч утга зүйн талаасаа сэргээсэн язгуур үндэстэйгээ тохирч байх ёстой. Учир нь ижил дуудлагатай язгуур үгс энэтхэг-европ өвөг хэлэнд бас олон байсан. Жишээлбэл, эртний герман хэлний *bero* < \**bher-ō(n)* “баавгай” болон *beran* < \**bher-an* “авчиргах” гэсэн үгийн язгуурын аль аль нь \**bher-* боловч үгийн сангийн хувьд нэг нь нэр үгийн язгуур, нөгөө нь үйл үгийн язгуур. Хэрэв \**bher-ō(n)* гэсэн үгийн \**bher-*г үйл үгийн язгуур гэж үзвэл \*-*ō(n)* гэсэн дагавар залгаж \**bher-ō(n)* буюу “онцгой авчирагч” гэсэн утгатай үг үүснэ. Гэвч *bher-ō(n)* гэдэг үг бол герман хэлний “хүрэн, бор” гэсэн утгатай *braun* < \**bhr-uH-n* хэмээх үгтэй нэг гаралтай болох ба “бор зүсмийн (амьтан)” буюу *баавгайн* нэр болно. Тийм учраас *хог, хогшил* гэсэн хоёр үг хоорондоо огт холбогдолгүй.<sup>30</sup>

Ер нь аливаа үгийн гарлыг ярихдаа өөр хэлнээс орсон эсвэл тухайн хэлний уугуул үг үү, анхдагч утга нь шилжсэн үү, үгүй юү гэх мэт асуудлыг шийдвэл зохилтой.

**Гаг) Үг зүй.**

Ямар нэг язгуур үндсийн араас залгасан дагаврыг жишээлбэл, монгол хэлнийх үү, түрэг хэлнийх үү, хэл зүйн үүрэг, утгын хувьд ямар үүрэгтэй вэ гэдгийг тодорхойлон тэмдэглэх ёстой. Эсвээс “*мөхсөн*” (тухайн хэлэнд хэзээ ч бүтээлч бус, өөр хэлнээс авсан үг байж болно) нэг дагавар байлаа гэж бодоход улмаар язгуурын үндсэн утгыг тогтоох боломжгүй юм. Бас нэр үгийн язгуурыг үйл үгийн язгуураас салгах хэрэгтэй.

**Гад) Авианы хууль.**

Эртний язгуурыг сэргээх юм уу олон хэлний үгийг харьцуулахдаа нэгэнт тодорхой болсон авианы хуул(иуд)ийг баримтлахгүйгээр сэргээх, харьцуулах нь субъектив үр дүнтэй. Тэр мэт авианы хуульд дүрэмд үл харшлах байдлын зарчмыг XIX зуунд германы младограмматистууд (Junggrammatiker) боловсруулжээ.

<sup>28</sup> Ibid.

<sup>29</sup> Орч.: “орд (үгч. *оршиж суух газар*)-ын ажлын хариуцлагатай байж нүүдлийг даруухан, чимээгүйгээр дагаж явтугай” (Отгонтуяа 2007, 175 т).

<sup>30</sup> Д.Отгонтуяа тэднийг холбогдолтой гэж үзсэн (2007, 174-5 т).

Нэгэнтээ тогтсон авиан зүйн хуультай зөрж байвал дүрэмд харшид тохирсон авиан зүйн хууль байх ёстой. Жишээлбэл, V зууны хуучин зүүн герман (Ostgermanisch, Eastern Germanic) готи/готонес (Goten, Goths) нэртэй хүмүүсийн хэлэнд бүх богино \*e (/ɛ/) эгшгээс i (/i/, <i>) эгшиг үүссэн. Гэхдээ уг авиан зүйн хуулинд харшилдаг тохиолдол нь <r, h, hv> (≈ /r, ɣ, ɣβ/) гийгүүлэгчийн өмнө \*e (<ai>, /ɛ/) эгшиг хадгалагдаж үлдсэн эсвэл i эгшиг болсон, хожим i эгшиг дахиад e болсон гэж үзвэл энэ тохиолдолд тохирох бас нэг авиан зүйн хууль байна.

Утга зүй, үг зүй, авианы хууль гурвыг түүхэн-харьцуулсан хэл шинжлэлд салгалгүй хэрэглэх ёстой. Жишээлбэл, энэтхэг-европ латин, грек хоёр хэлний “*бурхан*” гэсэн утгатай, нэг гаралтай мэт харагдаж буй *deus*, *θεός* (theós) гэдэг хоёр үг хэлбэрээрээ их адилхан боловч хоорондоо огт холбоогүйг дээр дурьдсан гурван зарчмыг үндэслэн баталж болно.

Эцэст нь үг зүйн бүтцийн хувьд аливаа “*үгийн нас*” нь эх сурвалж бичигт тэмдэглэгдсэн насаас чухал. Учир нь ямар нэгэн эртний дагавар хэрэглэгдэхээ байсан тохиолдолд орчин цагийн хэлэнд уг дагавараар шинэ үг бүтээж болохгүй юм.

### Гб) Зохиогчийн дэвшүүлж буй санаа.

Onon, de Rachewiltz хоёрын тайлбар үндэслэлд итгэхэд бэрх. Өмнө өгүүлсэнчлэн чухал ажил алба хааж байсан Дөдэй-чэрби мэт хүн үнэндээ зарцаас муу хоол идэж байсан гэж үү?! Түүнээс гадна “*grazing his herds on pastures already grazed by the herds of others*” гэвэл Дөдэй-чэрби ордны адуу мал бусад хүмүүсийн нэгэнтээ идээшилсэн бэлчээрт буух нь юу бол.

Профессор Ш.Чоймаа эхний мөрийг их сонирхолтой тайлбарласан боловч зарим нэгэн асуудал басхүү хариултгүй хэвээр байна. Тэрээр *ide-* гэсэн үгийг *ite-* гэж үзсэн. Гэвч эртний (XIII зууны өмнөх) түрэг хэлэнд *ite-* гэсэн үйл үг тааралддаггүй<sup>31</sup> бөгөөд *idi-* гэж “хураах” (“собирать”)<sup>32</sup> гэсэн утгатай үйл үгийг *evdi-* гэсэн үгийн оронд буруу уншиж галигласан байна.<sup>33</sup> Тийм учраас “этэх” гэж “хураах” гэсэн утгатай монгол үйл үг нь дээр дурьдсан түрэг үгтэй холбогдолгүй бөгөөд монгол хэлэнд *ete-/ide-*<sup>34</sup> гэсэн сэлгэлт байхгүй байна.<sup>35</sup>

Бас түрэг хэлний зөвхөн үеийн эцэст орсон *-t* гийгүүлэгч монгол хэлэнд *-d* гийгүүлэгчээр сэлгэдэг бол бусад тохиолдолд түрэг хэлний *-t-* нь монгол хэлний *-t-* гийгүүлэгчтэй дүйцнэ.<sup>36</sup>

Түрэг хэл монгол хэл хоёрын хооронд эхний авианы *e/i* гэсэн эгшгийн сэлгэлт нь зөвхөн түрэг хэлний *idi*, монгол *эзэн* гэсэн үгст байгаа гэвэл авианы хуулийн эсрэг, ганцхан тохиолдол учраас үгийн гарлын шинжилгээнд холбоогүй биз ээ.<sup>37</sup>

Д.Отгунтуяа нь *qoγ* гэсэн үгийн гарлын тухай бичихдээ Сэцэнцогтын үгийн

<sup>31</sup> Надеяев нар 1969, Clauson 1972 үзнэ үү.

<sup>32</sup> Надеяев нар 1969, 203 т.

<sup>33</sup> Clauson (1972, 42 т) үүнийг илэрхийлж үзүүлсэн.

<sup>34</sup> Түрэг хэлэнд зөвхөн *et-* гэж “*совершать*” юм уу “*неть*” гэсэн утгатай үг байгаа байна (Надеяев нар 1969, 186 т).

<sup>35</sup> Нэг ганцхан *t > d* гэсэн дүрэмд харш нь “*В слове qadūni ‘его жестокость’ (= письм. qatayū inu) наблюдается \*t > d. Пример этот является единственным*” (Поппе 1938, 51 т).

<sup>36</sup> Poppe 1960, 49-51 т.

<sup>37</sup> Clauson 1972, 41 т.

гарлын талаарыг үндэс болгосон байна. Гэвч Сэцэнцогтын номд өгсөн мэдээлэл алдаатай байна. Жишээлбэл: \*qoy- \*qay- \*ay- гэсэн үеэр эхэлж буй янз бүрийн үгсийг шилэлгүй нэг нэгтэйгээ холбуулж ямар нэгэн авианы хууль, сэлгэлтийн нөхцөл өгөлгүй, тухайн үгийн түүхийн судлал, дагаврын үүргийн судлал хийлгүй дансалсан байна.<sup>38</sup> Тийм учраас “*хамар*” гэсэн үг “*хог*” гэсэн үгтэй холбоотой эсэхийг тодорхойлоогүй тул “*хог*” гэвэл хатах явцад хамаагүй гэдгийг хэлэхээс аргагүй болов уу.

Д.Отгонтуяагийн “*хогоол идэж*” гэсэн хэсгийн тухай хэлсэнчлэн “*хогоол хамар*” гэсэн орчин цагийн хэллэгтэй үнэхээр харьцуулж болох бол “*And follow the move modestly and quietly*” гэж орчуулах нь нийцэхгүй, зөвхөн “*хойноос/хамгийн сүүлд дагаж явтугай*” гэж орчуулах ёстой байна биз.<sup>39</sup>

### Гба) “*хог*” гэсэн үг

Орчин цагийн өмнөх хэлний толь бичгүүдэд *хог* гэсэн үг нь<sup>40</sup> “*junk, trash, remainder*”,<sup>41</sup> “*Satz, Rest*”,<sup>42</sup> “*kehricht, überbleibsel, krume*”,<sup>43</sup> “*dust particles; sweepings, dirt; garbage*”,<sup>44</sup> “*ныль, крохи, сорь, остатки, навозь*”,<sup>45</sup> гэх мэт утгатай болоод орчин цагийн монгол хэлээр “*хаягдал, үлдэгдэл*”,<sup>46</sup> “*нови, хаягдал, үлдэгдэл [...] хэмхдэг, үйрдэс [...] талхны хог; чихрийн хог*”,<sup>47</sup> “*Abfall [...] Krümel*”,<sup>48</sup> “*трусха, мусор, сор*”<sup>49</sup> гэсэн утга илтгэнэ.

Түүнээс үүссэн “*хoyлxр mör᠓ хoyлdž idnē das pferd frist die überbleibsel des heus*”,<sup>50</sup> “*qoyliqi* пастишь на травы, ходите на подножномь”,<sup>51</sup> “*хоглох* доедать, собирать остатки кормов”,<sup>52</sup> “*хоглох* малын хээр бэлчээрлэн идээшлэх” гэхэд “*хогдох* хог нунтаг болох”,<sup>53</sup> “*хоглох* Малд бог өвс, бордооны зүйлийг бага сага идүүлэх” гэхэд “*хогдох* элдэв хаягдлын нунтаграх: талх үйрч хогдох”<sup>54</sup> гэх мэт үгсээс үзвэл *хог* гэсэн үгийн үндсэн утга нь гол төлөв өвстэй холбогдолгүй байж бага сага байдал, үлдэгдсэн чанар ач холбогдолтой байсан нь илэрхий болох тул “*хэмхлэсэн өвс*”<sup>55</sup> гэх хятад орчуулгад зөвхөн *хэмхэлсэн* гэсэн үг нь угийн утгыг тэмдэглэхэд *өвс* гэсэн үг нь тайлбар л байна.

<sup>38</sup> Д.Отгонтуяа 2007, 174-5 т.

<sup>39</sup> Түүнээс гадна “[...] орд гэрийн хамаг **баг** идээнд **дарагдах** хүн нь Додай чэрби болж таарлаа” гэвэл “баг идээнд баригдах” гэсэн хэллэгтэй үнэхээр адилхан байна уу (Отгонтуяа 2007, 175 т)? Сүүлч нь “нүгэл хилэнц их хийх” гэж утгатай биш үү (Сүлд-Эрдэнэ нар 2013, 74 т).

<sup>40</sup> *Хог* гэсэн үг Мукаддимат ал-Адаб-д байхгүй байна (Поппе 1938).

<sup>41</sup> “*qoq ügei undefiled, completely*” (Krueger 1978, 282 т).

<sup>42</sup> Орч.: “шаар, үлдэгдэл” (Zwick 1853, 192 т).

<sup>43</sup> Орч.: “новш, үлдэгдэл, үртэс (хөрс)” (Ramstedt 1935, 181 т).

<sup>44</sup> Орч.: “*тоосны жижиг хэсгүүд, шавар, нови, тоос гэх мэтээс бүрдсэн хог нови*” (Lessing нар 1960, 951 т).

<sup>45</sup> Kowalewski 1844-49, 958 т.

<sup>46</sup> Чоймаа нар 2011, 798 т.

<sup>47</sup> Я.Цэвэл 1966, 681 т.

<sup>48</sup> Орч.: “*хаягдал [...] үйрдэс*” (Vietze 2005, 346 т).

<sup>49</sup> Муниева 1977, 591 т.

<sup>50</sup> Орч.: “*морь нь өвсний үлдэгдэл идэж байна*” (Ramstedt 1935, 181 т).

<sup>51</sup> Голстунский 1894, 146 т.

<sup>52</sup> Муниева 1977, 591 т.

<sup>53</sup> Я.Цэвэл 1966, 682 т.

<sup>54</sup> Дамбажав 2010, 637 т.

<sup>55</sup> Rachewiltz 2004, 841 т.

“Хог” гэсэн үгийн гарлыг мөшгөө. Түрэг хэлнүүдэд XIII зуунаас өмнө баримталсан *qoγ* гэсэн үгийн утга “*сop, соринка (в пище или глазу)*”,<sup>56</sup> үндсэн утга нь “*dust*”<sup>57</sup> гэж байсан бөгөөд өөр үгтэй холбоотой, үйл үгээс үүссэн нэр байлтай. Тийм үйл үг гэвэл<sup>58</sup> *qop* “*весь*” < \**qo-p* “*суусан, үндэслэсэн*” → болсон, бүрэн”, *god-* “*класть*”,<sup>59</sup> “*to put down, abandon, give up*”,<sup>60</sup> *qoγ-* “*класть*”,<sup>61</sup> “*to settle down*”<sup>62</sup> (< \**qoñ-*) гэсэн үгийг дурдаж болох хийгээд утгаас үзвэл энэ үйл үгсийн язгуур (\**qo-*) “*аажуу уужуу унаж суух, зөөлөн тавиад хэвтэх*” гэсэн утга байсан бөгөөд “үйл үгийн үр дүнг”<sup>63</sup> тэмдэглэх -*γ* гэсэн дагаврын үүргээр<sup>64</sup> “*аажуу уужуу унасан юм*” → “*тоос*” гэсэн утга болон хөгжсөн бололтой. Тэгвэл, монгол хэлний “хог” гэсэн үг түрэг хэлнүүдийн нэгээс орсон байж магадгүй.

Үүгээр “*новиш, тоос*” гэх мэт утгыг тайлбарлаж болох авч утга зүйг амархан бүрэн тайлбарлахгүй тул бас монгол хэлэнд холбоотой язгуур олдох эсэхийг үзье.

\**qo-* гэсэн эхлэлтэй олон язгуур байгаа боловч утга зүйн үүднээс зөвхөн дараах үгсийг анхаарах боломжтой байна. Үүнд: *qoγusun, qobur, qoru-, qorçai-, qotui-, qongqur, qoki, qomsa, qoçur-*.

### Гбβ) “*qoγusun*” гэсэн үг

Энэ үгийн бүтцийг \**qo-γu-sun* гэж задалж болох бөгөөд -*sUn* гэсэн дагавар нь үйл үгэнд залгасан дагавар буюу “*to form nouns designating the result of action*”<sup>65</sup> гэсэн утгатай эсвэл нэр үгэнд залгасан дагавар буюу “*to form nouns of which the meaning is usually the same as that of the primary word*”<sup>66</sup> гэсэн утгатай юм.

Энэ -*sUn* гэсэн дагаварын өмнөх *qoγu-* гэсэн үндсийн талаар би нэг өгүүлэлдээ *γu-* гэсэн дагавар нь үйлээс үйл үг юм уу нэр үг үүсгэх боломжтой, үйлийн үр дүнг илэрхийлэх үүрэгтэй гэж магадалсан.<sup>67</sup> Түүнчлэн \**qoγu-* гэдэг үгийг “юмгүй (байгаа) байх” гэж тодорхойлоод \**qo-* гэсэн язгуур нь “юмгүй болох” гэж тэмдэглэх нь дүгнэлт гарч байна.

### Гбγ) “*Qobur*” гэсэн үг

*Qoγusun* гэсэн үгийн тухай дээр хэлсний дагуу -*bur* гэсэн дагавар нь үйл үгээс үүсмэл нэр үгсийг бүтээх ёстой. Үүний дагуу -*bur* гэсэн дагавараар бүтээсэн үгсийн жишээг үзвэл нэр, үйлийн аль алинаас үг бүтээж байна. Жишээлбэл:

- нэр үгээс үүссэн: *ulabur, çagabur, talabur* зэрэг.
- үйл үгээс үүссэн: *quriyabur* (< *quriya-*), *singgebür* (< *singge-*), *kögebür* (<

<sup>56</sup> Надеяев нар 1969, 452 т.

<sup>57</sup> Clauson 1972, 609 т.

<sup>58</sup> Эдгээр үгсийг Clauson нэг гаралтай гэж үзсэн (Clauson 1972, 578 т).

<sup>59</sup> Надеяев нар 1969, 451 т.

<sup>60</sup> Clauson 1972, 595 т.

<sup>61</sup> Надеяев нар 1969, 453 т.

<sup>62</sup> Clauson 1972, 632 т.

<sup>63</sup> Gabain 1950, 70 т. Илүү нарийхан Erdal (1991, 222-223 т) тайлбарсан.

<sup>64</sup> “*Resultat des Verbuns, das passiv ist; aktives Substantiv und anderes*”; орч.: “үйл үгийн идэвхгүй утгатай болох үр дүн; идэвхтэй нэр үг гэх мэт” (von Gabain 1950, 70 т).

<sup>65</sup> Орч.: “үйл үгийн үр дүнг тэмдэглэх нэр үгсийг бүтээх” (Poppe 1954, 44 т).

<sup>66</sup> Poppe 1954, 49 т.

<sup>67</sup> Thomas 2011. 319-20 т.



*köge-*), *yobur* (*yo-dai*, *yo-du-yur*, *yo-ju-yur* харьцуулна уу) зэрэг.

Этгээрийн дунд *хураавар*, *шингэвэр* тодорхой байж *-bur* гэсэн дагавар үйлийн үр дүнгийн утгатай юмыг тэмдэглэж байна. Чингэхлээр *хөөвөр* гэсэн үг хөөх (хавагнах)-ийн үр дүнгийн утгатай юм болох ислийн хийгээр газар хөөнгөрч томорсон намаг<sup>68</sup> юм уу хөвсгөр, шигүү бус сэвсгэр юм<sup>69</sup> гэсэн утгатай билээ. Тэгэхэд *говор* (“навчгүй мод”,<sup>70</sup> “ургамалын иш гол эгц шулуун”)<sup>71</sup> гэсэн үгийн \**yo-* гэдэг язгуур чухамдаа “гуранхай, дэлдийх” гэсэн утгатай байх ёстой бөгөөд *yodai* гэдэг нь (“богино юм дэлдийх”)<sup>72</sup> (< \**yo-dai*; жишээлбэл *salba- salbadai* (бас *salbada-*), *julbu- julbudai*, *siyu-* “to pull up” *siyudai* “bag”<sup>73</sup> шиг бололтой) \**yo-* гэсэн үйл үгийн язгууртай байх ёстой гэмээр. Гэвч үүнийг таамаглахад ташаарч, *yoduyur*, *yojuyur* хоёроос үзвэл энэ тохиолдолд \**yo* бол нэр үг байсан учир **Гау**-ын дотор хэлсний ёсоор *хураавар* гэсэн мэт үгтэй харьцуулж болохгүй.

Чингэхлээр *qobur* гэсэн үгийн утга нь “юмгүй болохын үр дүнг илэрхийлэх юм” → “цөөхөн, хомс” гэж хөгжиж ирснийг харж болно.

### Гбδ) “Qogu-” гэсэн үг

Үйл үг бүтээх *-rU* дагаварын үүргийг судлахаар цөөхөн жишээ байна. Нэр үгэнд залгах *-rU* дагаврыг (жишээлбэл *coqu-ru-* < *coqu*) үл тооцвол *görü-* (< \**gö-rü-*), *gö-r*<sup>74</sup> (*görde-*, *görle-*) гэсэн үгс, *kirü-* (< \**ki-rü-*), *kir(i)dke-*, *kire-*,<sup>75</sup> *kires-*, *kireg* гэсэн үгс, *körü-* (< *kö-rü-*), *kölde-*, *kölmü-*<sup>76</sup> гэсэн үгтэй холбоотой бололтой учраас *-rU* гэсэн дагаврын үүргийг яг нарийн тогтоох нь хэцүү тул өмнө \**qo-* гэсэн язгуурын тухай өгүүлснээс болон *körü-*, *köldü-* гэсэн гэх мэт үгсийн утгаас үндэслэн үгийн утгыг нэг их өөрчлөхгүй гэж үзвэл *qoru-* нь \**qo-* гэсэн үгтэй адилхан “юмгүй болох” гэсэн утгатай гэж тойруулан хэлж болно.

### Гбε) “Qorçai-” гэсэн үг

Энэ үйл үг хэрвээ тухайлж буй үгсийн бүлэгт багтвал хийсвэр нэр үг бүтээх *-r* дагавраар<sup>77</sup> бүтсэн \**qor* гэсэн нэр үгээс *-çAi* (< \**-çAG-i*; *баацайх*, *баацгар* гэх мэтийг харьцуулна уу) гэсэн дагаврыг хэрэглэж үүссэн үйл үг байх ёстой боловч бүх *-çAi* дагавраар төгссөн үйл үгийг үгийн гарлын талаас үзвэл их асуудалтай<sup>78</sup> учир *-çA* гэсэн бүтээцтэй дагаврын дэлгэрэлт байсан болов уу. Үйл ба нэр үгэнд залгах *-çA* дагавар нь *-dA* дагаврын үүрэгтэй адилхан харагдана. Үүнд, *qoryuça-* нь *qoryuda-* гэсэнтэй утга адилхан (*qoryu* гэсэн үгээс үүссэн), *untuyuça-* гэсэн үйл үг *untuya(n)* гэсэн нэр үгээс, *jaruça-* гэсэн үйл үг *jaru-* гэсэн үйл үгээс, *tulyamça-*, *tulyamda-* хоёр *tulyam* гэсэн нэр үгээс тус тус үүссэн гэх мэт жишээг дурдаж болно. Дагавар *-çA*-ийн араас залгасан *-i* гэсэн дагавар нь үйл үгээс үүсмэл үйл үг бүтээх бөгөөд энэ

<sup>68</sup> Lessing нар 1960, 479 т.

<sup>69</sup> Дамбажав 2011, 2-р боть 714 т.

<sup>70</sup> Lessing нар 1960, 357 т.

<sup>71</sup> Дамбажав 2011, 1-р боть 419 т.

<sup>72</sup> Lessing нар 1960, 356 т.

<sup>73</sup> Lessing нар 1960, 700 т.

<sup>74</sup> Үйл үгэнд залгах *-r* гэсэн дагавар хийсвэр нэр үгсийг бүтээнэ (Porpe 1954, 49 т).

<sup>75</sup> Энэ *-rA* гэсэн дагавар үйл үг, нэр үгээс үүсмэл үйл үгсийг бүтээнэ (ж.: н.ү.-ээс *çögeke-re-*, *delbe-re-*, *büleke-re-* гэх мэт бөгөөд ү.ү.-ээс *neyidke-re-*, *seki-re-*, *buça-ra-* гэх мэт).

<sup>76</sup> *kölcü-* гэсэн үг утга зүйн үүднээс холбож болохгүй.

<sup>77</sup> Porpe 1954, 49 т.

<sup>78</sup> Би Чоймаа нарын бичсэн тонгоруу толь бичгийг (Чоймаа нар 2006) үндэслэн үзсэн.

үйл үгс нь *-Gar* гэсэн тэмдэг нэрийг бүтээх дагавартай холбогддог. Тэгэхлээр, *\*qo-r* “юмгүй болж байгаа байдал”, *\*qor-ца-* “юмгүй болж байгаа байдал бий болох” гэж үзэж болно.

### Гбэ) “Qotui-, qongqur” гэсэн үг

Энэ хоёр утга зүйн үүднээсээ хэлэлцэж буй үгсийн бүлэгт багтах бололтой. Гэвч нарийн үзвэл, энэ хоёрын бүтэц нэлээд асуудалтай. *-tUi* гэсэн дагавар гэвэл зөвхөн нэр үгэнд залгадаг *-tU* гэсэн дагаварын дэлгэрэлт бололтой учраас *qotui-* гэсэн үгийн язгуур нь үйл үг байж болохгүй. Бас *-ng, -Q/GUr* хоёр хэсгээс бүрдсэн *-ngQUr* гэсэн дагаварын бүх жишээ нь асуудалтай, шинжлэхэд хэцүү. Тийм учраас эднийг хасах хэрэгтэй байна.

### Гбн) “Qoçur-, qoki, qomsa”

*qoki, qomsa* энэ хоёр үг утга зүйн үүднээс тухайлж буй үгийн бүлэгт нийцэвч залгасан дагаварын хувьд асуудалтай байна. *qoki* гэсэн үг бол *-ki* дагавар нь нэр үгэнд залгадаг учраас *\*qo* нь үйл үгийн язгуур байж болохгүй учраас дээр сэргээсэн *\*qo-* гэсэн үйл үгтэй холбоогүй юм. Бас *-sa* гэсэн дагаварын үүрэг, гарал тодорхой бус улмаар ялангуяа хятадаас орсон үгэнд тааралддаг.

*qoçur-* гэсэн үг нь үйл үгэнд залгасан *-r* дагавраар нэмсэн шиг харагдаж байх (*sibqar-, sibqa-; qabsur-, qabsu-; qakir-, qaki-; jakir-, jaki-; tongyur-, tongyu-* гэх мэт) бөгөөд утга зүйн үүднээсээ<sup>79</sup> *\*qo* нь (*qoyin-a, qojim* зэрэг) “умар, ар” гэсэн утгатай үгэнд холбоотой бололтой.<sup>80</sup>

Нэгтгэн үзвэл, *qoγ* гэсэн үгийн үндсэн утга бол *\*qo-* гэсэн язгуур нь “юмгүй болох” гэсэн утгатай бөгөөд *\*qo-γ* нь *-γ* гэсэн дагаврын үүргийн ёсоор<sup>81</sup> “юмгүй болж байгаа юм, цөөхөн юм” гэсэн үндсэн утгатай байсан гэх нь зүйтэй. Түүнээс үүссэн утгыг амархан тайлбарлаж болно: “юмгүй болж байгаа юм, цөөхөн/багахан юм” → “үлдэгдэл” → “хаягдал” → “новш”.

Түүнчлэн монгол хэлний “хог” гэдэг үг хоёр үүсэл гаралтай бололтой. Эхийнх нь түрэг хэлнүүдийн нэгээс авсан үг, хоёрдугаарх нь уугуул монгол үг.

Хэрвээ МНТ-ны §234 зүйлийн хэллэгийн нэгдүгээр мөрийг дээр сэргээн гаргасан “хог” гэсэн үгийн утгаар шинээр уншвал:

*qoq idejü*

“цөөхөн / багахан идэж” гэсэн утгатай болно.

Хоёрдугаар мөрийн талаар, хомоол бол аргалаас хурдан бөгөөд дулаан багатай, илч муутай түлш болохыг малчид сайн мэдсээр ирсэн нь чухал ач холбогдолтой. Ганцхан хомоол түлбэл хоол хийхэд чухам тэнцэхгүй гал гарч байна. Иймээс, энэ мөр

*qoma'ul tülejü*

“хоол хийж болохооргүй юм түлж” / “багахан гал гаргаж” гэж ухаж болно.

Гэвч энэ тайлбар тов тодорхой бус. Хомоол түлж гэдгийг орчин тойрныг ариутгах арга хэмжээ гэж ухаарч ч болно. Харин энэ заншил дээр үеийн баримтгүй, дөнгөж саяхан баталсан байдалтай бөгөөд орчин цагийн заншлыг зүгээр дээр үед

<sup>79</sup> МНТ-д “zurückbleiben, sich verspäten” (хоцрох, хождох/хожимдох) утгатай (Haenisch 1939, 64 т).

<sup>80</sup> Starostin нар *qoçur-* гэсэн үгийг бусад зүйлсийн дунд орхон түрэг *qaç-* (“to run away, flee (убегать)”)–тай холбуулсан нь утга зүйн үүднээс үнэхээр холбогдолгүй (Starostin нар 2003, 751 т).

<sup>81</sup> “[I]t form[s] nouns designating results of actions, abstract ideas” (Poppe 1954: 45 т).

шилжүүлж болохгүй учраас энэ тайлбар бас тов тодорхой бус байдаг. Харин энэ асуудлыг АНТ (асрагч нэргийн түүх) шийдэх байх (доошоо үзнэ үү).

#### Д) Өөр сурвалжууд

ЛАТ (Лувсанданзаны алтан товч)-д МНТ-ны *idejü* гэсэн үйл үг биш *abču* гэж уламжлагдаж ирсэн байна. АНТ-нд *qamijü* гэж тааралдсны хамтаар үнэхээр Ш.Чоймаагийн санаа зарим талаар зөв, анхны гар бичмэлийн *etejü* үйл үгийг МНТ-ны хятад ханзаар бичсэн гар бичмэлд *idejü* болгон буруу уншиж байсан нь бололтой. Гэвч нөгөө талаар XVII зууны энэ хоёр эх сурвалжуудад МНТ-нд уламжлуулсан, амархан ухагдахгүй *хог идэж* гэсэн хэллэгийг ойлгоогүй учраас өөрийн ойлголтоор тайлбарлаж хөрвүүлсэн байх боломжтой. Энэ асуудлыг тодорхой шийдэж чадахгүй боловч хамгийн магад боломжийг тэмдэглэж чадна.

Анхны гар бичмэлүүдэд хэрвээ үнэхээр *etejü* бичсэн бол үүнийг өөрчлөгдсөн юм уу өөрчлүүлсэн хэвээр яагаад уламжлуулсан, АНТ, ЛАТ-д янз бүрийн маягаар өөрчилж бичих ямар хэрэг байсан юм бэ гэж амархан тайлбарлаж чадахгүй.

Ингэхэд *Ockham's razor*-ын ёсоор АНТ, ЛАТ-д нь ойлгоогүй хэллэгийг өөрчлөөд бичсэн нь (ганцхан хэрэгтэй таамаглал) МНТ-д буруу бичсэн бөгөөд АНТ, ЛАТ-д аль нэгэн учраас (аль нэгэн гар бичмэлд уламжлуулсангүй) эхэн үгийг өөрчилснөөс нь (хоёр хэрэгтэй таамаглал) дээр.<sup>82</sup>

АНТ, ЛАТ-д гарсан *ide*- юм уу *ete*- үгийн өөрчлөлтийн талаар утга зүйн үүднээс шийдвэрлэхээр үзэх ёстой.

МНТ, АНТ, ЛАТ, Хаадын үндэсний эрдэнийн товч-д *ete*- гэсэн үйл үг байхгүй бөгөөд дээр үеийн ховор үг байсан бололтой. Он Индү-ийн бичиг (1362)-д олдож буй *ulus-a qour-tu üyi:les-i eten tus-a-tu-yi yabuü:luysaba:r*<sup>83</sup> (16-р мөр) гэдгийг “улсад хортой үйлсийг этэн (≈ суга татан) тустайг явуулсаар” гэж ойлгоно. F. W. Cleaves “*eten*”-ыг “*extirpating*” гэж орчуулсан бөгөөд монгол *eten* гэдэг нь хятад зэрэгцээ хувилбарт тааралддаг “*removed*” гэсэн утгатай үйлийг хөрвүүлснийг тэмдэглэж бичсэн.<sup>84</sup>

Бусад толь бичигт *ete*- үйл үгийн өгсөн утга нь “*to pick, pluck out*”,<sup>85</sup> “*kratzen od. in der erde graben (nicht tief), schaufeln, pflügen tsas e. schnee schaufeln, wegfeigen (mit dem fuße, z.b. das pferd)*”,<sup>86</sup> “*выгребать; отметать*”,<sup>87</sup> “*urtu yaγum-a-yin ijügür-i nögege yaγum-a-yin douyuur širγyulju tegün-iyer nögege yaγum-a-yi tülkikü [...] abču qayaqu [:] yaqai čAr-A-dU ÜrdÜgdekü*”,<sup>88</sup> “*этүүр хэрэглэн өлгөх хамах; этэх хамах х о р ш .; хоол этэх*”<sup>89</sup> бий. Дундад үеийн монгол хэлний бусад сурвалж (Поппе 1938, Haenisch 1939, Жанчив 2002, Golden 2000), Ойрад (Kueger 1978), Ордос (Mostaert 1941-44), Монгол (Smedt/Mostaert 1933)-д энэ үйл үг байхгүй. Эртний

<sup>82</sup> Бас ялангуяа *lectio difficilior*(хэцүү уншлага)-ыг *lectio potior*(хүчтэй уншлага) гэж үздэг байна. Учир нь амархан ойлгогдохгүй юмыг ойлгомжтой болгон өөрчлөх нь ойлгомжтой юмыг ойлгогдохгүй юм болгон өөрчлөх нь илүү магад гэсэн үг. Гэвч энэ бол гарцаагүй бус.

<sup>83</sup> Tumurtogoo 2006, 29 т.

<sup>84</sup> Cleaves 1949, 108 т.

<sup>85</sup> Lessing 1960, 335 т.

<sup>86</sup> Ramstedt 1935, 128 т. Zwick (1853)-д энэ үйл үг байхгүй.

<sup>87</sup> Муниева 1977, 705 т.

<sup>88</sup> C.Noᠮᠵᠢᠨ 1999, 260-1 т.

<sup>89</sup> Я.Цэвэл 1966, 891 т. И.Дамбажав (2010)-д төстэй.

түрэгийн *et-* “to organize, put in order”,<sup>90</sup> “совершать/устраивать”<sup>91</sup> гэсэн үйл үг бас *ete-* хэвээр Монголд орсон бололтой (Kowalewski: “положить, накладывать (пищу, кормь) в посуду”,<sup>92</sup> Голстунский: “Класть, накладывать, наливать во посуду (пищу, кормь)”, I. J. Schmidt: “Speise oder Futter in ein Gefäß thun”<sup>93</sup> гэсэн).

Тэгээд *ete-* гэсэн үйл үгийн гурван утгыг тэмдэглэж болно (дандаа ойролцоо): 1-рт “өлгөж (ухаж) авах”, 2-рт “маажиж ухах” (зөвхөн хальмагт), 3-р “савд тавих, асгах”.<sup>94</sup> 3-р утга нь нэг ба 2-р утгатай холбоогүй, ижил бүтээвэртэй хэдий ч ялгаатай үйл үгийнх буй бөгөөд түрэг хэлүүдийн нэгээс олсон бололтой (*жиш.* эртний түрэг *et-*). 2-р утга зөвхөн хальмагт олдож бий бөгөөд Он Индү-ийн бичгийн дээр үеийн утга бас 1-р утгатай төстөй шиг харагдаж байх учраас *ete-* гэдгийг уг нь “өлгөж (ухан) авах” гэж тэмдэглэж болно. Түүнчлэн уг нь “хураах, цуглуулах” гэсэн утга байхгүй байсныг Он Индү-ийн бичгээс түвэггүй үзэж болно. Цаашдаа орчин үеийн “хуруугаар этэх” гэдэг нь ойролцоогоор “хуруугаар хальт цохиж шүргэн авах” утгатай. Нэг ба 2-р утгыг нэгтгэх гэвэл “(үзүүртэй) юмаар дороос нөгөө юмыг өлгөн авах” (эндээс бас Ramstedt-ын *schnee schaufeln* < “цасан доруур бариж авах” !?) гэж тойруулан ярьж болно. Харин *qoγ* гэсэн үгийг “тоос” (түрэг үг), “хэмхэлсэн ногоо” (хятад тайлбар), “бага юм” (бидний дээр олсон угийн утга) хамаагүй гэж үзвэл энэ тохиолдол бүрэнд *ete-* үйл үгийн утга сайн нийцэхгүй.

Харин дээр үед ч “хог” гэдэг нь орчин үеийн утгатай байсан гэж баталж чадахгүй боловч үгүйсгэж ч чадахгүй. Ийм тохиолдолд “хог” бас идсэн малын яс мас байсан бололтой. Гэхдээ ингэхээр дахиад нэг таамагласан юм байдаг (бас энэ тохиолдолд *ete-* үл нийцэн “хог савардах” юм уу “хамах, авах” шууд гэдэг нь дээр байх сан).

Тэгээд энэ хэллэгийн нэгдүгээр мөр уг нь “хог идэж” гэсэн талаар утга зүй сайн нийцэх төдийгүй ганцхан (бусад эх сурвалжийн талаарх) таамаглал л хэрэгтэй учраас энэ уншил хамгийн магад байна. Харьцуулбал “хог этэж” гэвэл утга зүй нийцэхгүй бөгөөд хоёр таамаглал хэрэгтэй (дээр үзнэ үү).

Хоёрдугаар мөрийн “хомоол түлж” гэдэг нь “газар ариутгаж” эсвэл “бага гал түлж” гэсэн аль утгатай вэ гэвэл “газар ариутгаж” гэсэн тохиолдолд нэг илүү таамаглал хэрэгтэй (дээр үзнэ үү) боловч шууд шийдэж чадахгүй. Гэвч АНТ-д энэ хэллэг хоёр мөртэй л биш гурван мөртэй байна.<sup>95</sup>

18a05-07

[...] *qorūqan-dur*

*baqūji qoq qatūji qomūqul tüle-*

*jū yabutuqai* [::]

*горхид бууж*

*хог хамаж*

*хомоол түлж явтугай*

<sup>90</sup> Clauson 1972, 36 т.

<sup>91</sup> Надеяев нар 1969, 186 т.

<sup>92</sup> Kowalewski 1844-49, 200 т.

<sup>93</sup> Голстунский 1895, 83 т.

<sup>94</sup> Schmidt 1835, 33 т.

<sup>95</sup> Дагуур хэлэнд “этэ-” бол “побеждать” гэсэн утгатай (Тодаева 1986, 141 т).

Дундад үеийн монгол хэлэнд эхний авианы хоолойн угаар хэлэгдэх гийгүүлэгч бүр дуугүй бөгөөд “горхи”-ийг *qorqan, qorqon, qoroqan* гэж бичсэн улмаар сайхан толгой холбож байх учраас “*qoruqan-dur baquju*” үнэхээр дээр үеийн вариант байж болно.

Хам сэдвийн үүднээс горхи нь багахан устай гол байдаг учраас “горхид бууж” бол “бага ус ууж” гэсэн утгатай гэж бодол төрж байна. Түүнчлэн энэ мөр бол манай хэллэгийн зөв ойлголтын нэг нэмэлт заалт байж болно:

*багахан ус ууж*

*багахан юм идэж*

*багахан гал түлж явтугай* гэж утга агуулгын зохицолтой. Өөр вариант бол “(аль нэгэн шалтгаанаас) горхид бууж хог идэж газар ариутгаж явтугай” гэж утга агуулгаар сайн таарахгүй.

Тийм учраас “хогоол түлж” гэдэг нь “бага гал түлж” гэсэн утгатай байсан нь утга агуулга зохицохоор үл барам аль ч таамаглал хэрэггүй учраас утга агуулга зохицохгүй, таамаглалтай “газар ариутгаж” гэснээс зохилтой мэт.

## Е) Дүгнэлт

Өгүүлсэн бүхнийг дүгнэн хэлбэл, “Дөдэй чэрби даран аж ордын хойноос хог идэж хогоол түлж явтугай” гэсэн хэллэг нь “Дөдэй чэрби (ордыг) хамгаалж (чухал ажил хийх, том алба хааж буй газар болох) ордын хойноос [багахан ууж] багахан идэж багахан галлаж явтугай” шууд утгаар тэмдэглэх зүйтэй. Харин шилжсэн утга нь “Дөдэй чэрби хамгийн чухал ажил хийх хүн болохоор **амарч тайван суулгүй амсхийх төдий байж, дандаа сэрэмжтэй байх ёстой**” хэмээн тайлж болно.

## НОМ ЗҮЙ

*Монгол Хэлний*

*И. Дамбажав*: Оюун Билгийн Мэлмийг Нээгч Аялгуу сайхан Монгол Үгийн Дээж. УБ: Өнгөт Хэвлэх ХХК, 2010.

*Ё.Жанчив*: Дөрвөлжин үсгийн монгол дурсгал. Улаанбаатар: Centre for Mongol Studies, 2002 (Monumenta Mongolica: Tomus III).

*Д.Заяабаатар*: Асрагч нэртийн түүх. УБ: МУИС, 2011.

*С.Norjin*: Mongyol kelen-ü toli. Köke qota: Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1999.

*Д. Отгонтуяа*: “Монгол Нууц Товчоон”-ы нэгэн хэлцийн орчуулгын тухайд. Монгол Судлал XXVII (285), 2007. 171-176 т.

*Г. Сүлд-Эрдэнэ нар*: Монгол Хэлний Өвөрмөц Хэлний Толь. УБ: Монсудар, 2013.

*Я.Цэвэл*: Монгол хэлний товч тайлбар толь. УБ: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966.

*Ш. Чоймаа нар*: Монгол Бичгийн Хэлний Тонгоруу Толь. II боть. Хөх хот: МУИС-ын хэвлэлийн газар, 2006.

*Ш. Чоймаа*: Монголын Нууц Товчоо – Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. УБ: «Мөнхийн Үсэг» ХХК, 2011.

*Ш. Чоймаа нар*: Монгол хэлний хадмал толь. УБ: Соёмбо принтинг, 2011.

*Гадаад Хэлний*

*G. Clauson: An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish. Oxford: Clarendon Press, 1972.*

*F. W. Cleaves: The Sino-Mongolian inscription of 1362 in memory of Prince Hindu. Harvard Journal of Asiatic Studies, 12 (1949), 1-133 т.*

*M. Erdal: Old Turkic Word Formation – A Functional Approach to the Lexicon. Vol. I. Wiesbaden: Harrassowitz, 1991.*

*A. von Gabain: Alttürkische Grammatik mit Bibliographie<sup>2</sup> Lesestücken und Wörterverzeichnis, auch Neutürkisch. Leipzig: Harrassowitz, 1950 .*

*P. B. Golden: The King's Dictionary. The Rasûlid Hexaglot: Fourteenth Century Vocabularies in Arabic, Persian, Turkic, Greek, Armenian and Mongol. Leiden: Brill, 2000.*

*К. Ө. Голстунский: Монгольско-Русский Словарь. Томъ первый. Санкт Петербургъ, 1895.*

*К. Ө. Голстунский: Монгольско-Русский Словарь. Томъ второй. Санкт Петербургъ, 1894.*

*E. Haenisch: Wörterbuch zu Manghol Un Niuca Tobca'an (Yüan-Ch'ao Pi-Shi) – Geheime Geschichte der Mongolen. Leipzig: Harrassowitz, 1939.*

*E. Haenisch: Die Geheime Geschichte der Mongolen – Aus einer mongolischen Niederschrift des Jahres 1240 von der Insel Kode'e im Keluren-Fluß. Leipzig: Harrassowitz, 1948 .*

*J. É. Kowalewski: Dictionnaire Mongol-Russe-Français. Kazan: Imprimerie de l'Université, 1844-49.*

*J. R. Krueger: Materials for an Oirat-Mongolian to English Citation Dictionary. Bloomington: Mongolia Society, 1978.*

*F. Lessing нар: Mongolian-English Dictionary. Berkeley/Los Angeles: University of California Press, 1960.*

*L. Ligeti: Histoire Secrète des Mongols. Budapest: Akadémiai Kiadó, 1971.*

*A. Mostaert: Dictionnaire Ordos. Peking: The Catholic University, 1941-44.*

*Б. Д. Муниева: Калмыцко-Русский Словарь. Москва: Издательство «Русский Язык», 1977.*

*В. М. Наделяев нар: Древнетюркский Словарь. Ленинград: Издательство «Наука», 1969.*

*U. Onon: The Secret History of the Mongols – The Life and Times of Chinggis Khan. London: Routledge, 2001 .*

*Н. Понне: Монгольсий Словарь Мукаддимат ал-Адаб. Москва: Издательство Академии Наук СССР, 1938.*

*N. Poppe: Grammar of Written Mongolian. Wiesbaden: Harrassowitz, 1954.*

*N. Poppe: Vergleichende Grammatik der Altaischen Sprachen – Teil 1 Vergleichende Lautlehre. Wiesbaden: Harrassowitz, 1960.*

*I. de Rachewiltz: The Secret History of the Mongols – A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century. 2 Volumes. Leiden/Boston: Brill, 2004.*

*G. J. Ramstedt: Kalmückisches Wörterbuch. Helsinki: Suomalais-Ugrilainen Seura, 1935.*



- I. J. Schmidt*: Mongolisch-Deutsch-Russisches Wörterbuch. St. Petersburg: Kaiserliche Akademie der Wissenschaften, 1835.
- S. A. Starostin нар*: Etymological Dictionary of the Altaic Languages. Leiden: Brill Academic Publishers, 2003.
- J. Ch. Thomas*: Zur Etymologie von Mongolisch noqai “Hund” – Überlegungen zur Sippe um vorgemeinmongolisch \*√no-. Zentralasiatische Studien (ZAS) (40), 2011. 313-341 т.
- Б. Х. Тодаева*: Дагурский язык. Москва: Издат. Наука, 1986.
- D. Tumurtogoo*: Mongolian Manuscripts in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries). Taipei: Institute of Linguistics, 2006.
- H.-P. Vietze*: Wörterbuch Mongolisch-Deutsch. Berlin: DAO-Verlag, 2006 .
- W. Zwick*: Handbuch der Westmongolischen Sprache. Hufingen: Heinemann, 1853.

**МОНГОЛ БОЛОН СОЛОНГОСЫН АНАГААХ УХААНЫ СУРВАЛЖ  
БИЧГҮҮДЭД РАШААН, УСНЫ ТУХАЙ ӨГҮҮЛСЭН НЬ**

П.Молор-Эрдэнэ  
Хан Жү Ён  
/ Dankook University/

**USES OF VARIOUS WATERS AND HOT SPRINGS WRITTEN ABOUT IN  
THE SOURCES OF MONGOLIAN AND KOREAN MEDICINE**

**Abstract**

The purpose of this study is to compare usages of various therapeutic waters and natural hot springs described in the four valuable medical sources of Mongolian and Korean medicine namely “Dongui bogam”, the encyclopedic scripture of medical knowledge and treatment techniques of East Asia edited by the Korean scholar Heo Jun (1539-1615), “The four medical tantra”, the principal textbook of Tibetan and Mongolian medicine, “The wonderful illumination to the understanding of knowledge”, a major sourcebook of Mongolian and Tibetan materia medica written by the Mongolian scholar Naiman Toin Jamphel Dorje (1792-1855) and “A Medicine and Medical Collection”, an important source covering the various area of Mongolian and Tibetan medicine, which was written by Mongolian scholar, Toin Lobsang Chopel in Tibetan (19<sup>th</sup> century).

Descriptions about various waters and springs in the sources can be ascertained in the type, rank, taste, nature, power, effects, methods and time of use, methods of collecting, caution and regime.

Notable similarities and differences were observed in the uses of various waters and hot springs written about in the sources of both medicines. Many more types of waters with a variety of therapeutic powers are described in “Dongui bogam” and many more specific powers can be noted such as curing near death infantile convulsive seizures due to fright, wrenched muscles due to intestinal convulsion, diabetes and mental condition etc. Specific uses of water written in the sources of Mongolian medicine are improving the stomach fire and digestion.

In the Mongolian medical sources, various types of natural and artificial hot springs are written and are described as being able to cure a variety of disorders especially joint conditions. Moreover, it is taught in the Mongolian medical sources, that special treatments and regimes of diet and behavior should be taken during and after the hot spring treatments. Certain skin disorders such as leprosy, syphilis and scabies are suggested to be treated by hot spring in “Dongui bogam”. Furthermore various interesting methods of water collecting are outlined in “Dongui bogam”, while important methods

of water storage are taught in the sources of Mongolian medicines. Cautions for uses of waters and hot springs are specifically described in the sources of both medicines. Taken together these suggest the very rich traditions of using various therapeutic waters and hot springs in both Mongolian and Korean medicine that have been passed down to date and that can mutually be strengthened, taught, studied and applied even the nature, climate and life style of the two countries are different.

**Key words:** therapeutic water, hot spring, sources of Mongolian medicine

### Удиртгал

Рашаан гэдэг нь шим авхуулагч гэсэн утгатай *rasāyana* гэсэн санскрит үг юм.<sup>1</sup> Ус газрын гүнд олон мянган жил байхдаа төрөл бүрийн эрдэс давс, хийг уусган авснаас энгийн уснаас өөр шинж чанартай эрдэст буюу рашаан ус болдог юм.

Хүн төрөлхтөн эрт дээр үеэс рашаан усыг ашиглан өвчин эмгэгийг анагааж ирсэн баялаг түүхтэй. Монгол орны зарим рашаануудын дэргэдээс хуучин, шинэ үеийн чулуун зэвсэг, хүрэл зэвсэг олддог нь Монголын газар нутагт амьдарч байсан эртний хүмүүсийн рашаан усыг ашиглаж байсныг гэрчлэх баримт мөн. VII-VIII зууны үед Орхон мөрний орчимд оршин амьдарч байсан Түрэгүүд Отгонтэнгэрийн халуун рашааныг хэрэглэж байсан тухай мэдээ Тан улсын бичигт үлджээ. “Идээ ундааны жинхэнэ товч”-д Юань гүрний Монгол хаад рашаан булгийн усыг хэрэглэж байсан тухай дурдсан байдаг. XVII зууны үеэс эхлэн рашаан усны дэргэд Манба дацангууд байгуулагдаж монгол эмч нар рашаан усанд орох, ууж хэрэглэх заавар журмыг боловсруулан, эмчилгээ хийж байжээ.

Монгол эмч мэргэд рашаан усны эмчилгээний чанарын талаар судар номдоо бичиж үлдээсэн нь олонтаа. Лувсанчоймболын “Анагаах ухааны эрхэм түүвэр”, Найман тойн Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг” зохиолуудад эмт ус, байгалийн халуун рашааны гарах газар, төрөл зүйл, бүрэлдэхүүн, үйлдэл, хэрэглээ зэргийн талаар тодорхой өгүүлсэн байдаг. Монгол Улсад рашаан усыг 1926 оноос эхлэн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж Орос, Монголын судлаачдын хийсэн хэд хэдэн удаагийн дорвитой ажлуудын үр дүнгүүд хэвлэгджээ. 1934 оноос эхлэн Хужиртын халуун рашаан, Улаанбаатар, Жанчивлан зэрэг анхны рашаан сувиллууд байгуулагдаж, техник, тоног төхөөрөмжөөр хангагдан ажиллаж эхэлсэн байна. Одоо Монгол орны нутаг дэвсгэр дээрх 180 орчим рашаан усны найрлага шинжлэгдээд байна.<sup>2, 3, 4, 5)</sup>

Түүхийн сурвалжид дурдсанд үндэслэж Солонгос улсад Гурван Улсын Үеэс (МЭӨ 57 - МЭ 668) рашаан усыг хэрэглэдэг байжээ гэж үздэг. “Чүсон гүрний цаг тооны бичиг”-т рашааны усны эмчилгээний талаар дурдсан 71 тохиолдол байдаг

<sup>1</sup> О.Дэмчигмаа. “Субашид”-ын монгол орчуулгуудын үгийн сангийн онцлог. Удам соёл ХХК, Улаанбаатар, 2013

<sup>2</sup> Б.Жанчив. Байгалийн зарим эмнэлэг. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, Улаанбаатар, 1965.

<sup>3</sup> Н.Оюунцэцэг, Д.Цэнд-Аюуш, Н.Төмөрбаатар, Т.Алимаа. Монгол анагаах ухааны засал. Мөнхийн үсэг ХХК, 2012.

<sup>4</sup> Д.Зоригтбаатар. Отгонтэнгэрийн рашаан эмчилгээний идэвхийн туршилт-эмнэлзүйн судалгаа. Докторын диссертаци, Улаанбаатар, 2011.

<sup>5</sup> С.Сээсрэгдорж. Анагаах ухааны дөрвөн үндсийн язгуурын үндэс түүний тайлбарууд. Мөнхийн үсэг ХХК, Улаанбаатар, 2012.

байна. Сурвалжуудад бичигдсэн баримтуудаас жишээ болгон дурдвал 1003 онд Гүрө улсын хаан Мүгжон хүндээр өвчилсөн түшмэлдээ халуун рашаанд орохыг зөвлөж байжээ. Мөн Чүсоны үеийн эцэг, хүү Тэжо болон Тэжон хаад халуун рашаанд тогтмол ордог байсан тухай бичжээ. 1326 онд хааны зарлигаар халуун рашааны дэргэд “Халуун ордон” нэртэй, рашаанд орох бага хэмжээний ордныг анх удаа барьж байсан байна. Сэжун хаан (1418-1450) зарлиг болгож халуун рашааны үйлдлийг судлуулж байснаас гадна уураар эмчлэх аргыг нэвтрүүлж, цусны даралт өндөртэй, зүрхний өвчтэй хүмүүсийг хэрэглэхийг хориглож байжээ. Унян хотод (одоогийн Асан хот) Сэжон хааны халуун рашааны ордон барьсан нь одоогийн Унняян Куангуан зочид буудал бөгөөд халуун рашааны үйлчилгээг эрхэлсээр байгаа аж. Үүнчлэн Солонгосын удаан жилийн түүхтэй рашаан усны газраас олныг дурдаж болно. 2002 оны байдлаар БНСУ-д 277 тооны рашаан усны газар бүртгэгдсэн ба халуун рашаанд түшиглэсэн амралт сувилал, аялал жуулчлалын бизнес өндөр хөгжжээ. Солонгосын анагаах ухааны рашаан, усны эмчилгээний талаар дэлгэрэнгүй тодорхой өгүүлсэн анагаах ухааны ном бол Солонгосын алдарт эмч Хө Жүний бичсэн “Дун уй бугам” юм.<sup>6,7,8,9,10)</sup>

Энэхүү судалгаа нь Монгол, Солонгосын анагаах ухааны сурвалж номуудад бичсэн эмт ус, халуун рашааны тухай мэдлэгийг харьцуулан судалж, хоёр орны уламжлалт анагаах ухааны рашаан усны эмчилгээний аргуудын адил төстэй талууд хийгээд ялгагдах онцлогуудыг тодруулах зорилт тавилаа.

### Судалгаанд ашигласан сурвалжуудын тойм

Судалгаанд “Анагаах ухааны дөрвөн үндэс” (цаашид АУДҮ гэж товчлон бичнэ) буюу *rgyud bzhi* (Ш. Болд, С. Отгонбүрэн, Рашаан зүрхний найман гишүүнт нууц уддисын үндэс, Мөнхийн Үсэг ХХК, 2012, монгол хадмал орчуулга), “Дун уй бугам” (цаашид ДБ гэж товчлон бичнэ) буюу *Dongui bogam* (Heo Jun, Dongui bogam, Ministry of Health and Welfare, 2013), “Анагаах Ухааны Эрхэм Түүвэр” (цаашид АУЭТ гэж товчлон бичнэ) буюу *gces btus snying nor* (Лувсанчоймбол, Жэдүйниннор, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, 1999, монгол орчуулга), “Үзэсгэлэнт нүдэн чимэг” (цаашид ҮНЧ гэж товчлон бичнэ) буюу *mdzes mtshar mig rgyan* (Жамбалдорж, Үзэсгэлэнт нүдэн чимэг, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, 1998, монгол орчуулга) зэрэг сурвалжуудыг ашиглав.

Эдгээр сурвалжуудын талаар бусад ном, судалгаанд бичсэнээс товчлон доор өгүүлэв.

АУДҮ бол Энэтхэгийн Аюурведээс улбаатай Төвөд, Монголын анагаах ухааны үндсэн сурах бичиг юм. АУДҮ-ийн үүсэл гарал нь Аюурведийн анагаах ухааны “Чарака Самхит”, “Сушрута Самхит” (МЭӨ200-МЭ200) гэсэн хоёр номын эмхэтгэл, Багватын бичсэн “Найман гишүүнтийн зүрхэн хураангуй” юм.

<sup>6</sup> 鄭麟趾 등, 『高麗史』, 경인문화사, 2009

<sup>7</sup> 金宗瑞 등, 『高麗史節要』, 민족문화추진회, 1968.

<sup>8</sup> 『朝鮮王朝實錄』, 국사편찬위원회, 1994

<sup>9</sup> 安鼎福, 『東史綱目』, 민족문화추진회, 서울, 1988.

<sup>10</sup> 一然, 『三國遺事』, 을유문화사, 서울, 1985

Багватын энэ ном болон уг номын Багватын өөрийн тайлбарыг Кашмирын эмч Чандранандан тайлбарлан “Найман гишүүнтийн зүрхний тайлбар үг утгын сарны гэрэл” гэдэг номыг бичиж Төвдийн орчуулагч Бирозанад өгснөөр Төвд хэл рүү орчуулагджээ (VIII зуун). Уг номд Төвдийн нэрт эмч Бага Ютог Ёндонгомбо (708-833) томоохон тайлбар болон нэмэлтүүдийг хийсэн ба үүн дээр Ломиг Ойдов болон тавдугаар Далай лам Лувсанжамц (1640-1682) зэрэг хүмүүс нэмэлт тайлбар сэлтийг хийжээ. ХҮI зуунаас бурхны шашин Монгол оронд хүчтэй дэлгэрэхийг дагалдан АУДҮ Монгол оронд дамжин иржээ. Ламын гэгээн Лувсанданзанжамц (1639-1704), Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788), Лүнригдандар зэрэг монгол эмч, мэргэд чухалд тооцогдох нэмэлт тайлбаруудыг хийсэн байна. АУДҮ-ийн анхны монгол орчуулгыг 1630 онд Шинба тойн хийсэн ба бүрэн хэмжээний, өнөөг хүртэл хамгийн сайнд тооцогддог орчуулгыг 1720 онд Минжүүр гүүшийг хийсэн гэж үздэг. АУДҮ бол Язгуурын Үндэс, Номлохуйн Үндэс, Эмчилгээний Үндэс, Хойд Үндэс гэсэн дөрвөн үндсэн хэсгээс бүрддэг. Усны тухай “Номлохуйн үндэс”-ийн “Идээ ундааны орон”-д, халуун рашаан болон хиймэл рашааны тухай “Хойд үндэс”-ийн “Дэвтээх засал”-ын бүлэгт өгүүлсэн байдаг.

ҮНЧ бол Монгол хүний төвөд хэлээр Монгол эмийн бодисын талаар дэлгэрэнгүй тодорхой бичсэн хамгийн томоохонд тооцогдох бүтээлд ордог. Жамбалдорж зохиолдоо нийт 879 төрлийн эмт бодисыг эрдэнийн, чулуун, шороон шимийн, өвсөн, модон, дан, амьтнаас гарах эм гэж 8 аймагт хуваан тэдгээрийн гардаг газар, ургах орчин, хэлбэр дүрс, амт чанар, чадал, эмд орох хэсэг, номхотгох арга зэргийг тодорхой тайлбарлан бичсэний зэрэгцээ эмийн бодисын 576 зураг тайлбарыг багтааж, биеийн оньс, ханах, төөнөх бэлчрийн зураг, мэс заслын багажийн хэлбэр дүрсийг зурж, зохих тайлбарыг хийсэн байдаг. Зохиогч номдоо АУДҮ болон Төвөдийн алдарт эмч нарын зохиол бүтээлүүд болох Данзанпунцагийн “Болор эрх”, “Болор бөмбүлэг”, Дэсрид Санжаажамцын “Хөх Биндэрьяа” зэрэг олон зохиолоос иш татан бичсэн байдаг. Усан эмийн тухай номын есдүгээр бүлэгт өгүүлжээ.

АУЭТ бол Монгол анагаах ухааны бүхий л салбарыг хамруулж, 90 гаруй өвчний шинж, эмчилгээний арга, төрөл бүрийн эмийн бодисын чадал, эмийн олон найрлага зэргийг тодорхой өгүүлсэн, уламжлалт анагаахын эмч, мэргэжилтнүүдийн гарын авлага болсон бүтээл юм. Лувсанчоймпэл зохиолоо Монгол, Төвөдийн эмч мэргэдийн бүтээлүүд болон “Дөрвөн Үндэс”, “Данжуур” зэргээс түүвэрлэж өөрийн туршлагаар олсон эмүүдийг оруулан төвөд хэлээр эмхэтгэн бичжээ. Байгальд байдаг таван төрлийн халууны рашааны талаар номын 118 дугаар бүлэгт бичсэн байна.<sup>11, 12)</sup>

Зүүн Азийн орнуудын анагаах ухааны мэдлэг, эмчилгээний аргуудын нэгдмэл нэвтэрхий толь, Солонгосын анагаах ухааны үндсэн сурах бичиг болох ДБ зохиолыг Солонгосын алдарт эмч Хө Жүн Солонгосын эзэн хааны удирдлагын доор анагаах ухааны мэргэжилтнүүд болон шүүмжлэгчдийн дэмжлэгтэйгээр 1613 онд эмхэтгэн бичжээ. Дун уй бугам гэдэг нь дорнын анагаах ухааны эрдэнийн

<sup>11</sup> Ц.Хайдав. Дорно дахины анагаах ухааны судар бичгийн тойм. Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх Үйлдвэр, Улаанбаатар, 1975.

<sup>12</sup> Ш.Болд. Монголын анагаах ухааны түүх. Адмон хэвлэх газар, Улаанбаатар, 2013.

